

**МОНГОЛ УЛСЫН УЛС ТӨР
ЭДИЙН ЗАСАГ
НИЙГЭМ**

ТОГТОЛЦОО БА БОДЛОГО

Номын редактор: Г. Чулуунбаатар, Доктор (Sc.D), Проф.

Номын эхийг бэлтгэсэн: Ё. Батболд, Фридрих - Эбертийн сангийн
ажилтан

Номд орсон тоо, баримт, мэдээллийн үнэн бодит байдлыг
зохиогчид хариуцах ба агуулгад илэрхийлэгдсэн санал дүгнэлт,
үзэл бодол нь зохиогчдын байр суурь болно.

МОНГОЛ УЛСЫН УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ:
ТОГТОЛЦОО БА БОДЛОГО

/Үйлдвэрчний эвлэлийн гишүүд,
дэмжигч, иргэдэд зориулсан гарын авлага/

АГУУЛГА

Удиртгал	6
Саркыт Зүльфикар (доктор, дэд профессор)	10
Нэгдүгээр бүлэг. МОНГОЛ УЛСЫН УЛС ТӨРИЙН ОРЧИН	11
1. Улс төрийн орчны тухай үндсэн ойлголт	11
2. Хууль тогтоох институт	21
3. Гүйцэтгэх эрх мэдэл (Засгийн газар)	26
4. Төрийн тэргүүн (Ерөнхийлөгч)	31
5. Шүүх засаглал	34
6. Нутгийн удирдлага	38
7. Төрийн алба	41
8. Улс төрийн нам, иргэний нийгэм	45
Ашигласан материал	50
Зохиогчийн тухай	51
Батчулууны Алтанцэцэг (доктор, дэд профессор)	52
Хоёрдугаар бүлэг. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	53
1. Эдийн засгийн үндсэн ойлголт, зарчмууд	53
2. Зах зээлийн тогтолцоо	58
3. Эдийн засгийн бодлого	67
4. Хөдөлмөрийн зах зээл	70
5. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл	74
Ашигласан материал	78
Зохиогчийн тухай	79
Доржготовын Наранцэцэг (доктор, профессор)	80
Гуравдугаар бүлэг. НИЙГМИЙН БОДЛОГО	81
1. Нийгмийн бодлого: мөн чанар, зорилго, хүрээ, хэрэгжүүлэгч субъектууд	81
2. Монгол улсын нийгмийн бодлогын эрх зүйн орчин ба хүний хөгжил	90
3. Боловсролын үйлчилгээ	93
4. Эрүүл мэндийн үйлчилгээ	95
5. Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ	101
6. Монгол Улсын нийгмийн бодлогын зарим чухал асуудал	106
Ашигласан материал	117
Зохиогчийн тухай	118
Цогтсайханы Уянга	119
Дөрөвдүгээр бүлэг. Монголын үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн ба Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо (МҮЭХ)	120
1. Монголын үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний түүхэн хөгжил	120
2. Өнөөгийн МҮЭХ-ны зохион байгуулалт	125
3. Хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн МҮЭХ-ны үйл ажиллагаа	128
Ашигласан материал	142
Зохиогчийн тухай	143
ХАВСРАЛТУУД	
Хавсралт 1. Монгол улсын төрийн байгуулал	144
Хавсралт 2. Монгол улсын төрийн байгууллын давуу болон сул тал	145
Хавсралт 3. МҮЭХ-ны үйл ажиллагаа, байр суурийн түүхчилсэн матриц	146
Хавсралт 4. МУ-ын Үндсэн хууль	148
Хавсралт 5. МУ-ын Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль	158

УДИРТГАЛ

Фридрих -Эбертийн Сан Монгол улсад 1990-ээд оны дунд үеэс эхлэн үйл ажиллагаагаа олон хэлбэрээр явуулж ирсний нэг гол чиглэл нь улс төрийн боловсрол олгох зорилгоор ном, товхимол бэлтгэн гаргах явдал билээ. Монгол дахь Фридрих -Эбертийн Сангаас эрхлэн уншигч Та бүхний гэрийн номын санд “Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгэм: тогтолцоо ба бодлого” хэмээх нэгэн шинэ бүтээлийг өргөн барьж байгаадаа баяртай байна.

Ардчиллыг хөхүүлэн дэмжиж, түгээн сурталчлах манай сангийн эрхэм зорилго нийгмийн ардчиллын /social democracy/ үзэл санаа, зарчмуудад тулгуурладаг. Нийгмийн ардчилал бол нийт иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулж, нийгмийн баялгаас тэгш хүртэх боломжийг олгож, гарааны тэгш байдлыг ханган шударга ёсыг дээдэлсэн энэ цаг үеийн тэмүүлэх учиртай нийгмийн тогтолцоо юм.

Нийгмийн баримжаатай төр бол нийгмийн ардчиллын гол цөм мөн. Улам бүр даяаршиж буй өнөөгийн дэлхий ертөнцөд эрх чөлөө, шударга ёс, эв нэгдлийн үнэт зүйлсийг иргэний, улс төрийн, нийгмийн, эдийн засгийн эрхийг хэрэгжүүлэх зорилтоор баяжуулж нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг руу шилжиж буй улс орны тоо өсөн нэмэгдсээр байна. Энэхүү үйл явцыг түүхэн хөгжлийн түршлага, өнөөгийн тулгарч буй асуудлууд дээр хийсэн дүн шинжилгээний үндсэн дээр гарч буй дүгнэлтэд суурилж гаргасан төрийн ухаалаг шийдвэрийн үр дүн гэж үзэж болно. Дэлхийн улс орнуудын дотор хүний хөгжлийн үзүүлэлтээрээ тэргүүлэх байр эзэлдэг Скандинавын орнууд бол энэ загварын сонгодог жишээ билээ.

Нийгмийн ардчиллын үзэл баримтлалд 3 гол тулгуур багана бий. Энэ бол хөдөлмөрийн шударга журам, нийгмийн баялгийн шударга хуваарилалтын журам түүнчлэн өргөн хүрээг хамарсан нийгмийн хамгааллын бодлого юм. Энэхүү тулгуурыг босгоход төрийн зохистой оролцоо зайлшгүй гэж үздэг. Гэхдээ хуучин социалист байсан орнуудын жишгээр хатуу төвлөрсөн бодлоготой байхыг сайшаадаггүй.

Нийгмийн ардчиллын загвар мөн сонгодог либерализмын нэгэн адилаар хувь хүний үүрэг хариуцлагыг чухалчилдаг. Энэ бол хүн бүр өөрөө өөртөө эзэн байж амьдралынхаа зураг төөргийг өөрөө бүтээнэ гэсэн үг. Харин төр засаг тийм боломжийг бүх талаар нь дэмжиж бүрдүүлэх үүрэгтэй. Нийгмийн ардчиллын онол хүн бол “нийгмийн амьтан” учраас өөрийн ашиг сонирхлын зэрэгцээ нийгэмтэйгээ хамт байж нийтийн ашиг сонирхлыг хүндэтгэдэг гэж үздэг. Хувь хүний ашиг сонирхол зөвхөн нийтийн эрх ашигтай зохицсон, эв санааны нэгдэлд үндэслэсэн нийгмийн тогтолцооны нөхцөлд л бодитой хангагддаг гэдгийг нэр хүндтэй олон судалгааны дүн батлан харуулдаг. Харин нийтийн эрх ашиг, хүсэл сонирхол, шаардлагыг хувь хүний эрх, эрх чөлөөтэй зохистой хослуулах хамгийн том арга хэрэгсэл бол иргэний нийгмийн идэвхтэй оролцоо юм.

Монгол улсын иргэдэд улс төр, эдийн засаг, нийгмийн бодлогод өөрийн дуу хоолойг хүргэх олон арга зам байдаг. Үүний нэг хэлбэр бол чөлөөт ардчилсан

сонгуульд саналаа өгөх явдал юм. Ардчилсан засаглалтай улсуудын иргэд сонгуульд чөлөөтэй, шууд, хараат бус байх зарчмын дагуу санал өгч парламентын гишүүдээ сонгодог. Иргэдийг төлөөлж эсвэл намын жагсаалтаар сонгогдсон парламентын гишүүд иргэдийн итгэлээс эх сурвалжтай эрх мэдлийнхээ үндсэн дээр /легитим/ гүйцэтгэх засаглалаа томилон ажиллуулдаг.

Ардчилсан засаглал бол ард түмний буюу олонхийн засаглал гэдэг. Энэ бол чухамдаа олонхи юу гэж шийднэ тэр шийдвэр л хууль ёсны хүчин төгөлдөр байна гэсэн үг. Мөн олонхийн гаргасан шийдвэр л бол “туйлын зөв” гэж шууд ойлгож болохгүй. Олонхын шийдвэр зөв эсэхийг ард түмний тодорхой хэсгийн итгэлийг хүлээсэн цөөнхи, иргэний нийгэм, иргэд сонгогчид хянаж, дүгнэдэг. Энэ бол ардчиллаар сонгогчдод олгогддог хамгийн том боломжийн нэг мөн.

Сонгогчдын боловсролын болон амьжиргааны түвшин тэдний сонголттой салшгүй холбоотой. Сонгогчдын боловсрол өндөр байх тусам тэдний аливаад хандах хандлага илүү нухацтай болж, асуудлыг язгуур үндсээс нь, тал бүрээс нь эргэцүүлэн бодож, шинжлэх ухаанаар батлагдсан баримт нотолгоотой мэдээллийг чухалчлан шүүмжлэлтэй, бүтээлч харах чадвар илүү хөгжсөн байдаг. Гэвч боловсролтой байх гэдэг бол их харьцангуй ойлголт. Нарийн мэргэжлийн боловсролыг голлон эрхэмлээд улс төрийн боловсролыг ойшоодоггүй нэгэн байхад аль алиныг нь чухалчилж, нийгэмд өрнөж буй хэлэлцүүлгүүдийг өөрийн бодол, ухаанаар тунгаан суух нь ч бас бий.

Өнөөгийн нийгэмд иргэний улс төрийн боловсрол хүн болгонд, тэр тусмаа хөдөлмөрчин хүний эрх ашгийг хамгаалдаг үйлдвэрчний эвлэл, түүний гишүүд, дэмжигчдийн хувьд бүр ч чухал. Улс төрийн боловсрол тэгвэл бидэнд яагаад хэрэгтэй вэ?

Нэгдүгээрт, бид сонгогчид. Бидний сонгосон улс төрчид нийтээр заавал дагаж мөрдөх төрийн бодлого, хууль тогтоомжийг батлан гаргана. Тийм шийдвэрүүд бидний амьдарч буй нийгмийн одоогийн болон дараа дараагийн жилүүдийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлно. Тиймээс бид хариуцлагатай сонголт хийх ёстой. Үүнд улс төрийн боловсрол хэрэгтэй.

Хоёрдугаарт, улс төр хэдийгээр хийсвэр ойлголт боловч бидний амьдралаас ангид нийгэмд оршин тогтнодог зүйл биш. Энэ бол бидний өдөр тутмын амьдралд тусгалаа олдог зүйл. Улс төрийн, эдийн засгийн, нийгмийн бодлого бие биетэйгээ аалзны тор шиг гинжин хэлхээгээр холбогдсон байдаг. Бүх шийдвэрийг зах зээлийн эдийн засгийн зохицуулалтад /Адам Смит: “үл үзэгдэгч гар”/ даатгаад орхивол энэ нь нийгмийн тэнцвэртэй байдал алдагдахад хүргэнэ. Улс төрийн шийдвэр болон төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд нь ихэнхдээ хоёр зорилгыг агуулсан байдаг: Үр өгөөжийг дээшлүүлэхэд эсвэл нийгмийн тэнцвэртэй байдлыг хангаж шударга ёсыг хэрэгжүүлэхэд. Өөрөөр хэлбэл яавал илүү том талхыг үр өгөөжтэй аргаар барьж болох вэ эсвэл уг талхыг ямар байдлаар хуваавал шударга болох эсэх дээр улс төрийн шийдвэрүүд гардаг гэсэн үг. Жишээлбэл: бидний сар тутмын цалингаас суутгадаг хүн амын орлогын албан татвар /10%/ болоод нийгмийн даатгалын санд төлж буй шимтгэлийн /10-12%/ хэмжээг тогтооход манай улсын улс төрийн тогтолцоо, эдийн засгийн үзүүлэлт, нийгмийн бодлого гэх мэт хүчин зүйлүүд нөлөөлнө.

Гуравдугаарт, улс төрийн боловсрол бол өөрөө боломж юм. Хүн өөрт заяагдсан

ба олдсон эрхээ эдэлж, түүнийхээ хэрэгжилтэд төрийн зүгээс ямар алхмууд хийж байгааг хянах эсвэл хийхгүй байгаа тохиолдолд шаардах, төр эрх мэдлээ урвуулан ашиглаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх чадвартай байх ёстой. Энэ чадварыг улс төрийн боловсролоор буюу улс төрийн тогтолцоо, түүний институциудын чиг үүрэг, эрх хэмжээний талаар тодорхой ойлголтын үндсэн дээр олж авна. Мөн нийгэм, улс төрийн амьдралд болж буй үйл явдлыг сонирхсоноор ирээдүйн аливаа хөгжлийн чиг хандлагыг ч тэндээс олж харах боломжтой болно.

Товчхондоо бол нэг талаас ардчиллын үзэл санаа, зарчмууд, нөгөө талаас улс төрийн боловсролоор олгогддог боломж хоёрыг иргэн бүр оновчтой, өгөөжтэй ашиглаж чадвал бид амьдарч буй нийгэмдээ эрх чөлөө шударга ёсыг бататган тогтоох бүрэн бололцоотой.

Фридрих -Эбертийн Сангаас эрхлэн бэлтгэсэн энэхүү гарын авлага нь юуны түрүүнд Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны идэвхтнүүд, гишүүд дэмжигчид, нийт иргэдийн улс төрийн боловсролд зориулан өнөөгийн Монголын улс төрийн, эдийн засгийн, нийгмийн тухай мэдлэг, мэдээллийг тоймлон хүргэх зорилготой болно. Гарын авлагад нийгмийн шинжлэх ухааны өнөөгийн төвшинд нийтлэг хэрэглэж буй ойлголт, үзэл баримтлал болон судалгаа шинжилгээний сүүлийн үеийн тоо, баримтыг ашиглав.

Бүтээлийн бүлэг бүрийг тус тусдаа зохиогчид туурвисан болно. Зохиогч бүр хариуцсан сэдвийнхээ хүрээнд өнөөгийн тогтолцоо, бүтэц зохион байгуулалтын талаархи шинжлэх ухааны болон хууль ёсны ойлголт, томъёоллыг тайлбарлав. Мөн тухайн сэдэвт холбогдох тодорхой асуудлыг тоо баримт, кейс жишээгээр тодорхой үндэслэж, өнөөгийн тулгарч буй сорилт, бэрхшээлийг тоймлон цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар товч ойлголт өгөхийг зорив. Хэдийгээр зохиогчид бүлгийн агуулгыг тус тусдаа гаргасан боловч ном маань нэг зорилгод чиглэгдсэн учраас бүхэлдээ бие биеэ нөхсөн, харилцан уялдсан ерөнхий мэдлэг, мэдээллийг тоймлон багтаасан нэг цогц бүтээл болсон гэж үзэж байна.

Өнөөгийн мэдээллийн эрин үед бид мэдээ, мэдээллийг интернет, сонин сэтгүүл, радио телевиз гээд олон сувгаар чөлөөтэй авах боломжтой. Тиймээс энэхүү ном нь зөвхөн мэдээлэл түгээх тоо баримтын цуглуулга байхаас аль болох зайлсхийж, тодорхой өгөгдөл /Жишээ нь: ядуурал/ дээр объектив дүн шинжилгээ хийж түүнээс үүсэж буй асуудлуудыг тодорхойлж /ядуурлын үр дагавар/, үүнийг шийдвэрлэхэд төрөөс баримталж буй бодлого хэр нийцтэй байгаа талаар уншигчдад эргэцүүлэл хийх боломж өгөхийг чухалчиллаа. Ингэхдээ "зөв" ба "буруу" гэж тамгалах эсвэл төрийн бодлогод зөвлөмж өгөхийг урьтал болголгүй гагцхүү иргэд бид ямар нийгэмд амьдрахыг хүсэж байна? үүний тулд яах хэрэгтэй вэ? гэдэгт хариулт авах улс төрийн хүсэл санааг идэвхжүүлэхэд манай номын гол зорилго оршино.

Номын эхний бүлгээс Та бүхэн өнөөгийн Монгол орны улс төрийн тогтолцоо, төрийн байгууламж, ардчилсан өөрчлөлтийн үр дүнгийн талаар орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны үүднээс цогц ойлголт авч мэдлэгийн сангаа баяжуулах болно. Мөн улс төрийн харилцааны зарим анхаарал татсан асуудал ч бас энэ бүлэгт тодорхой хэмжээгээр тусгагдсан байгаа.

Харин хоёрдугаар бүлэг уншигч таныг эдийн засгийн шинжлэх ухаан руу хөтөлнө. Энэ бүлэгт Монгол улсын эдийн засгийн тогтолцоо, зах зээлийн харилцаа, тэдгээрийн үндсэн зарчмуудыг эдийн засгийн ухааны үүднээс тоймлон гаргаж,

монгол төрийн эдийн засгийн бодлого, түүний хэрэгжилтийг бодит тоо, баримтад тулгуурлан бидний өдөр тутмын амьдралд тохиолддог жишээн дээр тайлбарласан буй.

Монгол улсын нийгмийн хамгааллын тогтолцоо, нийгмийн харилцааны онцлог, энэ салбарт төрөөс баримталж буй бодлого түүний зорилт, үр дүн, зарим үр дагаврын талаарх нэгдсэн ойлголтыг гуравдугаар бүлгээс авах болно. Нийгмийн баримжаатай төрийн бодлого Монгол улсад харьцангуй урт хугацаанд хэрэгжиж байгаагийн тодорхой үр дүн, мөн энэ бодлогыг хэрэгжүүлэх явцад гарч буй зарим сорилт бэрхшээлийг мөн энэ бүлэг хөндсөн байна.

Нийгмийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч бол нэг талаас үйлдвэрлэн бүтээгч ажилчин, ажилтнууд нөгөө талаас, төр оролцоод бүтээлч ажил олгогчид байдаг. Монгол улсын хувьд хөдөлмөрийн хүмүүсийн эрх ашгийг хамгаалж дуу хоолойг нь илэрхийлж байх үүрэгтэй байгууллага бол Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо юм. Монголын хөдөлмөрийн зах зээл дээр ажилчин, ажилтнуудыг төлөөлж Монголын үйлдвэрчний эвлэлийн Холбоо /МҮЭХ/, ажил олгогч-төрийг төлөөлж засгийн газар, ажил олгогч-хувийн хэвшлийнхнийг төлөөлж Монголын Ажил Олгогчдын Нэгдсэн Холбоо гэсэн 3 субъект хууль ёсны үүрэг хүлээж ажилладаг.

МҮЭХ-ны бүтэц зохион байгуулалт, эрх үүрэг, зорилгын талаар болон олон улсын хөдөлмөрийн харилцаанд дахь асуудлууд, сорилтууд ба цаашдын чиг хандлагыг нэгтгэн тоймлож дөрөвдүгээр бүлэгт оруулсан болно. Номын сүүлийн хэсэгт бүлгүүдтэй холбоотой хууль тогтоомж, бусад хэрэгтэй мэдээллүүдийг хавсаргасан байгааг мөн сонирхоорой.

Ц. Уянга
ФЭС-ийн хөтөлбөр хариуцсан ажилтан

Др. дэд проф. Саркыт Зүльфикар

Нэгдүгээр бүлэг. МОНГОЛ УЛСЫН УЛС ТӨРИЙН ОРЧИН

1. Улс төрийн орчны тухай үндсэн ойлголт
 - 1.1 Улс төр, түүний хамрах хүрээ
 - 1.2 Улс төрийн үзэл санаа/ үзэл баримтлал
 - 1.3 Улс төрийн дэглэмийн хэлбэр
 - 1.4 Төрийн тухай ойлголт
 - 1.5 Ардчилсан засаглал (шууд болон шууд бус ардчилал)
2. Хууль тогтоох институт
 - 2.1 Улсын Их Хурал – парламент
 - 2.2 УИХ-ын сонгууль
 - 2.3 УИХ-ын эрх үүрэг
 - 2.4 УИХ-ын зохион байгуулалтын хэлбэр
 - 2.5 Хууль тогтоох үйл явц
3. Гүйцэтгэх эрх мэдэл (Засгийн газар)
 - 3.1 Засгийн газар байгуулах процедур
 - 3.2 Засгийн газрын үйл ажиллагааны онцлог
 - 3.3 Шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр
4. Төрийн тэргүүн (Ерөнхийлөгч)
 - 4.1 Ерөнхийлөгчийн сонгууль
 - 4.2 Ерөнхийлөгчийн эрх үүрэг
5. Шүүх засаглал
 - 5.1. Шүүхийн тогтолцоо
 - 5.2. Үндсэн Хуулийн Цэц
6. Нутгийн удирдлага
 - 6.1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгууль
 - 6.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх үүрэг
 - 6.3. Нутгийн захиргааны чиг үүрэг
7. Төрийн алба
 - 7.1 Төрийн алба, түүний ангилал
 - 7.2 Төрийн албаны шинэчлэл
8. Улс төрийн нам, иргэний нийгэм
 - 8.1 Улс төрийн намын чиг үүрэг
 - 8.2 Улс төрийн намын хөгжлийн хандлага
 - 8.3 Иргэний нийгмийн хөгжлийн хандлага

Ашигласан материал
Зохиогчийн тухай

Нэгдүгээр бүлэг.

МОНГОЛ УЛСЫН УЛС ТӨРИЙН ОРЧИН

Улс төр (Politics) гэсэн үг хот улс - полис (Polis) гэсэн утгатай бөгөөд эртний Грекийн хот улсуудыг ингэж нэрлэж байв. Үе үеийн түүх, улс төрийн шинжлэх ухааны ном зохиолд энэ үгийг “төр”, “төр улс”, “улс төр” “бодлого” гэх мэт олон янзаар орчуулан хэрэглэдэг. Орчин үед бие даасан, тусгаар тогтносон улсын буюу төрийн хэргийг шийдэх явдлыг улс төр гэж ойлгох нь түгээмэл болжээ. Бид чухам энэ түгээмэл утгаар нь хэрэглэж байна.

Монгол улс орчин үеийн ардчилсан орны хувьд дэлхийн хөгжингүй улс орнуудад нийтлэг хэвшсэн улс төрийн тогтолцооны үндсэн шинжүүдийг тусгасан улс төрийн орчинтой болсон билээ. Монгол бол өвөрмөц статустай ерөнхийлөгчийн институт бүхий парламентын бүгд найрамдах улс мөн. Өнөөдөр Монгол улсад буй болсон улс төрийн орчин нь ардчиллын зарчим, үнэт зүйлсийг иш үндэс болгосон улс төрийн тогтолцоо, түүний бүрдэл хэсгүүд болсон төрийн байгуулал, улс төрийн институтууд, иргэний нийгэм, иргэдийн оролцоо бүхий улс төрийн олон талт харилцаанаас бүрдэж байна. Номын эл бүлэгт чухамхүү үүнд шууд холбогдох асуудлуудын тухай тоймлон өгүүлэх болно.

1. Улс төрийн орчны тухай үндсэн ойлголт

1.1. Улс төр, түүний хамрах хүрээ

Хүмүүс нийгмийн салшгүй хэсэг болж байдгийн хувьд эрх үүрэг, эрх мэдлийг хэрэгжүүлэх олон талт харилцаанд их бага хэмжээгээр өөрийн эрхгүй татагдан ордог. Учир нь нийгмийн харилцааны нэг бүрдэл хэсэг нь иргэдийн эрх үүргийг тогтоож, улмаар зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагууд буюу улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх институтууд байдаг. Тийм ч учраас эртний Грекийн суут сэтгэгч Аристотель “хүн бол улс төрийн оршихуй” мөн гэж тодорхойлжээ. Хүмүүс нийгмээрээ амьдрах нь улс төрийн харилцаанд зайлшгүй орно гэсэн үг юм. Тухайлбал, улс төрийн үйл явцыг байнга сонирхож, түүнд идэвхтэй оролцож байдаг хүмүүс бий. Бас улс төр надад огт хамаагүй гэж бодож явдаг хүмүүс ч буй. Гэтэл хүн амын орлогын албан татварыг нэмэх, хасах тухай эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэр хувь хүний болоод өрхийн орлогод нөлөөлдөг. Энэ тохиолдолд тухайн иргэн хэн байхаас үл хамааран эрх бүхий байгууллагын гаргасан улс төрийн шийдвэр түүний амьдралд нөлөөлж байна. Ийнхүү хүн улс төрийн үйл явцын салшгүй хэсэг болдог ажээ.

Нэгэнтээ Германы канцлер Бисмарк “улс төр бол эрх мэдлийг хэрэгжүүлэх урлаг” гэж тодорхойлсон байна. Улс төр гэдэг нь нийгмийн харилцаанд эрх мэдлийг хэрэгжүүлэх урлаг юм бол түүний хамрах хүрээг тодорхойлох шаардлагатай. Эрх мэдлийг хэрэгжүүлэх нарийн ээдрээтэй тогтолцоог бүрдүүлж байгаа талуудын

эрх үүрэг, өөр хоорондын харилцаа нь улс төрийн хамрах хүрээг тодорхойлно. Тухайлбал, ерөнхийлөгч, парламент, засгийн газар, төрийн захиргааны байгууллагууд, улс төрийн нам, улс төрийн манлайлагчид, сонгогчид, сонгуулийн тогтолцоо зэрэг нь улс төрийн хамрах хүрээг тодорхойлох гол үзүүлэлтүүд мөн. Гэтэл нөгөө талаар тухайн улсад улс төрийн ямар дэглэм, засаглалын хэлбэр тохиромжтой болохыг тодорхойлох шаардлагатай бол хүн амын бүтэц, соёл, зан заншил, төрт ёсны уламжлал, хөрш орнуудын байдал гэх мэт олон талт харилцааг судлах, тодорхойлох хэрэгцээ урган гардаг нь улс төрийн хамрах хүрээг нарийн ээдрээтэй болгодог. Иймд энэ бүгдийг харгалзан эрх мэдлийг хэрэгжүүлэх улс төрийн институтуудын харилцааг зохицуулах нь улс төрийг ямар нэг байдлаар урлаг болгож байна. Угтаа бол эдгээр нь улс төрийг нийгмийн шинжлэх ухааны бие даасан судлагдахуун (шинжлэх ухааны мэдлэг) болгож байгаа хэрэг. Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны янз бүрийн арга, хэрэгслүүд нь улс төрийн үзэгдэл, үйл явц тэдгээрийн хувьсал хөгжлийн тухай тодорхой мэдлэг, бодитой мэдээ баримт олж авснаар нийгмийн амьдралыг оновчтой зохицуулах мэдлэгийг бий болгодог. Улс төр бол эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэж үзвэл дараах гурван хүрээнд улс төрийн үйл явцыг ойлгож болно. Үүнд:

Улс төр бол шийдвэр гаргах үйл ажиллагаа: Улс төрийн харилцаанд оролцож байгаа талууд хуулиар олгогдсон бүрэн эрх, чиг үүргийнхээ дагуу тодорхой эрх ашгийг шалгуур болгон ямар нэг асуудлаар шийдвэр гаргана. Үүний тулд нийтийн болон хувь хүн, улс төрийн ямар нэг субъектийн эрх ашгийг уялдуулах, харилцан зөвшилцүүлэх шаардлага урган гарна. Талуудыг зөвшилцөлд хүргэсэн шийдэл, хувилбар санал болгож, түүнийг шийдвэр болгох нь улс төрийн үйл ажиллагаа мөн. Бидний өдөр тутмын амьдралд улс төрийн нам хоорондын, улс төрийн нам – иргэний хөдөлгөөн хоорондын, төрийн байгууллага болон иргэд хоорондын зөвшилцөлд тулгуурласан шийдвэр байнга гарч байдаг. Тухайлбал, 2012 оны УИХ-ын сонгуулийн үр дүн улс төрийн намууд зөвшилцөн эвслийн засгийн газар байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн. Улс төрийн намуудын зөвшилцөл нь УИХ-аас олонхийн дэмжлэг хүлээсэн засгийн газар байгуулахад чиглэгдэж байв.

Улс төр бол бодлого тодорхойлох үйл явц: Улс төрийн институтуудын гол үүрэг нь улс орны болоод орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх нийгэм-эдийн засаг, засаглалын бодлогыг тодорхойлох явдал байдаг. Тухайлбал, уул уурхайн салбарын өсөлт ДНБ, улсын төсвийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа улс тухайн салбарт гадны хөрөнгө оруулалтыг татах, байгаль орчны сөрөг нөлөөг бууруулах, бүс нутгийн хөгжлийг дэмжих, дэд бүтэц бий болгох гэх мэт нийгэм-эдийн засгийн шинж чанартай бодлого тодорхойлж хэрэгжүүлэх шаардлага тулгардаг. Гадны хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай, тогтвортой орчин бүрдүүлэхийг зэрэгцээ байгаль орчинд сөрөг нөлөө багатай уул уурхайн технологи нэвтрүүлж, бүс нутгийн хөгжлийг дэмжсэн бүтээн байгуулалт өрнүүлэх оновчтой, харилцан ашигтай бодлого тодорхойлж чадах эсэх нь улс төрийн мэдлэг, туршлага шаарддаг байна.

Улс төр бол бодлого шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих явдал юм: Бодлого, шийдвэр харилцан адилгүй үр дүн авчирч, зарим тохиолдолд сөрөг үр дагавар дагуулах нь бий. Ард түмэн засаг төрийн, өөрөөр хэлбэл УИХ, Засгийн газар гаргасан шийдвэр нь эерэг үр дүнд хүргээсэй гэж хүсэх нь зүй. Үүний тулд төрийн байгууллагууд тодорхойлсон бодлого, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилт,

гүйцэтгэлийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавих үүрэгтэй. Гүйцэтгэлийг хангах чиг үүрэг бүхий институт нь Засгийн газар, түүний харьяа яам, агентлагууд байдаг. Харин төрийн бодлогын хэрэгжилт, гүйцэтгэл нь ямар үр дүнд хүргэж байгаад хяналт тавих эрх үүрэг нь хуулиар УИХ-ын бүрэн эрхийн асуудал. \Монгол улсын төрийн байгууллын зураглалыг хавсралт 1-ээс үзнэ үү.\

1.2. Улс төрийн үзэл санаа/ үзэл баримтлал

Үзэл санаа (Ideology) гэсэн ойлголтыг Францын философич Дестут Де Троси 1796 онд санаа, үзэл судлал (Idea-ology) гэсэн утгаар анх хэрэглэжээ. Тэрээр үзэл санааг биологи, амьтан судлалын нэгэн адил шинжлэх ухааны судлагдахуун болно гэж таамаглаж, хүсэж байв. Түүхийн янз бүрийн судлаачид, түүний дотор философичид, улс төр судлаачид үзэл санааг янз бүрээр тайлбарлаж иржээ. Жишээ нь, марксистууд үзэл санаа бол нийгмийн тодорхой нэг анги зорилгоо хэрэгжүүлэх арга хэрэгсэл гэж үзэж байсан бол либерал үзэл санааг баримтлагчид нийгмийг залж, жолоодох итгэл үнэмшил, зарчмын үндсийг үзэл санаа хэмээн тодорхойлдог гэж үздэг.

Тодорхой үзэл санаа, түүний зарчим, үнэт зүйлсийг системтэй мэдлэг болгосныг **үзэл баримтлал** (Concept) гэнэ. Тухайлбал, өнөө үеийн хамгийн нөлөө бүхий улс төрийн гол хоёр үзэл баримтлалд ардчиллын үнэт зүйлийг хэрхэн тодорхойлж, хэрэгжүүлэхийг эрмэлзэж буйг харьцуулж үзье.

Либерал ардчилал	Социал-демократ (нийгмийн ардчилал)
• Хувь хүний мөн чанар, онцлог (Individualism) – хувь хүний эрхийг нийгмийн бүлгийн эрхийн эсрэг сэргүүлэн тавьдаг. Аливаа хүн өөрийн онцлог, чадавхид тохирсон байдлаар нийгмийн харилцаанд оролцоно; • Эрх чөлөө (Freedom) – Хувь хүний эрх чөлөө нийгмийн харилцааны үндэс мөн. Таны эрх чөлөө бусдын эрх чөлөөгөөр хязгаарлагдана. • Шалтгаан (Reason) – рационал шийдвэр нь бодит байдалд тулгуурласан байна; • Эрх тэгш байдал (Equality) – Хүн бүр харилцан адилгүй чадвартай байдаг. Гэхдээ ёс суртахууны хувьд хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй; • Хүлээн зөвшөөрөх (Toleration) – хүмүүсийн итгэл үнэмшил, хүсэл сонирхолд хүндэтгэлтэй хандаж, хүлээн зөвшөөрөх;	• Нийгмийн нийтлэг бүлэг – хүй элгэн (Community); • Ах дүүгийн барилдалгаа (Fraternity); • Нийгмийн эрх тэгш байдал (Social Equality); • Хэрэгцээ (Need); • Нийгмийн анги (Social class); • Нийтийн өмч (common ownership); • Нийгмийн баялгийг бүтээх үйл явцад зах зээлийн хууль үйлчлэх нь зайлшгүй. Өөрөөр хэлбэл баялаг бүтээх зохистой арга капиталист эдийн засагт бий; • Нөгөө талаар нийгмийн баялгийг ёс суртахуунтай хуваарилах замаар нийгмийн тэгш байдлыг хангахад төрийн оролцоо чухал;

Либерал ардчилсан үзэл баримтлалд хүний эрх, эрх чөлөө, өөрийн амьдрал, бусад хүмүүстэй харилцах дүрмээ тодорхойлох ёс суртахууны бие даасан байдал чухал

гэж үздэг. Иймд уг үзэл санаа/үзэл баримтлал нь бие даасан хувь хүний ойлголтод үндэслэдэг, нийгэм чөлөөт хувь хүмүүсийн нийлбэр, нийгмийн сонирхол нь бүхний нийтлэг сонирхол гэж тайлбарладаг. Энд хувь хүний амьдрал нь нийгмийнхээс, эрх нь нийтийн эрх ашгаас дээгүүрт тавигддаг. Харин социал-демократ үзэлд нийгмийн нийтлэг эрх ашгийг эн түрүүнд тавьдаг. Учир нь нийтийн эрх тэгш байдал, сайн сайхныг бүрэн хангаж чадаагүй нөхцөлд ардчиллын тухай яриа байх боломжгүй гэж үздэг.

Либерал болон социал-демократ үзэл баримтлалын зэрэгцээ улс төр-нийгмийн харилцаанд харьцангуй түгээмэл хэрэглэгддэг үзэл баримтлалын нэг бол консерватив (бүгд найрамдах) үзэл юм. Консерватив үзэл баримтлал дараах үндсэн шинж чанартай.

- **Уламжлал (Tradition)** – Уламжлалт үнэт зүйл, үнэлэмж, нийгмийн бүтэц, институцийг хадгалах.
- **Прагматизм (Pragmatism)** – Аливаа зүйлийг практик нөхцөл байдал, зорилготой уялдуулан өөрчлөх шаардлагатай.
- **Хүний сул – төгс бус чанар (Human imperfection)** хүн төрөлхийн сул талтай бодгаль. Өөрөөр хэлбэл залхуу, үлбэгэр, хүчгүй, авилгад өртөмхий. Иймд хүмүүсийг зөв чиглүүлэх учиртай.
- **Органик шинж (Organism)** – Нийгэм бол харилцан хамааралтай нэгжээс бүрдсэн органик бүтэц юм.
- **Шаталсан бүтэц (Hierarchy)** – Нийгэм шаталсан бүтэцтэй.
- **Эрх дарх (Authority)** – Нийгмийг манлайлагч хүч ямарваа үед зайлшгүй шаардлагатай.
- **Өмч (Property)** – Өмчтэй байх эрх нь хувь хүний эрх, эрх чөлөөтэй байх баталгаа болно.

Монгол улсын Үндсэн хуульд ардчилсан төр улс байх нөхцөлийг тухайлан тодорхойлсон байдаг. Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулна гэж заасан нь Монгол улс ардчилсан (либерал болон нийгмийн ардчиллын үзлийн аль алнийх нь үнэт зүйлийг агуулсан) улс болохыг тодорхой илтгэж байна. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. \Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 1.2 дахь зүйл\

Монгол улсын Үндсэн хуулийн оршил хэсэг

Монголын ард түмэн бид:

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
- хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.

1.3. Улс төрийн дэглэмийн хэлбэр

Улс төрийн сонгодог онолд улс төрийн дэглэмийг монархи буюу хаант засагтай, аристократ буюу язгууртны засагтай, ардчилсан буюу бүх нийтийн засагтай гэж хувааж үздэг. Судлаач Ф.Суттон нийгмийг газар тариаланд тулгуурласан, аж үйлдвэржсэн; Жамес Колеман өрсөлдхүйц, хагас өрсөлдхүйц, авторитар; Эйнштад бүдүүлэг, эцгийн эрхт, нүүдлийн, эзэрхийлэгч гүрэн, хот-төр, феодалын, төвлөрсөн бюрократ эзэнт гүрэн, орчин үеийн гэсэн бол хожим нь ардчилсан, авторитар, тоталитар, буурай хөгжилтэй гэж ангилсан байна.

Улс төрийн дэглэмийг авторитар, тоталитар, коммунист гэх мэтчилэн ангилж болохын зэрэгцээ засаглалын хэлбэрээр нь ерөнхийлөгчийн, хагас ерөнхийлөгчийн, парламентын засаглалтай гэх мэтчилэн ангилдаг. шинжлэх ухааны үндэслэлтэй хамгийн анхны улс төрийн дэглэмийн ангиллыг грекийн сэтгэгч Аристотель боловсруулжээ. Түүний ангиллын зорилго нь улс төрийн системүүдийн давуу хийгээд сул тал, ашигтай болон хор хөнөөлтэй шинж чанарыг олж илрүүлэхэд оршиж байв. Энэ нь юуны өмнө хот-улсууд (city states)-д хэрэглэсэн ангилал юм.

Хүснэгт № 1.1

Аристотелийн улс төрийн дэглэмийн ангилал

Дэглэмийн хэлбэр	Эрх мэдэл хэрэгжүүлэгч			
		Дангаар	Цөөнх	Олонх
	Сайн	Монархи	Аристократ	Полити
	Муу	Тирани (дарангуйлал)	Олигархи	Ардчилал

Эх сурвалж: Rod Hague & Martin Harrop Comparative Government and Politics. 5th edition. Palgrave 2001. p-24

Аристотель улс төрийн сайн тогтолцоонд монархи, аристократ, полити дэглэмийг; муу тогтолцоонд тирани, олигархи, ардчилсан дэглэмийг багтаажээ. Засаглалын сайн хэлбэр нь иргэдийн эрх ашгийн төлөө үйлчилдэг бол засаглалын муу хэлбэр нь цөөнх болон эрх мэдэлтний эрх ашгийн төлөө үйлчилж байгаагаараа ялгарна. Монархи хэлбэр нь эрх мэдлийг дангаараа хэрэгжүүлэх, ард түмний төлөөх систем байдаг бол аристократ хэлбэрт цөөнх ард түмний төлөө үйлчилж, полити засаглалд ард түмний сайн сайхны төлөө тэдний өөрсдийн засаглал оршин тогтнодог. Энэ гурван засаглалын хэлбэр нь эрх мэдлийг хэн хэрэгжүүлж байгаагаас үл хамааран ард түмний төлөө үйлчилсэн, тэдний эрх ашгийг дээдэлсэн улс төрийн систем юм. Тирани засаглалд хаан дангаараа эрх мэдэл хэрэгжүүлж, түүнийг өөрийн эрх ашигт нийцүүлэн нэвтрүүлдэг бол олигархийн дэглэмд цөөнх дан ганц тухайн цөөнхийн эрх ашигт үйлчилдэг. Ардчилсан дэглэмд олонх нь олон түмний эрх ашгийн төлөө үйлчлэх үүрэг бүхий засаглал хүлээн

зөвшөөрөгдсөн байдаг хэдий ч энэ нь нэг талаар ард түмний тодорхой хэсгийн төлөөлөл болсон зарим бүлгийн эрх ашгийг орхигдуулсан байж болох талтай байдаг.

Хүн төрөлхтний хөгжлийн шинэхэн түүх буюу XX зуун гэхэд дэлхийн улс орнуудыг улс төрийн дэглэмээр нь дараах үндсэн ангилалд хуваан авч үздэг болжээ. Үүнд:

- **Тоталитар дэглэм:** улс төр-нийгэм-эдийн засгийн бүхий л хүрээнд улс төрийн тодорхой хүчин дангаар эрх мэдлийг хэрэгжүүлдэг. XX зууны эхний хагасын Фашист Герман, Итали үүний тодорхой жишээ болно.
- **Цэргийн дэглэм:** Нийгмийн харилцааны бүхий л хүрээнд цэргийн эрх мэдэлтнүүд тодорхойлох, шийдвэрлэх үүрэгтэй. Засгийн эрхийг цэргийн эрх мэдэлтнүүд хэрэгжүүлдэг. Жишээ нь, 2011 онд Бирмд бүх нийтийн сонгууль болох хүртэл цэргийн дэглэм бүрэн утгаараа тогтож байв.
- **Авторитар дэглэм:** улс төр-нийгэм-эдийн засгийн хүрээнд тодорхой улс төрийн нам, хүчин давамгайлах хандлагатай. Социализмын үеийн ЗХУ, БНМАУ үүний тодорхой жишээ болно. Учир нь коммунист нам нийгмийн бүхий л хүрээнд давамгайлах шинжтэй байсан.
- **Ардчилсан дэглэм:** Улс төрийн эрх мэдлийг тайван замаар шилжүүлэх чөлөөт сонгуультай, олон намын тогтолцоотой, иргэдийн өмчлөх, үйлдвэрлэл эрхлэх эрхийг хязгаарлаагүй. Эдүгээ олон улс орон ардчилсан дэглэмийг сонгоод байна. Тухайлбал, Монгол улс Үндсэн хуулиар болон улс төрийн бодит харилцааны гол шинжээрээ ардчилсан дэглэмтэй улс юм.

1.4. Төрийн тухай ойлголт

Төр бол хүн төрөлхтний түүхэнд хамгийн эрт үүссэн улс төрийн гол институци мөн. Монгол хэлний төр гэдэг үгийг англиар (state), герман хэлэнд (staat), франц хэлэнд "etat" оросоор (государство) гэх мэтээр хэрэглэдэг. Төр гэдэг бол хамгийн ерөнхий агуулгаараа 1) тодорхой газар нутагтай, улс төрийн удирдлага, зохион байгуулалт бүхий бүлэг хүмүүсийн хууль ёсны нэгдэл, 2) улс орныг удирдах байгууллагыг илэрхийлдэг байна. Түүнчлэн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх институцийн удирдлага дор хэрэгжих төрийн захиргаа, хууль тогтоох, батлан хамгаалах, цагдан сэргийлэх улс төрийн эрх мэдлийг бүхэлд нь багтаасан ойлголт юм. Энэ бүхнийг хураангуйлан төр бол улс орныг удирдах институтуудын харилцан уялдаатай цогц нэгдэл гэж ойлгож болно.

Шинжлэх ухааны ном зохиолд дурдагдсан зүйлүүдээс үзээд төр, түүний мөн чанар, бүтэц, үйл ажиллагааг бүрэн илэрхийлэх тогтсон нэг тодорхойлолт гаргах нь амаргүй боловч төр, түүний институтууд нийгмийн харилцаанд, хүмүүсийн амьдралд шууд болон шууд бус байдлаар тусгалаа олж, үйлчилж байдаг гэдгийг нийтлэг хүлээн зөвшөөрсөн бий. Өөрөөр хэлбэл, хүмүүс төрийн институт нь нийгмийн бусад институтээс ялгаатай болохыг өөрийн амьдралын туршлагаар ойлгож мэдэрдэг гэдгийг судлаачид онцолдог. Тухайлбал, Монгол улсын Ерөнхийлөгч гадаад улсаас Монгол улсад суух элчин сайдын жуух бичгийг ёслол

хүндэтгэлтэй хүлээн авч, засгийн газар, парламенттай тогтсон хэм хэмжээ, дэг жаягийн дагуу харилцаж байгаа нь улс төр, нийгэм, эдийн засгийн хүрээний бусад институтуудийн хэм хэмжээ, харилцааны зохицуулалтаас илтэд ялгаатай, цэвэр төрийн ажил гэдгийг иргэн бүр ямар нэг тайлбаргүйгээр ойлгодог.

Төрийн институтууд, тэднээс нийгмийн бусад хэсэгтэй харилцах харилцаанд эрх зүйт төрийн гол шалгуур болох хуулийн хүрээнд, тогтсон хэм хэмжээг дагаж мөрдөх зарчим, албан ёсны болон уламжлалын хувьд хэвшсэн ёс, дэг жаягийг баримтална. Түүнчлэн төр нь шаардлагатай тохиолдолд хуулийн хүрээнд албадлага хэрэглэдгээр бусад институтээс ялгаатай. Гэхдээ энэ нь төр хүссэн үедээ аливаа харилцаанд хөндлөнгөөс оролцож, албадлага хэрэглэнэ гэсэн үг биш юм. Харин үүний эсрэгээр нийгмийн амьдралд чухал хэрэгтэй болон хүлээн авч болохгүй зан үйл, үйлдлийг төр тодорхойлж, хянах, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх үүрэг хэрэгжүүлнэ. \James W Mcauley. An Introduction to Politics, State & Society. Sage Publication, London. 2003. p. 22\ Төрийн албадлага нь нэг талаар нийгмийн тодорхой хэсэг бүлгийн үйлдлийг хязгаарлаж байгаа хэрэг боловч нөгөө талаар нөгөө нийтийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалт байдгаараа онцлог.

Эдүгээ хүн төрөлхтөн бараг бүхэлдээ төр, төрт ёсны хөгжлийн ямар нэг хэлбэрийг буй болгон хөгжиж буй ч төргүй буюу төрт ёс, төрийн институт өдөр тутмын харилцаанд нь хэвшин тогтоогүй тийм бүлэг хүмүүс буюу нийгмийн нийтлэгүүд (хүй элгэн) байсаар байна. Тухайлбал, Суданы өмнөд хэсгийн овог аймгууд, Шинэ Гвинейн ширэнгэн ой дахь хүмүүс үүний тод жишээ юм. Эдгээр хүй элгэн, овог аймгууд нь нийгмийн зохион байгуулалтын энгийн буюу нийтлэг бүтэцтэй, үйлдвэрлэлийн хувьд түүврийн аж ахуйд тулгуурласан байдаг учраас тухайн газар зүйн байршилд олон хүн амыг хамарсан нарийн зохицуулалт, их хэмжээний нийгмийн баялаг буюу нөөцийг (баялгийг) дахин хуваарилах шаардлага, хэрэгцээ байхгүй байгаа юм. \Colin Hay, Michael Lister and David Mash (ed). (2006) The State: Theories and issues. p.248\ Нэг үгээр хэлбэл тэдний амьдрал ахуй, өдөр тутмын харилцаанд засаглалыг хэрэгжүүлэх албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн, нэгдмэл институт бий болох шаардлага одоогоор буй болоогүй байна.

1.5. Ардчилсан засаглал (шууд болон шууд бус ардчилал)

Ардчилал гэсэн үг, ойлголтыг хүмүүс, улс төрийн институтууд өдөр тутмын харилцаанд түгээмэл хэрэглэж байгаа нь түүнийг чухам яг юу гэж ойлговол зохих вэ гэсэн асуулт тавихад хүргэдэг. Ардчилал (democracy) хэмээх ойлголт эртний Грекээс гаралтай. Эрх мэдэл, засаглах гэсэн утгатай кратос (kratos), ард түмэн гэсэн утгатай демос (demos) гэх хоёр үгийн холбоогоор ард түмний засаг хэмээх ерөнхий утгыг илэрхийлдэг. Ардчилал нь ард түмний болон олонхийн засаглал буюу иргэд засгийн эрх барих улс төрийн үйл явцыг илэрхийлсэн ойлголт болно.

Эртний Грекийн суут сэтгэгчид Аристотель, Платон нар эд баялаг, эр хүчинд дулдуйдан хэсэг бүлэг хүмүүс засгийн эрхийг барьж байх нөхцөлийн эсрэг ард түмэн (хот улсын иргэд) хамтран шийдвэр гаргаж, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг ард түмний засаглал буюу ардчилал гэж тодорхойлсон байна. Үүнээс хойш ардчиллын талаар олон зуун тодорхойлолт гарсан. Тэр бол эрдэмтдийн

нарийвчлах асуудал. Харин өнөөдөр ардчилал ард түмний ажил, амьдралын хэм хэмжээ, зохицуулалт болжээ. Иймд хүний амьдралын түгээмэл ойлголт болохын хувьд ардчилал ямар үнэт зүйл, харилцааг илэрхийлж байгааг тодорхойлох нь чухал. Чингэхдээ улс төр судлаачдын өнөөдөр дэвшүүлсэн тодорхойлолт, дүгнэлтэд үндэслэх нь зүй. Эдүгээ судлаачид хийгээд улмаар олон нийтийн тунд ардчиллын талаар дараах нийтлэг үндэслэлүүд түгээмэл болжээ. Үүнд:

- Ард түмэн (төрийн үйл хэрэгт шууд оролцох боломжгүй хүмүүс) улс төрийн үйл хэрэгт оролцох боломжийг бүрдүүлсэн улс төрийн тогтолцоо, засаглал.
- Мэргэшсэн улс төрчид, төрийн албан хаагчдын дэмжлэгт тулгуурлан иргэд улс төрийн бодлого тодорхойлж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд шууд, бие даан оролцох бололцоо бүрдүүлсэн засаглал, засгийн газар.
- Хувь хүний мэдлэг чадварт тулгуурлан төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлсэн төрийн тогтолцоо.
- Нийгмийн эрх тэгш, сайн сайхан байдлыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааны нэгдэл.
- Олонх эрх мэдлээ хэрэгжүүлж байгаа үйл явцад хяналт тавих замаар цөөнхийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зохион байгуулалт, тогтолцоо.
- Бүх нийтийн, чөлөөт, шууд оролцоотой сонгуульд тулгуурлан засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх хэлбэр.
- Иргэдийн улс төрийн оролцоонд тулгуурлах бус тэдний эрх, ашиг сонирхлыг шалгуур болгон төрийн үйлчилгээг зохион байгуулах хэлбэр.
- Төрийн эрх мэдлийг тэнцвэртэй хуваарилан улс төрийн институтийн зохистой бүтцийг бүрдүүлж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн нэгдмэл орон зайг бий болгох.
- Олон намын тогтолцоо, олон ургальч үзэл, эрх баригч болон сөрөг намуудын хоорондын байнгын үр ашигтай яриа хэлэлцээ, иргэний нийгмийн байгууллагуудын бие даасан үйл ажиллагаа, улс төрийн маргааны соёл зэргийг багтаасан улс төрийн амьдралын нэгдмэл орон зай.

Ардчилсан засаглалыг улс төрийн үзэл санаа, үзэл баримтлалын үнэт зүйлтэй уялдуулан либерал ардчилал, социал-демократ (нийгмийн ардчилал) гэх мэтчилэн ангилж болохын зэрэгцээ улс төрийн тогтолцооны бүрдэл институтууд нь хэрхэн зохион байгуулагдаж байгааг шалгуур болон ангилж ч болно. Үүнийг ардчилсан дэглэмтэй улсад иргэд засаглалын үйл явцад хэрхэн оролцож байгаагаар тайлбарладаг. Ийнхүү улс төр, захиргааны үйл явцад иргэд хэрхэн оролцож байгааг шалгуур болгон шууд болон шууд бус (төлөөллийн) ардчилал гэж ангилдаг.

Шууд ардчилал: Шууд ардчилал (оролцоот ардчилал)-д иргэд улс төрийн засаглалд ямарваа зуучлал, төлөөлөлгүй, өөрийн эрх мэдлийг шууд хэрэгжүүлэх хэлбэрээр оролцоно. Үүнийг иргэдийн оролцоог зохион байгуулах үндсэн хэлбэр гэж үздэг. Шууд ардчилалд иргэд ямарваа институт, субъектээс үл хамааран

бодлого тодорхойлж, шийдвэр гаргах үйл явцад (санал асуулга явуулах, бүх нийтийн хэлэлцүүлэг, телевизийн ярилцлага зохион байгуулах хэлбэрээр) шууд биечлэн, тасралтгүй оролцоно. Шууд ардчиллын хэлбэр нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч институт болон иргэд, засаглалын субъект болон объект болж байгаа талуудыг бие биесээс нь ялгаж салгах бололцоо бүрдүүлнэ. Эртний грекийн Афины иргэд улс төрийн шийдэл шаардлагатай тодорхой асуудлаар бүх нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, санал хураадаг байв. Ийнхүү Афин хотын иргэд тодорхой асуудлыг хэлэлцэхэд шууд оролцож, саналаа бие даан илэрхийлэх боломжтой байсан учраас эцсийн шийдвэрт тэдний ашиг сонирхол ямар нэг хэмжээгээр тусгалаа олдог байжээ. Афины хот улсад хэрэгжүүлсэн ардчиллын энэ хэлбэрийг шууд ардчилал, Афины ардчилал ч гэж нэрийдэх нь бий.

Орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд шууд ардчиллын тухай асуудлыг өргөн хүрээнд судлах болжээ. Сүүлийн үеийн судалгааны мэдээллээс үзэхэд шууд ардчилал дараах давуу талтай. Үүнд:

- Иргэд өөрсдийн хувь заяа, ашиг сонирхолд хамаарах тодорхой асуудалд шууд оролцож, санал өгөх боломжтой тул ардчиллын үнэт зүйл болох иргэний эрх, эрх чөлөөг бүхий л хүрээнд өргөжүүлдэг.
- Иргэд улс төрийн үйл явцын талаар илүү мэдээлэл, ойлголттой байдаг тул тэдний улс төр, төрийн захиргааны үйл ажиллагаатай холбоотой мэдлэгийг дээшлүүлдэг.
- Хувийн ашиг сонирхлыг илүүд тавьсан улс төрчдийн оролцоог багасгаж, иргэд өөрсдийн үзэл бодол, ашиг сонирхлыг илэрхийлж, хамгаалах боломжтой.
- Төрийн шийдвэр хүчин төгөлдөр байх эрх зүйн үндэс баталгаатай болдог. Учир нь иргэдийн шууд оролцоотой гарсан шийдвэр нь эрх зүйн төдийгүй, ёс зүйн хувьд үр дүнтэй үйлчлэх боломжтой.

Шууд бус ардчилал: Иргэд тодорхой төлөөллийн байгууллага, этгээдээр дамжуулан улс төр, төрийн захиргааны түвшинд бодлого тодорхойлж, шийдвэр гаргах үйл явцад оролцох хэлбэрийг шууд бус ардчилал гэж үздэг. Дийлэнх улс орнуудад түгээмэл тогтсон ардчиллын хэлбэр нь шууд бус (төлөөллийн) ардчилал юм. Иргэд сонгууль өгсний дараа хууль тогтоох, шийдвэр гаргах улс төрийн институтын үйл ажиллагаанд шууд оролцох боломж хязгаарлагдмал байдаг. Харин тэд өөрсдийнхөө өмнөөс бодлого тодорхойлж, шийдвэр гаргах этгээдийг сонгож, тэднээр дамжуулан өөрсдийн ашиг сонирхлыг шийдвэрлүүлэх боломж бий.

Орчин үед үндэсний түвшинд улс төрийн үйл явцад иргэд оролцох зохион байгуулалт нь шууд бус буюу төлөөллийн ардчиллын хэлбэр болжээ. Учир нь үндэсний түвшинд бодлого тодорхойлж, шийдвэр гаргахад иргэд шууд оролцох цаг хугацаа, орон зай, зохион байгуулалтын боломж хязгаарлагдмал байдаг нь шууд бус ардчиллыг өргөжүүлсэн байна. Нөгөө талаар улс төрийн бодлого, шийдвэрийг оновчтой, өгөөжтэй, чадварлаг, тогтвортой хэрэгжүүлэхийн тулд мэргэшсэн улс төрийн институтууд бий болсон байна. Тухайлбал, парламент, засгийн газар, орон нутгийн засаг захиргаа зэрэг нь үндэсний болон нутаг

орныхоо хэмжээнд бодлого тодорхойлж, шийдвэр гаргах улс төрийн мэргэшсэн, тодорхой чиг үүрэг, эрх үүрэг бүхий институтууд болно.

Монгол Улсад үндэсний түвшинд шууд бус ардчиллыг хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий улс төрийн институт нь хууль тогтоох чиг үүрэг бүхий парламент (Улсын Их Хурал) юм. Улсын Их Хурал нь бүх нийтийн чөлөөт ардчилсан сонгуулийн үр дүнд байгуулагддаг төлөөллийн байгууллага билээ. Орон нутагт иргэдийн төлөөллийн байгууллага (аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал) нь мөн адил шууд бус ардчиллыг хэрэгжүүлэх институт юм.

Орон нутгийн хурал, захиргааны байгууллагууд иргэдтэй ойр байж, тэдний хүсэл, ашиг сонирхлыг тодорхойлж, шийдвэр болгох бололцоо харьцангуй өргөн байдаг. Үүний тулд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга замыг нэвтрүүлэх бололцоо байгааг судлаачид тэмдэглэж байна. Тухайлбал, УИХ-ын гишүүн, удирдахуйн ухааны доктор Су. Батболд Төрийн захиргаа сэтгүүлд өгсөн ярилцлагадаа:

“Үндсэндээ сум, аймгийн захиргааны албан хаагчид бол үйлчилгээний албан хаагчид шүү дээ. Ард түмнийхээ дунд орж ажилладаг, асуудлыг нь шийддэг, тодорхой асуудлаа шийдэхгүй байгаа иргэдийг уриалдаг, зохион байгуулдаг тийм алба болох хэрэгтэй. Гэтэл манайд сумын Тамгын газрын ажилтан ч ялгаа байхгүй, яам агентлагийн ажилтан ч ялгаа байхгүй бүгдээрээ дарга нар болчихсон. Аливаа асуудалд гүнзгий орж, түүндээ иргэдийг уриалан дуудаж зохицуулж, зөвлөгөө өгч ажилладаг хүн алга. Тодорхой хууль дүрмийн заалт барьцхаад л бүгдээрээ хянагч, шалгагч, бүгдээрээ хүнд сурталтаны дүр гаргасан тийм л улс болчихдог байхгүй юу. Хамгийн түрүүнд үүнийг л өөрчилмөөр байна. Иргэдэд юу тулгараад байна, түүнийг нь яаж шийдэх, бүс, аймгийн хэмжээнд ямар асуудал байна, хариуцсан салбарт ямар асуудал байна, үүнийгээ иргэдтэй хамтарч шийдэх буюу тэдэнтэй зөвлөдөг шууд ардчиллын зохион байгуулалт, арга хэрэгслийг нэвтрүүлэх нь аль аль талдаа үр ашигтай байх юм” гэжээ.

Шууд ардчиллын боломжит туршлагыг улс төр, төрийн захиргааны харилцаанд нэвтрүүлж, үндэсний болон орон нутгийн бодлого, шийдвэрт иргэдийн оролцоог өргөжүүлж, улмаар үндэсний болон орон нутгийн хөгжлийг нийгэм-эдийн засгийн бодит нөхцөл байдал, эрэлт хэрэгцээтэй нийцүүлэх, уялдуулах боломжтой. Ийм учраас сүүлийн жилүүдэд иргэд, иргэний нийгмийн дуу хоолой, оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны оновчтой механизм бүрдүүлэхэд буюу оролцоот хийгээд шууд ардчиллын тогтолцоо бүрдүүлэхэд анхаарал хандуулах боллоо.

2. Хууль тогтоох институт

2.1. Улсын Их Хурал – парламент

Дэлхий улс орнуудад хууль тогтоох гол эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагыг ерөнхийд нь парламент гэж нэрлэдэг. Парламент (parlamentum) гэсэн латин үг нь үлгэр жишээ болох, ёгт зүйрлэл; “үг хэлэх” “ярих” гэсэн утгатай байх бөгөөд нэр томъёоны хувьд “хурал доторх ярилцлага” “нийтэд хамаатай асуудал” гэсэн утга санаа илэрхийлдэг. Англиар parliament; Германаар parlament; Францаар parlement, Оросоор парламент гэдэг ажээ. \Д. Лүндээжанцан. Л. Өлзийсайхан Парламент ёс. УБ., 2006. 270 дахь тал Парламент\ (parler) Франц хэлэнд ярих, зөвлөлдөх, хэлэлцэх гэсэн олон салаа утга илэрхийлдэг. \Andrew Heywood. Key Concepts in Politics. Palgrave, New York 2001. p.214\ Үүнээс үзвэл тодорхой асуудлыг хэлэлцэж, зөвлөлдөн шийдвэр гаргах эрх үүрэг бүхий институтийг парламент гэдэг бөгөөд тус үйл явцад шууд оролцох эрх бүхий этгээдийг парламентын гишүүн гэх ажээ. Иймд парламент нь сонгуулийн үр дүнд олж авсан эрхээ тулгуур болгон хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж, засгийн газар эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь эрх зүйн хувьд дэмжлэг үзүүлнэ.

Хорьдугаар зууны хоёр дахь хагасаас эхлэн парламентын шинэ хоёр төрөл буюу загварын тухай хэлэлцүүлэг дэлгэрээд байна. Эдгээр нь хэлэлцэгч парламент – Вестминистрийн (Их Британийн) загвар, үйлдэгч парламент (working parliament) – Боннын (Германы) загвар. \Klaus Van Beyme. Transition to Democracy in Eastern Europe. 1996 McMillan Press. p.56\ Тэдгээр нь дор бүрнээ онцлох шинж чанар, харилцааг төлөөлдөг. Хэлэлцэгч парламентад (debating parliament) - сонгуулийн үр дүнд нэг нам давамгайлж, олонх болж улмаар хууль тогтоох институц, түүний эрх мэдлийг хянах боломжтой болдог. Хууль тогтоох институтэд олонх болж чадсан улс төрийн хүчин засгийн газраа бүрдүүлдэг нь парламент-засгийн газар өөр хоорондоо уусах - нэгдэх үндсэн нөхцөл шалтгаан болдог. Иймд парламент нь засгийн газрын боловсруулсан хууль, түүний үйл ажиллагааг дэмжих эрх зүйн баримт бичгийг түргэн хугацаанд хэлэлцэн баталж, үүгээрээ гүйцэтгэх засаглалд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй институт болдог. Энэ тохиолдолд парламентын үйл ажиллагааны эх сурвалж, зорилго нь засгийн газраас оруулсан аливаа асуудлыг хэлэлцэхэд л оршино.

Үйлдэгч парламентын үйл ажиллагааны зарчим нь хуулийн төсөл, бодлого, хөтөлбөрийг дан ганц хэлэлцэх бус түүнд шүүмжлэлтэй хандаж, эдгээр баримт бичгийн боловсруулалт, түүнээс гарч болох үр дүн, үр дагаврыг бодитой үнэлж дүгнэх замаар эрх зүйн баримт бичиг болгох явдал юм. Үйлдэгч парламент нь ухаалаг “хуулийн үйлдвэр” гэгддэг. Нэн ялангуяа байнгын хороод хуулийн төслийг эд ширхэг бүрээр шүүн хэлэлцэж зөвшилцөлд хүрдэг. Нөгөө талаар сонирхлын болон шахалтын бүлгүүд тухайн хуулийн төслийг хэлэлцэх, батлах явцад нөлөөлөх боломжтой. Парламент - засгийн газрын уусалт (парламентын гишүүн нэгэн зэрэг засгийн газрын гишүүн байх), нэгдэл ямар нэг хэмжээгээр байж болох хэдий ч эрх мэдлийн сонгодог хуваарилалт хадгалагдаж, парламент - засгийн газрын хүчийг тэнцвэржүүлэх харьцаа улс төрийн үйл явцад тогтсон байдаг.

2.2. УИХ-ын сонгууль

Монгол Улсын Их Хурлын сонгууль Монгол улсын иргэд иргэд засгийн эрх мэдлээ хэрэгжүүлэх үндсэн дээр хууль тогтоох байгууллагыг өөрсдийн төлөөлөгчдөөр бүрдүүлэх үндсэн арга юм. УИХ-ын сонгууль нь 1) ээлжит сонгууль; 2) ээлжит бус сонгууль; 3) нөхөн сонгууль; 4) дахин сонгууль гэсэн төрөлтэй. УИХ-ын бүрэн эрхийн хугацаа дуусахтай зэрэгцэн 4 жил тутамд хууль тогтоох байгууллагын бүрэлдэхүүнийг шинэчлэн сэлбэх сонгуулийг ээлжит сонгууль гэнэ. Тухайлбал, 2012 онд явагдсан УИХ-ын сонгууль нь ээлжит сонгууль юм.

Ээлжит бус сонгуулийг УИХ бүрэн эрхийнхээ хугацаанаас өмнө тарах шийдвэрийг Үндсэн хуульд зааснаар өөрөө буюу эсхүл ерөнхийлөгч гаргасны дараа явуулна. Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойших хугацаанд УИХ ээлжит бус сонгууль явагдаагүй. Учир нь мөнхүү хугацаанд УИХ өөрөө тарах болон, түүнийг тараах шийдвэр гараагүй. Нөхөн сонгуулийг УИХ-ын гишүүний орон гарсан, нас барсан бол орны гишүүнийг

сонгохоор товлож явуулна. Дахин сонгуулийг ээлжит, ээлжит бус, нөхөн сонгууль нь аль нэг тойрогт хүчингүй болсон нөхцөлд явуулдаг.

“Дахин сонгууль” гэж ээлжит, ээлжит бус сонгуулийг бүхэлд нь хүчингүйд тооцсоны дараа шинээр улсын нийт нутаг дэвсгэрт, эсхүл ээлжит, ээлжит бус болон нөхөн сонгуулийг нэг буюу хэд хэдэн тойрогт хүчингүйд тооцсоны дараа тухайн тойрогт явагдах сонгуулийг хэлнэ. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 4.7 дахь зүйл

2012 оноос эхлэн УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулах болсон. Өөрөөр хэлбэл, УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлж байгаа улс төрийн намууд үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан тойргуудад нэр дэвшүүлсэн мажоритар тогтолцооны зэрэгцээ үндэсний хэмжээнд тухайн намаас нэр дэвшүүлсэн хүмүүсийн жагсаалтыг харж намыг сонгож санал өгөх пропорционал тогтолцооны зарчмаар өрсөлдүүлэхээр болсон. УИХ-ын сонгуульд өрсөлдсөн 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг улс төрийн нам болон улс төрийн намуудын сонгуулийн эвслийн жагсаалтаас тус тус сонгоно. Сонгуулийн холимог тогтолцоо нь мажоритар болон пропорционал тогтолцооны сүл талыг багасгаж, давуу талыг товойлгох зорилт агуулсан. Үүний зэрэгцээ тухайн улс төрийн намаас нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь эмэгтэйчүүд байхаар заасан нь улс төрийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад жендэрийн тэгш байдлыг хангахад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн алхам болсон.

Хуулиар эрх нь хязгаарлагдаагүй 25 нас хүрсэн Монгол улсын иргэн УИХ-д сонгогдох эрхтэй бол 18 нас хүрсэн иргэн сонгуульд саналаа шууд, чөлөөт зарчмын үндсэн дээр өгөх эрхтэй. Сонгууль товлон зарласан өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй. Сонгуульд оролцох нам, эвсэл УИХ-ын гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг сонгууль товлон зарласан өдрөөс хойш 20 хоногийн дараа эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана. Сонгуульд бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааг сонгууль товлон зарласан өдрөөс хойш 15 хоногийн дараа эхлүүлж, 12 хоногийн хугацаанд дуусгана.

Сонгууль зарласнаас хойших хугацаанд буюу сонгуулийн кампанит ажил өрнөж байх явцад сонгуулийн үйл ажиллагаанд төрийн албан хаагчдыг татан оролцуулах, төрийн байгууллагын аливаа нөөцөд тулгуурлан ухуулга

сурталчилгаа хийх, сонгогчдод эд материал, бэлэн мөнгө тараах, түүнтэй адилтгах амлалт өгөхийг хориглосон. Учир нь сонгуулийн шинэ хууль батлагдахаас өмнөх жилүүдийн (ялангуяа 2000, 2004, 2008 оны) сонгуулиар сонгогчдод эд материал тараах, хоосон амлалт өгөх замаар санал авах байдал давтагдаж ардчилсан сонгуулийн мөн чанар, үнэт зүйлийг сэвтээсэн үйлдэл гарч байв. Түүнчлэн сонгуулийн санал өгөх хуудсыг автомат машинаар уншиж, дүнг нь нэгтгэж гаргах шинэ туршлага нэвтрүүлсэн. Ямартай ч сонгууль шударга, нээлттэй, шууд зарчмаар болох нөхцөлийг боловсронгуй болгох тодорхой алхам хийгдэж байгаа нь зохих үр дүн өгч байна.

2.3. УИХ-ын эрх үүрэг

Шинэ Үндсэн хуулиар төрийн байгууллын хувьд Монгол Улс парламентын бүгд найрамдах улс байхаар тогтоосон. Үндсэн хуульд зааснаар УИХ бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ хадгална. \Монгол Улсын Үндсэн Хууль, 3-р Бүлэг 20-р зүйл\ Нөгөө талаар парламентад олонх болсон нам, олонх болсон улс төрийн хүчин байхгүй бол намүүд хоорондоо эвсэн засгийн газар байгуулах бөгөөд үүнийг УИХ-аар хэлэлцэн баталдаг. Ямартай ч гүйцэтгэх эрх бүхий институтийг үүсгэх, түүнд хяналт тавих эрхийг парламентад олгосон нь Монгол улс парламентын байгуулалтай улс болохыг харуулж байна.

Нөгөө талаар УИХ-ын тараах харилцааг зохицуулсан байдаг. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш 45 хоногийн дотор УИХ хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-ыг тараах тухай шийдвэр гаргана.

УИХ дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

1. Хууль тогтоох эрх мэдэл нь парламентын гол буюу түлхүүр үүрэг мөн. Өөрөөр хэлбэл УИХ хууль тогтоох (хуулийн төсөл хэлэлцэх, батлах) чиг үүргээ бие даан хэрэгжүүлнэ. УИХ хууль тогтоох төлөөлөгчдийн байгууллага бөгөөд улс төрийн харилцаанд ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл болж, ард түмнээс сонгогдсон төлөөллийн институтын хувиар бүх нийтээр дагаж мөрдөх хууль тогтоож, төр-нийгмийн харилцааг хуулиар дамжуулан удирдах зохион байгуулалт юм.
2. Ард түмний эрх ашиг, сонирхлыг төлөөлөх үүрэгтэй буюу төр - сонгогчдыг холбох чиг үүрэг хэрэгжүүлнэ. УИХ-ын гишүүдийг бүх нийтийн чөлөөт, шууд, ардчилсан сонгуулиар сонгодог нь түүний төлөөллийн буюу нийтийн эрх ашгийг улс төрийн хүрээнд илэрхийлж, шийдвэрлүүлэх чиг үүргийн бодит илэрхийлэл болно.
3. Хяналт – тэнцвэрийн харилцаа улс төрд төлөвших нэг үндэс нь хууль тогтоох институт нь гүйцэтгэх эрх мэдэлтэй институтийг хянах, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөх явдал юм. УИХ-аас Засгийн газрын үйл ажиллагаанд хуулийн хүрээнд хяналт тавих эрх мэдэл хэрэгжүүлнэ.

Улс төрчид улс төрийн үйл явцад суралцах, тэднийг тодорхой албан тушаалд томилох орчин болдог. \W.Lawrence Neuman. (2005) Power, State, and Society: An Introduction to Political Sociology. McGraw Hill. New York. p.83\ Парламентын энэ байдал нь албан бус шинжтэй боловч улс төрийн нам, хүчнүүд парламентаар дамжуулж шинэ улс төрчдийг бэлтгэх, улс төрд сургах арга зам эрэлхийлж улмаар гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх институтэд улс төрийн хариуцлагатай алба хаших үндсийг тавих хандлага тогтжээ.

2.4. УИХ-ын зохион байгуулалтын хэлбэр

Улсын Их Хурал өөрийн бүрэн эрхээ чуулган, Байнгын болон түр, дэд хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлдэг. Гэхдээ үйл ажиллагааны зохион байгуулалтынх нь үндсэн хэлбэр нь **чуулган** байна. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг Үндсэн хуулийн хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар нийт гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно. \Монгол Улсын Их Хурлын тухайн хуулийн 2-р Бүлэг, 8.4-р зүйл\

Монгол улсын парламент намрын болон хаврын чуулганы зохион байгуулалттай байх бөгөөд намрын чуулган 10 сарын 1-ны өдөр, хаврын чуулган 4 сарын 5-ны өдөр нээж 50-аас доошгүй ажлын өдөр хуралддаг. Ээлжит чуулганы чөлөө цагт зайлшгүй шалтгааны улмаас парламентын нийт гишүүдийн 1/3-ээс дээших шаардсанаар, эсвэл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган зарлан хуралдуулж болдог. Хэдийгээр хавар болон намрын чуулганы хуралдах ажлын хугацааг 50-аас доошгүй өдөр гэж заасан боловч чуулганы үйл ажиллагаа тухайн үеийн улс төрийн нөхцөл байдал, чуулганаар хэлэлцэх хуулийн төсөл, бодлогын асуудал заагдсан хугацаанд багтаагүй зэрэг шалтгаанаар үргэлжлэн хуралдаж болдог. Парламентын анхдугаар чуулганыг сонгуулийн албан ёсны дүн зарлагдсанаас хойш 30 хоногийн дотор ерөнхийлөгч зарлан хуралдуулдаг. Эдгээрийн зэрэгцээ УИХ-ын онцгой болон хүндэтгэлийн чуулганы хэлбэр бий.

Монгол улсын УИХ дарга, дэд даргатай. УИХ-ын сонгуульд олонх болсон улс төрийн нам, эвсэл УИХ даргад нэр дэвшүүлдэг. Аль ч нам, эвсэл суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл нь бусад нам, эвсэлтэй зөвшилцөн УИХ-ын даргад нэр дэвшүүлдэг. УИХ-ын даргад нэр дэвшүүлсэн гишүүний асуудлыг холбогдох байнгын хороо, намын бүлгүүд хэлэлцэж дүгнэлт гаргах бөгөөд улмаар УИХ-ын хуралдаанаар нээлттэй санал хурааж сонгоно. Харин УИХ дахь намын бүлэг бүр УИХ-ын дэд даргад тус тус нэр дэвшүүлж, сонгоно.

Байнгын хороод нь парламент дахь тодорхой чиглэл, асуудлаар мэргэшсэн бүтэц юм. УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал боловсруулж, урьдчилан хэлэлцэж, дүгнэлт гаргах, түүнчлэн эрхлэх асуудлын хүрээнд парламентын хяналтыг хэрэгжүүлэх нийтлэг чиг үүрэг хэрэгжүүлдэг. Ямар байнгын болон дэд, түр хороотой байхыг ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан УИХ тогтооно. УИХ дахь улс төрийн зохион байгуулалтын хэлбэрт **намын бүлэг** багтана. Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай нам /эвсэл/ бүлэг байгуулж болно. Нам эвслийн бүлэгт зөвхөн тухайн нам эвслээс нэрийг нь дэвшүүлж, сонгогдсон УИХ-ын гишүүд орно. \Монгол Улсын Их Хурлын тухайн хуулийн 2 д-р бүлэг, 21.1-р зүйл\

2.5. Хууль тогтоох үйл явц

Улсын Их Хурал бүрэн эрх, чиг үүргийнхээ хүрээнд хууль, бусад шийдвэр гаргадаг. Улсын их хурлын бусад шийдвэр нь тогтоол байна. Тодруулж хэлбэл парламент нь Монгол төрийн гадаад дотоод бодлогын үндсийг тогтоож, нийгмийн дээд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бөгөөд түүний онц бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Үндсэн хууль, бусад хуулийг батлах, өөрчлөх асуудал хамаардаг.

Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхээ гагцхүү чуулганаар хэрэгжүүлэх бөгөөд нэгдсэн болон Байнгын хороодын хуралдааныг бэлтгэн явуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой бусад асуудал хэлэлцэх, санал хураах, батлах, шийдвэр гаргахдаа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг баримтална. \Монгол Улсын Их Хурлын тухайн хуулийн 32.1-р зүйл\

Ерөнхийлөгч, УИХ, түүний гишүүд, Засгийн газар хууль санаачлах эрхтэй. Хууль санаачлах эрх бүхий субъектүүдийн санаачилсан хуулийг **хуулийн төсөл** гэж нэрлэнэ. Хуулийн төслийг холбогдох эрх бүхий байнгын хороо хариуцаж Чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангана. Хуулийн төслийг байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэхийн зэрэгцээ УИХ дахь намын бүлгүүд хэлэлцэж санал дүгнэлт гаргана. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж олонхийн санал авч зөвшөөрөгдсөн хуулийн төслийг холбогдох байнгын хорооны дарга УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр УИХ-ын даргад өргөн барина.

УИХ-ын чуулганд хэлэлцүүлэхээр өргөн барьсан хуулийн төслийг олонхийн саналаар батална. Чуулганы хуралдааны ирцийг нийт гишүүдийн олонх оролцсон нөхцөлд хүчинтэй гэж үздэг. Мөн ердийн журмаар хууль батлахдаа хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар баталдаг. УИХ-ын баталсан хуульд

Хуулийн төсөл өргөн барилаа (2011 оны 12 сарын 13-ны өдөр)

УИХ-ын гишүүн Д.Оюунхорол, Д.Очирбат, Ц.Мөнх-Оргил нарын гишүүд өнөөдөр тэтгэврийн зөрүүг арилгах тухай хуулийн төсөл өргөн барилаа. 1995 оноос өмнө тэтгэврээ тогтоолгосон хүмүүс, сүүлийн хэдэн жилд тэтгэвэрт гарсан хүмүүсийн төрөөс авч байгаа мөнгө хэт их зөрүүтэй байгаа. Тухайлбал, гучин хэдэн жил улсын сургуульд багшилчхаад 105 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа нь шударга бус гэж үзэж байгаа юм. Тиймээс суурь тэтгэврийг тогтоосон оныг нь харгалзан үзэж эхний ээлжинд 30 мянган төгрөгөөр нэмэх тухай энэ хуулийн төсөлд оруулжээ.

Эх сурвалж: <http://www.24tsag.mn/content/4538.shtml>

Ерөнхийлөгч хориг тавьсан нөхцөлд УИХ-ын хуралдаанд оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар тухайн хориг хүчингүй болгох боломжтой.

3. Гүйцэтгэх эрх мэдэл (Засгийн газар)


3.1. Засгийн газар байгуулах процедур

Засгийн газар нь гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх улс төрийн институт бөгөөд Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Засгийн газрыг Монгол улсын Ерөнхий сайд тэргүүлнэ. Монгол улсын Ерөнхийлөгч нь УИХ-д олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль эсвэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж эсвэл зөвшилцөн олонхоороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна. \Монгол улсын Үндсэн хууль, 2-р Бүлэг, 33.2-р зүйл\ Ерөнхийлөгчөөс ерөнхий сайдаар томилуулахаар санал болгосон хүнийг УИХ хэлэлцээд, олонхийн санал авсан нөхцөлд ерөнхий сайдаар томилж хууль батална. Өөрөөр хэлбэл парламентад олонх болсон улс төрийн нам, эвсэл эсвэл нам, эвслүүд зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг ерөнхий сайдаар томилж байгаа энэ процедур нь ерөнхий сайдыг парламент төрүүлж буй зохицуулалтыг илтгэнэ. Дийлэнх тохиолдолд Ерөнхий сайдад нэр дэвшүүлсэн хүн тухайн улс төрийн нам, эвслийн дарга буюу лидер, нөлөө бүхий улс төрч байдаг.

Ерөнхий сайд засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн парламентад өргөн барьдаг. Уг асуудлаар ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол парламентад өөрөө өргөн мэдүүлнэ. Үндсэндээ засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох эрхийг ерөнхий сайдад олгосон. Ерөнхий сайдын түр эзгүйд түүний үүрэг болгосноор Засгийн газрын аль нэг гишүүн хавсран гүйцэтгэдэг.

Зураг 1.1

Засгийн газар байгуулах процедур



Засгийн газар нь өөрийн санаачлагаар болон УИХ-аас итгэл хүлээлгээгүй нөхцөлд огцордог. Тухайлбал, Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцровол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно. \Монгол улсын Үндсэн хуулийн 3-р Бүлэг 43.2-р зүйл\ Парламент засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан, Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн

авснаас хойш арван тав хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнээс үзэхэд засгийн газрыг огцруулах санаачлага засгийн газрын тэргүүн, сайд нарын тэн хагас, ерөнхийлөгч, парламентаас гарч болохоор байна. Засгийн газар өөрөө санаачилга гаргаж байгаа нь хамтын хариуцлага хүлээх буюу кабинетын зарчимтай уялдаж байгаа бол парламентаас санаачлага гаргаж байгаа явдлыг эрх мэдэл хуваарилах зарчмын хүрээнд хууль тогтоох институт нь гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх институтэд хяналт тавих зохицуулалттай холбож ойлгох нь зүйтэй. Харин ерөнхийлөгчөөс засгийн газрыг огцруулах санаачилга нь дийлэнх тохиолдолд улс төрийн хямралт байдлыг шийдвэрлэх зорилттой уялдах учиртай.

Хүснэгт 1.2

Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш томилогдсон Ерөнхий сайд нар

	Овог нэр	Сонгогдсон /бүрэн эрх нь дуусгавар болсон огноо	Улс төрийн намын харьяалал/засгийн газрын хэлбэр	Төрсөн он/ сонгогдох үеийн нас	Бүрэн эрхийн хугацаа нь дууссан шалтгаан
1	Пунцагийн Жасрай	1992.07.21-1996.07.19	МАХН /дангаараа	1933.10.25-2007.10 59 настайдаа	Парламентын бүрэн эрхийн хугацаа дуусаж шинэ засгийн газар байгуулагдсан/ сөрөг хүчин сонгуульд ялсан
2	Мэндсайханы Энхсайхан	1996.07.19-1998.04.23	МҮАН / МСДН-тай эвсэж бүрдүүлсэн засгийн газар	1955 41 настайдаа	Улс төрийн сөрөг хүчин өөрийнх нь намтай хамтран огцруулах санаачилга гаргасан
3	Цахиагийн Элбэгдорж	1998.04.23-1998.12.09	МҮАН / МСДН-тай эвсэж бүрдүүлсэн засгийн газар	1963 35 настайдаа	Эрх барьж байгаа улс төрийн хүчин буюу өөрийнх нь нам огцруулах санаачлага гаргасан
4	Жанлавын Наранцацралт	1998.12.09-1999.07.22	МСДН/ МҮАН-тай эвсэж байгуулсан засгийн газар	1957-2007 41 настайдаа	Улс төрийн сөрөг хүчин огцруулах санаачилга гаргасан
5	Ням-Осорын Туяа	1999.07.22-1999.07.30	МСДН	1958 41 настайдаа	Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч / гадаад хэргийн сайд
6	Рэнчинямын Амаржаргал	1999.07.30-2000.07.26	МҮАН/ МСДН-тай эвсэж бүрдүүлсэн засгийн газар	1961 38 настайдаа	Парламентын бүрэн эрхийн хугацаа дуусаж шинэ засгийн газар байгуулагдсан/ сөрөг хүчин сонгуульд ялсан
7	Намбарын Энхбаяр	2000.07.26-2004.08.20	МАХН/дангаараа	1958 42 настайдаа	Парламентын бүрэн эрхийн хугацаа дуусаж шинэ засгийн газар байгуулагдсан/ эвслийн засгийн газар байгуулагдсан
8	Цахиагийн Элбэгдорж	2004.08.20-2006.01.13	МАН /эвслийн МАН, МАХН	1963 43 настайдаа	Сөрөг хүчнээс төлөөлөлтэй засгийн газрын гишүүдийн тал нь огцрох хүсэлт гаргасан
9	Миеэгомбын Энхболд	2006.01.26 – 2007.11.07	МАХН/ эвслийн – МАХН, БНН, Эх Орон нам, Шударга Ёсны Нам	1964 42 настайдаа	Өөрийн хүсэлтээр огцрох хүсэлт гаргасан
10	Санжийн Баяр	2007.11.22-2009.10.29	МАХН/ эвслийн – МАХН, ИЗН, Шударга Ёсны Нам	1956 52 настайдаа	Эрүүл мэндийн шалтгааны улмаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан
11	Сүхбаатарын Батболд	2009.10.29-2012.08.10	МАН/ эвслийн – МАН, ИЗН, Шударга Ёсны Нам	1963 46 настайдаа	Парламентын бүрэн эрхийн хугацаа дуусаж шинэ засгийн газар байгуулагдсан/ сөрөг хүчин сонгуульд ялсан
12	Норовын Алтанхуяг	2012.08.10-аас	АН/эвслийн МАХН, ИЗН, МҮАН	1955 54 настайдаа	

Жич: Ерөнхий сайд нарын дундаж нас 44.5 байна.

3.2. Засгийн газрын үйл ажиллагааны онцлог

Засгийн газрын тэргүүн буюу Ерөнхий сайд Засгийн газрыг удирдан зохион байгуулж, төрийн бодлогыг хэрэгжүүлж, хууль сахиулах ажлыг УИХ-ын өмнө хариуцна. Засгийн газар үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнана. \Монгол улсын Үндсэн хуулийн 3-р Бүлэг 41.1,2-р зүйл\ Засгийн газар үйл ажиллагааныхаа мөрийн хөтөлбөрийн төслийг бүрэн эрхийнх нь хугацаа эхэлснээс хойш 60 хоногийн дотор, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл зэрэг баримт бичгийн төслийг өргөн мэдүүлэх үүрэг хүлээдэг. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг парламентын нэгдсэн чуулганаар хэлэлцэн шийдвэр гаргана. Засгийн газрын үйл ажиллагаа дараах онцлогтой. Үүнд:

- Парламентад олонх болсон улс төрийн нам, эвсэл нь засгийн газраа байгуулна;
- Засгийн газар үйл ажиллагаагаа зөвхөн парламентын өмнө тайлагнаж, хариуцна. Парламентаас итгэл хүлээсэн эсэхээс хамааран засгийн газрын оршин байх хувь заяа шалтгаална;
- Засгийн газрын нэгдмэл удирдлага, хамтын хариуцлагыг түүний цөм буюу манлайлах бүтэц болох Засгийн газрын кабинет хангадаг;
- Парламентын гишүүн нь нэгэн зэрэг гүйцэтгэх засгийн бүрэлдэхүүнд орж ажиллах боломжтой.

Монгол Улсын Засгийн газар нь үйл ажиллагаагаа танхимын зохион байгуулалтаар (кабинетын зарчмаар) хэрэгжүүлдэг. Танхимын зохион байгуулалтыг хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь Засгийн газрын хуралдаан мөн. \Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 3 бүлэг 17.4 зүйл\ Засгийн газрын хуралдаанаар парламентаас даалгасан, ерөнхийлөгчөөс санал болгосон асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргадаг. Танхимын зарчмаар үйл ажиллагаа явуулах тул хэлэлцэж байгаа асуудлаар Засгийн газрын гишүүдээс санал хурааж эцсийн шийдвэр гаргадаг.

Засгийн газрын хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд: 1 /хуулийн төсөл; 2/ хуульд өөрөөр заагаагүй бол УИХ-д өргөн мэдүүлэх бусад шийдвэр; 3/ Засгийн газарт чиглэл өгөх тухай ерөнхийлөгчийн зарлиг; 4/ Засгийн газрын бодлогод өөрчлөлт оруулахаар өөрийн гишүүнээс ирүүлсэн санал; 5/ Ерөнхий сайд дангаар шийдвэрлээгүй болон Засгийн газрын гишүүдээс эрхлэх асуудлаараа өөрсдөө тохиролцож чадаагүй саналын зөрөөг шийдвэрлэх асуудал зэрэг нь болно. Засгийн газрын ажлын алба нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна. Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, мөрийн хөтөлбөр, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд болон Ерөнхий сайд, танхимын үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг, зөвлөгөө өгч, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх институтын үр нөлөөтэй, үр ашигтай, тасралтгүй, хэвийн жигд ажиллагааны таатай орчин бүрдүүлж ажиллах үүрэг хүлээдэг.

Засгийн газар нь үйл ажиллагааны зохих хүрээ салбарыг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу яамдтай байдаг. Яамдыг ерөнхийлөгчтэй зөвшилцөж, ерөнхий сайдын мэдүүлснээр УИХ байгуулж, татан буулгана. Яамдыг чиг үүргээр нь ерөнхий чиг үүргийн, салбарын чиглэлийн гэж ангилдаг. Ерөнхий чиг үүргийн яам нь нэгдсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлогын хэрэгжилтийн явц байдалд хяналт шинжилгээ хийх, үр дүнд нь

үнэлгээ өгөх, түүнчлэн чиглэлийн яамдын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх чиг үүрэг хэрэгжүүлдэг. Чиглэлийн яам нь хариуцсан чиглэл, салбарын төлөвлөлт, бодлого удирдамжаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, бодлогын хэрэгжилтийн явц байдалд хяналт шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх чиг үүрэг хэрэгжүүлдэг.

3.3. Шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр

Сонгуульд ялалт байгуулсан улс төрийн хүчин улс орны хэмжээнд хэрэгжүүлэх нийгэм-эдийн засаг-улс төрийн зорилтуудаа тодорхойлсон мөрийн хөтөлбөрийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлдэг. Зарим талаар сонгуулийн өмнө өгсөн амлалт нь тухайн засгийн газрын мөрийн хөтөлбөр болох хэдий ч нөгөө талаар сонгуульд оролцсон бусад улс төрийн нам, хүчний мөрийн хөтөлбөрт тусгасан тэргүүлэх ач холбогдолтой зорилтуудыг мөрийн хөтөлбөрт тусгах нь бий. 2012 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газар эвслийн засгийн газар юм. Иймд Засгийн газрын мөрийн хөтөлбөрт Ардчилсан нам, Иргэний зориг нам, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн зорилтууд тусгалаа олсон байдаг. Шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр дараах үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:

- Ажилтай, орлоготой Монгол хүн
- Эрүүл чийрэг Монгол хүн
- Эрдэм боловсролтой Монгол хүн
- Аюулгүй орчинтой Монгол хүн

Ардчилсан нам голлосон Засгийн газрын мөрийн хөтөлбөрт либерал үзэл санааг тулгуур болгосон зорилт дэвшүүлсэн болох нь тодорхой байна. Учир нь мөрийн хөтөлбөрийн үндсэн дөрвөн зорилт нь хүний хөгжилд чиглэсэн, иргэдийг хөгжлийн үр шимээ хүртэгч байгаад зогсохгүй, хөгжлийн үйл явцад оролцогч

Эрдэм боловсролтой Монгол хүн

Монголын онцлог бүхий, олон улсын стандартад нийцсэн, хөрвөх чадвартай боловсролыг эх орондоо олж авах, эзэмшсэн мэдлэг, мэргэжлээрээ ажил, хөдөлмөр эрхлэх боломжтой байх, эх орны хөгжлийн ирээдүй Монгол хүнээ сургаж бэлтгэх нь боловсролын салбарын гол зорилт байх болно.

болгох үзэл санааг шалгуур болгожээ. Тухайлбал, эрдэм боловсролтой “Монгол хүн” зорилт нь Монгол хүний өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх дэд зорилт, үйл ажиллагааг агуулж байгаа юм.

Мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн хамгийн томоохон зорилт нь “Ажилтай орлоготой Монгол хүн” бөгөөд дотроо тодорхой салбар, хүрээг хамарсан бүрдэл хэсэгтэй байна. Үүнд:

1. Үйлдвэржүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого;
2. Ноос, ноолуур, арьс ширний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого;
3. Уламжлалт мал аж ахуй, мах, сүүний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого;

4. Аялал, жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого;
5. Өндөр технологи, био, нано, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлэх бодлого;
6. Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого;
7. Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх бодлого;
8. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого;
9. Нийгмийн хамгааллын бодлого;

Шинэчлэлийн Засгийн газар уул уурхайн салбараас эдийн засаг шууд болон хэт хамааралтай байгаа байдлыг багасгаж, урт хугацаанд тогтвортой хөгжлийг хангах, өрсөлдөх чадвар бүхий олон тулгуурт эдийн засгийг бий болгох нь эдийн засгийн бодлогын тэргүүлэх зорилт гэж үзсэн болно. Үүнийг энгийнээр “эдийн засгаа солонгоруулах” бодлого гэж томъёолжээ. Учир нь дан ганц уул уурхайн салбарын өсөлт нь урт хугацаанд бусад салбарын өрсөлдөх чадварыг бууруулдаг ижил төстэй бусад орны туршлагыг харгалзжээ. Эдийн засгийн бүхий л салбарыг бүхэлд нь хамарсан төрийн бодлого нь ажлын байр шинээр бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх эцсийн дүндээ өөрөө өөрийгөө тэтгээд явах чадвартай “Ажилтай-орлоготой Монгол хүн” бий болох нөхцөл гэж үзжээ.

Шинэчлэлийн Засгийн газрын нийгмийн хамгааллын чиглэлээр дэвшүүлсэн тодорхой зорилт хэрэгжсэн жишээ бий. Тухайлбал, “1990-1995 оны хооронд өөрөөс үл хамаарах шалтгааны улмаас ажил хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэдийн ажилласан жил тасарсныг ажилласнаар нөхөн тооцох эрх зүйн орчин бүрдүүлэх” гэсэн зорилт тавьсан бөгөөд энэ зорилтыг хангах хуулийг баталж, мөрдөн хэрэгжүүлж эхлээд байна.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн биелэлтийг жил тутам УИХ хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгдөг. 2013 оны төгсгөл бол шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн биелэлтийн явцад үнэлэлт дүгнэлт өгөх жил юм. Харин 2016 оны сонгууль нь шинэчлэлийн Засгийн газрын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн биелэлтэд шууд үнэлэлт өгөх боломжийг сонгогчдод олгоно.

4. Төрийн тэргүүн (Ерөнхийлөгч)

4.1. Ерөнхийлөгчийн сонгууль

Парламентын засаглалтай улсад төрийн тэргүүний буюу ерөнхийлөгчийн институт ажилладаг олон улсын жишиг бий. 1990 онд өрнөсөн улс төрийн шинэчлэл, ардчилсан үйл явцын үр дүнд тоталитар дэглэмээс ардчилсан дэглэмд шилжсэн пост-коммунист улсуудад бараг нэгэн зэрэг ерөнхийлөгчийн институт үүсжээ.

Бүгд Найрамдах Монгол Ард улсын АИХ-ын XI удаагийн сонгуулийн 8 дугаар чуулган 1990 оны 3 сард Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс боловсруулсан үзэл баримтлалын дагуу БНМАУ-ын төрийн дээд институтийн бүтцийн тухай тогтоол гаргаж, түүнд БНМАУ-ын төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч байхаар тогтоосон. Энэ нь БНМАУ-ын "Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль"-ийг боловсруулах үзэл баримтлал болсон байдаг. 1990 оны 09 сарын 03-ны өдөр БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль, БНМАУ-ын Ардын Их Хурлын анхдугаар хуралдааны дэгд заасан журмын дагуу ерөнхийлөгчид нэр дэвшүүлэн хэлэлцэж, саналыг нууцаар хураасан дүнгийн тухай Санал хураах комиссын тогтоолыг үндэслэн БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр Пунсалмаагийн Очирбатыг сонгосон хууль баталсан байна. \Ардын эрх. 1990.09.06\

1992 оны шинэ Үндсэн хуулиар ерөнхийлөгчийн институтийн эрх хэмжээ, үүрэг, улс төрийн бусад институттэй харилцах хэлбэрийг шинэчлэн тодорхойлсон байна.

Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш сонгогдсон ерөнхийлөгчид:

Ерөнхийлөгчид	Бүрэн эрхийн хугацаа
П.Очирбат	1993 – 1997
Н.Багабанди	1997 – 2005
Н.Энхбаяр	2005 – 2009
Ц.Элбэгдорж	2009 оноос

Тухайлбал, дэд ерөнхийлөгчийн албан тушаал байхгүй болсон бөгөөд, ерөнхийлөгчийн эрх хэмжээ гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх бүтцэд багтсан байхаар хуульчилжээ. Өөрөөр хэлбэл ерөнхийлөгчийн институтийг парламентын байгуулалтай улсын ерөнхийлөгчийн эрх мэдэл, эрх хэмжээг шалгуур болгон тодорхойлжээ.

Монгол улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн. \Монгол улсын Үндсэн хуулийн 3-р бүлэг, 30.1-р зүйл\ Ерөнхийлөгчөөр дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол улсын уугуул иргэнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. \Монгол улсын Үндсэн хуулийн 3-р бүлэг, 30.2-р зүйл\ Үндсэн хуулийн энэ заалтаар ерөнхийлөгчийн төрийн тэргүүний статус, түүнийг бүх нийтийн чөлөөт шууд ардчилсан сонгуулиар сонгох нөхцөлийг тодорхойлсон байна.

Монгол улсын төрийн тэргүүнийг сонгох сонгууль хоёр шаттай явагддаг. УИХ-д суудал бүхий нам дангаараа буюу хамтран ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлэх эрхтэй. Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргадаг. Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд нийт сонгогчид оролцож, нууц санал хураалт явуулан, сонгогчдын

олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийн хүлээн зөвшөөрсөн хууль гаргана. УИХ-аас ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэн хууль гаргаж байгаа процесс нь ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шат юм. Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч сонгогчдын олонхийн санал аваагүй бол анхны санал хураалтад сонгогчдоос хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Монгол улсын ерөнхийлөгчөөр зөвхөн ганц удаа улиран сонгогдох боломжтой. Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхэлж, шинэ ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болдог.

4.2. Ерөнхийлөгчийн эрх үүрэг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн институт бол Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрх бүхий төрийн чухал институт мөн. Ерөнхийлөгч Улсын их хурлын чуулганы хуралдаанд тааллаараа оролцож улс орны гадаад, дотоод бодлогын талаар мэдээлж, төрийн бодлогын аливаа асуудлаар УИХ-д санал болгоно. Ерөнхийлөгч УИХ-ыг тараах, өөрөө тарах тухай санал оруулах эрхтэй. Тухайлбал, УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн бол парламентад өөрөө тарах санал оруулдаг. Түүнчлэн ерөнхий сайдаар томилуулахаар нэр дэвшүүлсэн хүнийг парламент 45 хоногт багтаан томилоогүй бол парламентыг тараах эрхтэй. УИХ ерөнхий сайдыг тогтсон хугацаанд томилохгүй байх магадлал маш бага бөгөөд хэрэв ийм нөхцөл байдал үүссэн бол улс төрийн үйл явцыг түргэтгэх үүднээс ерөнхийлөгч парламентыг тараах эрхээ хэрэгжүүлэх боломжтой юм.

Гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх тодорхой бүрэн эрх бий. УИХ-д олонх болсон улс төрийн нам, эвсэл, тийм улс төрийн хүчин байхгүй бол намууд өөр хоорондоо зөвшилцөөд ерөнхий сайдад нэр дэвшүүлсэн хүнийг ерөнхий сайдаар томилох саналыг ерөнхийлөгч УИХ-д оруулна. Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх эрхтэй бөгөөд энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болдог.

Үүний зэрэгцээ дараах бүрэн эрхийг ерөнхийлөгч хэрэгжүүлнэ. Үүнд: 1/ УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг УИХ-аар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ; 2/ Гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, УИХ-тай зөвшилцөн Монгол улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах; Монгол улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох; 3/ Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах; 4/ Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх; 5/ Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол УИХ-ын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгнө. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор УИХ хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. 6/ Ерөнхийлөгч Монгол улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. \Монгол улсын Үндсэн хуулийн 3-р бүлгийн 33.1.1, 3, 4, 10, 12; 33.1.3 дах зүйл\

Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн зарлиг, захирамж гаргаж, Монгол улсын нутаг дэвсгэрт бүх нийтээрээ үүнийг дагаж мөрдөнө. Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Үндсэн хуулийн 34 зүйлийн 2-т заасны дагуу ерөнхийлөгч өөрөө буюу УИХ хүчингүй болгоно. \Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007. 202 дахь тал\ Ерөнхийлөгчийн түр эзгүйд, эсхүл огцорсон, нас барсан, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн бол түүний бүрэн эрхийг УИХ-ын дарга хэрэгжүүлнэ.

Ерөнхийлөгчид хариуцлага хүлээлгэх эрх хууль тогтоох институтэд өгөгдсөн байна. Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, бусад хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн тухай асуудлыг УИХ-ын нийт гишүүний 1/3-ээс доошгүй нь албан ёсоор тавивал Үндсэн хуулийн 35-р зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу УИХ-аар хэлэлцэж, ерөнхийлөгчийг огцруулах эсэхийг шийддэг. Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн Хуулийн Цэцийн дүгнэлтийг үндэслэн УИХ-аар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналаар огцруулна.

Үндсэн хуулиар Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрх нь гүйцэтгэх эрх мэдэлд ойр байхаар тодорхойлжээ. Тухайлбал, засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр товлосон асуудлыг тухай бүр ерөнхийлөгчид урьдчилан танилцуулдаг. Гэхдээ эдгээр нь ихэвчлэн бодлогын чанартай асуудал байдаг. Ерөнхийлөгч тухайн асуудлаар засгийн газрын гаргаж байгаа шийдвэрийн төслийг судалж, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл түүнийгээ бичиж засгийн газарт өгдөг. Ерөнхийлөгч засгийн газрын хуралдаанд тааллаараа оролцож, саналаа илэрхийлнэ. Гэхдээ засгийн газрын хуралдааныг даргалах болон гаргаж байгаа шийдвэрт нь санал өгөх хэлбэрээр нөлөөлөхгүй.

Монгол улсын Үндсэн хуулиар ерөнхийлөгчид олгосон бүрэн эрхийг гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх институтэд ойр байхаар тодорхойлсон байдаг нь хүчтэйвтэр ерөнхийлөгчтэй парламентын байгуулалтай улс гэж үзэх үндэслэл юм. \П.Очирбат. Монгол улсын ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр. УБ., 2001\ Монгол улсын төрийн байгууллын давуу болон сул талыг хавсралт 2-оор үзүүлэв. Монгол улсын ерөнхийлөгч бол манай төрийн байгууллын тогтолцоонд өвөрмөц байр суурь эзэлдэг онцгой нэгэн институт мөн. Түүний өвөрмөц бөгөөд онцгой шинж нь бүх ард түмнээс сонгогдож, УИХ-д ажлаа хариуцдаг, тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчвөл Үндсэн Хуулийн Цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурал огцруулдаг зэрэг Үндсэн хуулийн заалтаар тодорхойлогдоно. \Д.Лүндээжанцан. Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2001. 198 дахь тал\

5. Шүүх засаглал

5.1. Шүүхийн тогтолцоо

Манай нийгэм улс төрийн ном зохиол, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлэгт “Засаглал” хэмээх ойлголтын зэрэгцээ “Төрийн эрх мэдэл”, “Удирдлага” гэсэн ойлголтуудыг ойролцоо утгаар хэрэглэдэг. Энэ нь ямар шинжлэх ухааны үүднээс асуудлыг ярьж байна гэдгээсээ гол төлөв хамаардаг. Энэ номын тухайд бол улс төрийн шинжлэх ухааны үүднээс “Засаглал” гэдэг утгыг нь гол болгон хэрэглэж байна.

Францын философич, сэтгэгч, хуульч Монтескю “Хуулийн амин сүнс” номдоо засаглалын эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлэх (хаан төрийн бүхий л эрх мэдлийг хэрэгжүүлдэг) нь хүмүүсийн эрх, эрх чөлөөг хязгаарлаж байгаа тул эрх мэдлийг хуваарилах ёстой гээд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэж хувааж үзсэн. Засаглал хуваарилах зарчим нь 1992 оны шинэ Үндсэн хуулийн тулгуур үзэл баримтлал болсон байдаг. “Засаглалын эрх мэдлийг хуваарилах” \ хууль зүйн ном зохиолд “төрийн эрх мэдлийг хуваарилах” гэдэг\ гэдэг нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх институтууд бие биенээсээ үл хамаарч, харилцан бие биенээ хянаж байхын зэрэгцээ тэнцвэртэй байхын хэлж байгаа бөгөөд монгол улсын хувьд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага болох шүүхийг УИХ, Засгийн газартай тэнцвэртэй хэмжээнд хүртэл хөгжүүлж, бэхжүүлснийг ойлгож болно. \Ганбат Ч. Шинэ зуун ба шүүх. “Шүүх эрх мэдэл-шинэ зуун” олон улсын онол-практикийн бага хурлын (эмх). 2001. 36 дахь тал\



Шүүх засаглал \Шүүх эрх мэдэл\ гэдэг нь шүүн таслах ажиллагаа явуулах бүрэн эрхийн цогц нийлбэр бөгөөд эрүү, иргэн, захиргааны болон Үндсэн хуулийн хэрэг, маргааныг хууль тогтоомжид заасны дагуу хянан шийдвэрлэх бүрэн эрх; эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах бүрэн эрх; хяналтын бүрэн эрхийг агуулна. Социалист системийн үед эрүү, иргэний хэрэг шийдвэрлэхийг “шүүн таслах ажил” гэж ойлгож байсан бол шинэ Үндсэн хуулийн зарчмаар “эрүүгийн хэрэг, эрх зүйн маргаан” буюу “хэрэг маргаан” гэснээрээ Үндсэн хуулийн, захиргааны хуулийн хүрээнд үүсэж болох аливаа маргааныг шийдвэрлэх гэсэн агуулгатай болжээ. Зөвхөн иргэд, хуулийн этгээдийн хоорондын төдийгүй засаг төрийн байгууллагуудын, нутгийн удирдлагын байгууллагуудын тэр битгий хэл Үндсэн хуулийн маргаантай асуудлыг шийдвэрлэх эрх юм. Монгол улсад шүүх эрх мэдлийг дан ганц шүүх эдлэх бөгөөд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг Үндсэн хуулиар хориглосон байдаг. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх гурван салааны нэг болох шүүх эрх мэдэл дан ганц албан ёсоор байгуулагдсан шүүхэд хадгалагдсан нь эрх мэдлийн тэнцвэртэй хуваарилалт онолын хувьд хэрэгжиж байгааг илтгэнэ.

Шүүхийн тогтолцоо нь эрх хэмжээ, өмнөө тавьсан зорилт, зорилгын дагуу байгуулагдсан шүүхүүдийн нийлбэр юм. Шүүхийн үндсэн тогтолцоо нь:

- Улсын дээд шүүх;
- Аймаг, нийслэлийн шүүх;
- Сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ.

Түүнчлэн дагнасан шүүх байгуулж болох бөгөөд харин тусгай шүүх байгуулахыг хориглосон. Монгол улсад дагнасан шүүхийн зорилт бүхий Захиргааны хэргийн шүүх байгуулагдан, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байна.

Сум буюу сум дундын, дүүргийн шүүх: сум буюу сум дундын, дүүргийн шүүх нь хүн амд хамгийн ойр ажилладаг анхан шатны шүүх болно. Эдгээр шүүхүүдийг түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал, бүс нутаг, нутаг дэвсгэрийн ойр дөт байдал, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хэрэг, маргааны гаралтын түвшинг харгалзан аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж гаргасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн УИХ байгуулж, өөрчлөн байгуулж, татан буулгадаг. Одоо сум буюу сум дундын болон дүүргийн 38 бие даасан шүүх ажиллаж байна. Тус шүүх нь ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

Аймаг, нийслэлийн шүүх: Аймаг, нийслэлийн шүүх нь давж заалдах шатны; аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх нь анхан шатны шүүх болно. Мөн Шүүхийн тухай хуульд заасанчлан хуулиар харьяалуулсан хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг. Аймаг, нийслэлийн 22 бие даасан шүүх ажиллаж байна. Аймаг, нийслэлийн шүүх болон аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх нь ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

Улсын дээд шүүх: Улсын дээд шүүх нь Монгол улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүхийн эрх үүргийг хэрэгжүүлдэг. Улсын дээд шүүх нь ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг УИХ-д танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал

Шүүгчийн тангараг

Шүүгч томилогдсон өдрөөсөө хойш 30 хоногийн дотор хамт олон болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийн өмнө “Шүүгч би шүүх эрх мэдлийн ариун журамт үүрэг, Монгол улсын Үндсэн хуульт байгуулал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж хэрэг маргааныг хэнээс ч хараат бус, зөвхөн Монгол улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйг чанд сахиж явахаа ард түмэндээ батлан танграглая. Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал шүүгчийн албан тушаалаас нэн даруй огцорч хуульд заасан хариуцлага.” гэж төрийн сүлдэнд тангараг өргөнө.

болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно. \Монгол Улсын Үндсэн Хууль, 3-р бүлэг 51-р зүйлийн 2\ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг УИХ-д танилцуулж, Ерөнхийлөгч томилно.

Шүүх эрх мэдэл нь төрийн эрх мэдлийн бие даасан салаа болохын хувьд шүүх,

шүүгчид хараат бусаар, бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангагдсан байдаг. Үндсэн хуульд “шүүх бие даасан байх”, “шүүгч хараат бус байх”, “шүүх, шүүгч зөвхөн хуульд захирагдах” гэсэн харилцан хамааралтай зарчмуудыг бүрэн утгаар нь томъёолсны дээр тэдгээрийг хангах зохион байгуулалт, эрх зүйн болон улс төр-эдийн засгийн баталгаа, механизмын

үндсийг тогтоож өгсөн. \Чимид Б. Шүүх эрх мэдлийн талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд. “Шүүх эрх мэдэл-шинэ зуун” олон улсын онол-практикийн бага хурлын (эмх). 2001. 42 дахь тал\ Тухайлбал, шүүгч эдийн засгийн хувьд хараат бус байх, авилга, гадны нөлөөнд автахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс 2013 онд Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчдийг цалинг нэмэгдүүлэх үндэслэлийг судлан тогтоож, шүүгчдийн цалинг УИХ-аар шинэчлэн батлуулсан. Үүнтэй уялдан шүүгчдийн цалин өндөр байхаар тогтоогджээ. Энэ нь шүүх гадны нөлөөнд автаж, нэг талыг тэр тусмаа мөнгөтэй этгээдийн талд үйлчилдэг гэсэн иргэдийн хардлагыг багасгах, шүүгчид илүү хариуцлагатай, бие даасан байдлаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн “Шүүхийн шинэчлэлийн” зорилтын хүрээнд хийсэн бодитой алхам юм.

Шүүгчийн эдийн засгийн бие даасан байдлыг хангах шийдвэр

2013 оны 4 сарын 15-аас хэрэгжиж буй Шүүхийн тухай багц хуульд шүүгчдийн бие даасан хараат бус байдлыг хангахад чиглэгдсэн бүхий л арга хэмжээг Шүүхийн ерөнхий зөвлөл авч хэрэгжүүлэх боломжийг хангаж өгсөн. Ийнхүү Шүүхийн ерөнхий зөвлөл нь түүхэндээ анх удаа шүүгчдийн цалинг шинэчлэн тогтоожээ. Өмнө нь төрийн тусгай албан хаагчдын цалинтай дүйцэхүйц хэмжээгээр тогтоож байсан Улсын Дээд шүүхийн шүүгчийн цалин 1.1 сая төгрөг байсан. Шинэчилсэн цалингийн жишгээр шүүн таслах ажлын, төрийн албанд олон жил ажилласны гэх мэт тогтмол нэмэгдлийг авахгүй хэдий ч шүүгч таван жил тутамд хоёр хувийн нэмэгдэл авах, шүүгчийн үйл ажиллагааны түвшинг 3-5 жил тутамд тогтоон дүгнэлт гарган, цалин нэмэх эсэх нь тодорхой болох юм. Ийнхүү анхан шатны шүүхийн шүүгчдийн цалин 3.7 сая төгрөг, давж заалдах шатны шүүхийн шүүгчийн цалин 3.9-4 сая төгрөг, хяналтын шатны шүүхийн шүүгчийн цалин 4.5 сая төгрөг байхаар тогтлоо. Ажил, мэргэжлийн түвшинг тогтоогоод, таван жил тутмын хоёр хувийг нэмээд тооцохоор шүүгч сард дунджаар 5 сая төгрөгийн цалин авахаар болж байна. Энэ шийдвэр 2014 оны 1 сарын 2-оос эхлэн хэрэгжих юм.

Шүүхийн ерөнхий зөвлөл: Шүүхийн ерөнхий зөвлөл нь бүх шатны шүүхийн удирдлага, зохион байгуулалт, захиргааны үйл ажиллагаатай холбоотой асуудлыг улсын хэмжээнд нэгтэн судалж, асуудлыг боловсруулан төрийн бусад эрх мэдэл бүхий байгууллагатай харилцах үүрэг бүхий хамтын удирдлагын, орон тооны бус байгууллага юм. Шүүхийн ерөнхий зөвлөл 14 гишүүнээс бүрдэх бөгөөд түүнд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, УИХ, Ерөнхийлөгч томилсон тус бүр 1 хүн, Шүүгчдийн зөвлөлөөс сонгосон бүх шатны шүүхээс тус бүр 2 шүүгч, нийслэлийн шүүхээс 1 шүүгч багтана.

5.2. Үндсэн Хуулийн Цэц

Монгол улсын Үндсэн хуулийн Цэц Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй байгууллага бөгөөд Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн. \Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 1 бүлгийн 1.1 дэх зүйл\ Үндсэн хуулийн цэц нь хараат бус байж, хэлэлцэж буй асуудлын хүрээнд гишүүд нь эрх тэгш, шударга шийдвэрлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмыг хангаж ажиллана. Монгол улсын Үндсэн хуулийн Цэц нь Монгол улсын Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавина гэдэг нь тухайн хяналтад харьяалагдах этгээдийн үйл ажиллагаанд Үндсэн хуулийн заалт нэг бүрийг хэрэгжүүлэхийг шаардах, зөрчил

гарсан тохиолдолд арилгуулах чиг үүрэг гүйцэтгэх явдал юм. \Энхбаатар Ч. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007. 284 дэх тал\ Үндсэн хуулийн Цэц дараах эрх зүйн харилцаанд хяналт тавина. Үүнд:

- УИХ-аас гаргаж буй хууль, бусад шийдвэр
- Ерөнхийлөгчийн зарлиг, бусад шийдвэр
- Засгийн газрын шийдвэр
- Монгол улсын олон улсын гэрээ
- Сонгуулийн Ерөнхий хорооноос ард нийтийн санал асуулга, УИХ, түүний гишүүн, Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар гаргасан шийдвэрүүд хамаарах бөгөөд эдгээр актууд Үндсэн хууль зөрсөн эсэх тухай маргааныг хянадаг.

Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг УИХ, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор УИХ зургаан жилийн хугацаагаар томилдог. УИХ, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд Шүүх, Улсын ерөнхий прокурор, иргэд гэсэн үндсэн субъектүүд Цэцэд хандаж аливаа хууль, эрх зүйн акт, шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянуулах өргөдөл, хүсэлт гаргах боломжтой.

6. Нутгийн удирдлага

6.1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгууль

Монгол улсын засаг захиргааны нэгжид нутгийн өөрийн удирдлагын байгууллага нь аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал байдаг. Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль нь тухайн аймаг, сум, дүүрэгт байнга оршин сууж байгаа иргэд нутгийн өөрөө удирдах байгууллагаа өөрсдийн төлөөлөгчдөөр бүрдүүлэх үндсэн арга юм. Сонгууль нь парламентын сонгуулийн нэгэн адил ээлжит, ээлжит бус, нөхөн, дахин сонгууль гэсэн төрөлтэй.

Ээлжит сонгууль: Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9.3-т зааснаар дөрвөн жил тутам явагдаж байгаа сонгуулийг хэлнэ.

Ээлжит бус сонгууль: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15.1-д заасны дагуу аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал-ын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд явагдах сонгуулийг хэлнэ.

Дахин сонгууль: Ээлжит, ээлжит бус сонгуулийг бүхэлд нь хүчингүйд тооцсоны дараа шинээр аймаг, сум, дүүргийн нийт нутаг дэвсгэрт, эсхүл ээлжит, ээлжит бус болон нөхөн сонгуулийг нэг буюу хэд хэдэн сум, баг, хороонд хүчингүйд тооцсоны дараа тухайн сум, баг, хороонд явагдах сонгуулийг хэлнэ.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуулийг холимог хэлбэрээр буюу хувь тэнцүүлэх болон нэг буюу олон мандаттай олонх (мажоритар)-ын хэлбэрээр явуулдаг. Аймгийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь тухайн аймагт, сумын Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь тухайн суманд, дүүргийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь тухайн дүүрэгт санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө шилжин суурьшиж, байнга оршин суугчаар бүртгүүлсэн сонгуулийн эрх бүхий иргэн байна. Үүгээр урьд өмнө тухайн орон нутагт оршин суугаагүй иргэн Хурлын төлөөлөгч тэр бүү хэл Хурлын тэргүүлэгч, дарга хүртэл болдог байсан тохиолдолд хязгаарлалт хийжээ.

6.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх үүрэг

Монгол улсад засаг захиргааны нэгжийн бие даасан байдлыг хангаж, тухайн орон нутгийн иргэд өөрт хамаатай асуудлаар бодлого тодорхойлж, шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх боломжийг нутгийн өөрөө удирдах байгууллагад олгосон байдаг. Нутгийн өөрийн удирдлагын баталгаа нь хүн амд үзүүлж буй бүхий л үйлчилгээг сайжруулах, орон нутгийн бие даасан байдлыг хангах, ардчиллыг бүхий л талаар хөгжүүлэх нийгмийн хэргийг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгддэг.

Нутгийн өөрийн удирдлагын төлөвшлийн шалгуур нь түүний үйл ажиллагааны зарчим, бүрэн эрх хэрхэн хэрэгжиж байгаагаар тодорхойлогддог байна. Үүнд:

Газар нутгийн бүрэн эрх: Нутгийн өөрийн удирдлагын үйл ажиллагааны үндэс нь өөрийн эзэмшлийн нутаг дэвсгэртэй байх буюу оршин суугчид газар нутагтаа эзэн нь байх явдал юм. Өөрөөр хэлбэл, газар нутагтай холбогдолтой асуудлаар

бодлогын түвшинд асуудал шийдвэрлэх шаардлагатай бол оршин суугчидтай зайлшгүй зөвшилцөх асуудлыг эрх зүйн хүрээнд хуульчилсан.

Төсөв санхүүгийн бүрэн эрх: Нутгийн өөрийн удирдлага нь орон нутгийнхаа нийгэм, эдийн засгийн асуудлыг бие даан шийдвэрлэх шаардлагыг хангахын тулд төсөв, санхүүгийн хувьд бие даасан байх учиртай.

Хүний нөөцийн бүрэн эрх: Орон нутагт хүний нөөцийн асуудлаа өөрсдөө шийдвэрлэдэг байх нь ажил, үйлчилгээний үр дүнг сайжруулах, хариуцлагыг өндөржүүлэхэд хүний нөөцийн асуудлаа өөрсдөө шийдвэрлэх нөхцөл болдог.

Зохион байгуулалтын бүрэн эрх: Нутгийн өөрийн удирдлагын байгууллага бүтэц, зохион байгуулалтын асуудлаа өөрөө шийдвэрлэдэг байх нь уян хатан, цомхон, орон нутгийнхаа онцлогт тохирсон ажил, үйлчилгээ явуулахад ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

Орон нутагт мөрдөх эрх зүйн хэм хэмжээг тогтоох бүрэн эрх: Нутгийн өөрийн удирдлагын байгууллага орон нутагт тулгамдсан асуудлыг хараат бусаар, бие даан шийдвэрлэх нөхцөлийг хангах зорилгоор тухайн орон нутагт мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтооно.

Монгол Улсын Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлгийн 57-63 дугаар зүйлээр нутгийн өөрийн удирдлагатай холбогдуулан “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага” гэсэн тусгайлсан бүлэг оруулсан байна. Нутгийн өөрийн удирдлагын хуваарь, хамрах хүрээг 57 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд, аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана” гэж заасны дагуу нийслэл, 21 аймаг, 330 сум, 9 дүүрэг, 1558 баг, 160 хороо байгуулагдан ажиллаж байна.

“Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн” хэмээн ардчилал, иргэний нийгмийн харилцаанд чухал байр суурь эзэлдэг нутгийн өөрийн удирдлагыг тусгайлан авч үзсэн байна.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиар нутгийн удирдлагын тогтолцоо шинэчлэгдэн нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулан хэрэгжүүлэх тухай зааснаар нийгмийг бүхэлд нь удирдаж байсан төрийн төвлөрсөн удирдлагыг халж, нутгийн захиргааны байгууллагатай хослон ажиллах үүрэг бүхий нутгийн өөрөө удирдах байгууллага (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэдийн Нийтийн Хурал) байгуулагдсан. Эдгээр хурлууд нь иргэдийн ашиг сонирхлын асуудлыг бүхэлд нь хамарч, ардчилсан тогтолцооны суурь, иргэн төвтэй нийгмийн үндэс болж зохицуулагддаг байгууллага юм.

Орон нутгийн Хурлын Төлөөлөгч нь юуны өмнө тухайн нутгийн иргэдийг төлөөлөх үүрэгтэй. Орон нутгийн хэмжээний бодлого, шийдвэрт иргэдийн санаа бодлыг тусгах, тэдний эрх ашгийг хамгаалах ажлыг төлөөлж гүйцэтгэнэ. Хэдийгээр өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн дагуу төлөөлөгч нь Хуралд улс төрийн тодорхой намыг төлөөлөх боловч үндсэн үүрэг нь өөрийг нь сонгосон нутгийн иргэдийг төлөөлөх явдал билээ. Нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулан ажиллах тухай энэхүү заалтыг улам гүнзгийрүүлэн Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай

хуулийн наймдугаар зүйлийн 2-т “Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар” гэж тодорхойлсон байна.

6.3. Нутгийн захиргааны чиг үүрэг

Монгол улсад засаг захиргааны хуваарийн дагуу байгуулагдсан гурван шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж үйл ажиллагаа явуулдаг. Тэдгээр нэгжүүдэд орон нутаг нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлдэг гурван шатны а) аймаг, нийслэл; б) сум, дүүрэг; в) баг, хорооны засаг дарга байдаг.

Эхний хоёр шатны засаг даргыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн засаг даргыг Ерөнхий сайд, сум, дүүргийн засаг даргыг харьяалагдах аймаг, нийслэлийн засаг дарга томилдог. Баг, хорооны засаг даргыг баг, хорооны Иргэдийн Нийтийн хурлаас нэр дэвшүүлж, харьяалагдах сум, дүүргийн засаг дарга томилно.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нарт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх болон иргэдийнхээ үзэмж, санаачлага, хариуцлага дор бусдад олгогдоогүй, хуулиар хориглоогүй эрхийн хүрээнд ажиллан нутгийн захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг оногдуулсан. Засаг дарга нь нэг талаас Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, нөгөө талаас хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангуулах үйл ажиллагаа зохион байгуулна. Бүх шатны засаг даргын эрх үүргийг дараах байдлаар багцлан ойлгож болно. Үүнд:

- Тухайн засаг захиргааны хөгжлийг хангах эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого тодорхойлж, төсөв, төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэх;
- Тухайн засаг захиргаанд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад дэмжлэг үзүүлэх хүн амын нийтлэг үйлчилгээг хангах ажлыг зохион байгуулах;
- Газар нутгийн эзэмшил тогтоох, эдэлбэр газар олгох, байгалийн баялаг, ашигт малтмал ашиглах, олборлохтой холбогдсон асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;
- Иргэд хуульд заасан эрх үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;
- Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээг тухайн засаг захиргааны түвшинд зохион байгуулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Байгалийн гэнэтийн аюул, хүн малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, гал түймрээс эсэргүүцэх, улсын аюулгүй байдлыг хангахтай холбогдсон ажилд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх.

Орон нутагт нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг Засаг даргын Тамгын Газар хэрэгжүүлдэг. Монгол улсын Үндсэн хуулийн жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар мөн” “Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно” гэж заасан байна. Нутгийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоог тухайн орон нутгийн онцлог, хүн ам, нутаг дэвсгэрийн ялгавартай байдлыг харгалзан тогтоодог.

7. Төрийн алба

7.1. Төрийн алба, түүний ангилал

Төрийн алба (олон улсын нэр томъёогоор “civil service” буюу зарим тохиолдолд иргэний алба, нийтийн алба/үйлчилгээ гэж орчуулдаг) гэдгийг уламжлалт утгаар нь авч үзвэл, засгийн газрын (ардчилсан, дарангуйлагч, хаант, тоталитар дэглэмтэй байхаас үл хамаарч) тэргүүний удирдлага, хяналтын дор Засгийн газрын чиг үүргийг хэрэгжүүлдэг томилогдсон албан тушаалтнуудын байгууллага юм. \Удирдлагын академи. Төрийн албан хаагчдад зориулсан сургалтын материал: Төрийн албаны өөрчлөлт шинэчлэлийн тухай удиртгал хичээл. УБ., 2000. хуудас I-8\

Төрийн зорилт, чиг үүргийг Монгол улсын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэдэг. Төрийн алба нь төрийн зорилт, чиг үүргийн хүрээнд төрийн бодлого тодорхойлох, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага, албан хаагчдаас бүрдэнэ. Иймд төрийн алба нь тодорхой эрх үүрэг бүхий байгууллага, тэдгээрийн албан хаагчдаас бүрдсэн тогтолцоо юм. Тухайлбал, яам, агентлаг, дүүргийн Засаг даргын тамгын газар зэрэг нь төрийн албаны тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагууд болно. Төрийн албаны мөн чанар нь ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх явдал юм. Төрийн албан тушаалыг төрийн албаны тухай хуульд зааснаар дараах байдлаар ангилдаг.

Хүснэгт 1.3 Төрийн албаны ангилал, хамаарах албан тушаал

Ангилал	Хамаарах албан тушаал
Төрийн улс төрийн албан тушаал: Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах, мөн тэдгээрийн бүрэн эрхийнх нь хугацаанд өөрт нь үйлчлэх орон тооны дараахь албан тушаал хамаарна:	Монгол улсын Ерөнхийлөгч; Их Хурлын дарга; Монгол Улсын Ерөнхий сайд; Монгол Улсын Их Хурлын дэд дарга, гишүүн; Засгийн газрын гишүүн; Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга; дэд сайд; Ерөнхий сайдын зөвлөх; Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга; Ерөнхийлөгчийн зөвлөх; бүх шатны Засаг дарга болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч; улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал; Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал; Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, хот, тосгоны захирагчийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалтай адилтган үзнэ.
Төрийн захиргааны албан тушаал: Төрийн захиргааны албан тушаалд төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах чиг үүрэг бүхий дараах албан тушаал хамаарна:	Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, шүүх, Үндсэн хуулийн цэц, прокурорын байгууллагын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал; Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны албан тушаал; Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны, бүх шатны шүүхийн тамгын газар, судалгааны төв, бусад туслах нэгжийн болон зааснаас бусад Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хорооны ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал; Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал; Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал; яамны Төрийн нарийн бичгийн дарга, яам болон хуульд өөрөөр заагаагүй бол тохируулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийн удирдах болон гүйцэтгэх албан тушаал; Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн; Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал; хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх улсын төсвөөс санхүүждэг нутгийн захиргааны байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал; аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;


Төрийн тусгай албан тушаал: Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулах, нийгмийн хэв журмыг хамгаалахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор; Монголбанкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга; Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаал; Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, цагдаагийн төв байгууллагын дарга, Хилийн цэргийн удирдах газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, шүүхийн шинжилгээний байгууллагын дарга; дипломат албан тушаал; зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн; Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
Төрийн үйлчилгээний албан тушаал: Төрийн үйлчилгээний албан тушаалд төрийн суурь үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараах албан тушаал хамаарна:	Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал; боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг зэрэг улсын төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал; боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн яам, агентлагийн харьяа буюу дэргэд ажилладаг, улсын төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

Эх сурвалж: Төрийн албаны тухай хууль

Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэж үздэг. Төрийн албан хаагч Монгол улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; эх орон, ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах; харьяа дээд шатны албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх; төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх үүрэг хүлээдэг. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчид мэргэшсэн, чадварлаг, үнэнч шударга байх нь төрийн албаны чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх шалгуур болдог. 2013 оны байдлаар төрийн албанд 162769 хүн ажиллаж байгаа бөгөөд тэдгээрийн төрийн улс төрийн 2798 (1.71%), төрийн захиргааны 16179 (9.94%), төрийн тусгай 28773 (17.68%), төрийн үйлчилгээний 115019 (70.67%) албан хаагч байна.

Зураг.1.2 2013 оны төрийн албан хаагчдын тооллогын дүн (хувь)

Эх сурвалж: csc.gov.mn




Төрийн албан хаагчдын дийлэнхийг төрийн үйлчилгээний албан хаагчид бүрдүүлдэг. Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий албан хаагчдын тоо нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд энэ нь төрөөс боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилттой уялдаатайн дээр төрийн захиргааны байгууллагад туслах ажил, үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчид шинээр шаардагдаж байгаатай ямар нэг байдлаар холбоотой юм.

Төрийн албан хаагчдын тоо нэмэгдэх хандлагатай байгаад иргэд ихээхэн шүүмжлэлтэй ханддаг. Учир нь төрийн алба томрохын хэрээр хэт нүсэр бүтэцтэй болж, хүнд суртал нэмэгдэж байна гэж үзэх хэсэг бий. Нөгөө талаар төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээ, төрийн чиг үүрэг нэмэгдэхийн хэрээр төрийн байгууллага бүтэц, бүрэлдэхүүний хувьд тэлэх хандлага бусад улс орнуудад түгээмэл байдаг. Төрийн албан хаагчдын тооны өөрчлөлтийг доорх зургаас үзнэ үү.

Зураг 1.3.

Төрийн албан хаагчийн тооны өөрчлөлт



Эх сурвалж: csc.gov.mn

Төрийн албан хаагчдын тоог багасгаж төрийн албаны зардлыг бууруулах боломжтой гэж судлаачид үздэг. Нөгөө талаар төрийн үйлчилгээ иргэн бүрт тэгш, хүртээмжтэй хүргэх зорилтыг хангахын тулд төрийн албаны бүтэц, бүрэлдэхүүнийг өргөжүүлэх шаардлага мөн адил гарч байдаг. Хэдий тийм боловч төрийн зарим чиг үүргийг төрийн бус болон бизнесийн байгууллагаар гэрээлэн эсхүл шилжүүлэн гүйцэтгүүлэх замаар төрийн албаны нүсэр бүтцийг задлах, улмаар төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бий.

7.2. Төрийн албаны шинэчлэл

Дэлхийн улс орнуудын төрийн албаны ихэнхэд эрт цагт цэрэг дайны болон шашин сүм хийдийн удирдлагаас улбаалан орж ирсэн удирдлагын уламжлалт хэлбэр буюу бюрократ загвар давамгайлдаг. Төрийн албанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд энэхүү загвар байнга шинэчлэгдэж боловсронгуй болж байна. Монгол улсад шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш бий болсон төрийн алба мөн адил нийгэм-эдийн засаг-засаглалын өөрчлөлттэй уялдан шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаа билээ.

Төрийн албаны шинэчлэл нь сүүлийн хорь орчим жилийн хугацаанд Монгол улсын Засгийн газрын анхаарлын төвд байсаар ирсэн. Монгол улсад төрийн албаны шинэчлэл нь гурван үе шаттай хийгдсэн. **Нэгдүгээр үе шат (1990-1993):** Монгол улсын төрийн байгууллын бүтэц, тогтолцоог бүрдүүлж, үүнтэй холбогдсон эрх зүйн болон бодлогын хүрээ заагийг бий болгосон. Энэ хүрээнд дараах алхамууд хийгдсэн.

- Нам төвтэй улс төрийн тогтолцоог халж, төр төвтэй улс төрийн тогтолцоо бүрдүүлсэн;
- Шинэ Үндсэн хууль батлагдаж, түүнтэй нийцүүлэн төрийн институтуудын эрх зүйн зохицуулсан хуулиуд батлагдсан.
- Төрийн эрх мэдлийг тэнцвэржүүлж, хуваарилсан;

Хоёрдугаар үе шат (1993-2000): Төрийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх чадварлаг, мэргэшсэн төрийн албыг бүрдүүлэх. Энэ үе шатны гол алхамуудыг дурдвал:

- Засгийн газрын удирдлагын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн;
- Төрийн албаны хуулийг баталж, төрийн албаны эрх зүйн орчныг тодорхой болгосон;

Гуравдугаар үе шат (2000 оноос): Төрийн албаны үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн. Энэ хүрээнд дараах алхамууд хийгдэж байна.

- Засаглалын чадавхийг бэхжүүлэх;
- Төрийн байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх;
- Төрийн үйлчилгээний үр нөлөө, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг болно.

Төрийн албаны шинэчлэл нь үргэлжилж буй үйл явц юм. Учир нь төрийн албыг чадварлаг, хүнд сурталгүй, авилгаас ангид, үр дүнтэй, үр ашигтай болгох зорилт эдүгээ ч тавигдаж байна. Шинэчлэлийн Засгийн газар төрийн үйлчилгээний албыг нийтийн алба болгон өөрчлөн зохион байгуулах зорилт тавьж байгаа бөгөөд үүнтэй уялдуулан гадны улс орнуудын туршлагыг судлах ажил хийгдэж байна. Гэхдээ төрийн үйлчилгээний албаны нэрийг өөрчилж нийтийн алба болгохоор төрийн албаны шинэчлэл дуусгавар болохгүйн ойлгомжтой. Хамгийн гол нь төрөөс иргэдэд хүргэх нийтлэг үйлчилгээний чанар, хүртээмж, үр өгөөжийг нэмэгдүүлэх явдал нь төрийн албаны шинэчлэлээс хүлээгдэх үр дүн байх юм.

8. Улс төрийн нам, иргэний нийгэм

8.1. Улс төрийн намын чиг үүрэг

Улс төрийн нам бол улс төрийн харилцааны голлох институтийн нэг мөн. "Party" хэмээх үг нь латин гаралтай (pars) гэсэн үг бөгөөд хуваагдах, салах гэсэн утгатай. Тухайн үед ижил утга бүхий сект "sect" (латины secare - таслах, цавчих, хайчлах, хуваах "to sever, to cut, to divide") гэсэн үг мөн дээрх утгаар хэрэглэгдэж байжээ. XVI зуунаас улс төрийн эсрэг үзэл санаатай хүчин бий болж, хэлбэрших үед буюу нэг хүний гарт засаглал төвлөрч түүний эсрэг эрх мэдэл бүхий бүлгүүд нэгдэн гарч ирснээр тэдгээр бүлгүүдийг тусгайлан нэрлэх болсноор "party" гэдэг үг улс төрийн хэрэглээний эргэлтэд оржээ.

Нам судлаач Ж.Сартори улс төрийн намыг "Улс төрийн үзэл санаа, үзэл баримтлал, сонирхлоороо нэгдсэн хүмүүсийн бүлэг" \Sartori G. Parties and Party System. London. 1976. p.23\ гэж тодорхойлсон байна. Монгол улсын Улс төрийн намын тухай хуульд үүнтэй ижил агуулгаар намыг тодорхойлжээ. Тухайлбал, Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн нэгдүгээр зүйлд: "Нам нь Монгол улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол улсын иргэдийн нэгдэл мөн" гэжээ.

Орчин үеийн улс төрийн тогтолцоонд улс төрийн намуудын үүргийг тодорхой хүрээнд хязгаарлаж болох хэдий ч зарим тохиолдолд нийгмийн харилцааны бүхий л хүрээнд улс төрийн намын оролцоотой хэрэгжсэн үйл ажиллагаа, түүний шууд үр дүн, үр дагавар гарч байдаг. Улс төрийн намыг ашиг сонирхлын нэгтгэх суваг гэж үздэг. Улс төрийн нам ардчиллыг өргөжүүлэх, төрийн үйл ажиллагаанд иргэд, сонгогчдын төлөөллийг хангах үүргийг улс төрийн зохион байгуулалтаар дамжуулан хэрэгжүүлдэг нь улс төрийн практикт нэгэнт хүлээн зөвшөөрөгдөөд байна. Цаашлаад улс төрийн манлайлагчдыг бэлтгэх, хөгжүүлэх үүргийг нам хэрэгжүүлнэ. Өнөө цагт улс орны бодлогыг тодорхойлж, хүмүүсийг араасаа дагуулах авьяас чадвартай манлайлагчид (удирдагчид) улс төрийн нам дотор бэлтгэгдэж, сонгогдож, шилэгддэг улс төрийн соёл төлөвшиж байна.

Судлаачид олон талт ангиллыг санал болгосон байх хэдий ч намуудыг нийтлэг шинж чанараар нь дараах гурван бүлэг болгон ангилсан байна.

Элит нам (elite political party): Намын бодлого, үйл ажиллагааг намын элит (манлайлагчид)- үүд хөтөлж, чиглүүлдэг, үзэл суртал нь тодорхой бус, нийгмийн дээд хэсэгт суурилдаг, гишүүнчлэл нь итгэл үнэмшил гэхээсээ элит дагасан шинжтэй байдаг. \Довчин Ё (ред), Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2010, 328 дахь тал\ Улс төрийн аливаа сонирхол нийгмийн элит хэсгийн дунд илүү илэрдэг бөгөөд энэ нь яваандаа улс төрийн нам болон зохион байгуулагдах үндэс болжээ.

Олон түмний нам (mass political party): Нийгмийн бүлгийн ялгарал, давхраажилт хүчтэй явагдахын хэрээр нийгмийн тодорхой хэсгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн, улс төрийн намууд бий болсон. Нөгөө талаар бүх нийтийн сонгуулийн эрх нь олон түмний нам өргөжих хүчин зүйл болдог.

Өргөн хүрээний нам (Catch all political party): XX зууны хоёрдугаар хагаст олон намын тогтолцоо, түүнтэй уялдсан сонгуулийн тогтолцоо төлөвшиж, улмаар улс

төрийн нөхцөл байдалд нийцүүлэн хүн амын бүхий л хэсгийн дэмжлэгийг авах шаардлага улс төрийн намуудад тавигдсан. Нөгөө талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, харилцааны шинэ дэвшилтэт технологи нь улс төрийн намын лидерүүдэд нийгмийн бүхий л хүрээнд хүрч ажиллах бололцоо олгож, нам - олон нийтийн харилцааг хялбаршуулсан. Үүнийг өргөн хүрээний (бүхнийг шүүрэгч гэж ч орчуулж болох) нам гэж үздэг. Энэ төрлийн нам нь нийгмийн тодорхой бүлгийг төлөөлөх бус үндэсний эрх ашиг, сонирхлыг бүхэлд нь удирдлага болгох учиртай.

Эдгээрийн зэрэгцээ зохион байгуулалт, сонгуульд оролцож байгаа технологи, засгийн эрх барих үйл явцад оролцох хэлбэрийн шалгуур болгон намуудыг сонгогчдын таашаалд нийцэх зорилготой клиент (client), хөтөлбөрийг гол болгосон (programist), засгийн эрхийг хамтран барих замаар улс төрийн зорилгоо гүйцэлдүүлэх картел (cartel) нам гэж бүлэглэж болно. Гэхдээ эдгээрийн аль алины шинж чанарыг өөртөө шингээсэн улс төрийн намууд ч байна.

Монгол улсад дээд шүүхэд бүртгэлтэй 22 \Улсын Дээд Шүүхийн цахим хуудас (www.supremecourt.mn)-д тавигдсан албан ёсны мэдээллийг иш үндэс болгов\ улс төрийн нам байна. 2012 оны 10 сарын 23-ны өдөр 22 дахь улс төрийн нам (Монголын Консерватив Нам)-ыг Улсын Дээд Шүүх бүртгэжээ. Монгол улс олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрснөөр барууны болон зүүний чиг баримжаатай улс төрийн хүчнүүд шинээр бий болсон. Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, улс төрийн олон ургальч үзлийн үндсийг тавьж, нийгмийн харилцаанд төлөвшүүлэхэд улс төрийн намуудын үүрэг зайлшгүй байсан гэдэгтэй улс төр судлаачид санал нэгддэг.

Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг гол хоёр улс төрийн нам \МАН, АН\ үндэсний түвшинд зохион байгуулагдсан хатуу бүтцээрээ олон түмний намын хэв шинжийг илэрхийлдэг. Нөгөө талаар МАН, АН-ыг “кадрын”, “олон түмний”, “өргөн хүрээний” намын зарим хэв шинжийг агуулсан нам гэж үзэж болох юм. Учир нь энэ хоёр нам гишүүнчлэлд ач холбогдол өгөхийн зэрэгцээ нийгмийн бүхий л хүрээний дэмжлэгийг өөртөө татах мөрийн хөтөлбөр, үндэсний болон орон нутгийн түвшний зохион байгуулалт, хүний нөөц зэрэг шинж чанарыг хадгалж байна. Харин бусад намууд нь эрх зүйн хувьд нам байх шалгуурыг хангасан сонирхлын картел, кардын, хөтөлбөрт суурилсан, клейнт төвтэй намуудын хэв шинжийг илтгэдэг. Ихэнх улс төр судлаачид “Ардчиллын замаар хөгжиж буй улстай харьцуулахад улс төрийн хоёр голлох намын хүчтэй нөлөөлөл бүхий намын систем тогтож байгаа нь Монголын онцлог болж байна” \Монголын нийгмийн өөрчлөлт. Шинжлэх Ухааны Академи, Философи Социологи Эрхийн Хүрээлэн, Даш-Ёндон Б (ред), УБ., 2008, 269 дэх тал\ гэж үздэг.

8.2. Улс төрийн намын хөгжлийн хандлага

Улс төрийн намуудын уламжлалт хэв шинж өөрчлөгдөж байна. Учир нь намууд дан ганц тодорхой бүлгийн ашиг сонирхол, зарим тохиолдолд зөвхөн язгууртан, элитүүдийн хүсэл сонирхлын үр дүнд бий болж, түүнтэй уялдсан улс төрийн манлайлал хэрэгжүүлдэг байсан зохион байгуулалт, чиг үүрэгт зарчмын өөрчлөлт гарлаа. Нөгөө талаар дан ганц нийгмийн тодорхой анги, нийтлэг бүлгийн ашиг сонирхлыг төлөөлөх бус нийгмийг бүхэлд нь хамарсан улс төрийн бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх хандлага давамгайлж байна. Иймд өргөн хүрээний намын хэв шинж улс төрийн намуудын үзэл баримтлал, зохион байгуулалт, үйл ажиллагаанд эрчтэй нэвтэрч байгаа юм.

Өргөн хүрээний нам хөгжих нөхцөл аяндаа төлөвшсөн үзэгдэл бишээ. Харин үүний эсрэгээр дараах хоёр хүчин зүйл онцгой үүрэгтэй байсан гэж ойлгож болно. Үүнд: 1) Улс төрийн намууд сонгуульд ялалт байгуулж, засгийн эрхийг авах, нэг бол засгийн эрх барихад идэвхтэй оролцох сонирхол нь улс төрийн намууд олон нийтэд нээлттэй нам болоход түлхэц өгсөн. 2) Сонгогчид мөн адил өөрсдийгөө ямар нэг улс төрийн үзэл санаа, үзэл баримтлалын салшгүй хэсэг гэж абсолют (туйлын) байдлаар ойлгохоос татгалзаж, иргэд, өөрийнх нь ашиг сонирхол, ямар ч нөхцөлд, ямар ч улс төрийн намаар дамжиж хэрэгжих бололцоотой гэж ойлгох болсон явдал юм.

Монгол улсад 2008 оныг хүртэл УИХ-ын сонгууль мажоритар тогтолцоогоор явагдсан нь хоёр нам давамгайлсан улс төрийн намын тогтолцоо төлөвших нөхцөл болсон. Өөрөөр хэлбэл үндэсний түвшинд зохион байгуулагдан сонгуульд оролцох чадавхтай хоёр нам бий болсон юм. Сонгуулийн үр дүн ч мөн адил үүнийг баталж байна. Харин 2012 оны сонгуулийг холимог хэлбэрээр явуулсан нь УИХ-д улс төрийн гурав дахь хүчин өргөн төлөөлөлтэй болох нөхцөл болсон. Гэхдээ 2012 оны хавар өрнөсөн улс төрийн үйл явц улс төрийн гурав дахь нам улс төрд хүчтэй орж ирэхэд нөлөөлөх хүчин зүйл болсон байх ч талтай. Үүнийг цаашид өрнөх улс төрийн үйл явцад нарийн шинжилгээ хийсний үндсэн дээр тодорхойлох боломжтой.

Монголын улс төрийн гол хоёр нам хатуу гишүүнчлэлтэй, төрийн бус (сонирхлын бүлгүүд)-ийг өөртөө нэгтгэх, дэргэдээ байгуулах зохион байгуулалт хэрэгжүүлж байгаа нь тэднийг Скандинавын олон түмний намын хөгжлийн хэв шинжтэй адилгаж болохоор болгож байна. Үүний зэрэгцээ улс төрийн гол намуудад газар нутгийн тархалтын хэв шинж ажиглагдаж байна. Тухайлбал, улс төрийн намын тухай хуульд намуудын үйл ажиллагааны зарчмыг тодорхойлохдоо "Нам үйл ажиллагаагаа нутаг дэвсгэрийн зарчмаар явуулна", 13.6-д "нам энэ хуульд нийцүүлэн өөрийн онцлогт тохирсон зохион байгуулалтын бүтцийг төв, орон нутгийн түвшинд байгуулан ажиллуулна" гэж газар нутгийн тархалтыг шалгуур болгох зохион байгуулалтыг хатуу зааж өгчээ.

2008 онд улс төрийн гол хоёр хүчин сонгуулийн үр дүнгээс үл хамааран эвслийн засгийн газар байгуулсан. Энэ байдал нь бодлогоор нэгдэх картел намын шинжийг илэрхийлж байв. Гагцхүү түүнээс хойш өрнөсөн улс төрийн үйл явц нь намууд бодлогын картел бус ашиг сонирхлын картел үүсгэж байв. Учир нь бодлогын картелд улс төрийн намууд засгийн газрыг аль болох тогтвортой байлгахыг эрмэлздэг бол ашиг сонирхлын картелд улс төрийн хүчнүүд өөрт ашигтай улс төрийн нөхцөл байдал үүсэхэд эвслээс шууд гардаг. 2012 оны сонгуулийн өмнө ардчилсан нам эвслийн засгийн газраас гарсан үйлдэл нь үүний илрэл мөн.

Монголд сонгуулийн өмнөх жил, нэг бол сонгуулийн үр дүнгээс шалтгаалан шинээр нам байгуулах практик түгээмэл ажиглагддаг. Сонгуулийн өмнө шинээр байгуулагдаж байгаа намууд гол төлөв тодорхой элитүүдийг дагасан, нэг бол тэдний байгуулсан намууд байдаг тул элит намын хэв шинж улс төрийн гурав дахь хүчний дунд ажиглагдаж байна. Тухайн элит (лидер) улс төрийн үйл явцад идэвхтэй оролцохоо больсон нөхцөлд нам нь улс төрийн хувьд ач холбогдолгүй болох хандлага ажиглагддаг. Үүнийг гол нь улс төрийн намууд бүрэн төлөвшиж чадахгүй байгаатай холбож үзэх нь зүйтэй.

"Улс төрийн намууд өнөө хэр сайтар төлөвшин цэгцэрч амжаагүй, үүнээс болж намуудыг үнэлэх олон түмний үнэлэмж буурч, намууд ч засаглалын харилцаанд

хууль ёсны байр сууриа бүрэн олж авч чадахгүй байгаа нь намын системийн төлөвшлийн үйл явцад тодорхой байдлаар нөлөөлж байна” \Монголын нийгмийн өөрчлөлт. Шинжлэх Ухааны Академи, Философи Социологи эрхийн Хүрээлэн, УБ., 2008,269 дэх тал\ гэж нам судлаачид үздэг. Иймд намуудыг үнэлэх олон түмний үнэлэмж буурч, намууд ч засаглалын харилцаанд хууль ёсны байр сууриа бүрэн олж авч чадахгүй байгаа нь намуудын төлөвшлийг түргэтгэх улс төрийн бодит шаардлага байгааг харуулж байна.

8.3. Иргэний нийгмийн хөгжлийн хандлага

Иргэний нийгмийн тухай ойлголт эртний Грек, Ромд үүссэн бөгөөд Ромын хууль эрх зүйд “иргэний нийгэм” хэмээх ойлголтыг иргэний эрхийн субъектүүдийн нийлбэр гэсэн утгатай байжээ. Иргэний нийгэм үүсэж хөгжсөн тухайд хамжлагат ёсыг халсан дундад зууны үетэй холбон үздэг. Улмаар хөрөнгөтний ардчилсан хувьсгал гарч иргэний нийгмийн цөм болсон хүний эрх, эрх чөлөөний асуудал хурцаар тавигдаж ардчилсан үйл явц идэвхжин иргэний нийгмийн төлөвшил эрчимжсэн билээ. XX зууны эхэн үеэс “иргэний нийгэм”-ийн тухай асуудлыг төр, улс төрийн амьдралаас хамааралгүй орших хүмүүсийн харилцаа, үйл ажиллагааны талбар гэж ойлгох хандлага бий болжээ.

Энэ ч үүднээс иргэний нийгмийг соёлжсон, хувийн, өөрөөр хэлбэл, хувь хүмүүсийн эрх ашиг, сонирхлоо хэрэгжүүлэх хүрээ буюу төрийн зүгээс хүмүүсийн хувийн амьдрал, “иргэний хэрэгт” оролцох ёсгүй хүрээ гэж үздэг. Олон улсын байгууллагууд иргэний нийгмийг “...төр, зах зээл, гэр бүлээс хамаарахгүй хүрээ, орон зай...” гэх мэтээр тодорхойлсон нь бий. Иргэний нийгмийн зохион байгуулалт, иргэдийн эрх ашгаа хамгаалах зорилтын үүднээс ярих юм бол иргэний нийгмийн дараах үндсэн шинжүүдийг онцолдог. Иргэний нийгмийн байгууллагууд нь дараах хэлбэртэй байж болно. Үүнд: Нийтлэг бүлгүүд (сум, баг, хороо, дүүрэг), мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллагууд, хоршоод, түр зуурын сонирхлын бүлгүүд гэх мэт байдлаар ойлгож байлаа.

Авторитар дэглэмээс ардчилалд шилжиж байгаа улсуудад төрийн эрх мэдлийг хязгаарлан, иргэдийн эрх чөлөөг хангах нөхцөл нь иргэний нийгмийн хөгжилтэй холбогддог. Эрх мэдэл үүсэх цэг нь ард түмэн, иргэд болж байдаг. Иймд иргэний нийгмийн байгууллагууд ямар үүрэгтэй байх вэ гэдэг асуулт урган гарч байна. Иргэний нийгмийн байгууллагуудын нийгэмд гүйцэтгэх үүргийг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

- Нийгмийн бүлгүүдийн эрхийг хамгаалах;
- Олон талт ашиг сонирхлыг илэрхийлэх;
- Эвлэлдэн нэгдэж, тодорхой зохион байгуулалтад орох замаар эрх үүргээ хэрэгжүүлэх;
- Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;
- Нийгмийн хөгжил, амьдралын чанарын баталгаа болох;
- Төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

1990-ээд оноос ардчилсан өөрчлөлтийн эрчимтэй өрнөлтөөр Монгол улсад иргэний нийгмийн байгууллага, иргэдийн сайн дурын зарчмаар байгуулагдсан эвсэл холбоод байгуулагдах үйл явц өрнөж, улмаар 1990 онд Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль, 1992 онд Шинэ Үндсэн хууль батлагдсанаар иргэдийн ТББ байгуулах хууль эрх зүйн шинэ орчин бүрдэж эхэлсэн гэж үзэж болно.

Монгол улсын Үндсэн хуульд "...улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж..., эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно" хэмээн тунхаглаж, мөн хуулийн 14.2-т "хүнийг...үзэл бодлоор...ялгаварлан гадуурхаж үл болно", 16.10-д "нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй" хэмээн зааснаар Монголын нийгэмд иргэн хүн үзэл бодол, ашиг сонирхлоороо эвлэлдэн нэгдэх, иргэний нийгмийн бүрдэл хэсгүүд бий болон хөгжих улс төр, эрх зүйн суурь орчин баталгаажсан билээ.

1997 оны 1 сард "Төрийн бус байгууллагын тухай хууль"-ийг УИХ батлан гаргасан. Хууль батлахын өмнөхөн буюу 1996 оны эцсээр улсын хэмжээгээр явуулсан тоо бүртгэлээс үзэхэд манай улсад 770 төрийн бус байгууллага байгуулагдаад байв. Гэтэл шинэ хууль хэрэгжиж эхлэх хүртэл богино хугацаанд 100 гаруй төрийн бус байгууллагууд шинээр байгуулагдсан байна. Эдгээр нь үндсэн хуулиар тодорхойлсон эрх зүйн ерөнхий удирдамж болон бусад хууль тогтоомжуудад заасан хэм хэмжээг баримталж үйл ажиллагаа явуулж байсан боловч тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үүрэг эрс нэмэгдэж үйл ажиллагааных нь эрх зүйн үндсийг нарийвчлан тодорхойлох шаардлагын улмаас дээр дурьдсан төрийн бус байгууллагын тухай хууль батлагдсан байна. Монголд 2000 онд 1800 гаруй, 2005 оны 1-р улирлын байдлаар 4700 орчим, 2009 онд 7000 гаруй өдгөө 8000 (зарим эх сурвалжид 12000 гэж бий) ТББ байна.

Хүснэгт 1.4

Иргэний нийгмийн байгууллага 2005-2010 он

Хариуцлагын хэлбэр	2006	2008	2010
Төрийн бус байгууллага	5118	6858	8329

Эх сурвалж: Статистикийн эмхтгэл. УБ., 2008, Монгол улс дахь Хүний эрхийн төлөв байдлын тухай илтгэл. 2010. ХЭҮК

Монгол улсад иргэний нийгэм нь төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хяналт тавиад зогсохгүй төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой юм. Энэ чиглэлд олон санал санаачилга гарч байгаа хэдий ч одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн бус байгууллагын хуулийг өөрчлөн баталж, иргэний нийгмийн байгууллагуудын эрх зүйн орчин боловсронгуй болгох бодит шаардлага тавигдаж байгаа болно.

Ашигласан материал

Хууль

1. Монгол улсын Үндсэн хууль
2. Улсын Их Хурлын тухай хууль
3. Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай хууль
4. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
5. Монгол улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
6. Монгол улсын Засгийн газрын тухай хууль
7. Шүүхийн тухай хууль
8. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль
9. Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль
10. Төрийн албаны тухай хууль
11. Төрийн бус байгууллагын тухай хууль

Ном, өгүүлэл, нийтлэл

12. Даш-Ёндон Б(ред), Монголын нийгмийн өөрчлөлт. Шинжлэх Ухааны Академи, Философи Социологи Эрхийн Хүрээлэн, УБ., 2008,
13. Довчин Ё (ред), Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2010, 328 дахь тал
14. Ганбат Ч. Шинэ зуун ба шүүх. “Шүүх эрх мэдэл-шинэ зуун” олон улсын онол-практикийн бага хурлын (эмх). УБ., 2001
15. Зүльфикар С. “Пост-коммунист орнуудын төрийн тогтолцооны харьцуулалт”. Доктор (PhD)-ийн диссертаци. УБ., 2008
16. Очирбат П. Монгол улсын ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр. УБ., 2001
17. Лүндээжанцан Д, Өлзийсайхан Л. Парламент ёс. УБ., 2006. 270 дахь тал
18. Лүндээжанцан Д. Монгол улс дахь

төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2001

19. Чимид Б. Шүүх эрх мэдлийн талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд. “Шүүх эрх мэдэл-шинэ зуун” олон улсын онол-практикийн бага хурлын (эмх). УБ., 2001
20. Энхбаатар. Ч Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007. 202 дахь тал
21. Монгол улс дахь Хүний эрхийн төлөв байдлын тухай илтгэл. 2010. ХЭҮК
22. Ардын эрх сонин 1990 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр
23. Andrew Heywood. Key Concepts in Politics. Palgrave, New York 2001. p.214
24. Colin Hay, Michael Lister and David Marsh(ed). (2006) The State: Theories and issue
25. James W McAuley. An Introduction to Politics, State & Society. Sage Publication, London. 2003.
26. Klaus Van Beyme. Transition to Democracy in Eastern Europe. 1996 McMillan Press. p.56
27. W.Lawrence Neuman. (2005) Power, State, and Society: An Introduction to Political Sociology. McGraw Hill. New York
28. Sartori G. Parties and Party System. London. 1976
29. Rod Hague & Martin Harrop Comparative Government and Politics. 5th edition. Palgrave 2001

Цахим хуудас

30. www.supremecourt.mn
31. www.csc.gov.mn
32. www.parliament.mn
33. www.legalinfo.mn
34. www.open-government.mn
35. www.president.mn

Зохиогч



Саркыт Зүльфикар

(доктор, дэд профессор)

Удирдлагын академийн Улс төр судлал,
нийгмийн удирдлагын тэнхмийн эрхлэгч

Боловсрол

2008 Удирдлагын академи, төрийн захиргааны доктор

1998 Турк улсын Мимар Синаны Их Сургууль, социологч

Судалгааны чиглэл

- Харьцуулсан улс төр судлал
- Төрийн захиргаа
- Нийгмийн бодлого

Үндсэн ажлын туршлага

1998-2008	Удирдлагын академи (Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт)-д багш, ахлах багш
2009-2012	Удирдлагын академийн Нийгмийн удирдлагын тэнхмийн эрхлэгч
2012 оноос	Удирдлагын академийн Улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхмийн эрхлэгч

Бүтээл

Судалгааныхаа чиглэлийн хүрээнд олон тооны судалгааны ажил, өгүүлэл бичиж хэвлүүлсэн. Бүтээлийн дэлгэрэнгүй жагсаалтыг ФЭС-тай холбогдон авч болно.

Др. Дэд проф. БАТЧУЛУУНЫ АЛТАНЦЭЦЭГ**Хоёрдугаар бүлэг. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

1. Эдийн засгийн үндсэн ойлголт, зарчмууд
 - 1.1. Эдийн засгийн ухаан юу судалдаг вэ?
 - 1.2. Эдийн засгийн сэтгэлгээний зарчмууд
 - 1.3. Эдийн засгийн тогтолцоо, түүний төрөл
2. Зах зээлийн тогтолцоо
 - 2.1. Хэрэглэгчийн сонголт ба эрэлтийн хууль
 - 2.2. Үйлдвэрлэлийн зардал ба нийлүүлэлтийн хууль
 - 2.3. Зах зээлийн тэнцвэр
3. Эдийн засгийн бодлого
 - 3.1. Үнэ зохицуулалтын бодлого
 - 3.2. Татвар татаасын бодлого
4. Хөдөлмөрийн зах зээл
 - 4.1. Хөдөлмөрийн эрэлт
 - 4.2. Хөдөлмөрийн нийлүүлэлт
 - 4.3. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр
 - 4.4. Хөдөлмөрийн зах зээл ба үйлдвэрчний эвлэл
5. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл
 - 5.1. Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал
 - 5.2. Монгол Улсын хөдөлмөрийн бодлого

Ашигласан материал

Зохиогчийн тухай

Хоёрдугаар бүлэг. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Эдийн засгийн бодлогыг дотор нь микро түвшний бодлого ба макро түвшний бодлого гэж ангилж болно. Микро түвшний бодлого нь тухайн нэг зах зээл, эсвэл тодорхой бүлэг, хүрээг хамардаг. Жишээ нь, Монголд өнөөдөр хэрэгжиж буй махны үнийг тогтворжуулах, цалингийн доод түвшин тогтоох, ноос, ноолуур үйлдвэрлэгчдийг дэмжих бодлогууд микро түвшний бодлого хамаарна. Харин макро түвшний бодлого нь улсын эдийн засгийг бүхэлд нь хамардаг мөнгөний бодлого, төсвийн бодлого, татварын бодлого зэрэг багтдаг. Макро түвшний бодлогыг авч үзэхэд макро эдийн засгийн нэлээд өргөн мэдлэг хэрэгтэй бөгөөд энэ бүлэгт багтаах боломжгүй тул бид микро түвшний өргөн хэрэгждэг бодлогуудад гол анхаарлаа хандуулна. Энэ бүлэгт, өнөөгийн Монгол улсын эдийн засгийн тогтолцоог товч таницуулж, эдийн засгийн бодлогын шинжлэх үндэс болдог эдийн засгийн ухааны зарчмууд, ялангуяа, хоёр гол зах зээл болох бүтээгдэхүүний зах зээл болон хөдөлмөрийн зах зээл, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын тухай авч үзнэ.

1. Эдийн засгийн үндсэн ойлголт, зарчмууд

1.1. Эдийн засгийн ухаан юу судалдаг вэ?

Эдийн засгийн ухаан нь сонголтын тухай шинжлэх ухаан юм. Хувь хүний үйл хөдлөл, ялангуяа, хүн хэрхэн шийдвэр гаргадаг нь эдийн засгийн ухааны нэг гол судлагдахуун болдог. Мэдээж эдийн засаг бүхэлдээ хувь хүмүүсээс гадна компани, үйлдвэрчний эвлэл, засгийн газар, төрийн бус байгууллагууд зэрэг олон байгууллагуудаас бүрддэг боловч эдгээрийн аливаа шийдвэр гаргахад хувь хүмүүс шийдвэрлэх үүрэгтэй байдаг билээ.

Та шинэ хувцас, хувийн байшин, сайхан машинтай эсвэл хувийн онгоцтой болмоор байна уу? Хүн бүр л үүнийг хүсдэг шүү дээ. Хувь хүний хувьд та бидний хэрэгцээ хязгааргүй гэж хэлж болно. Харин хүн бүрийн хэрэгцээг бүрэн дүүрэн хангах боломж нь бүтээгдэхүүн болон нөөцийн ховор хомс байдлаар хязгаарлагдаж байдаг. Байгаль дээр байгаа бүтээгдэхүүн болон нөөцийн хэмжээ нь бидэнд хэрэгцээтэй хэмжээнээс бага байгааг ховор хомс байдал гэж нэрлэдэг. Тухайлбал, хичнээн их хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн ч түүнийг бид хүссэн хэмжээгээрээ чөлөөтэй, үнэ төлбөргүй хэрэглэх боломжгүй л бол түүнийг ховор хомс байна гэж үздэг. 2012 онд Монгол Улс 245935.0 тонн төмс хурааж авсан байна. Ийм их төмс хурааж авсан ч, энэ нь Монголын нийт төмсний хэрэгцээнээс бага буюу эдийн засгийн утгаар ховор хомс байгаа тул бид чөлөөтэй, үнэ төлбөргүй хэрэглэх боломжгүй байна. Иймд төмсний хэрэгцээгээ хангахын тулд Та зах зээл дээр худалдагдаж буй үнийг төлөх ёстой. Ингээд харахаар хүнс, хувцас, эд хогшил, боловсрол, үндэсний аюулгүй байдал, чөлөөт цаг гэх мэт нь эдийн засгийн утгаар бол цөм ховор хомс бүтээгдэхүүн болно.

Нэг талаас хүний хязгааргүй хэрэгцээ, нөгөө талаас байгаль, нийгэм дэх бүтээгдэхүүн нөөцийн хязгаарлагдмал байдал нь сонголт хийхийг шаарддаг. Боломжит хувилбаруудаас сонгох шаардлага нь бүтээгдэхүүн, нөөцийн ховор хомс байдлаас үүсдэг. Бид нэг хэрэгцээгээ хангахаар сонгосон бол нөгөө хэрэгцээгээ ямар нэг байдлаар хязгаарласан, эсвэл хойшлуулсан, эсвэл бүр татгалзсан гэсэн үг. Бидэнд ийнхүү тулгарч буй бүтээгдэхүүн, нөөцийн ховор хомс байдал, сонголт болон харилцан солилцох шаардлага нь эдийн засгийн шинжилгээний суурь болдог юм.

Эдийн засгийн нөөцүүд нь бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэхэд ашиглагддаг орцууд бөгөөд эдгээр нөөцүүд нь хязгаарлагдмал байдаг тул бүтээгдэхүүн, үйлчилгээ ховор хомс байдаг. Газар, байгалийн баялаг, машин, тоног төхөөрөмж, технологи, хөдөлмөр зэрэг нь хязгаарлагдмал нөөцийн жишээ юм. Нөөцийг дотор нь хүний нөөц, биет нөөц болон байгалийн нөөц гэж ангилж болно. Хүний нөөцөд хувь хүний мэдлэг, чадвар, авьяас, зэрэг ордог. Биет нөөц буюу капитал гэдэгт машин, тоног төхөөрөмж, барилга байгууламж зэрэг ордог ба байгалийн нөөц гэдэгт газар, гол ус, ашигт малтмал зэрэг багтдаг.

Ийнхүү ховор хомс байдал нь хуваарилалтыг шаардана. Өөрөөр хэлбэл, аль нэг бүтээгдэхүүн эсвэл нөөц ховор хомс байгаа бол түүнийг хэн нь авах, хэн нь авахгүйг тодорхойлох шалгуурууд хэрэгтэй болно. Энэхүү сонголтыг хэрхэн хийж буйгаас хамааран хүмүүсийн үйл хөдлөл өөрчлөгддөг. Тухайлбал, хэрэв нөөц болон бүтээгдэхүүний хуваарилалтыг төр хийдэг бол бүтээгдэхүүний хуваарилалтад тухайн хүний улс төрийн статус, болон улс төрийн үйл явцыг өөрчлөх чадвар чухал болно. Хүмүүс ховор хомс нөөц, бүтээгдэхүүнээс ахиухан хүртэхийн тулд төрийн эрх мэдэлтэн болох эсвэл эрх мэдэлтнүүдийг лоббидох, тэдэнтэй холбоо сүлбээ тогтооход өөрсдийн цаг болон хөрөнгө мөнгөө зарцуулах болно.

Хуваарилалтын өөр нэг арга нь дарааллын \очерийн\ арга буюу хэн түрүүлж ирсэнд нь бүтээгдэхүүнийг хуваарилах арга юм. Энэ тохиолдолд, хамгийн хурдан дарааллын эхэнд очдог, дугаарлан хүлээхэд цагаа зарцуулахад бэлэн хүмүүст бүтээгдэхүүн хуваарилагдана.

Харин зах зээлийн тогтолцоо нь бүтээгдэхүүн болон нөөцийг тухайн бүтээгдэхүүнийг авах хүсэлтэй бөгөөд зах зээлийн үнийг төлөхөд бэлэн байгаа хүмүүст хамгийн эхэнд хуваарилах бололцоотой.

Монгол Улс 1990 оноос өмнө социалист орон байсан бөгөөд энэ тогтолцооны үед эдийн засгийн төвлөрсөн төлөвлөлтийн зарчмыг хэрэгжүүлж, төр бараг бүхий л бүтээгдэхүүн, нөөцийн хуваарилдаг байв. Энэ үед бараа бүтээгдэхүүний үнэ, тариф, хүмүүсийн цалин, орлого жигд, тогтмол байсан ч бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, хүртээмж нь хангалтгүй, олдоц нь ховор байжээ. Тэр үед одоогийн өргөн хэрэглээний бараа болсон бохь, кока-кола, пицца, компьютер зэрэг олон нэр төрлийн бүтээгдэхүүн огт байсангүй. Өргөн хэрэглээний бүтээгдэхүүн болох мах, жимс хүртэл ховор, хүрэлцээ муутай байлаа. Тухайлбал, “Улаанбаатарт байгаа миний аав” гэж киноноос алим хэр ховор бүтээгдэхүүн байсныг харж болно. Энэхүү систем нь 70 орчим жил болоод нөөцийн үр ашиггүй хуваарилалтын улмаас оршин тогтох аргагүйд хүрч задарсныг бид мэдэж байгаа. Эдийн засгийн шилжилтийн эхэн үед өргөн хэрэглээний бүтээгдэхүүн улам ховордож талх, мах, гурил авахын тулд хүмүүс ажлын цагаар дэлгүүрт урт дараалалд зогсох, улмаар хоосон хонохдоо ч хүрч байлаа. Үүний улмаас төрөөс өргөн хэрэглээний зарим

бүтээгдэхүүнийг картаар хуваарилж байсан бөгөөд бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмж чадахгүй байв.

Өрсөлдөөн нь нөөцийн ховор хомс байдал болон хүмүүсийн амьдралын нөхцөлөө сайжруулах хүсэл сонирхлоос бий болдог. Ямар ч нийгмийн үед, аль ч эдийн засагт өрсөлдөөн байдаг нь жам ёс. Бүтээгдэхүүнийг үнээр хуваарилдаг ч бай, өөр аргаар хуваарилдаг ч бай өрсөлдөөн байсаар байдаг ба бүтээгдэхүүний хуваарилалтын аргаас хамаарч хүмүүсийн өрсөлдөөний техник, арга барил өөрчлөгддөг. Бүтээгдэхүүнийг хэн дугаарын эхэнд байгаад нь хуваарилдаг бол хүмүүс дугаарын хамгийн эхэнд зогсоход цагаа хуваарилах бөгөөд цаг хугацааг бүтээгдэхүүнээ хүлээн үр ашиг багатай зарцуулах болно. Хэрэв бүтээгдэхүүнийг төрөөс шууд хуваарилдаг бол хүмүүс улс төрд нөлөө олоход өөрсдийн цаг, нөөцөө зарцуулах болно. Бүтээгдэхүүнийг хуваарилах арга нь үнэ бол хүссэн бүтээгдэхүүнээ худалдан авах чадвараа сайжруулахын тулд хүмүүс орлоготой болох ёстой. Ингэж зах зээлийн хуваарилалт нь хүмүүсийг орлого бий болгох үйл ажиллагаа, тухайлбал, бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл явуулахыг нь дэмждэг.

Эдийн засгийн шинжилгээнд эдийн засгийн зарчмуудыг баримтлах ёстой. Эдийн засгийн шинжилгээ нь эдийн засгийн бодлого боловсруулах үндэс болдог. Иймд эдийн засгийн сэтгэлгээний үндсэн зарчмуудыг авч үзье.

1.2. Эдийн засгийн сэтгэлгээний зарчмууд

Ховор хомс нөөцийг ашиглахад зардал шаардлагатай. Нөөц зардлынхаа хэмжээнд аль нэг хэрэгцээг сонгосон бол нөгөө нэг хэрэгцээг ямар нэг хэмжээгээр золиослох хэрэгтэй болно. Сонголтын үр дүнд золиослогдох болсон хамгийн өндөр өртөгтэй алтернативыг алдагдсан боломжийн өртөг гэдэг. Тухайлбал, аймгийн төвд 1 тэрбум төгрөгийн стадион бариулсан гэж үзье. Гэтэл энэ хөрөнгийг эмнэлэг барих, сургууль барих, зам барих гээд өөр зүйл хийхэд зарцуулж болох байсан гэдгийг мартаж болохгүй. Өөрөөр хэлбэл, эдийн засагт үнэгүй хоол гэж байхгүй бөгөөд энэхүү ховор хомс нөөцөөр хийж болох байсан өөр сонголтууд золиослогддог.

Хувь хүмүүс зорилготойгоор сонголтоо хийдэг бөгөөд өөрсдийн хязгаарлагдмал нөөцийг хамгийн үр ашигтай зарцуулахыг хичээдэг. Тодорхой үр ашгийг байж болох хамгийн бага зардлаар хүртэхийг хэмнэх гэдэг. Хэмнэлт нь хувь хүмүүсийн зорилготой, ухаалаг шийдвэрийн үр дүн юм. Жишээлбэл, адилхан үр ашигтай хувилбаруудаас хүмүүс хамгийн бага зардалтайг нь буюу хамгийн хямдыг нь сонгодог.

Урамшууллыг ашиглан хүмүүсийн сонголтыг урьдаас тааварласан чиглэл рүү өөрчилж болно. Учир нь бусад хүчин зүйл тогтмол байхад, тухайн хувилбарыг сонгосноор хүртэх хувь хүний үр ашиг (зардал) өсвөл (буурвал) тэр сонголтыг хийх магадлал нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, урамшууллын механизм ажилладаг. Хэрэв бензиний үнэ өсөж, машины хэрэглээний зардлыг нэмэгдүүлбэл хүмүүс машин бага хэрэглэх шийдвэр гаргахад хүрэх жишээтэй.

Хувь хүн аливаа эдийн засгийн шийдвэр гаргахдаа тухайн сонголтоос хүртэх үр ашиг болон зардлын ялгааг л харьцуулдаг. Тухайлбал, үйлдвэрлэгчид нэмж нэг бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс орж ирэх орлого болон түүнийг үйлдвэрлэхэд гарах зардлыг харьцуулсны үндсэн дээр шийдвэр гаргадаг байна.

Мэдээлэл нь илүү сайн сонголт хийхэд тусалдаг боловч мэдээлэл олж авах нь өөрөө бас зардалтай. Мэдээлэл хайхад цаг хугацаа болон мөнгөн зардал гарна. Иймд хүмүүс мэдээлэл олж авахад хэмнэлт хийхийг хичээдэг. Жишээ нь, хүмүүс хувцас авахдаа дэлгүүрүүдээр орж сонголт хийхийн өмнө зурагтын рекламаас эхлээд хэрэгтэй мэдээлэл цуглуулна. Ингээд хэд хэдэн дэлгүүрээр орсны дараа цааш нь нэмж дэлгүүр орсноос хүртэх өгөөж бага гэж үзсэн үедээ л сонголтоо хийдэг.

Эдийн засгийн үйл явдал нь өөрийнхөө анхны нөлөөнөөс гадна тодорхой хугацааны дараа л мэдэгддэг хоёрдогч нөлөөнүүдийг бий болгоно. Анхны нөлөө нь голдуу шууд ажиглагддаг бол хоёрдогч нөлөө нь тодорхой хугацааны дараа илэрдэг бөгөөд заримдаа хэмжихэд хүндрэлтэй байдаг. Жишээ нь, оюутнуудад нийтээр нь тэтгэлэг өгөхийн шууд нөлөө нь олон хүн дээд боловсрол эзэмших сонголт хийхэд хүргэж болох шууд нөлөөтэй. Боловсролын зардалд ингэж нөлөөлснөөр хүмүүс дээд боловсрол эзэмших шийдвэрээ хайнга хийх, чанар муутай сургуулиудад элсэн суралцах зэрэг шийдвэр гаргаснаар боловсролын чанар муудах шууд бус нөлөөтэй байж болзошгүй юм.

Ямар нэгэн бүтээгдэхүүний өртөг нь субъектив бөгөөд хувь хүний таашаалаас хамааран өөр өөр байдаг. Жишээлбэл, Гамлет жүжгийн билетийг хүмүүс хэрхэн үнэлэх вэ? Зарим хүмүүс маш өндөр үнэ төлөхөд бэлэн байхад зарим хүмүүс үнэгүй байсан ч гэртээ үлдэхийг илүүд үзэж болно.

Эдийн засгийн онолын үр нөлөөний гол шалгуур нь түүний бодит амьдралын үйл явдлыг таамаглах, тайлбарлах чадвар юм. Тийм шалгуурыг эдийн засгийн ухаанд дор дурсан үндсэн чиглэлээр тодорхойлон авч үздэг.

Позитив болон норматив эдийн засаг. Позитив эдийн засаг нь эдийн засгийн харилцааг байгаагаар нь шинжлэх ухааны аргаар судлахыг хэлнэ. Позитив эдийн засгийн аливаа дүгнэлтийг үнэн эсвэл худал болохыг нь шууд нотлох боломжтой. Жишээ нь, мөнгөний нийлүүлэлт өсөхөд инфляц өсдөг гэсэн дүгнэлтийг бид амьдрал дээр амархан нотолж чадна. Харин норматив эдийн засаг нь эдийн засгийн аливаа асуудалд юу байх ёстой вэ гэдэг тухайд үнэлгээ бодол хийж, дүгнэлт өгдөг. Норматив дүгнэлт нь субъектив үнэлэмжийг харуулдаг бөгөөд үнэн худлыг нь батлах боломжгүй юм. Жишээ нь, инфляцийн түвшинг буулгах ёстой гэдэг нь норматив дүгнэлт болно, үнийг хэн ч барин тавин нотолж чадахгүй.

Худалдаа өртөг бий болгох нь. Аливаа арилжааны суурь нь харилцан ашиг хүртэх явдал мөн. Солилцоо нь бүтээгдэхүүнүүдийг тэдгээрийг илүү өндөр үнэлдэг хүмүүс рүү шилжүүлэх замаар өртөг бий болгодог. Шилжүүлгийн зардал нь эрэл хайгуул хийх, хэлцэл хийх, солилцоо хийхэд зарцуулсан цаг хугацаа, хүчин чармайлт болон бусад нөөцүүд юм. Шилжүүлгийн зардал нь боломжит худалдаанаас хожоо бий болгох чадварыг маань бууруулна. Зуучлагч \дундын хүн\ гэдэг нь худалдаж авч, зарж, эсвэл худалдааг зохион байгуулдаг хүн бөгөөд шилжүүлгийн зардлыг бас бууруулахад нөлөөлнө.

Өмчийн эрхийн ач холбогдол. Өмчийн эрх гэдэг нь ямар нэгэн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг хэрэглэх, хянах, үр ашиг хүртэх эрх юм. Хувийн өмчийн эрхүүд нь exclusive\ганцаар хэрэглэх эрх, дээрэмчдийн эсрэг хуулийн хамгаалалт, бусдад шилжүүлэх эрх зэргийг багтаана. Хувийн өмчтөн нь бусдын хүсэлд хүндэтгэлтэй хандаж, бусдад хамгийн өндөр үнэлэгддэг нөөцийг хэрэглэх, хөгжүүлэх эрмэлзэлтэй байдаг. Энэ нь худалдах болон түрээслүүлэх эрхийн хэрэгжилтээр

тодорхой харагддаг. Мөн хувийн өмчтөн нь өмчөө хайрлан хамгаалж, удирдахыг л юуны түрүүнд эрмэлзэнэ. Хувийн өмчийн эрхтэй үед хэрэв өмч нь бусдын өмчид халдах байдлаар хэрэглэгдсэн бол эзэн нь хариуцлага хүлээнэ. Харин нийтийн эзэмшлийн өмч нь ихэнхи тохиолдолд тааруухан арчилгаатай, хэтэрхий\хэт их үрэлгэн ашиглагддаг талтай.

Үйлдвэрлэлийн боломж. Хязгаарлагдмал нөөцтэй эдийн засаг нөөцөө хувцасны үйлдвэрлэл болон хүнсний үйлдвэрлэлийн хооронд хуваарилдаг гэж үзье. Эдийн засаг дахь нөөцийн хэмжээ өсвөл бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэх чадвар нэмэгдэнэ. Технологийн дэвшил нь эдийн засгийн үйлдвэрлэлийн боломжийг өргөтгөдөг. Эдийн засагт үйлчилдэг дүрэм, журам \хуулиуд, институтууд, бодлого\ сайн байвал үйлдвэрлэлийг өсөх боломж бүрдэнэ.

Худалдаа, үйлдвэрлэл, амьжиргааны түвшин. Хөдөлмөрийн хуваарь нь бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өөр өөр ажилчдаар гүйцэтгүүлдэг цуврал үйл ажиллагаануудад хуваадаг. Нарийн мэргэшил болон хөдөлмөрийн хуваарь нь дараах гурван шалтгаанаар үйлдвэрлэл өсөхөд нөлөөлнө. Үүнд:

- Нарийн мэргэшил нь хүмүүст өөрсөндөө байгаа чадварын давуу талаа ашиглах боломжийг нэмэгдүүлдэг.
- Нарийн мэргэшсэн ажилчид нь цаг хугацааны явцаар улам чадвартай болж хөгждөг.
- Хөдөлмөрийн хуваарь нь олноор-үйлдвэрлэх технологийг хөгжүүлэх боломж олгодог.

Харьцангуй давуу талын онолоор бүтээгдэхүүн бүрийг бага алдагдсан боломжийн өртөгтэй үйлдвэрлэгч, үйлдвэрлэвэл худалдааны түншүүдийн нийт үйлдвэрлэл нь хамтдаа хамгийн их байх магадлалтай.

1.3. Эдийн засгийн тогтолцоо, түүний төрөл

Эдийн засгийн үндсэн асуудлуудыг хэрхэн яаж, ямар аргаар шийдвэрлэж байгаагаас нь хамааруулан эдийн засгийн тогтолцоог төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо, уламжлалт эдийн засгийн тогтолцоо, зах зээлийн эдийн засгийн тогтолцоо гэж ангилдаг. Монгол Улс 1990 оны шилжилтээс өмнө цэвэр төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоотой байсан. Энэ тогтолцооны үед эдийн засгийн үндсэн асуудлуудыг төрөөс төвлөрсөн төлөвлөгөөгөөр дамжуулан шийдвэрлэж байсан. Тухайлбал, төрөөс 5, 15 жилийн хугацаатай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг байлаа. Энэ тогтолцоо 1990-ээд оноос задарч зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих үйл явц өрнөсөн билээ.

Эдийн засгийн тогтолцооны нэг төрөл бол уламжлалт эдийн засгийн тогтолцоо юм. Уламжлалт эдийн засгийн тогтолцооны үед эдийн засгийн үндсэн асуудлуудыг шийдвэрлэхдээ олон арван жилээр уламжилж ирсэн аргыг гол болгон хэрэглэдэг байна. Гэхдээ даяаршлын үйл явц эрчимтэй өрнөж буй өнөө үед ийм тогтолцоо дангаараа орших боломжгүй болжээ.

Эдийн засгийн тогтолцооны орчин үеийн хамгийн түгээмэл хэлбэр бол зах зээлийн эдийн засгийн тогтолцоо юм. Энэ тогтолцооны гол онцлог нь эдийн засгийн

үндсэн асуудлуудыг зах зээлийн аргаар шийдвэрлэж байдаг оршино. Практикт эдгээр тогтолцоо нь дангаараа биш, ихэнхдээ холимог хэлбэртэй байдаг. Монгол улс бол өнөөдөр хувийн өмчид суурилсан олон хэвшил бүхий зах зээлийн эдийн засгийн тогтолцоо хөгжиж буй орон юм.


2. Зах зээлийн тогтолцоо

2.1. Хэрэглэгчийн сонголт ба эрэлтийн хууль

Зах зээл нь олон сая хүмүүсийн эдийн засаг, санхүүгийн үйл хөдлөлийг үнэ, урамшууллаар дамжуулан зохицуулж байдаг. Таны очиж үйлчлүүлдэг хүнсний зах эсвэл супермаркетад Архангайн ааруул, Булганы айраг, Өвөрхангайн хоормог, Хэнтийн мэхээртэй тос, Төвийн сүү гээд л олон төрлийн бүтээгдэхүүн байдаг. Ийм олон нэр төрлийн бүтээгдэхүүнийг цаг тухайд нь нийлүүлж, бүтээгдэхүүн бүрийн эрэлт нийлүүлэлт нь хоорондоо тохирч илүүдэл, хомсдол бараг үүсдэггүй нь бүр ч гайхамшигтай. Үүнийг ямар ч төрийн оролцоо, бодлогогүйгээр зах зээл өөрөө зохицуулж байгаа.


Бүтээгдэхүүний үнэ бидний сонголтод нөлөөлнө. Ямар нэг бүтээгдэхүүний үнэ өсөхөд бид тэр бүтээгдэхүүнийг хэрэглэхийн тулд бусад олон бүтээгдэхүүнээс татгалзахад хүрдэг. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүний үнэ өсөхөд түүний хэрэглээний алдагдсан боломжийн өртөг нь нэмэгдэнэ. Эндээс үзвэл, аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний зардал нэмэгдэхэд тэдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалт буурах хандлагатай байна. Эрэлт нь хэрэглэгчид ямар хэмжээний үнээр хичнээн хэмжээний бүтээгдэхүүн худалдан авахад бэлэн байгааг харуулна.

Эрэлтийн хуулиар, тухайн бүтээгдэхүүний үнэ болон хэрэглэгчдийн худалдан авахыг хүсэж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ нь хоорондоо урвуу хамааралтай байдаг. Урвуу хамаарал гэдэг нь бүтээгдэхүүний үнэ өсвөл түүнийг худалдан



авах тоо хэмжээ буурна гэсэн үг. Үүнийг бид тухайн бүтээгдэхүүнтэй орлуулах бүтээгдэхүүнүүдээр тайлбарлах боломжтой. Бүтээгдэхүүний үнэ өсөхөд хэрэглэгчид түүнийг бусад бүтээгдэхүүнээр орлуулах хандлагатай байдаг. Тухайн бүтээгдэхүүний үнийн янз бүрийн түвшин ба түүнд харгалзах бүтээгдэхүүний эрэлтийн тоо хэмжээний хамаарлыг харуулсан муруйг эрэлтийн муруй гэдэг. Махны зах зээлийн эрэлтийг авч үзье. \Зураг 1\

Эрэлтийн муруйн хэлбэр нь эрэлтийн хуулийг дүрсэлж байна. Зургаас харахад бүтээгдэхүүний үнэ өсөхөд хэрэглэгчид махыг бага хэмжээгээр худалдаж авч байна. Эрэлтийн муруйн өндөр нь хэрэглэгчид нэмэлт нэгж бүтээгдэхүүн худалдаж авахын тулд төлөхөд бэлэн байгаа хамгийн өндөр үнийг харуулдаг. Эндээс эрэлтийн муруйн өндөр нь нэмэлт нэгж бүтээгдэхүүнийг хэрэглэгч хэр үнэлж байгааг дүрсэлж байна. Жишээ нь, махны хэрэглээ 5000 тонн байхад нэмэлт нэг кг




эрэлтийн муруй бүхлээрээ шилжилт хийдэг. Хэрэглэгчийн тоо өсвөл эрэлт өснө. Улаанбаатар хотод зун оюутны тоо цөөрөхөд интернетийн эрэлт буурна. Ингэснээр, 15000 төгрөгийн сарын төлбөрт харгалзах үйлчлүүлэгчдийн тоо 30000 болно. \Зураг 4\

Худалдан авагчийн орлого. Худалдан авагчийн орлого өсвөл тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ өөрчлөгдөөгүй байхад эрэлт өсөж, эрэлтийн муруй баруун гар тийш шилжинэ. Зураг 4-т дүрсэлснээр D1 эрэлтийн муруй (хөх) шилжиж D2 (ногоон) болж баруун гар тийш шилжинэ. Зах зээлийн үнэ хэвээрээ 15000 төгрөг байсан ч интернет хэрэглэгчдийн тоо өсч 70000 болж байна. Худалдан авагчийн орлого буурвал тухайн бүтээгдэхүүний эрэлт буурна.

Тухайн бүтээгдэхүүнтэй хослох бүтээгдэхүүн. Тухайн бүтээгдэхүүнтэй хослон хэрэглэгддэг бүтээгдэхүүнийг хослох бүтээгдэхүүн гэдэг. Жишээлбэл, нүдний шил, нүдний шилний хүрээ, машин бензин нь хосолж хэрэглэгддэг бүтээгдэхүүнүүд болно. Бусад хүчин зүйл тогтмол байсан ч гэсэн, тухайн бүтээгдэхүүнтэй хослох бүтээгдэхүүний үнэ буурвал тухайн бүтээгдэхүүний эрэлт өсөж, хослох бүтээгдэхүүний үнэ өсөхөд эрэлт нь буурдаг.


Зураг 5. Хослох бүтээгдэхүүн ба эрэлтийн өөрчлөлт



Зураг 5-д машин болон бензиний зах зээлийг харуулж байна. Машины зах зээлийн үнэ 5000000 төгрөг байхад эрэлтийн хэмжээ нь 500 ширхэг байна. Бензиний зах зээлийн үнэ 1500 төгрөгөөс 1800 төгрөг болж өссөн. Бензиний үнэ өсөхөд бензиний өөрийн эрэлтийн хэмжээ буурч байна. Машин бензин хоёр нь хосоороо хэрэглэгддэг бөгөөд бензиний үнэ өсөх нь машины хэрэглээний зардлыг өсгөх тул машины эрэлт бас буурна. Машины зах зээлийн үнэ 5000000 төгрөг байхад эрэлтийн хэмжээ буурч 450 болжээ. Зураг дээр D1 (хөх) эрэлтийн муруй зүүн тийш шилжиж D2 (улаан шаргал) болсон байна.

Тухайн бүтээгдэхүүнтэй орлох бүтээгдэхүүн. Орлох бүтээгдэхүүн гэдэг нь тухайн бүтээгдэхүүнтэй ижил зориулалттай бүтээгдэхүүн буюу өрсөлдөгч бүтээгдэхүүн юм. Тухайн бүтээгдэхүүний үнэ буурахад түүний эрэлтийн хэмжээ өсөж, харин тухайн бүтээгдэхүүнтэй орлох бүтээгдэхүүний эрэлт буурна. Харин тухайн бүтээгдэхүүний үнэ өсвөл өөрийнх нь эрэлт буурч, түүнтэй орлох бүтээгдэхүүний эрэлт өсдөг.

Зураг 6. Орлох бүтээгдэхүүн ба эрэлтийн өөрчлөлт



Жишээ нь, хонь, үхрийн мах нь харилцан орлох бүтээгдэхүүнүүд юм. Хонины махны зах зээлийн үнэ кг нь 7000 төгрөг бөгөөд зах зээлийн эрэлтийн хэмжээ нь 5000 тонн байна. Үхрийн махны зах зээлийн үнэ кг нь 8500 төгрөгөөс буурч 7500 төгрөг болжээ. Ингэснээр үхрийн махны эрэлтийн хэмжээ өснө. Түүнчлэн, зарим хэрэглэгчид хонины махны оронд үхрийн мах хэрэглэх бөгөөд хонины махны зах зээлийн үнэ кг нь 7000 төгрөг хэвээр байсан ч эрэлтийн хэмжээ нь 4500 тонн болж буурсан байна. Хонины махны эрэлтийн бууралтыг зураг 6-д эрэлтийн муруйн шилжилтээр дүрсэлж байна.


Үүнээс үзвэл, эрэлтийн муруй дээрхи цэгүүдийн шилжилт нь эрэлтийн муруй бүхлээрээ шилжилт хийхээс ялгаатай ойлголт юм. Эрэлтийн муруй дээрхи цэгүүдийн хөдөлгөөн нь тухайн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс хамаарч эрэлтийн тоо хэмжээнд өөрчлөлт орсныг харуулдаг бол үнээс бусад хүчин зүйлийн тухайлбал, орлого, таашаал сонирхол, хүлээлт, орлох хослох бүтээгдэхүүний үнэ зэрэг хүчин зүйлүүдийн өөрчлөлтийн нөлөөгөөр эрэлтийн муруй бүхлээрээ шилжилт хийж байна.

Хүлээлт. Эрэлтийн өөрчлөлтөд нөлөөлдөг өөр нэг хүчин зүйл бол хүмүүсийн ирээдүйн талаарх хүлээлт юм. Хүлээлт гэдэг нь хэрэглэгч эдийн засгийн үзүүлэлтүүдийн талаар өөрт байгаа мэдээлэлдээ үндэслэн ирээдүйн өөрчлөлтийн талаар таамаглал хийнэ гэсэн үг. Шигтгээ 1-д МУИС-ийн Эдийн засгийн сургуулиас хийдэг Хэрэглэгчийн итгэлийн индекс түүвэр судалгаанд оролцсон өрхүүдийн үнийн түвшний өсөлт буюу инфляцын талаарх хүлээлтийг дүрсэлсэн байна. Тухайлбал, 2012 оны 10 сард өрхүүд жилийн дараа буюу 2013 оны 10 сард инфляцын түвшин 9.3 хувь байна гэж таамаглаж байжээ.

Хүлээгдэж буй инфляци

Зураг А-д ХИИ судалгааны үнийн ерөнхий түвшин өснө гэж хүлээж байсан өрхүүдийн инфляцийн хүлээлтийг дундаж, дээд болон доод хязгаараар харуулж байна.

Зураг А.



2010, 2011, 2012 онд Улаанбаатар хотод инфляцийн түвшин 11.3, 12.6 болон 15 хувь байсан. Үүнээс үзэхэд хүлээгдэж буй инфляцийн түвшин бодит утгатай нилээд ойр байна.

Эх үүсвэр: Хэрэглэгчийн итгэлийн индекс түүвэр судалгааны тайлан, МУИС, ЭЗС, 2012 он

Хэрэв хэрэглэгчид бүтээгдэхүүний үнэ өснө гэж хүлээж байгаа бол хямд дээр нь боломжийн хирээр ахиухан авахаар шийдэх бөгөөд ингэснээр эрэлтийг өсгөнө. Жишээлбэл, ОХУ бензиний экспортын татварыг удахгүй нэмнэ гэсэн мэдээлэл тарвал хүмүүс удахгүй үнэ нь өснө гэж таамаглах бөгөөд хямд байгаа дээр нь нөөцлөхийг хичээж, бензиний эрэлт өснө. Иймэрхүү мэдээллийн дараа ШТС-ууд дээр урт дараалал үүсэх нь элбэг тохиолддог.


2.2. Үйлдвэрлэлийн зардал ба нийлүүлэлтийн хууль

Үйлдвэрлэгчид нь нөөцүүдийг худалдан авч тэдгээрээр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Нөөцийг нэг зориулалтаар ашиглах нь түүнийг өөр бусад зориулалтаар ашиглах боломжоос татгалзахад хүргэдэг бөгөөд энэ алдагдсан боломжийн зардлыг үйлдвэрлэгчид үүрдэг. Бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай нөөцүүдийг ашиглахад гарч байгаа үйлдвэрлэлийн зардлуудын нийлбэрийг үйлдвэрлэлийн алдагдсан боломжийн зардал гэдэг. Компаниуд өөрийн эзэмшдэг нөөцүүдийн алдагдсан боломжийн өртөг болон бусад нөөцийн зардлыг нөхөж чадахгүй бол үйл ажиллагаагаа зогсооход хүрнэ.

Эдийн засгийн зардал нь үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа бүх нөөцийн зардлыг оруулж тооцдог. Харин нягтлан бодох бүртгэлийн зардал нь компанийн өөрийнх нь эзэмшдэг нөөцийн алдагдсан боломжийн өртгийг зардалд оруулж тооцдоггүй. Нийлүүлэлт нь үнийн янз бүрийн түвшинд үйлдвэрлэгчид хэчнээн хэмжээний бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэхэд бэлэн байгааг харуулна. Нийлүүлэлтийн хуулиар, бүтээгдэхүүний үнэ болон түүний нийлүүлэлтийн хэмжээ нь хоорондоо эерэг хамааралтай байдаг. Бүтээгдэхүүний үнэ өсөхөд үйлдвэрлэгчид тухайн


бүтээгдэхүүнийг илүү их хэмжээгээр нийлүүлэхэд бэлэн байдаг. Тухайн бүтээгдэхүүний үнийн янз бүрийн түвшин ба түүнд харгалзах бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тоо хэмжээний хамаарлыг харуулсан муруйг эрэлтийн муруй гэдэг. Махны зах зээлийн нийлүүлэлтийг авч үзье.

Зураг 7-д махны нийлүүлэлтийн муруйг дүрсэлжээ.




Нийлүүлэлтийн муруйн хэлбэр нь нийлүүлэлтийн хуулийг дүрсэлж байна. Зургаас харахад бүтээгдэхүүний үнэ өсөхөд нийлүүлэгчид махны нийлүүлэлтийн хэмжээгээ нэмэгдүүлж байна. Бүтээгдэхүүний хэмжээ бүрт харгалзах нийлүүлэлтийн муруйн өндөр нь үйлдвэрлэгчдийн тухайн нэгжийг нийлүүлэхэд шаардах хамгийн бага үнийг харуулдаг. Эндээс нийлүүлэлтийн муруйн өндөр нь тухайн нэгж бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд гарах алдагдсан боломжийн зардлыг харуулна. Жишээ нь, 4000 тонн мах нийлүүлэхэд 6000 төгрөгийн үнэ шаардаж байгаа бол 6000 тонн мах нийлүүлэхэд 10000 төгрөгийн үнэ шаардаж байна. Нэг кг махны зах зээлийн үнэ нь 8000 төгрөг бөгөөд энэ үнээр үйлдвэрлэгчдийн нийлүүлэх махны хэмжээ нь 5000 тонн байна. Зах зээлийн үнийн энэ түвшинд 6000 дах тонн мах зах зээлд нийлүүлэгдэхгүй. Учир нь зах зээлийн үнэ 8000 төгрөг байгаа нь үүнийг нийлүүлэхэд гарах алдагдсан боломжийн зардлыг нөхөхөд хангалтгүй байна. Иймд үйлдвэрлэгчид нийлүүлэхгүй. Харин 4000 дах тонн мах зах зээлд нийлүүлэгдэнэ. Учир нь нэмэлт нэг кг мах нийлүүлэхэд гарах зардал нь зах зээлийн үнээс доогуур байна.

Үйлдвэрлэгчийн илүүдэл. Үйлдвэрлэгчийн илүүдэл нь нийлүүлэгчийн тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийн тулд шаардах байсан хамгийн бага үнэ ба бүтээгдэхүүнийг нийлүүлээд авсан зах зээлийн үнэ хоёрын зөрүү юм. Иймд нийлүүлэлтийн муруйгаас дээш, зах зээлийн үнээс доош орших талбайн хэмжээгээр үйлдвэрлэгчийн илүүдлийг хэмждэг. Зах зээлийн солилцоонд оролцсоноор үйлдвэрлэгчдийн авч буй хожоог үйлдвэрлэгчийн илүүдэл харуулдаг. Зах зээлийн үнэ өсөхийн хирээр тухайн зах зээл дэх үйлдвэрлэгчийн илүүдэл өсдөг.



Зураг 8-д зах зээлийн үнэ 8000 төгрөгөөс доош, нийлүүлэлтийн муруйгаас дээш орших талбай буюу үйлдвэрлэгчийн илүүдлийг улаан шаргалаар будсан байна. Зах зээлийн үнэ өсөхөд үйлдвэрлэгчийн илүүдэл өсдөг. Тухайлбал, махны зах зээлийн үнэ 10000 төгрөг болвол үйлдвэрлэгчийн илүүдэл цэнхрээр будсан талбайн хэмжээгээр нэмэгдэж байна.


Нийлүүлэлтийн өөрчлөлт. Өмнө жишээ авсан нэг компаний интернетийн үйлчилгээний төлбөр сарын 15000 төгрөг бол нийлүүлэлтийн муруй нь компаниудын нийлүүлэх интернетийн үйлчилгээний хэмжээ 50000 байхыг харуулж байна.



Харин интернетийн үйлчилгээний сарын төлбөр нь 10000 төгрөг болвол нийлүүлэлтийн хэмжээ нь 40000 болно. Тухайн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэмжээ үнээсээ хамааран өөрчлөгдөхийг нийлүүлэлтийн тоо хэмжээний өөрчлөлт гэдэг.

Технологийн дэвшил. Нийлүүлэлтэд бүтээгдэхүүний үнээс гадна олон хүчин зүйл нөлөөлдөг. Жишээ нь, технологийн дэвшил гарснаар интернетийн үйлчилгээ үзүүлэхэд гардаг алдагдсан боломжийн зардал буурвал нийлүүлэлт өснө. Зураг 9-д нийлүүлэлтийн муруй S_1 (хөх) байснаа S_2 (улаан) болж баруун тийш шилжсэн байна. Сарын төлбөр 15000 төгрөг байхад нийлүүлэлт нь 70000 болж өссөн байна. Нийлүүлэлт нь дараах хүчин зүйлсийн нөлөөгөөр өөрчлөгддөг. Нөөцийн үнийн өөрчлөлт, технологийн өөрчлөлт, байгалийн болон улс төрийн таагүй өөрчлөлт, татвар, татаасын өөрчлөлт зэрэг нь нийлүүлэлтийг өөрчилдөг. Нийлүүлэлтийн өөрчлөлтийг графикт нийлүүлэлтийн муруйн шилжилтээр дүрсэлж байна. Нийлүүлэлт өөрчлөгдөхөд нийлүүлэлтийн муруй бүхэлдээ баруун эсвэл зүүн тийш шилждэг.

Нөөцийн үнэ Нөөцийн үнэ өсөхөд үйлдвэрлэлийн зардал өснө. Тухайлбал,




хөдөлмөрийн нөөцийн үнэ болох цалин өсвөл нийлүүлэлтийн хэмжээ буурна. Үүнийг зураг 10-д нийлүүлэлтийн муруй S_1 (хөх) зүүн тийш шилжиж S_3 (ногоон) байна. Өмнө нь сарын төлбөр 15000 байхад интернетийн үйлчилгээний нийлүүлэлт 50000 байсан бол төлбөр хэвээрээ байхад нийлүүлэлт 30000 болж буурсан байна.

Байгалийн болон улс төрийн таагүй өөрчлөлт нь нийлүүлэлтэд олон талын нөлөө үзүүлдэг. Тухайлбал, зудын гамшгаас болж малын тоо цөөрвөл махны нийлүүлэлт буурна. Татварын тоо, хэмжээ нэмэгдвэл, үйлдвэрлэгчдийн татварын дараах орлого буурах тул нийлүүлэлт буурдаг. Харин үйлдвэрлэгчдэд олгох татаас, бусад төрлийн санхүүгийн дэмжлэг өсвөл нийлүүлэлт өснө. Татвар, татаасын бодлогын талаар энэ бүлгийн дараагийн хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

2.3. Зах зээлийн тэнцвэр


Зах зээлийн тэнцвэр гэдэг нь нэгэнт хүрсэн бол тэр хэмжээндээ үргэлжлүүлэн байх хандлагыг илэрхийлсэн зах зээлийн нөхцөл юм. Тэнцвэр нь зах зээлийн нөлөөлөх хүчнүүд хоорондоо тэнцвэржсэний үр дүн юм. Өмнөх хэсэгт бид зах зээлийн үнэд харгалзах эрэлтийн хэмжээ, нийлүүлэлтийн хэмжээний тухай ярьсан. Энэ хэсэгт бид зах зээлийн үнэ буюу зах зээлийн тэнцвэрийн үнэ хэрхэн тогтдогийг авч үзнэ. Хэрэглэгчид болон үйлдвэрлэгчид бие биенээсээ хамааралгүйгээр тус тусдаа шийдвэрээ гаргадаг бөгөөд зах зээл тэдний сонголтыг зохицуулж, үйл ажиллагаанд нь нөлөөлдөг. Зах зээл нь нарийн болон өргөн хүрээтэй байж болно. Нарийн хүрээтэй зах зээлийн жишээ нь алтан тариан дээд гурилын зах зээл бол өргөн хүрээтэй зах зээлийн жишээ нь бүх хэрэглээний бүтээгдэхүүнийг агуулсан зах зээл болно. Эрэлт, нийлүүлэлтийн эсрэг тэсрэг хүч тэнцвэртэй байхыг зах зээлийн тэнцвэр гэдэг.

Зах зээл тэнцвэртэй байхад нийлүүлэлтийн тоо хэмжээ нь эрэлтийн тоо хэмжээтэй тэнцүү байдаг бөгөөд ийм нөхцөлд хэрэглэгч, үйлдвэрлэгч хоёулаа сонголтоо хэрэгжүүлэх боломжтой юм. Бүтээгдэхүүний үнэ өсөхөд хэрэглэгчдийн эрэлтийн хэмжээ буурах ба харин үйлдвэрлэгчдийн нийлүүлэлтийн хэмжээ өснө. Бүтээгдэхүүний зах зээлийн үнэ нь хэрэглэгчийн эрэлтийн хэмжээг үйлдвэрлэгчийн нийлүүлэлтийн хэмжээтэй тэнцвэржүүлэх чиглэлд өөрчлөгдөж байдаг. Хэрэв хэрэглэгчийн эрэлтийн хэмжээ нь нийлүүлэлтийн хэмжээнээс их байвал үнэ өснө. Харин хэрэглэгчийн эрэлтийн хэмжээ нь нийлүүлэлтийн хэмжээнээс бага байвал зах зээлийн үнэ буурна. Зах зээл тэнцвэрт ортол үнэ зохицуулна. Зах зээлийн эрэлтийн хэмжээг нийлүүлэлтийн хэмжээтэй тэнцүү байлгадаг үнийг зах зээлийн тэнцвэрийн үнэ гэнэ. Үүнийг зураг 11-т үзүүлэв.



Жишээ нь, махны зах зээлийн үнэ кг нь 10000 төгрөг байхад эрэлтийн хэмжээ 4000 тонн бөгөөд нийлүүлэлтийн хэмжээ нь 6000 тонн байна. Эрэлтийн хэмжээнээс нийлүүлэлтийн хэмжээ их байгаа нь зах зээл дээр илүүдэл бий болгоно. Үйлдвэрлэгчид энэ илүүдэл бүтээгдэхүүнээ борлуулахын тулд үнээ бууруулах бөгөөд энэ процесс зах зээлийн илүүдэл алга болж тэнцвэр тогтох


хүртэл үргэлжилнэ. Харин махны зах зээлийн үнэ кг нь 6000 төгрөг байвал энэ хямд үнийн түвшинд эрэлтийн хэмжээ 6000 тонн байна. Харин үйлдвэрлэгчдийн



хувьд энэ үнээр 4000 тонн мах л нийлүүлнэ. Энэ нь зах зээл дээр махны хомсдол бий болгодог. Зарим хэрэглэгчид мах худалдан авч чадахгүйд хүрэх бөгөөд тэд мах авахын тулд арай өндөр үнэ төлөхөд бэлэн байна. Ингэснээр махны үнэ өсөх ба энэ үйл явц зах зээл тэнцвэрт орох хүртэл үргэлжилнэ. Зах зээлийн тэнцвэрт үнэ болох 8000 төгрөгийн үнээр хэрэглэгчдийн эрэлтийн хэмжээ нь 5000 тонн ба үйлдвэрлэгчдийн нийлүүлэлтийн хэмжээ нь 5000 тонн байна.

Эрэлт, нийлүүлэлт бусад хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдвөл зах зээлийн үнэ түүнд зохицон өөрчлөгдөж шинэ тэнцвэрт хүрнэ. Жишээ нь, Зураг 12-т үзүүлснээр, хэрэглэгчдийн орлого өссөнөөр махны эрэлт өсвөл хуучин зах зээлийн тэнцвэрт үнэ 8000 төгрөгийн хувьд махны эрэлтийн хэмжээ 7000 тонн болно. Харин энэ үнийн түвшинд нийлүүлэлтийн хэмжээ 5000 тонн хэвээр байна. Зах зээл дээр эрэлт өссөнөөс үүдэн хомсдол бий болж энэ нь зах зээлийн үнийг өсгөнө. Энэ үйл явц шинэ тэнцвэр тогтох хүртэл буюу махны үнэ 10000 төгрөг болох хүртэл үргэлжилнэ.

Нийгмийн нийт хожоо. Үйлдвэрлэгчийн илүүдэл болон хэрэглэгчийн илүүдлийн нийлбэрээр нийгмийн нийт хожоо хэмжигддэг. Нийгмийн нийт хожоо бол



үйлдвэлэгч болон хэрэглэгчийн аль алинд нь хохирол учруулахгүйгээр нийгэмд баялаг бүтээгдэж, ингэснээр нийгэм бүхэлдээ хожоотой байх тухай ойлголт юм. Зураг 13-т цэнхэр болон ногоон гурвалжны талбайгаар нийгмийн нийт хожоо хэмжигдэнэ. Зах зээлийн үнэ өөрчлөгдөх тохиолдол болгонд үйлдвэрлэгч хэрэглэгчийн хожоонд өөрчлөлт орно. Үүнийг дагалдаж, нийт нийгмийн хожоо ч бас өөрчлөгдөх нь ойлгомжтой.


3. Эдийн засгийн бодлого

3.1. Үнийн зохицуулалтын бодлого

Хэрэглэгчид бүтээгдэхүүний үнэ дэндүү өндөр байна, ард түмний амьжиргаа үүнээс болж доройтож байна гэж гомдоллох нь элбэг байдаг бол нийлүүлэгчид үнэ дэндүү доогуур байна, үндэсний үйлдвэрлэл хөгжихгүй байна гэж үздэг.


Зах зээлийн зохицуулалтад сэтгэл дундуур байгаа нийгмийн янз бүрийн бүлэг засгийн газарт нөлөөлөн зах зээлд үнийн зохицуулалт хийлгэж болно. Үнийн зохицуулалтыг засгийн газраас үнийн дээд эсвэл доод түвшин тогтоох бодлогоор дамжуулан хийдэг.

Үнийн дээд түвшин тогтоох бодлого. Засгийн газраас бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үнийг заасан түвшнээс өндөр тогтоохыг хориглосон зохицуулалт хийхийг үнийн дээд түвшин тогтоох бодлого гэдэг.



Үнийн дээд түвшинг зах зээлийн үнээс дээгүүр тогтоосон тохиолдолд зах зээлийн үнэд нөлөөлөхгүй. Доогуур тогтоовол нөлөөлдөг байна. Зураг 14-д үнийн дээд түвшин тогтоох бодлого, түүний нөлөөг харуулж байна. Жишээ нь: Талхны зах зээлийн үнэ нь 1200 төгрөг ба тэнцвэрт эрэлтийн хэмжээ ба нийлүүлэлтийн хэмжээ нь 50000 ширхэг байсан. Засгийн газраас талхны зах зээлд үнийн дээд түвшин тогтоох зохицуулалт хийсэн гэж үзье. Уг зохицуулалтаар талхны үнийг 900 төгрөгөөс хэтрүүлж тогтоож болохгүй. Энэ тохиолдолд, үнийн ийм доогуур түвшинд хэрэглэгчдийн талхны эрэлтийн хэмжээ өсч 50000 ширхэг байснаа 60000 ширхэг болов. Харин талх үйлдвэрлэгчдийн хувьд ийм доогуур үнээр нийлүүлэх хэмжээ нь 50000 байснаа буурч 40000 болох ба борлуулалтын хэмжээ нь 40000 болно. Талхны зах зээл дээр 20000 ширхэг талхтай тэнцүү хэмжээний хомсдол үүсч байна. Ийм бодлогын шууд нөлөө нь зах зээл дээрх бүтээгдэхүүний хомсдол юм. Үнийг дээд түвшингээр хязгаарласан тул уг хомсдлыг зах зээл өөрөө шийдэх боломжгүй бөгөөд бүтээгдэхүүний хуваарилалтыг зах зээлийн бус өөр аргаар шийдвэрлэнэ. Магадгүй очерийн аргаар шийдвэрлэх, эсвэл танил талдаа түрүүлж хуваарилах гэх зэрэг аргаар хуваарилагдаж болно.


Зах зээл дээр ямар нэгэн үнийн зохицуулалт байхгүй үед нийгмийн хожоо Зураг 13-т дүрсэлсэн талбайгаар хэмжигдэж байсан. Харин үнийн дээд түвшин тогтоосноор нийгмийн нийт хожоо Зураг 146-ийн шар өнгөөр будсан талбайгаар хэмжигдэж байна. Зах зээлд үнийн зохицуулалт хийснээр борлуулалт 40000 болж бууран нийгмийн хожоо бас буурч, хуваарилалтын үр ашиг муудсан байна.



Практикт, үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний чанарыг тогтмол байлгаад үнийг өсгөж болно, эсвэл бүтээгдэхүүний чанарыг бууруулаад үнийг тогтмол байлгаж болно. Жишээ нь, нэг ширхэг талхны үнэ 900 төгрөгөөс өндөр байж болохгүй гэсэн зохицуулалтад талхны жинг өмнөхөөс нь арай багасгаад нийлүүлж болзошгүй. Иймд ийм бодлогын шууд бус нөлөө нь бүтээгдэхүүний чанар муудах байж болно.

Үнийн доод түвшин тогтоох бодлого.

Засгийн газраас бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үнийг заасан түвшнээс доогуур



тогтоохыг хориглосон зохицуулалт хийхийг үнийн доод түвшин тогтоох бодлого гэдэг. Үнийн доод түвшинг зах зээлийн үнээс доогуур тогтоосон тохиолдолд зах зээлийн үнэд нөлөөлөхгүй. Харин зах зээлийн үнээс дээгүүр тогтоовол нөлөөлнө. Зураг 15-д үнийн доод түвшин тогтоох бодлого, түүний нөлөөг харуулж байна. Үнийн дээд түвшин тогтоох нь хэрэглэгчдийн сонирхолд нийцэж байдаг бол үнийн доод түвшин нь үйлдвэрлэгчдийн сонирхолд нийцэж байдаг.


Жишээ нь: Үр тарианы зах зээлийн үнэ нэг тонн нь 250000 төгрөг ба тэнцвэрт эрэлтийн хэмжээ ба нийлүүлэлтийн хэмжээ нь 90000 тонн байсан. Засгийн газраас үр тарианы зах зээлд үнийн доод түвшин тогтоох зохицуулалт хийсэн бөгөөд уг зохицуулалтаар үр тарианы үнийг 300000 төгрөгөөс доогуур тогтоож болохгүй гэж үзье. Энэ тохиолдолд, үнийн ийм дээгүүр түвшинд тариалангийн компаниудын үр тарианы нийлүүлэлтийн хэмжээ өсөж 90000 тонн байснаа 110000 тонн болов. Харин гурил үйлдвэрлэгчдийн хувьд ийм өндөр үнэд харгалзах эрэлтийн хэмжээ нь 90000 байснаа буурч 70000 тонн болно. Үр тарианы зах зээл дээр 30000 тонн үр тариа борлогдохгүй бөгөөд илүүдэл үүсэж байна. Ийм бодлогын шууд нөлөө нь зах зээл дээрх бүтээгдэхүүний илүүдэл юм. Үнийг доод түвшингээр хязгаарлаагүй бол зах зээлийн үнэ буурснаар уг илүүдлийг арилгах боломжтой. Зарим компаниуд үнийн ийм өндөр түвшинд хүрэхүйцээр бүтээгдэхүүнийхээ чанар эсвэл дагалдах үйлчилгээгээ сайжруулж болно, харин зарим нь бүтээгдэхүүнээ борлуулж чадахгүйд хүрнэ.

Үнийн доод түвшин тогтоох бодлогын нэг өргөн хэрэглэгддэг төрөл нь хөдөлмөрийн зах зээл дээр цалингийн доод түвшин тогтоох бодлого юм. Энэ бодлогын тухай дараагийн хэсэгт авч үзнэ.

3.2. Татвар, татаасны бодлого

Татварын бодлого. Зах зээлийн тэнцвэрт үнэд засгийн газраас тухайн бүтээгдэхүүнд ногдуулж байгаа татвар нөлөөлдөг. Засгийн газраас татварыг үйлдвэрлэгчид эсвэл хэрэглэгчид төлөхөөр хуульчилж болно. Гэвч энэхүү татварын ачааллыг татвар төлөгч дангаараа үүрдэггүй.


Эдийн засагчдад татварын ачаалал хэрхэн хуваарилагдаж байгаа нь сонирхолтой байдаг. Зураг 16-д татварын бодлогын нөлөөг дүрсэлсэн байна. Татваргүй байх үед зах зээлийн тэнцвэрт үнэ 10000 төгрөг бөгөөд борлуулалтын хэмжээ 6000 байна. Засгийн газраас цамц үйлдвэрлэгчдийг бүтээгдэхүүн бүрт 1000 төгрөгийн татвар төлөхөөр хуульчилсан гэж үзье. Үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний үнэ дээр энэ татварыг нэмж зарна. Үүнийг нийлүүлэлтийн муруй зүүн тийш шилжиж байгаагаар харуулж байна.



Нийлүүлэлт буурснаар зах зээлийн тэнцвэрт үнэ өсөж нэгэнт буй болсон ба тэнцвэрийн хэмжээ бас буурна. Татварын ачаалал үйлдвэрлэгч, хэрэглэгчдэд хэрхэн хуваарилагдаж байгааг зургаас харъя. Цамцны зах зээлийн үнэ 10500 төгрөг болох бөгөөд зах зээл дээрх борлуулалтын хэмжээ бүүрч 5000 болсон байна. 1000 төгрөгийн хэмжээний татварын хувьд 10500 гэсэн үнээр худалдан авагч бүтээгдэхүүнийг худалдан авч байна. Татваргүй байсан бол 10000 төгрөгийн үнээр авах байсан учраас худалдан авагчдад нэгж бүтээгдэхүүн тутамд 500 төгрөг үйлдвэрлэгчдэд 500 төгрөгтэй тэнцэх татварын ачаалал ногдож байна.

Татаасны бодлого. Татаас нь үйлдвэрлэгчид эсвэл хэрэглэгчдэд засгийн газраас хийдэг мөнгөн төлбөр бөгөөд голдуу нэгж бүтээгдэхүүнд ногдуулдаг. Татаас нь хэрэглэгчдэд тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах боломжтой хямд болгох, эсвэл салбарын үйлдвэрлэгчдийн ашигт ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэгждэг. Жишээ нь, засгийн газраас бензиний үнийг хямдруулах зорилгоор 200 төгрөгийн татаас 1 литр бензинд ногдуулсан гэж үзье. Татаас ногдуулахаас өмнө зах зээл дээр бензиний үнэ 1500 төгрөг, бензиний борлуулалт 30000 литр байсан. Харин ийм бодлого хэрэгжсэний дараа бензиний эрэлт өсөх ба эрэлтийн муруй баруун тийш шилжинэ. Татаасны бодлогын үр дүнд зах зээлийн тэнцвэрийн үнэ 1600 төгрөг, борлуулалтын хэмжээ нь 31000 литр болно.

Татаасны бодлогын үр дүнд хэрэглэгчид бензинээ 1400 төгрөгөөр авах бөгөөд тэдний зардал 100 төгрөгөөр хямдарсан байна. Харин нийлүүлэгчдийн хувьд борлуулалт нь 1000 литрээр өсөх ба нэг литр бензинээ 100 төгрөгөөр илүү үнээр борлуулна. Энэ бодлого нь бензиний эрэлтийг өсгөж, үнийг 100 төгрөгөөр нэмэгдүүлснээр хэрэглэгчид болон үйлдвэрлэгчид үр ашгийг нь хагас хагасаар хүртэж байна.



4. Хөдөлмөрийн зах зээл

4.1. Хөдөлмөрийн эрэлт

Хөдөлмөрийн зах зээл дээр цалингийн төлөө хүмүүс бусдад болон компаниудад хэрэгтэй хөдөлмөрийн үйлчилгээг нийлүүлдэг. Бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэгчид нь хөдөлмөр, түүхий эд зэрэг нөөцүүд ашиглан үйлдвэрлэл явуулдаг. Хөдөлмөрийн нөөцийн эрэлт нь бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтээс бий болдог үүсмэл эрэлт юм. Хэрэглэгчдийн бүтээгдэхүүний эрэлтээс нөөцийн эрэлт бий болдог. Жишээ нь, дэлгүүрийн эзэн хэрэглэгчдэд үйлчилгээ нь эрэлттэй байдаг тул худалдагч авч ажиллуулдаг. Цалин нь хөдөлмөрийн нөөцийн үнэ юм. Хөдөлмөрийн эрэлтийн муруй нь янз бүрийн цалингийн түвшинд ашиглагдах хөдөлмөрийн нөөцийн тоо хэмжээг илэрхийлдэг. Зураг 17-д цалингийн түвшин өсөхөд хөдөлмөрийн эрэлтийн тоо хэмжээ буурч байгааг харуулж байна. Энэ нь хоёр шалтгаантай. Нэгдүгээрт, хэрэв хөдөлмөрийн нөөц үнэтэй болвол түүнийг арай хямд нөөцөөр орлуулдаг. Хоёрдугаарт, тухайн нөөц үнэтэй болох нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг үнэтэй болгодог бөгөөд хэрэглэгч түүнээс цөөхнийг худалдаж авдаг.

Компаниуд өөрсдийн зардлыг хамгийн бага байлгадаг нөөцийн хослолыг ашигладаг бөгөөд нэг нөөцийн үнэ өсөхөд түүний хэрэглээг түүнээс бага зардалтай нөөц орлуулдаг. Иймд бусад хүчин зүйл тогтмол байхад тухайн нөөцийг орлуулах боломжтой илүү сайн нөөц байвал нөөцийн эрэлтийн муруй нь илүү мэдрэмжтэй байдаг. Хэрэв нөөцийн үнэ өссөнөөр тухайн бүтээгдэхүүний үнэ өсвөл хэрэглэгчид түүнийг орлуулах бүтээгдэхүүнийг хэрэглэснээр тухайн бүтээгдэхүүнийг худалдан авах зардлаа бууруулдаг. Ингэснээр бага эрэлттэй болсон тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардагдах нөөцийн хэмжээ багасаж, эрэлт нь буурна. Жишээ нь, сүүний үйлдвэрийн ажилчид үйлдвэрчний эвлэлээрээ дамжуулан амжилттай хэлцэл хийн цалингаа нэлээд хэмжээгээр өсгөсөн байна. Цалингийн зардлын энэхүү өсөлт Монголын сүүний үйлдвэрийн зардлыг өсгөх ба энэ нь Монголд үйлдвэрлэсэн сүүний үнийг өсгөнө. Дотоодын сүүний үнэ өсөхөд олон хэрэглэгчид орлуулах бүтээгдэхүүн болох гадаадад үйлдвэрлэсэн сүү худалдаж авах ба энэ нь дотоодын сүүний борлуулалтыг бууруулж улмаар сүүний үйлдвэрлэгчдэд шаардлагатай ажилчдын тоо буурна.

Бусад хүчин зүйл тогтмол үед, тухайн бүтээгдэхүүний эрэлт мэдрэмжтэй бол түүний үйлдвэрлэхэд шаардлагатай нөөцийн эрэлт бас илүү мэдрэмжтэй байна. Энэ нь нөөцийн эрэлтийн үүсмэл шинж чанартай холбоотой юм. \ Амархан орлуулах боломжтой нөөц, бүтээгдэхүүн\ Нөөцийн эрэлтийн мэдрэмж нь үйлдвэрлэлд болон хэрэглээнд орлуулахад хэр хялбар байхаас хамаардаг байна. Нөөцийн эрэлтэд цаг хугацаа нөлөөлнө. Нөөцийн үнийн өөрчлөлтөд бүрэн зохицоход үйлдвэрлэгчдэд хугацаа шаардагддаг. Ер нь үйлдвэрлэгчид илүү үнэтэй нөөцийн хэрэглээг бууруулж, илүү хямд нөөцөөр орлуулах өөрчлөлтийг шууд тэр дор нь хийх боломжгүй байдаг.

Хэрэглэгчдийн хувьд ч гэсэн үнийн өөрчлөлтөд тохируулан хэрэглээгээ шууд зохицуулахад амаргүй байж болно. Жишээ нь, татварын улмаас тамхины үнэ өсөхөд тамхи татдаг хүмүүс шууд тамхины хэрэглээгээ бууруулах боломжгүй байж болно. Харин цаг хугацаа өнгөрөхийн хирээр олон олон хэрэглэгчид тамхины хэрэглээгээ бууруулна. Иймд цаг хугацаа өнгөрөхийн хирээр нөөцийн эрэлт улам


мэдрэмжтэй болдог.

Хөдөлмөрийн эрэлтэд нөлөөлдөг хүчин зүйлс. Тодорхой хүчин зүйлийн нөлөөгөөр хөдөлмөрийн эрэлтийн муруй бүхлээрээ шилждэг. Бүтээгдэхүүний эрэлт өөрчлөгдөхөд тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашиглагддаг нөөцийн эрэлт мөн өөрчлөгдөнө. Хэрэглээний бүтээгдэхүүний эрэлт өсвөл түүний үйлдвэрлэлд ашиглагддаг хөдөлмөрийн эрэлт өснө. Харин хэрэглээний бүтээгдэхүүний эрэлт буурвал түүний үйлдвэрлэлд ашиглагддаг хөдөлмөрийн эрэлт буурна.

Хөдөлмөрийн нөөцийн бүтээмж өөрчлөгдвөл түүний эрэлт өөрчлөгдөнө. Хөдөлмөрийн нөөцийн бүтээмж өсвөл нөөц илүү үнэ цэнэтэй болдог. Тухайлбал, ажилчдын үр чадвар нэмэгдэхэд тэдний бүтээмж өсөж, улмаар түүний эрэлт өсдөг. Түүнчлэн хөдөлмөрийн нөөцийн бүтээмж нь бусад хүчин зүйлийн хэмжээнээс хамаардаг. Нэмэлт тоног төхөөрөмж, капитал нь хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлдэг. Технологийн дэвшил нь нөөцийн бүтээмжийг бас сайжруулдаг. Жишээ нь, компьютер нь олон салбарт нөөцийн бүтээмжийг сайжруулах боломжийг бүрдүүлсэн байна.

Хөдөлмөрийн нөөцтэй холбоотой бусад нөөцийн үнэ өөрчлөгдөхөд хөдөлмөрийн нөөцийн эрэлт өөрчлөгддөг. Тухайн нөөцийн үнэ өсөхөд түүнийг орлодог нөөцийн эрэлт өснө. Харин хосолдог нөөцийн эрэлт буурна.


Хөдөлмөрийн эрэлт нь компаний орлогод тухайн ажилчны оруулж буй хувь нэмэр буюу түүний ахиу бүтээгдэхүүний орлогоос хамаардаг. Учир нь компани ажилчин нэмж авахдаа түүний бүтээх ахиу бүтээгдэхүүнтэй холбоотой орлогыг харах бөгөөд өрсөлдөөнт зах зээлд түүнд энэ орлоготой тэнцүү хэмжээний цалин олгодог. Хөдөлмөр гэсэн хүчин зүйлийн ахиу бүтээгдэхүүний орлогыг тодорхойлбол энэ нь хөдөлмөрийн ахиу бүтээгдэхүүнийг, ахиу орлогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Пүүсийн нэг ажилчинд ноогдох капитал хэдий чинээ их байх тутам хөдөлмөрийн ахиу бүтээгдэхүүний орлого өндөр байна.



4.2. Хөдөлмөрийн нийлүүлэлт


Хөдөлмөрийн эрэлтийн нэг адил хөдөлмөрийн нийлүүлэлт нь ажил эрхлэлтээс бий болох үр ашиг болон ажил эрхлэхэд гарах зардлаар тодорхойлогддог. Хүмүүс ажил эрхлэлтээс бий болох үр ашиг нь түүний зардлаас давсан нөхцөлд л зөвхөн хөдөлмөрөө нийлүүлнэ. Хэрэв ажил олгогч бусад ажил олгогчдын санал болгож буй цалин, урамшуулал болон ажлын байрны нөхцөлтэй дор хаяж адилхан санал тавьсан нөхцөлд ажилтан авч ажиллуулж чадна. Хүмүүс өөрт нь хамгийн сайн нөхцөл санал болгож байгаа ажил олгогчид л хөдөлмөрөө нийлүүлнэ. Бусад хүчин зүйл тогтмол үед, цалин өсөхөд хүмүүс хөдөлмөрийн нөөцөө нийлүүлэх сонирхол нэмэгдэнэ. Хувь хүний хөдөлмөрийн нийлүүлэлтийн сонголт нь чөлөөт цаг болон ажиллах цагийн хооронд хийгддэг сонголт юм. Чөлөөт цаг буюу зах зээлийн бус

үйл ажиллагаа гэдэгт унтах, сурах, тоглох, цэвэрлэгээ хийх, хар зах дээр арилжаа хийх зэрэг олон төрлийн үйл ажиллагаа багтаж болно. Чөлөөт цагаа сонгосноор тэр цагт ажиллаад олж болох байсан орлогоо алдана гэсэн үг. Хөдөлмөрийн зах зээл дээр хүмүүс тодорхой түвшний цалингаар тодорхой цаг ажиллах хүсэлтэй байгааг хөдөлмөрийн нийлүүлэлт илэрхийлнэ. Хөдөлмөрийн нийлүүлэлт нь цалингийн түвшнээс шууд хамааралтай. Цалин хэдий чинээ өндөр байх тутам ажиллах цагийн тоо буюу хөдөлмөрийн нийлүүлэлт нэмэгдэж, цалин буурах тутам хөдөлмөрийн нийлүүлэлт багасаж байдаг.




Цалин нэмэгдэхийн хирээр хөдөлмөрийн нийлүүлэлт өсөх ерөнхий хандлага байдаг ч гэсэн зарим тохиолдолд ажилтан цалингийн хангалттай өндөр түвшинд очмогц өөрийн чөлөө цагаа эрхэмлэдэг. Энэ тохиолдолд, хөдөлмөрийн нийлүүлэлтийн муруйн хэлбэр нь шулуун биш байна.

4.3. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр



Одоо хөдөлмөрийн зах зээл дээр тэнцвэр хэрхэн тогтохыг авч үзье. Бусад зах зээлийн нэг адил хөдөлмөрийн зах зээл дээр хөдөлмөрийн эрэлт, хөдөлмөрийн нийлүүлэлт харилцан үйлчилснээр тэнцвэр тогтдог. Цалин нь хөдөлмөрийн үнэ бөгөөд хөдөлмөрийн зах зээл дээр илүүдэл байвал буурч, хомсдол байвал өссөнөөр зах зээлийг тэнцвэржүүлдэг.

Түүнчлэн, хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлт өсөж, буурах нь зах зээлийн тэнцвэр өөрчлөгдөх нэг шалтгаан болдог. Хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлт өөрчлөгдсөнөөр



хөдөлмөрийн эрэлт нийлүүлэлтийн муруй баруун, зүүн гар тийш шилжинэ. Жишээлбэл, орон сууцны эрэлт өсвөл барилгын компаниудын хөдөлмөрийн эрэлт өснө (Зураг 20). Өмнө нь зах зээлийн тэнцвэрт цалин 300000 төгрөг байсан бөгөөд 6000 хүн ажиллаж байсан. Харин эрэлт өссөнөөр эрэлтийн хэмжээ 7000 болж өссөн. Гэвч энэ цалингийн түвшинд хөдөлмөрөө нийлүүлэх ажилчдын тоо 5000 хэвээр байна. Барилгын салбарт ажилтан

дутагдалтай болох бөгөөд компаниуд ажилтан олж авахын тулд цалингаа нэмэх болно. Ингэснээр зах зээл дээр шинэ тэнцвэрт цалингийн түвшин тогтоно.

Цалингийн ялгаа. Цалин ялгавартай байхад нөлөөлдөг гол хүчин зүйл бол мэдлэг боловсролын түвшин, мэргэжлийн өндөр ур чадвар, онцгой авъяас, хөдөлмөрийн нөхцөл зэргийг дурдаж болно.

Хөдөлмөрийг дотор нь энгийн хөдөлмөр нарийн чадвар шаарддаг хөдөлмөр гэж хувааж болно. Энгийн хөдөлмөр нь тусгай мэргэжил, ур чадвар шаардаад байхааргүй хөдөлмөрийн чадвартай хүн бүр хийж чадах хөдөлмөр юм. Мэргэжил дадлага бага шаарддаг хөдөлмөрийн эрэлт харьцангуй бага байдаг бөгөөд мэргэжил, ур чадваргүй ажилчдын цалин харьцангуй доогуур байдаг. Харин нарийн чадвар шаарддаг хөдөлмөр нь тусгай мэргэжил, ур чадвар шаарддаг бөгөөд ийм хөдөлмөрийн эрэлт өндөр байдаг. Мэргэжил ур чадвартай ажилчдын бүтээмж өндөр бөгөөд харьцангуй өндөр цалингаар ажилладаг.

Мэргэжил ба цалин

2012 онд, ямар нэгэн мэргэжил, мэргэжилтэй хүмүүс огт мэргэжилгүй хүмүүсээс 35 хувиар өндөр цалинтай байсан. Тухайлбал, 2012 онд ямар нэгэн мэргэжил эзэмшсэн хүмүүсийн сарын дундаж цалин 464000 төгрөг байсан бол огт мэргэжилгүй хүмүүсийнх 342900 төгрөг байсан байна. 2012 онд ажлын байрны ихэнхийг мэргэжил, мэргэжилтэй хүмүүс авсан байна. Тухайлбал, мэргэжилтэй гурван хүн тутмын хоёр нь ажилтай байхад мэргэжилгүй хоёр хүн тутмын нэг нь л ажилтай байжээ.


Эх үүсвэр: ҮСХ-ны ажиллах хүчний судалгааны тоон мэдээлэл, 2012

Дээрх мэдээллээр монголын хөдөлмөрийн зах зээл дээр мэргэжилтэй болон мэргэжил ур чадваргүй хүмүүсийн хоорондын ялгааг харуулсан байна. Мэргэжилтэй ажилчдын цалин 35 хувиар өндөр төдийгүй, ажилтай магадлал нь илүү өндөр байдаг байна.

Хөдөлмөрийн төгс өрсөлдөөнт зах зээл. Хөдөлмөрийн өрсөлдөөнт зах зээл дээр маш олон аж ахуйн нэгжүүд тодорхой мэргэжлийн ажилтан авахын төлөө өрсөлддөг. Харин нөгөө талаас, ижилхэн мэргэжилтэй олон тооны мэргэжилтэй ажилчид ажилд орохын төлөө өрсөлддөг. Ийм өрсөлдөөнтэй байдаг тул аж ахуйн нэгж ч, ажилчид ч цалинд нөлөөлөх чадваргүй байдаг бөгөөд цалин нь дээр өгүүлсэнчлэн салбарын хөдөлмөрийн эрэлт, хөдөлмөрийн нийлүүлэлтээр тодорхойлогддог.

4.4. Үйлдвэрчний эвлэл ба хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөрийн зах зээл дээр үйлдвэрчний эвлэлийн байгууллага ихээхэн нөлөө үзүүлдэг. Энд цалин, урамшууллын асуудал голлох байр суурийг эзэлдэг. Нэг ажилчин дангаараа хөдөлмөрийн зах зээлийн өчүүхэн хувийг эзэлдэг тул цалинд шаардлага тавих боломжгүй байдаг. Иймд томоохон хөдөлмөрийн зах зээлд оролцож буй ажилчид үйлдвэрчний эвлэлд нэгдэж, цалин урамшуулал, ажлын байрын нөхцөл, ачаалал зэрэг чиглэлээр нэгдсэн шаардлага тавих нь дэлхийн аль ч оронд түгээмэл байдаг үзэгдэл юм.



Зураг 21-д үйлдвэрчний эвлэл ажилладаг болон үйлдвэрчний эвлэл байдаггүй хөдөлмөрийн зах зээлийг харьцуулж байна. Эхлээд энэ хоёр салбарт цалингийн түвшин 350000 төгрөг байна гэж үзье. ҮЭ-тэй салбарын ажилчид цалингаа нэмэх шаардлага тавьснаар хөдөлмөрийн зах зээл дээр цалин нь 400000 төгрөг болсон байна. Компаниуд тэдний шаардлагыг хүлээж аван цалинг нэмж харин энэ өндөр цалингийн түвшинд ажиллуулах хүний тоо 5000 байснаа буурч 4500 болж байна. Ажилгүй болсон хүмүүс үйлдвэрчний эвлэлгүй зах зээлд очин хөдөлмөрийн нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ. Энэ нь ҮЭ-гүй хөдөлмөрийн зах зээл дээр цалингийн түвшинг бууруулахад хүргэж байна. ҮЭ нь гишүүдийнхээ цалинг нэмэгдүүлэхийн төлөө ажилладаг бөгөөд тэд цалин болон ажиллагсдын тоог зэрэг нэмэх боломжгүй юм. Иймд цалин хөлсийг нэмэгдүүлдэг боловч энэ нь компаний зүгээс цалингаа өсгөхийн тулд хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ажиллагсдын тоог цөөрүүлэхийг зөвшөөрөхөд хүрдэг.

5. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл

5.1. Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал

Ажиллах хүчин нь эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажил хийж байгаа болон ажил хайж байгаа хүн амыг багтаадаг. Харин ажиллах хүчний оролцоо гэдэг нь хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчинд багтаж байгаа хүн амын эзлэх хувийн жинг харуулдаг. Монгол улсад ажиллах хүчний оролцоо буюу хөдөлмөрийн идэвх жилээс жилд улам бүр буурах хандлагатай байна. Тухайлбал, 2000 оны хүн амын орон сууцны тооллогоор ажиллах хүчний оролцооны түвшин 62 хувь байсан бол 2010 онд 56.4 хувь болж 5.6 пунктээр буурсан байна. Өөрөөр хэлбэл, 2000 онд 100 хөдөлмөрийн насны хүн амд 62 ажиллах идэвхтэй хүн ногдож байсан бол 2010 онд 56 болж буурсан байна. Энэхүү буурах хандлага хот, хөдөөд ялгаагүй ажиглагдаж байна. Гэвч Монголд хөдөөгийн хүн амын хөдөлмөрийн идэвх хотын хүн амтай харьцуулахад илүү өндөр байдаг. Энэ нь тэдний эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотой байж болох юм. Хүйсийн хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн идэвх аль аль нь буурах хандлагатай байна. 40-өөс дээш насны бүлгийн хувьд эмэгтэйчүүдийн идэвх нэмэгдэж, эрэгтэйчүүдийн идэвх буурсан

байна. Энэ оролцооны идэвх буурч байгаад залуучуудын дунд ялангуяа 25-с доош насны залуучуудын дунд хөдөлмөрийн идэвх буурч байна. 25-аас доош насны залуучуудын дунд хөдөлмөрийн идэвх буурч байгаа гол шалтгаан нь суралцах явдал байна.

Хүн ам ба хөдөлмөрийн нөөц

Үндэсний статистикийн хорооны хүн ам ба ажиллах хүчний тоон мэдээллээс үзэхэд 1990-ээд оны эхэн үеэс хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд 1.4 болж буурсан ба 2000-2010 онд дунджаар 1.5 хувь байна. Үүний улмаас хөдөлмөрийн нөөцийн өсөлт буурах хандлага ажиглагдаж эхлээд байна. Энэ хандлага ойрын 10 гаруй жилд хадгалагдах болно. Ингэснээр Монгол улсын хөдөлмөрийн нөөцийн суурь нь хумигдаж байна. Уул уурхайн салбарын эрчимтэй өсөлттэй зэрэгцээд ойрын хэдэн жилд том хэмжээний бүтээн байгуулалтын ажлууд хувийн болон төрийн секторт аль алинд нь хийгдэхээр байна. Үүнийг дагаад МУ-дах хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ч бас эрс өсөх болно. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн эрэлт ийнхүү хурдацтай өсөх боловч дотоодын хөдөлмөрийн нийлүүлэлтийн өсөлт эрэлтээ гүйцэхгүй байх хандлагатай байна. Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн суурь нь хөдөлмөрийн нөөц буюу 15-аас дээш насны хүн ам байдаг. МУ-ын хүн ам 1956-аас 1990 он хүртэл өндөр хурдацтай буюу жилд дунджаар 2.5-аас дээш хувиар өсч ирсэн. Үүнтэй холбоотойгоор хөдөлмөрийн насны хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин (нэг хүнд ногдох хөдөлмөрийн насны хүн ам) 2010 он хүртэл 30 гаруй жил өссөн бөгөөд үүнийг хүн амын цонх гэж нэрлэдэг. Тухайлбал, 2010 оны хүн ам орон сууцны тооллогоор МУ-д нийт хүн амын 72.7 хувьтай тэнцэх тооны буюу 1905969 (ажиллах хүчний судалгаа 2010, 1863.4 мянга) хөдөлмөрийн насны хүн байна. Өөрөөр хэлбэл, 100 хүн тутамд хөдөлмөрийн насны 73 хүн ногдож байна. Энэ үе нь нийгмийн хамгааллын салбарт хөрөнгө оруулалт хийх, эдийн засгийн болон хүний хөгжилд маш таатай үе байдаг.

Ажиллах хүчний оролцооны түүвэр судалгааны үр дүнгүүдээс харахад боловсролын түвшингээр хөдөлмөрийн идэвх ялгаатай байдаг байна. Дээд боловсролтой хүн ам 25-аас дээш насандаа хөдөлмөрийн идэвх илүү өндөр байдаг байна.

МУ-д ажиллах хүчний оролцоо буюу хөдөлмөрийн (ажил хийх) идэвх жилээс жилд улам бүр буурах хандлагатай байна.

5.2. Монгол Улсын хөдөлмөрийн бодлого

Монгол Улсын хөдөлмөрийн бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын тухай Үзэл баримтлал бусад холбогдох хууль, бодлогын баримт бичиг, хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлдэг. Үүнд, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль багтана. Хөдөлмөрийн тухай хууль 1999 оны 5 сард шинэчлэгдэн батлагдсан бөгөөд МУ-ын хөдөлмөрийн харилцааг зохицуулдаг гол хууль юм. Үүнээс хойш цаг үеийн тодорхой шаардлагаар бага хэмжээний нэмэлт өөрчлөлт оруулж ирсэн байна. Эл хуулиар хөдөлмөрийн харилцааны маш өргөн хүрээг хамруулан зохицуулдаг учраас Хөдөлмөрийн тухай хуулийг иргэд нарийвчлан судалж байх шаардлагатай юм. Номын энэ хэсэгт

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, ажилгүйдлийн тэтгэмжийн бодлого болон цалингийн доод түвшний бодлогыг товч тайлбарлаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого нь нэг талаас Монгол Улсын иргэдийн ажил эрхлэлтийг бүх талаар дэмжих, нөгөө талаас иргэдээ гадаадын ажиллах хүчний өрсөлдөөнөөс хамгаалахад чиглэсэн байдаг.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын эрх зүйн гол баримт бичиг нь 2011 оны 6 сард шинэчлэн батлагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль юм. Энэ хууль хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, түүний төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулдаг. \Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль. 2011он\ Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд хөдөлмөр зуучлалын үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олоход хүндрэлтэй иргэдэд зээл олгох, ажил олоход хүндрэлтэй иргэн ажиллуулсан бол ажил олгогчийг дэмжих болон ажил эрхлэлтийг дэмжих зорилгоор нийтийг хамарсан ажил зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа багтдаг. Хөдөлмөрийн яам болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв, хөдөлмөрийн төв бирж зэрэг харьяа байгууллагууд энэхүү хуулийн хэрэгжилтийг хангаж ажилладаг.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, ашигт малтмалын тухай хууль зэрэг хуулиуд бас хөдөлмөрийн харилцаатай холбоотой зохицуулалтууд бий. Тухайлбал, эдгээр хууль нь гадаадын иргэний хөдөлмөр эрхлэлтийг ажил олгогчид ногдуулсан төлбөрөөр дамжуулан хязгаарладаг. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь гадаадын иргэнийг ажлын байраар хангасан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний ажлын байрны төлбөрийг төлнө. \“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн 9.1-9.2 заалтаар 2 дахин, ашигт малтмалын тухай хуулийн 43.1-43.2 заалтаар 10 дахин нэмэгдүүлсэн тэнцэх хэмжээний төлбөр төлнө.\

Эндээс үзвэл, Монгол Улсын хөдөлмөрийн бодлогын гол үзэл баримтлал нь бүхэлдээ монгол хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гадаадын өрсөлдөөнөөс хамгаалахад чиглэгдсэн байна.

Энэхүү бодлого нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилготой. Тухайлбал, хөдөлмөр зуучлалын үйлчилгээг сайжруулснаар ажил хайхад шаардагдах цаг хугацааны болон мөнгөн зардлыг бууруулж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. Мөн хөдөлмөр эрхлэлтийн сургалтаар дамжуулан иргэдэд мэргэжил, дадал олгож улмаар хөдөлмөрийн зах зээл дээрх чадвартай ажилтны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. Мөн гадаадын иргэдийг ажиллуулахад өндөр зардалтай болгосноор монгол хүмүүст өрсөлдөөний давуу тал олгож байна. Ингэснээр иргэдийн ажил олох магадлалыг нэмэгдүүлж байна.

Ажилгүйдлийн тэтгэмж. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль нь 1994 оны 7 сард батлагдсан бөгөөд нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжийн төлбөр, тэтгэмж авах нөхцөл, хугацаа, болон хэмжээг зохицуулдаг. Энэхүү тэтгэмж авах ердийн хугацаа нь 76 хоног байдаг бөгөөд 2009 оны эдийн засгийн хямралтай холбоотойгоор 76 хоног байсныг 2009.08.01-2011.01.01 хугацаанд 126 хоног болгон уртасгасан байна.


Түүнчлэн тэтгэмжийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байхаар зааж өгсөн. Ажилгүйдлийн тэтгэмж нь ажилгүйдлийн улмаас иргэдийн амьжиргааны түвшин түр хугацаанд эрс буурахаас сэргийлдэг.

Ажилгүйдлийн тэтгэмж нь макро эдийн засгийн тогтворжуулах бодлогын нэг хэсэг болдгоороо онцлогтой. Эдийн засгийн байдал тааруухан үед олон хүн ажилгүй болоход ажилгүйдлийн тэтгэмжийн зардал өсдөг бөгөөд эдийн засгийн байдал сайжирч, ажилгүйдэл буурахад тэтгэмжийн зардал буурч байдаг.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль 2010 оны 4 сард батлагдсан. Өмнө нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн газраас тогтоодог байсан бол энэ хуулиар хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоодог байхаар зохицуулалт хийж өгсөн байна. 2011 оны 4 сарын 1-д сарын цалингийн доод хэмжээг 140400 төгрөг гэж тогтоосон байсныг 2013 оны 9 сарын 1-ээс 192000 төгрөг байхаар болгож өсгөсөн байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох бодлогыг хөдөлмөрийн зах зээл дээр үнийн доод түвшин тогтоох бодлого гэж харж болно.

Хөдөлмөрийн хөлсний доод түвшин тогтоох бодлогыг ажиллагсдын цалингийн орлогыг нэмэгдүүлэх зорилготой бодлого гэж тайлбарладаг. Цалингийн доод түвшин нь хөдөлмөрийн зах зээлийн мэргэжил, дадалгүй ажиллагсад буюу хамгийн бага цалинтай бүлэгт нөлөөтэй бодлого юм. Өөрөөр хэлбэл, өндөр мэргэжил, дадалтай түүндээ таарсан өндөр цалинтай ажиллагсад төдийлөн хамаагүй байдаг.

Одоо энэхүү бодлогод шинжилгээ хийж үзье. Хэрвээ цалингийн доод түвшин тогтоогоогүй бол мэргэжил, дадалгүй ажиллагсдын хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт сарын цалин 165000 төгрөг бөгөөд 300000 хүн ажилтай байна. Харин цалингийн доод түвшин 192000 болсноор эдгээр ажилчдын эрэлтийн хэмжээ 270000 болж буурах ба харин энэ өндөр цалингийн түвшинд хөдөлмөрийн нийлүүлэлтийн хэмжээ 330000 болж өснө.



Өмнө нь 165000 төгрөгийн цалингаар 300000 хүн ажилтай байсан бол одоо 192000 төгрөгийн илүү өндөр цалингаар 270000 хүн ажиллах болно. Үүнээс үзэхэд энэ бодлого бүтээмж багатай ажиллагсдад арай өндөр цалингаар ажиллах боломжийг нэмэгдүүлдэг ч, ажилгүй болж сарын орлого 0 болох магадлалыг бас өсгөдөг байна.

Ашигласан материал

1. Gwartney, J.D., R.L. Stroud, R.S. Sobel, D.A. Macpherson, Economics: Private and Public Choice, Thomson Southwestern, 11th edition, 2006.
2. Colander, D.C., Economics, McGraw-Hill, 7th edition, 2008.
3. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, 2-р хэвлэл, 2008.
4. Хэрэглэгчийн итгэлийн индекс судалгааны тайлан, МУИС, ЭЗС, 2012.
5. Хөдөлмөрийн тухай хууль
6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
7. Ашигт малтмалын тухай хууль
8. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
9. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль
10. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль
11. Статистикийн жилийн эмхтгэл, Үндэсний статистикийн хороо, 2011, 2012
12. Ажиллах хүчний судалгааны тайлан, Үндэсний статистикийн хороо, 2011, 2012
13. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, үндэсний дөрөв дэх илтгэл, МУ-ын ЗГ, 2011

ЗОХИОГЧ

БАТЧУЛУУНЫ АЛТАНЦЭЦЭГ

Эдийн засгийн ухааны тэнхмийн эрхлэгч

Монгол Улсын Их Сургууль

БОЛОВСРОЛ

Ph.D., Эдийн засаг, АНУ, Виржиниагийн Их Сургууль, 2010 оны 5 сар

Магистр, Эдийн засаг, АНУ, Виржиниагийн Их Сургууль, 2007 оны 5 сар

Магистр, Эдийн засаг, Англи, Манчестерийн Их Сургууль, 1998 оны 12 сар

Бакалавр, Эдийн засаг, Монгол Улсын Их Сургууль, 1995 оны 6 сар



ДИССЕРТАЦИ

“Хөдөлмөрийн нийлүүлэлт болон портфелийн хуваарилалтад мэдээллийн хязгаарлалт нөлөөлөх нь”

Удирдагчид: Eric Young, Chris Otrok, Emily Blanchard

АЖИЛ

Тэнхимийн эрхлэгч, ЭЗУ-ы тэнхим, 2013 оны 2 сар-

Дэд профессор, Монгол Улсын Их Сургууль, 2010-

Үндэсний зөвлөх, ҮХШХ, 2011.02-2011.03

Багш, Виржиниагийн Их Сургууль, 2007, 2009

Хичээлийн туслах ажилтан, Виржиниагийн Их Сургууль, 2005-2007

Багийн ахлагч, Хотын бүртгэлийн үйл явцын судалгаа, МСС, 2011-2012

Багийн ахлагч, Өмч хувьчлалын Монголын эдийн засагт үзүүлсэн нөлөөллийн судалгаа, ТӨХ, 2011

Багийн ахлагч, Бөөний зээлийн эрэлтийн судалгаа, БСС, Дэлхийн Банк, 2010

Үндэсний зөвлөх, Нээлттэй Нийгмийн Хүрээлэн, 2009

Хүний хөгжлийн илтгэл 2011-ийн эх бичигч, НҮБХХ Монгол, 2009

Судалгааны туслах ажилтан, Хонг Конгийн Их Сургууль, 2008

Үндэсний зөвлөх, Нээлттэй Нийгмийн Хүрээлэн, 2004

Үндэсний зөвлөх, НҮБХХ Монгол, 2004

БҮТЭЭЛ

Судалгааныхаа чиглэлийн хүрээнд олон тооны судалгааны ажил, өгүүлэл бичиж хэвлүүлсэн. Бүтээлийн дэлгэрэнгүй жагсаалтыг ФЭС-тай холбогдон авч болно.

Доктор (Ph.D), проф. Доржготовын Наранцэцэг

Гуравдугаар бүлэг. НИЙГМИЙН БОДЛОГО

1. Нийгмийн бодлого: мөн чанар, зорилго, хүрээ, хэрэгжүүлэгч субъектүүд
 - 1.1. Нийгмийн бодлого, түүний мөн чанар, хэрэгжүүлэгч субъектүүд
 - 1.2. Нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн хэлбэр \даатгал, халамж, тусламж\
 - 1.3. Нийгмийн бодлогын стратеги ба түүний давуу тал, ач холбогдол
 2. Монгол улсын нийгмийн бодлогын эрх зүйн орчин ба хүний хөгжлийн хүчин зүйл
 - 2.1. Нийгмийн асуудлуудын эрх зүйн зохицуулалтууд
 - 2.2. Нийгмийн бодлогын цөм нь хүний хөгжил болох нь: Хүний хөгжлийн индекс
 - 2.3. Нийгмийн бодлогын хүрээ, үндсэн чиглэл
 3. Боловсролын үйлчилгээ
 - 3.1. Боловсролын үйлчилгээ гэж юу вэ?
 - 3.2. Боловсролын функц ба үзүүлэлтүүд
 - 3.3. Боловсролын чанар, уян хатан байдал ба хүртээмж
 4. Эрүүл мэндийн үйлчилгээ
 - 4.1. Эрүүл мэндийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт
 - 4.2. Эрүүл мэндийн даатгал
 - 4.1.1. Иргэд эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хэмжээ
 - 4.1.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээ
 - 4.1.3. Монгол Улсын иргэнд үнэ төлбөргүй үзүүлдэг тусламж , үйлчилгээ
 5. Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ
 - 5.1. Даатгалын тухай үндсэн ойлголтууд
 - 5.2. Нийгмийн даатгалын шимтгэл ба нийгмийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж
 - 5.3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хувь хэмжээ
 6. Монгол Улсын нийгмийн бодлогын зарим чухал асуудал
 - 6.1. Ажилгүйдлийг багасгах нь
 - 6.2. Ядуурал, түүнийг буруулах нь
 - 6.3. Макро эдийн засаг ба хөдөлмөрийн зах зээл, цалин хөлс
 - 6.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих төрийн бодлого
 - 6.5. Нийгмийн соёлын өөрчлөлт ба иргэдийн улс төр, эрх зүйн боловсрол
- Ашигласан материал
Зохиогчийн тухай

Гуравдугаар бүлэг. НИЙГМИЙН БОДЛОГО

Аливаа улс орны нийгмийн бодлого гагцхүү хүндээ чиглэж, тухайн орны хөгжил цэцэглэлт нь ч хүний хөгжлөөс шууд хамаардаг. Төрийн бодлогын энэ салбарт эмэгтэйчүүд, хүүхдүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд залуучууд зэрэг нийгмийн бүх бүлэг давхрааг хамарч, нийт хүн амд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ үзүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг багасгах гээд өргөн хүрээтэй, олон асуудлыг багтдаг.

Монгол Улс нь ардчилал, зах зээлийн жамаар хөгжиж буй орны хувьд нийгмийн бодлогын олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилтыг хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрээд байна. Юуны өмнө, өнгөрсөн 20 гаруй жилд хүн амынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн социал харилцааг ардчилал, зах зээлийн жамаар хөгжүүлэх бодлого, эрх зүйн суурь орчинг бүрдүүлжээ. Хүн ам, ам хөгжлийн асуудлаарх төрийн бодлого тодорхой болж, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль зэрэг гол хуулиудыг батлан хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрээд байна.

Монгол Улсын Засгийн газрын бүтцэд нийгмийн асуудлыг хариуцах төрийн захиргааны төв байгууллага, тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд ажиллаж байна. Монгол улсын Засгийн газар НҮБ-ын салбарын байгууллагууд, гадаадын төрөлжсөн сангууд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай олон талын түншлэлийг хөгжүүлж, төрийн тодорхой зарим чиг үүргийг хувийн хэвшил, ТББ-ууд хэрэгжүүлдэг болов. Номын гуравдугаар бүлэгт эл өргөн хүрээтэй асуудлыг тоймлон тайлбарлах болно.

1.Нийгмийн бодлого: мөн чанар, зорилго, хүрээ, хэрэгжүүлэгч субъектүүд


1.1. Нийгмийн бодлого, түүний мөн чанар, хэрэгжүүлэгч субъектүүд

Нийгмийн бодлого гэдэг нь нийт улсын болон бүс нутагт нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн шинжтэй бүх талын үйлчилгээг иргэдэд үзүүлэх, хүн амын нөхөн үржихүйн болон амьдралын хэвийн нөхцөлийг хангахтай холбоо бүхий төрийн бодлогын өргөн хүрээтэй салбар, чиглэлийг нэгтгэн илэрхийлсэн ойлголт мөн. Аливаа улс орон нийгмийн бодлогоороо дамжуулан НҮБ-ын хүний эрхийн түгээмэл Тунхаг болон Үндсэн хуулиараа тодорхойлсон хүний эрх, эрх чөлөөг ханган хэрэгжүүлэх нийгмийн баталгааг бүрдүүлэхийг зорьж байдаг. Иймээс улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдалтай уялдаж байнга өөрчлөгдөн боловсронгуй болж байх ёстой. Өрөөр хэлбэл, тодорхой нөхцөл байдалд үндэслэн нийгмийн бодлогыг тодорхойлоод хэрэгжүүлэх явцдаа үзүүлэлтүүдийг хянах, үнэлж дүгнэх, энэ үндсэн дээрээ өөрчлөн сайжруулж байх боломжтой байдаг.

Нийгмийн амьдрал улам нэгдмэл цогц шинжтэй болж байгаа нь хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааны чиглэлийг олон талтай, бас цогц байхыг шаардаж байна. Төрийн бодлогын цогц шинж, гол чиглэл гэдэг нь олон талт бодлогын арга хэмжээ, үйл ажиллагааны зайлшгүй үндэс байх албан ёсны зохион байгуулалтын

гол зарчим, чиг хандлага нь юм. Төрийн яам, Засгийн газрын агентлагууд, худалдааны фирмүүд, эмнэлэг, их сургуулиуд гээд бусад ямар ч байгууллагын үйл ажиллагаа нь бодлогын тодорхой зарчимтай болж, нэгэн чиг хандлагад зангидагдан цэгцэрсэн тохиолдолд л үр дүнтэй байдаг. Төрийн нийгмийн бодлогын үндсэн зарчим, гол бүрэлдэхүүн хэсгүүдийг Зураг 1-д харууллаа.

Зураг. 1



Нийгмийн бодлогыг хэрэгжүүлэгч субъектүүд. Нийгмийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, хувийн компани, иргэний нийгмийн байгууллагууд гээд олон субъект оролцдогийг дээр тэмдэглэсэн. Гэхдээ үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх төрийн нийгмийн бодлогыг тодорхойлогч, хэрэгжүүлэгч гол субъект нь төр, түүний янз бүрийн шатны байгууллагууд байдаг.

Монгол Улсын хувьд Үндсэн хуульд: “УИХ төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэнэ. Төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиглэлийг тодорхойлно” (Үндсэн хуулийн 25.1, 25.7 зүйл) гэж заасны дагуу төрийн нийгмийн бодлогын үндсийг тодорхойлогч гол субъект хууль тогтоогч эрх мэдлийг хэрэгжүүлэгч парламент буюу УИХ юм. Монгол Улсын Их хуралд нийгмийн бодлогын асуудлыг дагнан хариуцсан “Нийгмийн бодлогын байнгын хороо” хэмээх бүтцийн байгууллага ажилладаг.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд: “Засгийн газар ... салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх; Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж УИХ-д өргөж гарсан шийдвэрийг биелүүлнэ” (Үндсэн хуулийн 38.2, 38.3 зүйл) гэж заасны дагуу нийгмийн бодлогыг хэрэгжүүлэгч хамгийн гол субъект нь Монгол улсын Засгийн газар мөн. Засгийн Газарт нийгмийн бодлогыг Хүн ам хөгжлийн яам, Эдийн Засгийн хөгжлийн Яам, Хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол Шинжлэх ухааны яам голчлон хариуцдаг.

Засгийн Газрын 2012 оны 14 дүгээр тогтоолын дагуу Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам нь өөрийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг: “Монгол Улсын хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэн бүрийн нийгмийн баталгааг дээшлүүлэх таатай орчныг бүрдүүлэн хүний хөгжлийг хангахад оршино” хэмээн тодорхойлжээ. Түүнийг хэрэгжүүлэхийн тулд “хүн амын хөгжлийн урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах” зорилтуудыг өмнөө тавьж ажиллаж байна. Үүнээс гадна Засгийн газар тохируулагч 12, хэрэгжүүлэгч 30-н агентлагтай. Хэрэгжүүлэгч агентлагуудаас нийгмийн бодлогыг Хүүхдийн төлөө газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн халамж үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар салбар, салбарынхаа чиглэлээр хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ажилладаг.

Нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагаа өөр хоорондоо ялгаатай олон арга хэлбэрээр хүмүүсийн сайн сайхан байдалд /нийгмийн хамгаалалд/ нөлөө үзүүлж байдаг. Нэгд, хүмүүсийн сайн сайхны бодлогуудыг үндсийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж батлуулна. Мөн бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргана. Жишээ нь, Засгийн газар шинэ нийгмийн үйлчилгээ нэвтрүүлэх хөтөлбөрөөр дамжуулан нийгмийн нөхцөл байдлыг сайжруулж болно. Хоёрт, Засгийн газар нийгмийн нөхцөл байдалд нөлөө үзүүлэх эдийн засаг, хүрээлэн буй орчин, өөр бусад бодлогуудын шууд бус нөлөөгөөр нийгмийн сайн сайхан байдал, нийгмийн хамгааллыг сайжруулахад нөлөөлж болно. Жишээ нь, өөр бусад орнуудтай худалдаа үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогоор дамжуулан ажил эрхлэлтийн шинэ шинэ боломжууд, түүнчлэн худалдаа арилжаа өсөн нэмэгдсэнтэй холбоотойгоор тэнд ажиллагсдын нийгмийн хамгаалал, орлого нэмэгдэж болно. Гуравт, Засгийн газраас хэрэгжүүлж буй нийгмийн бодлого нь урьдаас төлөвлөгдөөгүй, гэнэтийн арга замуудаар хүмүүсийн сайн сайхан байдалд нөлөөлнө.

Нийгмийн бодлого судлаач эрдэмтэд Засгийн газраас нийгмийн хамгааллыг дэмжих гурван шууд механизмыг тодорхойлсон байдаг. Эдгээрийн нэг дэх нь нийгмийн үйлчилгээний хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх үр дүн бүхий бодлого юм. Ихэнхи засгийн газрууд нийгмийн үйлчилгээг нэвтрүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааны арга замуудыг удирдах болон тэдгээрийн зорилгыг тодорхойлох бодлогыг ашиглаж байдаг. Олон улсын хэмжээнд нийтлэг тотсон жишгээр эдгээр үйлчилгээ нь:

- эрүүл мэнд,
- боловсрол,
- орон сууц,
- орлогын баталгаатай байдал,
- гэр бүлийн болон олон нийтийн хамгааллын салбарын хүрээнд хэрэгждэг.

Эдгээрийн сүүлийн хоёр салбарыг ихэвчлэн “нийгмийн хамгааллын бодлого”-д хамааруулан авч үздэг.

Нийгмийн бодлого судлаач зарим эрдэмтэд нийгмийн бодлогыг дан ганц нийгмийн үйлчилгээгээр хязгаарлагдахгүй байх санал дэвшүүлдэг. Тухайлбал, нийгмийн бодлогын хамрах хүрээнд зам тээврийн бодлого, соёл болон чөлөөт цаг, амралтын бодлого, хот төлөвлөлтийн бодлого, цагаачдын бодлого зэргийг хамруулахыг санал болгодог. Мөн нөгөө талаас, өдгөө нийгмийн бодлого судлал нь илүү мэргэшэх чиг хандлагатай болж байна. Тухайлбал, нийгмийн бодлогын чиглэлийн судалгааны хүрээнээс эрүүл мэнд, боловсрол, орон сууцны бодлогын асуудлыг салган тусгайд нь авч үзэх судалгааны шинэ чиглэлүүд хэдийнээ бий болжээ. Судалгааны явцад буй болж буй энэхүү шинэ хандлагууд бүгд л нийгмийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулахад ашиглагдах ёстой.

Нийгмийн бодлогоор дамжуулан нийгмийн амьдралд нөлөөлж буй хоёр дахь арга зам нь хууль дүрэм журмын хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Засгийн газрууд ажил олгогч, сууц эзэмшигч, боловсролын институтууд, худалдааны фирмүүд болон нийгмийн хамгаалалд шууд нөлөө үзүүлэх хэмжүүрүүдийг ашиглаж буй өөр бусад байгууллага, нэгжүүдэд тухайн үйл ажиллагааг эрхлэн явуулах эрх олгож, тэр

эрхийг хэрэгжүүлэх хууль, дүрэм журам тогтоодог. Нийгмийн бодлогын чиглэлээр гарсан хууль, журам дүрмийн хэрэгжилтийн талаар хийсэн зарим судалгаанаас үзэхэд засгийн газраас батлан хэрэгжүүлж буй дүрэм, журмууд нь орон сууц, эрүүл мэнд, орлого, ажил эрхлэлт болон боловсрол зэрэг нийгмийн хамгааллын олон хүрээнд янз бүрийн хэмжээнд хэрэгжиж байгаа нь харагддаг. Түүнчлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ тогтоох, татварын хяналт, стандарт тогтоох аливаа дүрэм журам ба зохицуулалтууд нь хүмүүсийн сайн сайхан байдалд нөлөөлж байдаг чухал хүчин болно. Энэ бүхнийг нарийн судалж, нийгмийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд харгалзан тооцдог байх нь чухал.

Засгийн газрын нийгмийн хамгаалалд нөлөөлдөг гурав дахь зам нь татварын систем юм. Нийгмийн салбарт татварын системээр дамжуулан хэрэгжүүлэх бодлого бол бодит халамж хамгаалал юм. Засгийн газар тодорхой татварын төрлүүдээрээ дамжуулан нийгмийн хамгаалалд шууд нөлөө үзүүлж байдаг. Худалдааны татварт энэ төрлийн хэд хэдэн хөшүүргийг ашигладаг.

Монгол улсын үе үеийн Засгийн Газар эдгээр зарчим, арга замыг ашиглан нийгмийн бодлого боловсруулан хэрэгжүүлж иржээ. Өнөөгийн шинэчлэлийн Засгийн газар нийгмийн бодлогынхоо үндсэн зорилтуудыг "2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгасаныг номын нэгдүгээр бүлэгт дурьдсан байгаа. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх нийгмийн бодлогын гол үйл ажиллагаа доорхи хөтөлбөрүүдэд хураангуйлан тодорхой болгожээ. Эдгээр хөтөлбөрүүд нь монгол хүний хөгжлийг бодлогоор дэмжихэд чиглэсэн өөр хоорондоо нягт уялдаатай бодлогын зорилтуудаар холбогдож байгаа болно.

Нэг. "АЖИЛ ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН"

- Цалин, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ.
- Цалин тэтгэврийн хэмжээг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг өсгөхгүйн тулд нийтэд зарлахгүйгээр салбар бүрээр нэмнэ.
- Ажилгүйдлийг бууруулах үүднээс хөдөлмөрийн багтаамж ихтэй салбаруудыг бодлогоор дэмжинэ.

Хоёр. "ЭРҮҮЛ ЧИЙРЭГ МОНГОЛ ХҮН "

- Бүх шатны эмнэлэг эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана.
- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг тарифийн ялгаваргүйгээр эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.
- Эх хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэд 3 жилд нэг удаа эрүүл мэндийн иж бүрэн оношлогоонд хамруулна.

Гурав. “ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ МОНГОЛ ХҮН”


- Сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх, өргөтгөх замаар хүүхдийн ая тухтай сурч хүмүүжих орчинг бүрдүүлнэ.
- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа сурагчдын сургалтын тэтгэлгийг бууруулалгүйгээр суралцах сонирхлыг дэмжиж ажиллана.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, тэдний авъяас, хөдөлмөр бүтээлийг дэмжинэ.
- Багш, эмч, инженер бэлтгэх асуудал дээр онцгой анхаарал хандуулж, амжилттай суралцаж байгаа оюутныг дэмжинэ.

(www.politics.news.mn)

1.2 Нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн хэлбэр \даатгал, халамж, тусламж\

Нийгмийн бодлого хэрэгжүүлэх арга хэрэгсэл нь тодорхой хөтөлбөр, санхүүжилтийн норм, норматив, стандарт, хууль, баталгаа, журам зэргээс бүрдэнэ. Нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх гол арга хэлбэрүүдийг дор дурдсан гурван үндсэн чиглэлээр ангилан тодруулж болох юм. \Зураг 2\

Зураг 2




Нийгмийн хангамж гэж юу вэ? Нийгмийн хангамж нь хүн амын эмзэг хэсэгт хамрагдах иргэдэд тэтгэвэр тэтгэмж олгох, хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амьжиргааг дээшлүүлэх агуулга бүхий нийгмийн хамгааллын арга хэмжээ юм. Өрнөдийн орнуудад нийгмийн хангамжийн тогтолцоо 1930-аад оны үеэс хөгжиж энэ талын зардал улсын төсөвт томоохон байр суурь эзэлдэг. Хөгжиж буй оронд нийгмийн асуудалд анхаарал тавих болсны нэгэн адил Монгол улс ч энэ талаар багагүй анхаарал тавьж байгаа билээ. Сүүлийн жилүүдэд энэ чиглэлд авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ, тухайлбал, хавтгайруулсан нийгмийн халамжийн хөтөлбөрүүд нь улсын төсөвт багагүй ачаалал өгөх болсноор зарим зүйлийг эргэн харж өөрчлөх алхам хийж байна.

Нийгмийн даатгал гэж юу вэ? Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Нийгмийн даатгалын үндсэн төрлүүдийг

Зураг 3-д харуулав.

Зураг 3




Нийгмийн даатгалын сан ямар эх үүсвэрээс бүрддэг вэ? Нийгмийн даатгалын сангийн орлого хуульд заасны дагуу дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл,
- Ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл
- Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсан хүү
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд оногдуулах алданги
- Улсын төвлөрсөн төсвөөс олгох хөрөнгө
- Бусад эх үүсвэр

Нийгмийн халамж гэж юу вэ? Нийгмийн халамж нь нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, тэдгээрийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулахад чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээ юм. Харин нийгмийн эмзэг бүлэгт: **а**. тэжээн тэтгэх төрөл садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие ахмад настан, **б**. хөгжлийн бэрхшээлтэй иргэн, **в**. хүнд нөхцөлд байгаа хүүхэд, **г**. ядуу амьдралтай олон хүүхэдтэй өрх толгойлсон эх (эцэг) хамаарна. Нийгмийн халамжийн тэтгэврийн төрлүүдийг халамжийн хуульд нарийвчлан тодорхойлж, төрийн шат шатны байгууллагын халамжийн \нийгмийн\ ажилтнууд хариуцан хэрэгжүүлдэг. \Зураг 4\

Зураг 4



1.3. Нийгмийн бодлогын стратеги ба түүний давуу тал, ач холбогдол

Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх төрийн нийгмийн бодлогыг төрийн удирдлагын бүх түвшинд нарийвчлан тодорхой болгон боловсруулж, хэрэгжүүлдэг.

Үүний зэрэгцээ үйлдвэр, корпорац, янз бүрийн нийгэмлэг, түүнчлэн ашгийн бус сангуудын зүгээс нийгмийн тодорхой асуудлаар бодлого боловсруулж, хэрэгжүүлэх нь ардчилсан орнуудад түгээмэл байдаг зүйл.

Аливаа төрийн бодлогын стратегийн зорилго нь нийгмийн харьцангуй тогтвортой байдлыг хангахад оршино. Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нийгмийн бодлого нь:

- өлсгөлөн, хурц халдварт өвчин, байгалийн болон техникийн сүйрэл, сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй хүн ам зүйн тэсрэлт гэх мэт гамшгаас урьдчилан сэргийлэх, үр дагаврыг зөөлрүүлэх төрийн баталгааг бий болгох,
- нийгмийн түгшүүрт байдлыг намжаахад чиглэсэн материаллаг нөөц, зохион байгуулалтын хүч чармайлтыг зохицуулах
- хүн амын амьжиргааны тодорхой түвшинг хангах, нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлэх
- нийгмийн үнэт зүйлс, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг сахих, тэдгээрийг нийгэмд ноцтой хор уршиг тарихуйцаар зөрчих явдлыг гаргуулахгүй байх нөхцлийг бүрдүүлэх зэрэгт чиглэдэг.

Томоохон хэмжээний нийгмийн асуудал бол аль ч улс оронд, ямар ч нийгэмд байнга л гарч байдаг зүйл. Тийм учраас үндэсний хэмжээнд урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх нийгмийн бодлогын стратегийг нэг удаагийн буюу нэг хэсэг арга хэмжээгээр бус, төлөвлөж тодорхойлсон хугацаанд дэс дараатай шийдвэрлэх шаардлагатай байдаг. Чухам ийм зорилгоор хүн амыг нийтэд нь хамарсан, эсвэл тодорхой зорилтод бүлэгт чиглэсэн янз бүрийн хөтөлбөр, төсөл боловсруулан хэрэгжүүлэх оновчтой байдаг. Ийм хөтөлбөр, төсөл нь тодорхой нэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа, арга хэмжээний цогц байдгаараа онцлог юм. Энд бий болсон нөхцөл байдлыг тодорхойлж, асуудлыг шийдвэрлэх хугацаа, үе шат, авах арга хэмжээ, хэрэгжүүлэх арга замыг тусгасан байдаг. Монгол хэрэгждэг өрхийн амьжиргааг дэмжих, жижиг бизнесийг дэмжих зэрэг төсөл хөтөлбөрүүд нь үүний жишээ болно.

Нийгмийн бодлого нь нийгмийн төлөвлөлтөд үндэслэдэг. Төлөвлөлт гэдэг нь ирээдүйд тодорхой зорилго, зорилтод хүрэхийн тулд нарийвчилсан тооцоо, судалгаа хийж, одоо байгаа нөөцөө хэрхэн хамгийн үр дүнтэй ашиглах талаар сонголт хийсэн шийдвэр гаргах процесс юм. Төлөвлөлт нь тасралтгүй үргэлжлэх шинжтэй. Нийгэм эдийн засгийн томоохон хэмжээний ахиц, өөрчлөлт хийхэд чиглэгдсэн урт болон дунд хугацааны төлөвлөлтийг хөгжлийн төлөвлөлт гэнэ.

Төлөвлөлт ба бодлого боловсруулах үйл явц нь өөр хоорондоо нягт холбоотой боловч ялгаатай ойлголтууд юм. Бодлого боловсруулах процесс нь шаардагдаж байгаа хөгжил, өөрчлөлтийн хэв маягийн тухай шийдвэрүүдийг гаргаж байдаг бол төлөвлөлт нь тухайн өөрчлөлт, хөгжилд хэрхэн хүрэхийг шийдэж байдаг үйл явц юм. Хэдийгээр ихэнхи тохиолдолд улс төрчид бодлогын шийдвэрийг гаргаж байдаг ч энэхүү шийдвэр нь төлөвлөгчдийн боловсруулсан мэдээлэл ба хувилбаруудад суурилсан байдаг.

Үндэсний хөгжлийн төлөвлөлтөнд нийгмийн хүчин зүйлсийн нөлөөлөл, ач холбогдлыг маш нарийн харгалзан үзэх шаардлагатай. Ийм хүчин зүйлс нь:

-Хүний хүчин зүйл

-Нийгмийн хэрэгцээний нөхцөл байдал /урьд өмнө нь хэрэгжиж байсан олон хөтөлбөрүүд эдийн засгийн зорилгод хүрэхийн төлөө тэмүүлж байсан ба ялгаатай олон нийгмийн хэрэгцээг хангах тухай асуудлыг үл ойшоодог байсан/

-Хөгжлийн төлөвлөлт нь нийгмийн тэгш байдал, шударга ёстой холбоотой байдаг.

-Хүний хөгжлийн нэгдмэл байдал

Хөгжлийн төлөвлөлтөд нийгмийн хүчин зүйлсийг уялдуулахдаа юуны өмнө, нийгмийн өөрчлөлтөд мониторинг хийх хэрэгтэй байдаг. Ийм мониторингийн үр дүнд нийгмийн бүтэц, гэрлэлт гэр бүлийн харилцааны өөрчлөлтөөс эхлээд нийгмийн бүлгүүдийн шинж байдал, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид гарч буй өөрчлөлт, хүмүүсийн хоорондын харилцаа, ёс заншил ба хандлагад гарч буй өөрчлөлт зэргийг хамарсан цогц мэдээлэл бүрдэнэ. Нийгмийн өөрчлөлтийн талаарх ийм мэдээлэл нь нийгмийн хөгжлийн тухайн цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн салбарыг бүхэлд нь хамарсан хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, нийгмийн тодорхой үзэгдлүүдийн үр нөлөөг хянах гол үндэслэл, чухал хэрэглэгдэхүүн болдог.

Нийгмийн бодлогын тодорхой зорилтуудыг хангах хөтөлбөрүүдийн томъёолоход нийгмийн төлөвлөлтийн мэргэжилтнүүд чухал үүрэгтэй бөгөөд тодорхой бодлогыг албан ёсоор батлах эцсийн шийдвэрийг улс төрчид гаргадаг ч төлөвлөлтийн мэргэжилтнүүд бодлогын альтернатив хувилбаруудыг боловсруулахад оролцож, тэдэнд мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг.

Үндэсний хөгжлийн хөтөлбөрүүдийн нийгмийн үр нөлөөг хянах. Нийгмийн салбарт шинэ бодлого, хөтөлбөрийг боловсруулан томъёолох үед тэдгээрийн нийгэмд үзүүлж болох үр нөлөөг урьдаас тооцон харгалзах, ямар нөлөө үзүүлж буйг нь хянах бололцоог бүрдүүлдэг. Энэ нь үндсэндээ эдийн засгийн агуулгатай байдаг учраас хөгжлийн хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.


Нийгмийн бодлого нь олон салбарын бодлогын уялдаа зохицлыг хангахад чухал үүрэгтэй. Нийгмийн бодлого боловсруулах хэрэгжүүлэх үйл явцын бүх үе шат хүн ам зүйн хийгээд улс төр, эдийн засгийн хөгжлийн бодлоготой салшгүй холбоотой байдаг. Жишээлбэл, эдийн засгийн бодлогын үр дүнгээр бий болдог санхүүгийн боломж нь нийгмийн бодлогын чиглэлээр хэрэгжүүлж болох хөтөлбөр, арга хэмжээний эдийн засгийн баталгааг бүрдүүлдэг. Эдийн засгийн бодлого нь нөөц хуримтлалыг бүтээх, арвижуулахад голлон чиглэдэг бол нийгмийн бодлого уг нөөцөд тулгуурлаж баялгийн тэгш, шударга хуваарилалтад анхаарч хүн амын эрүүл мэнд, боловсрол, мэргэжил гэх мэт асуудлуудад анхаарлаа хандуулдаг. Эргээд боловсрол, эрүүл мэндийн салбартаа хөрөнгө оруулснаар хүний хөгжлийн үзүүлэлтүүд, амьдралын чанарын төвшин дээшилж, улс орны эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлдэг байна.

Хэдий тийм боловч нийгмийн болон эдийн засгийн бодлого зорилгын хувьд хоорондоо ялгаатай байдгийг тэмдэглэх нь зүй. Эдийн засгийн бодлого бол үр ашигтай үйлдвэрлэлийг явуулах зорилготой байдаг бол харин нийгмийн бодлого

нь энэ үйлдвэрлэл дээр тулгуурлаж хүн амын амьжиргааны төвшинг дээшлүүлэх, эд баялгийг хүмүүст жигд хуваарилан хүртээх, энэ салбарт шударга ёсыг бэхжүүлэхийг гол зорилгоо болгож байдаг. \Зураг 5\

Зураг 5

Нийгмийн бодлогын хүрээнд их хөрөнгө зарж, хавтгайруулсан халамжийн бодлого



хэрэгжүүлж нийгмийн зорилтуудыг хэт дөвийлгөснөөс эдийн засагт сөргөөр нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, нийгмийн асуудалд хэтэрхий их хөрөнгө зарцуулснаас эдийн засагт оруулах хөрөнгө багасаж эдийн засгийн өсөлт удааширдаг зүй тогтолтой. Чухам ийм учраас зүүний болон барууны үзэл баримтлалтай улс төрийн намууд засгийн эрхэнд ээлжлэн гардаг байна. Нийгмийн салбарын хөгжил хоцрогдоод нийгмийн бодлогын илүү өгөөжтэй, хүндээ чиглэсэн хөтөлбөрүүдийг иргэд шаардаад эхлэхэд зүүний улс төрийн хүчнүүдийн байр суурь бэхэждэг. Харин эдийн засагт хүндрэл гарч өсөлт удааширсан үед барууны чиглэлтэй намуудын нөлөө өсдөг байна.

2. Монгол улсын нийгмийн бодлогын эрх зүйн орчин ба хүний хөгжил

2.1 Нийгмийн асуудлуудын эрх зүйн зохицуулалтууд

Нийгмийн бодлогоор дамжуулан хүний эрх чөлөөг хангах, хамгаалан бэхжүүлэх, хүний хөгжлийг хөхүүлэн дэмжих нь дэлхийн аль ч улс орны хувьд төрийн бодлогын амин чухал чиглэлийн нэг байдаг. Хүний эрхий хамгаалалт, түүний нийгмийн баталгаа нь хүний хөгжлийн үндэс суурь, ардчилал, ардчилсан засаглалын гол шалгуур үзүүлэлтийн нэг болдог.

Монгол улсад сүүлийн жилүүдэд олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцын дагуу хүний эрх, үндсэн эрх чөлөөг ханган хэрэгжүүлэх талаар дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, Үндсэн хуулиараа тогтоосон хүний эрхийг дээдлэн хэрэгжүүлэх хууль, эрх зүйн баталгааг бүрдүүлэх чиглэлд идэвхтэй ажиллаж байна. Үүний үр дүнд Монгол улс өнгөрсөн хугацаанд хүний эрхийн олон улсын гэрээнд бараг бүгдэд нэгдэн орж, эдгээрт заагдсан хүний эрх, эрх чөлөөг 130 гаруй хуулиар баталгаажуулаад байна.

Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр нийгмийн бодлогын хуучин үзэл баримтлал, нийгмийн халамж, хамгааллын тогтолцоогоо үндсээр нь өөрчлөх шаардлага гарсан билээ. Энэ ажил юуны өмнө салбарын гол хуулиудыг шинэчлэх, шинээр хууль, бодлогын баримт бичиг боловсруулан батлах замаар нийгмийн бодлогын цоо шинэ эрх зүйн орчин бүрдүүлэх ажлаас эхэлсэн билээ. Өнөөдөр Монгол Улс нийгмийн даатгал, нийгмийн халамжийн орчин үеийн жишигт нийцсэн хуулиудтай болж, энэ чиглэлийн олон улсын гол гол гэрээ, конвенциудад нэгдэн ороод байна. |Хүснэгт 1\

Иргэний эрх зүйтэй холбоотой ямар хууль тогтоомжууд байдаг вэ?

Хүснэгт 1

Нийгмийн даатгалтай холбоотой хууль тогтоомж	Нийгмийн халамжтай холбоотой хууль тогтоомж	Олон улсын конвенц
-Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай -Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай -Тэтгэвэрийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай -Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай -Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай -Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай -Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай -Нийгмийн даатгалын тухай хууль	-Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай -Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль -Гэр бүлийн тухай хууль -Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль -Нийгмийн халамжийн тухай хууль -Тэтгэмжийн хэмжээг тогтоох тухай -Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай -Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай -Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль -Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль	-Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт -Хүүхдийн эрхийн тухай конвенц -Хүүхэд худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенц -Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц -Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц Эх сурвалж: www.knun.gov.mn

2.2 Нийгмийн бодлогын цөм нь хүний хөгжил болох нь: Хүний хөгжлийн индекс

Хүн бүхэн өдөр тутамд эдийн засгийн, нийгмийн, улс төрийн, соёлын гэх мэт чиглэлээр янз бүрийн сонголт хийж байдаг. Хүний хөгжил бол энэхүү сонголтуудыг өргөжүүлж, тодорхой үр дүнд хүрэх үйл явц юм. Хүний хөгжил хүний эрхтэй нягт холбоотой бөгөөд хүний хөгжил нь хүний чадавхи болон боломжийг нэмэгдүүлснээр сонголт хийх эрх чөлөөг өргөжүүлнэ. Хүний эрх тэрхүү эрх чөлөөг хамгаалахад чиглэгддэг. Хүний сонголтыг өргөжүүлнэ гэдэг нь чадавхийг бий болгон сайжруулж буй хэрэг мөн.

Тодорхой хувь хүн эрүүл, мэдлэгтэй, ур чадвартай, амьжиргааны боломжийн түвшинд амьдарч, ажиллах эсэх нь хүний чадавхиас хамаарна. Хүний чадавхийг сайжруулахын тулд сайн хоол тэжээл, эрүүл мэндийн анхан шатны чанартай үйлчилгээ, сайн боловсрол, өндөр ур чадвар, ундны усны найдвартай хэрэглээ, хүртээмжийг сайжруулах шаардлагатай байдаг. Үүнд чиглэсэн төрийн нийгмийн бодлого нь хүний хөгжлийн гол үзүүлэлтүүдэд тулгуурлан хэрэгждэг байна. Орчин үед дараах гол үзүүлэлтүүдээр хүний хөгжлийг хэмждэг болжээ.

Хоол тэжээл: Сайн хоол тэжээлтэй байх нь хүмүүсийн зөвхөн бие бялдрын хөгжилд чухал байгаад зогсохгүй, тэдний оюун ухааны болон сэтгэлзүйн хөгжилд маш чухал нөлөөтэй гэж үздэг. Аливаа хүн тодорхой хэмжээний орлоготой байж хүнсний нөөцөө бүрдүүлнэ. Нэгэнт байгаа хүнсний нөөцийг зөв хэрэглэх нь сайн хоол тэжээлтэй байх асуудлын гол утга учир мөн. Олдсоны хэмжээгээр хэрэглэх, дуртай, амттай бүхнээ идэж уух нь сайн хоол тэжээлтэй байгаа хэрэг биш, гол нь зохистой, ухаалаг хэрэглээ байдаг.

Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж: Урт удаан, эрүүл энх амьдрах нь хүний амьдрах, ажиллах чадавхийн маш чухал хүчин зүйлийн нэг. Хүмүүс эрүүл амьдрах боломжгүй бол бүтээлч амьдралаар амьдарч чадахгүй. Анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж нь эрүүл, удаан амьдрахын суурь нь болдог. Эрүүл мэндийн аливаа үйлчилгээг нийт хүн амд, иргэн бүрд чанартай, хүртээмжтэй байлгах нь нийгмийн бодлогын эрхэм чухал зорилт мөн.

Боловсрол: Мэдлэг нь хүний чадавхийг хөгжүүлдэг тул мэдлэг бол эрх мэдэл гэж үзэх нь бий. Харин боловсрол бол зөвхөн мэдлэг биш, мэдлэгтэй байхын зэрэгцээ түүнийгээ амьдрал ахуйдаа үр дүнтэй ашиглах дадал зуршлыг бас багтаадаг. Үүнийг л чанартай боловсрол гэнэ. Боловсролд суурилсан чадавхи нь хүн өөрийн амьдралд нөлөөлдөг бүх үйл ажиллагаанд оролцох хангалттай боломжийг бүрдүүлнэ. Боловсрол бол мэдлэгийн бий болгож сайжруулах гол хэрэгсэл. Боловсролын үйлчилгээ бол хүмүүст анхан шатны ур чадварыг бий болгодог суурь боловсролоос эхлэн мэргэжлийн, мэргэшлийн ур чадварыг бий болгоход үйлчилдэг дээд боловсрол, техник мэргэжлийн боловсрол хүртэл олон үе шат бүхий цогц үйлчилгээ юм.

Ундны ус, ахуйн хэрэглээний усны хангамж: Ундны найдвартай ус нь урт удаан, эрүүл амьдрахын нэг үндэс. Ахуйн хэрэглээний усны хангамж муутайгаас олон хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь зөрчигдөж байдаг. Ийм учраас хүний хөгжлийг хангах нэг чухал үзүүлэлт болохынх нь хувьд усны хангамж, үйлчилгээний асуудал нийгмийн бодлогын төвд байдаг.

Олон улсын хэмжээнд улс орнуудын хүний хөгжлийн байдал ямар байгааг харьцуулах үүднээс НҮБ-ын хэмжээнд нийтлэг мөрддөг аргачиллаар улс орнуудын хүний хөгжлийн индексийг /ХХИ/ тодорхойлдог болоод бараг 20-иод жил болж байна. Жил бүр НҮБ дэлхийн хүний хөгжлийн индексийг гаргаж, нийтийн хүртээл болгодог. Монгол Улс 1997 оноос эхлэн 2 жил тутам Монголын хүний хөгжлийн Үндэсний илтгэлийг бэлтгэн гаргадаг болоод байгаа билээ.

Тухайн орны хүн амын амьдралын түвшин ямар байгааг харуулдаг гол үзүүлэлт нь хүний хөгжлийн индекс /ХХИ/ юм. ХХИ нь хүний хөгжлийн үндсэн хэмжүүр болох эрүүл энх, урт удаан амьдрал, мэдлэг ба амьжиргааны түвшний үзүүлэлтүүдийн нэгдсэн индекс юм.

Хэмжигдэхүүн	Эрүүл, урт наслалт	Мэдлэг	Амьжиргааны түвшин	
Үзүүлэлт	Төрөлтөөс тооцсон дундаж наслалт	Сургуульд суралцсан дундаж хугацаа	Сургуульд суралцах хугацаа	Нэг хүнд ноогдох ҮНО
Бүрэлдэхүүн индексүүд	Дундаж наслалтын индекс	Боловсролын индекс		ҮНБ индекс
Хүний хөгжлийн индекс				

Эх сурвалж. Буян.Д., Нийгмийн тухай мэдлэг. УБ., 2011 Эх сурвалж. Буян.Д., Нийгмийн тухай мэдлэг. УБ., 2011

Хүний хөгжлийн индексийг тооцон гаргах нь хүний хөгжилд учир дутагдалтай ямар зүйл байгааг олж илрүүлэх, түүнийг шийдэх арга хэмжээ авах, дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшингийн хаана нь яваагаа мэдэх, өрсөлдөх, байгаа түвшингээ дээшлүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

2.3. Нийгмийн бодлогын хүрээ, үндсэн чиглэл

Монгол Улсын төрийн бодлогын тогтолцоонд нийгмийн бодлогын хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд: хүн амын бодлого, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, орлого, цалин хөлс, тэдгээрийн инфляцын хоорондын хамаарал, нийгмийн хамгааллын бодлого, боловсролын бодлого, эрүүл мэндийн бодлого, орон сууцны бодлого, усны гэх мэт бодлогын олон салбар чиглэлүүдийг хамруулдаг. Үүнийг нийгмийн бодлогын харьцангуй тодорхой хүрээ, чиглэл гэж ойлгож болно.

Нийгмийн бодлогын хүрээг үүнээс ч өргөн утгаар ойлгох нь бий. Өргөн утгаар бол нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг бүхий л байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ энд багтдаг. Тухайлбал, түүх соёлын дурсгал, тэдгээрийг хамгаалах асуудал, музей, номын сан, биеийн тамир, соёл, шинжлэх ухаан, урлаг, хэвлэл мэдээлэл зэрэг салбарын асуудлууд бүгд л нийгмийн бодлогын хүрээнд хамрагдах болдог.

Бидний хувьд энэ удаад нийгмийн бодлогын энэ өргөн хүрээтэй асуудлыг бүгдийг хамруулан тайлбарлах зорилго тавиагүй бөгөөд гагцхүү аль ч орны нийгмийн бодлогын суурь асуудлууд гэж үздэг боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн халамж, нийгмийн даатгалын тогтолцоо, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл ядууралтай тэмцэх хөдөлмөрийн хүний хувьд нэн чухал, үйлдвэрчний эвлэлүүдийн үйл ажиллагаанд онцгой анхаарч байх шаардлагатай тийм хүрээг л хамруулан авч үзэхийг чухалчлав.

3. Боловсролын үйлчилгээ

3.1. Боловсролын үйлчилгээ гэж юу вэ?

Боловсролын үйлчилгээ бол төрийн нийгмийн бодлогын нэн чухал салбар, хүрээ мөн. Чухам иймээс ямар ч улс оронд, аль ч нийгэмд боловсролыг чухалчилж үздэг. Боловсрол нь зөвхөн хувь хүний хэрэгцээ төдийгүй нийгмийн чухал үнэт зүйл мөн. Сүүлийн үед боловсролын үйлчилгээг хүүхдүүдэд зөвхөн тоо бодуулж, уншуулж сургах, оюутан залуус мэдлэг олгохоор хязгаарлахаа больж, мэдээлэл ашиглах, мэдсэнээ амьдралд хэрэгжүүлэх өргөн хүрээтэй үйл явцыг хамарсан цогц үйлчилгээ гэж үзэх боллоо.

Боловсрол хувь хүн болоод нийгэмд ямар хэрэгцээтэй байдгийг Зураг 6-д дүрслэн харууллаа. Эндээс хувь хүний хэрэгцээ нь гол төлөв хүнийг өөрийг нь чадавхижуулах, нийгмийн баталгааг нь хангахад чиглэсэн байгаа бол нийгмийн хэрэгцээ нь улс орны эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын олон талт хөгжлийн шаардлагаас урган гардаг нь тодорхой байна.

Зураг 6

Боловсролын хувь хүний хэрэгцээ

Боловсролын хувь хүний хэрэгцээ

- өдөр тутмын амьдрал
- ирээдүйн баталгаа
- нийгэмд эзлэх байр суурь
- амьдралын зорилгодоо хүрэх
- орлогоо нэмэгдүүлэх
- ажлын байр
- мэдээллийг олж авах гэх мэт

Боловсролын нийгмийн хэрэгцээ

Улс орны хөгжилд

- Хүн амд боловсрол олгосноор эдийн засгийн өсөлтийг хангах, боломжтой болдог
- Боловсорсноор технологийг шинэчилж, энэ нь эдийн засгийн өсөлтөнд нөлөөлдөг
- Мэргэжлийн боловсролыг аж үйлдвэрийн бодлоготой холбох хэлбэрээр

Улс төрийн хөгжилд


- Эдийн засгийн өсөлтийг хангаснаар дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлдэг.
- Боловсролтой хүмүүс нь эргээд боловсролыг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр болдог. Энэ нь хувь хүний хэрэгцээ, нийгмийн хэрэгцээ болж байгаа хэрэг.

3.2 Боловсролын функц ба үзүүлэлтүүд

Боловсрол хувь хүн, байгууллага, нийгмийн хэмжээнд янз бүрийн чиг үүрэгтэй \ функц\ байдаг. Тэдгээрийн хамгийн гол функц нь хүнд мэдлэг мэдээлэл олгох, хүнийг хүмүүжүүлж, нийгэмшүүлэх явдал юм. Энэхүү үйл явцын дийлэнх хэсэг нь бүх шатны сургууль, боловсролын үйлчилгээний байгууллагаар дамждаг. Сургуульд шинжлэх ухааны мэдлэгийн үндсийг эзэмшихийн зэрэгцээ хүн соёл, иргэншлийн үнэт зүйлсээс суралцдаг.

Боловсролын үзүүлэлт. Аливаа улс орны боловсролын хөгжлийн байдлыг харуулах үндсэн үзүүлэлтүүдийг мэргэжлийн эрдэмтэд боловсруулан олон улсын хэмжээнд нэгдсэн үзүүлэлтийн системээр гаргадаг болжээ. \Зураг 7\

Боловсролын үзүүлэлт



Энэ үзүүлэлтээр Баруун Европ, Умард Америкийн орнууд 100%, Зүүн Өмнөд Европ, Балтын орнууд 97-98%, Латин Америк, Карибын арал, Ойрхи Дорнод, Номхон далай Зүүн Ази 84-87%, Африк, Өмнөд Азид 49% байна. Гэвч 60 жилийн өмнөхтэй харьцуулахад буурай орнуудын боловсролын төвшин өссөн байгаа юм. Монголд 96% байсан бол одоо 83%-тай байна. Энэ өөрчлөлт нь хот хөдөөгийн шилжилт хөдөлгөөнтэй голлон холбоотой болохыг судлаачид тэмдэглэжээ.

Ихэнх оронд сургалтын тогтолцоо нь бага, дунд, дээд гэсэн шатлалтай байдаг. Сурагч багшийн харьцааг улс орон бүр өөрөөр тогтоодог. Нэг багшид ногдох хүүхдийн тоо. Нэг багшид олон хүүхэд ногдох тусам сургалтын чанар мууддаг. Хүүхэд бүртэй харьцах боломж бага байдаг. Төсвөөс боловсролын салбарт зарцуулж буй хөрөнгийн хэмжээг НҮБ-ээс жишиг болгон тогтоосон байдаг. Хөгжиж буй орнуудын хувьд боловсролд зарцуулах хөрөнгө нь ДНБ-ний 3.7%-тай байна. Тухайлбал: Африкт 3.8%, Монголд 5.5%-тай байна. Энэ үзүүлэлт өмнөх тогтолцооны үед 11.5%-ай байсан бол одоо буурсан нь эдийн засагт үүссэн хүндрэлтэй холбоотой.

3.3 Боловсролын чанар, уян хатан байдал ба хүртээмж

Нийгмийн бодлогод боловсролын асуудлыг авч үзэхдээ чанар, уян хатан байдал, хүртээмж гэсэн гурван гол үзүүлэлтийг гол болгон баримталдаг байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн бодлогын нэг гол чиглэл болсон боловсролын бодлогын бүтэц энэ үзүүлэлтээр тодорхойлогдоно гэсэн үг.

Боловсролын чанарыг үнэлэхдээ олон улсын хэмжээнд дор дүрдсэн гурван багц үзүүлэлтийг ашигладаг бөгөөд Монгол улсад ч энэ үзүүлэлтийг хэрэглэж бодлогоо тодорхойлдог.

- (a) Нэг сурагчид ногдох зардал. Энэ зардал багасвал боловсролын чанар муудна. Жишээ нь: багш хүүхдийн харьцаа, хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, анги танхимд зарцуулж буй хөрөнгө, багшийн мэдлэг дээшлүүлэх зардал гэх мэт зардлууд орно.
- (b) Боловсрол нь улс орныхоо соёл, ёс зүйтэй хэр нийцэж байгаа тухай асуудал багтана.
- (c) Сургалтын явц дахь хүүхдийн оролцоо. Сүүлийн үед сурагч төвтэй сургалтыг илүү үр дүнтэйд тооцдог болсон. Энэ нь хүүхдийн бүтээлч чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ.

Боловсролд хүмүүс хамрагдахгүй байх нь олон талын учир шалтгаантай байх боловч ихэнх тохиолдолд дараах гол нөхцөл, онцлогтой холбоотой хүчин зүйлүүд хүүхэд болон насанд хүрэгчдийн аль аль нь сургуульд хамрагдахгүй байх шалтгаан болдог байна.

- (a) Хэлний онцлог, сургалт явуулж буй гол хэлийг сайн мэдэхгүй нөхцөлд тэр сургуульд суралцах боломжгүй.
- (b) Хот хөдөөгийн ялгаа. Бодлого боловсруулагчид төвлөрөл ихтэй газрууд, хотод, их хөрөнгө оруулалт хийхийг дэмжиж, алслагдсан, хүн ам багатай хөдөө орон нутагт бага хөрөнгө хуваарилдгаас хөдөөд сургууль завсардалт их гардаг.
- (c) Ядуурал- нийгэм эдийн засгийн байдал. Сургууль завсардаад буй хүүхдүүдийн хувьд завсардаж буй гол шалтгааны нэг нь тухайн хүүхэд гэр бүлийнхээ орлогод нэмэр болж амьжиргаагаа дэмжих зорилгоор ажил хийх шалтгаанаар сургууль завсарддаг.
- (d) Эцэг эхийн боловсрол. Эцэг эх нь боловсролыг үнэлдэггүй, өөрсдөө боловсрол доогуур гэр бүлийн хүүхэд сургууль завсардах нь илүү байдаг.
- (e) Жендерийн байдал. Энэ асуудал нь дэлхий нийтийн хувьд том асуудал болж байна. Зарим оронд охидын боловсролыг илүү дэмжиж, охид бүх шатны сургуульд илүү хамрагдаж байгаа бол зарим улсад хөвгүүд илүү хамрагддаг гэх мэт. Монгол улсын хувьд, мал хувьчилсан, худалдаа наймаа эрхлэх зэрэгтэй холбоотойгоор хөдөөгийн малчдын хүүхдүүд, ялангуяа хөвгүүд сургуулиас олноороо завсардах хандлага үргэлжилсээр байна.

Боловсролын уян хатан байдал нь боловсролын үйлчилгээний хүртээмжээс шууд хамааралтай байдаг. Үүнээс үндэслэн аль ч улс оронд албан ба албан бус боловсролын тогтолцоо байдаг. Албан боловсролын тогтолцоо нь сургуулиар дамжиж олгогдог бол албан бус боловсрол нь тодорхой зорилтод бүлгүүдэд чиглэсэн байна. Тухайлбал, сургууль завсардсан хөдөөгийн айл өрхийн хүүхдүүдэд зуны сургалт, явуулын багш зэрг хэлбэрээр боловсрол олгож ирсэн. Үүнээс гадна мэдээллийн технологи эрчимтэй хөгжиж буй орчин үед зайн сургалтын хэлбэрийг өргөн ашиглах боломж бүрдэж байна.

4. Эрүүл мэндийн үйлчилгээ

4.1 Эрүүл мэндийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт

Иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх нь нийгмийн бодлогын нэн чухал чиглэл мөн. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас “эрүүл мэнд гэдэг бол зөвхөн өвчин эмгэггүй байх төдийгүй бие бялдар, оюун санааны хувьд ч эрүүл байх явдал юм” гэж тодорхойлсон байдаг. Монгол Улс хүн амынхаа эрүүл мэндийг хамгаалах талаар тодорхой амжилтанд хүрсэн орны тоонд ордог. Өнөөдөр Монголд зах зээлийн зарчмаар ажилладаг төрийн зохицуулалт бүхий эрүүл мэндийн тогтолцоо төлөвшин хөгжиж байна.

Эрүүл мэндийн үйлчилгээ ямар түвшинд байгааг хэмжих нэгдсэн аргачлал, шалгуур үзүүлэлтийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон бусад олон улсын байгууллагууд боловсруулан олон улсын хэмжээнд хэрэглэж байгаа билээ. Дэлхий нийтэд эрүүл мэндийн байдлыг хэмжих үзүүлэлтүүдийг тооцохдоо дараах хүчин

зүйлсийг харгалзан үздэг байна.

- **Дундаж наслалт.** Дундаж наслалт нь тухайн орны байгаль, цаг уурын нөхцөл, эдийн засгийн хөгжлийн түвшин зэрэг олон хүчин зүйлээс хамаарах боловч энд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ шийдвэрлэх үүрэгтэй. Энэ үзүүлэлт доогуур орнуудад Сахарын Африк, Энэтхэг, Монгол гэх мэт улсууд өнөөгийн байдлаар орж байна. Өндөр хөгжилтэй орнуудын хувьд дундаж наслалт 75-аас дээш байна. Монгол хүний төрөлтөөс тооцсон дундаж наслалт өнөөдөр 67.3 байгаа нь сүүлийн үед уртасч буйн илэрхийлэл юм.
- **Хүүхдийн нас баралт.** Бага насны хүүхдийн эндэгдэл бол бас л олон хүчин зүйлээс хамаардаг үзэгдэл. Дэлхий нийтийн жишгээр 1000 хүүхдийн 28 нь эндэж байсан бол 1990 оны байдлаар 1000 хүүхдийн 10 нь 5-аас доош насандаа эндэж байна.
- Дэлхийн зарим улсуудад нүүрлэж байгаа **байгаль орчны бохирдол** нь эрүүл мэндийн байдлыг хэмжих үзүүлэлтэд зайлшгүй харгалзах ёстой хүчин зүйлийн нэг болоод байна. Монгол улсын хувьд экологийн доройтол, байгаль орчны бохирдол нь хүний эрүүл аюулгүй орчин амьдрах эрхийг ноцтой зөрчихөд хүрээд байна.
- **Ядуурал.** Ядуурал бол хүн амын эрүүл мэндэд хамгийн хүчтэй нөлөөлдөг нийгмийн хүчин зүйл юм. Ядуу зүдүү байдлаасаа болж эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдах боломжгүй хүмүүсийн тоо дэлхий дахинд ч, Монгол улсад нэмэгдсээр байгаа. Монгол улсад ядуурал 2003 онд 36.1 хувь байсан бол 39.2 болж өссөн нь үүний нэг илэрхийлэл юм. Иймээс ядуучууд бол нийгмийн эрүүл мэндийн бодлогын гол зорилтод бүлэг байх учиртай.
- Үүнээс гадна **эрүүл мэндийн үзүүлэлт**эд дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хэмжээ, 10000 хүнд ногдох эмнэлгийн орны тоо, нэг эмчид ногдох хүний тоо, нялхсын эндэгдэл, нэг сувилагчид ногдох хүний тоо зэргийг хамруулж бодлого боловсруулах мэдээллийн суурь болгодог.

Эрүүл мэндийн гол үзүүлэлтүүдийг дэлхийн улс орнуудын эдийн засгийн хөгжил, орлогын байдалтай харьцуулан хэрэглэдэг. Чингэхдээ нас баралт, халдварт ба халдварт бус өвчлөл, амиа хорлох зэрэг нийтлэг үзүүлэлтийг сонгодог байна. Эрүүл мэндийн зарим үзүүлэлтийг дэлхийн улс орнуудыг эдийн засгийн байдлаар бага орлоготой, дундаж орлоготой, өндөр хөгжилтэй гэсэн 3 төвшинд зааглан харьцуулж гаргасныг Хүснэгт 2-т харууллаа.

Хүснэгт 2

Бага орлоготой орнуудад	Дундаж орлоготой орнуудад	Өндөр хөгжилтэй орнуудад
- Өвчлөлт өндөр. Халдварт өвчин нас баралтад их нөлөөлдөг байсан. Халдварт бус өвчин, гэмтэл нь нас баралтад төдийлөн ихээр нөлөөлөөгүй. - Эрт нас баралт ихтэй.	- Халдварт ба халдварт бус өвчний хувь тэнцүү. Халдварт өвчнөөс болж нас барах нь бага байдаг.	- Халдварт бус өвчин дийлэнхи хувийг эзэлдэг. 16-25 насандаа амиа хорлох, осолд орох нь нас баралтын төвшинд тодорхой хувиар нөлөөлдөг. Дунд насандаа зүрх судас, хавдраас болж нас бардаг. Сэтгэцийн өвчин нэлээд хувийг эзэлдэг.

Эдийн засгийн хөгжил сайжирч, хүн амын орлогын түвшин дээшлэхийн хэрээр хүний дундаж наслалт уртасч хүн амын эрүүл мэндийн байдал сайжирдаг нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Энэ бүхэнтэй уялдаж сүүлийн жилүүдэд дэлхийн хөгжилтэй орны хүн амд өндөр настны эзлэх хувийн жин ихсэж байна.

Дээр дурдсан зүйлүүдийг нэгтгэн дүгнэж үзвэл хүн амын эрүүл мэндэд сайнаар нөлөөлөгч хүчин зүйлс нь: амьжиргааны төвшин, хүнсний хангамж, эмэгтэйчүүдийн боловсрол, биотехнологийн дэвшил /вакцин, бактерийн эсрэг эм\, орлогын тэнцүү хуваарилалт, ус, усан хангамж, орон сууц, эмнэлгийн үйлчилгээний хүртээмж, эрүүл мэндийн боловсрол зэргийг багтааж байна.

Нийгмийн бодлогын чиглэлээр эрүүл мэндийн салбарт төр дараах чиглэлээр зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай байдаг. Үүнд:

- Ядуурлыг бууруулахад төрөөс эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулах,
- Эрүүл мэндийн зарим арга хэмжээг хүн амыг бүхэлд нь хамруулан зохион байгуулах,
- Эрүүл мэндийн хувийн хэвшлийн үйл ажиллагааг төрөөс дэмжихийн зэрэгцээ татвар болон стандартын арга механизмаар зохицуулах

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого

- Хүн амын эрүүл мэнд төрийн тусгай анхааралд байна.
- Иргэдэд Эрүүл Мэндийн Анхан Шатны үйлчилгээг ялгаваргүйгээр ижил төвшинд олгоно.
- Өмчийн төрөл харгалзахгүйгээр эрүүл мэндийн байгууллагад ижил тэгш хандана.
- Үндсэн хуульд заасны дагуу иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг төрөөс үнэ төлбөргүй олгоно
- Иргэдэд төлбөртэй, төлбөргүй үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын хууль зохицуулна. Төрийн албан хаагчдын ЭМД-ын 70% -ийг төр хариуцна.

Өнөөдөр Монгол улсын эрүүл мэндийн салбарт олон төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. Зорилго нь Эрүүл Мэндийн Анхан Шатны үйлчилгээг иргэдэд ойртуулахад чиглэж байна. Азийн хөгжлийн банк, ЭМНХЯ хамтран 1997 оноос НҮЭМ-үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлсний зэрэгцээ ДОХ-той тэмцэх үндэсний хөтөлбөр, Иод дутагдлын эмгэгийг устгах зэрэг олон тооны төсөл хөтөлбөрүүдийг хамтарч хэрэгжүүлээд байна.

Одоогийн байдлаар Монгол улсын эрүүл мэндийн салбарт нийт 1500 гаруй эмнэлгийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаагийн дотор:

- Хэвтэн эмчлүүлэх 513
- Асрамжийн 20
- Амбулаторийн үзлэг 735
- Эмнэлэгийн хэрэгслийн худалдаа эрхэлдэг байгууллага 254 байна.

Бүх эмнэлгийн 58.6% нь Улаанбаатарт байна. 1 эмчид 375 хүн оногдож байна. Хүн амын 92.2% эрүүл мэндийн даатгалд хамрагджээ /2012 оны байдлаар/

4.2. Эрүүл мэндийн даатгал

4.2.1. Иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хэмжээ

Монгол улсад хэрэгжүүлж байгаа Иргэний эрүүл мэндийн даатгал нь нийгмийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоо бөгөөд нийгмийн бодлогын эрүүл мэндийн салбарын хүрээнд хамаарагдана. Энэхүү даатгалын харилцааг хуулиар зохицуулна. Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль 1997 онд батлагдаж, улмаар 2002, 2006, 2010 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Эрүүл мэндийн даатгалд иргэд хамруулах нь хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжид чухал нөлөө үзүүлж байдаг. Өөрөөр хэлбэл, иргэний эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэд тухайн даатгалын шугамаар үзүүлдэг тусламж, үйлчилгээг авч чадахгүй.

Эрүүл мэндийн даатгал гэдэг нь иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу даатгалын хураамж авах замаар даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, даатгуулагчийг эмчлүүлэхэд гарах эмчилгээ, үйлчилгээний зардлын төлбөрийг уг сангаас төлөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Эрүүл мэндийн даатгал нь заавал даатгуулах, сайн дураар даатгуулах гэсэн хэлбэртэй байна. Эрүүл мэндийн сайн дураар даатгуулах хэлбэрт Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн өөрийн сонголтоор хамрагдах боломжтой байдаг. Харин заавал даатгуулах хэлбэрт Монгол улсын хуулийн дагуу дор дурдсан иргэд хамрагдах ёстой. Үүнд:

- Аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, аж ахуйн нэгж, байгууллагын болон иргэний малыг тэдэнтэй байгуулсан гэрээний дагуу маллаж байгаа малчин
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч, аж ахуйн нэгжийн эзэн
- 16 хүртэлх насны хүүхэд\ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18 нас хүртэлх\
- Мэргэжлийн сургуульд суралцагч
- Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн
- Хүүхдээ 2 нас хүртэл нь өсгөн бойжуулж буй эх\ эцэг\
- Тахир дутуугийн 1,2 дугаар зэрэг тогтоолгосон иргэн
- Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч малчин
- Нийгмийн халамжид хамрагдсан иргэн

Даатгуулах иргэд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг ямар хэмжээгээр төлөх ёстойг хуулиар нарийвчлан тогтоосон байдгийг Хүснэгт 3-д үзүүлээ.

Заавал даатгуулагч	Төлөх шимтгэлийн хэмжээ /төг/		ЭМД-ын шимтгэлийг хариуцаж төлөх байгууллага
	Сарын	Жилийн	
16 хүртэлх насны хүүхэд, хэрэв ЕБС-д суралцаж байгаа байгаа бол 18 хүртэлх насны хүүхэд	670	8040	Улсын төсвөөс
Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн	670	8040	Улсын төсвөөс
Хүүхдээ 2 (ихэр бол 3) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг)	670	8040	Улсын төсвөөс
Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	670	8040	Улсын төсвөөс

Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэн	670	8040	Улсын төсвөөс
Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	Сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын 4 хувиар, үүнээс ажил олгогч 2 %-ийг, даатгуулагч өөрөө 2 %-ийг төлнө.		
Аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	Татварын албанд гаргасан орлогын мэдүүлгийг үндэслэн нийт орлогын 1 хувиар		
Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч	670	8040	Өөрөө
Малчин	670	8040	Өөрөө
Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд	670	8040	Өөрөө
Ял эдэлж байгаа хоригдол	670	8040	Хорих байгууллага
Гадаадын иргэн, харъяалалгүй иргэд	5360	64320	Өөрөө

4.2.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээ

Даатгуулагч эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ сар бүр төлөх үүрэгтэй бөгөөд даатгуулсан тохиолдолд тухайн жилдээ дараах 8 төрлийн тусламж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх эрхээр хангагдана.

(www.ndaatgal.mn)

Үүнд:

- Хэвтэн эмчлэх тусламж, үйлчилгээ
- Амбулаторийн тусламж, үйлчилгээ
- Оношлогоо шинжилгээ
- Уламжлалт эмчилгээ
- Нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ/ рашаан, сувиллын зардал/
- Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт
- Өдрийн эмчилгээ
- Хөнгөвчлөх эмчилгээ

Нэг даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сангаас олгох хувь, хэмжээг ихэнхи усад Засгийн газар тогтоодог. Монгол Улсын хувьд нэг даатгуулагчийн тусламж, үйлчилгээний хувьсах зардлын хэмжээг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар батлан улсын хэмжээнд хэрэгжүүлж байна. Тухайлбал, даатгуулагч дараах төрлийн үйлчилгээ авсан тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын хэмжээг хүснэгтээр харууллаа. \Хүснэгт 4\

Энд тогтоосон зардлын хэмжээг зарчимын хувьд даатгуулсан иргэн бүр эоүүл мэнийн тусламж үйлчилгээ шаардлагатай үедээ авах боломжтой байдаг. Гэхдээ иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хэрэгцээ шаардлага өөр өөр байдгаас даатгуулагч болгон адил байх боломжгүй. Энэ нь эрүүл мэндийн даатгалын тогтолцоо эв санааны нэгдлийн зарчмыг баримталж буйтай холбоотой юм.


Нэг даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сангаас олгох хувь, хэмжээ

Хүснэгт 4

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Зардлын хэмжээ /төг/
1	Хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ /115 бүлгийн 2500 оношийн хамааралтай бүлгээр/	108380-536060
2	Өдрийн эмчилгээ	68385-134212
3	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	9000-9720
4	Оношлогоо эмчилгээ	30 000
5	Уламжлалт эмчилгээ	80 000
6	Нөхөн сэргээх эмчилгээ	50000-52290
7	Хөнгөвчлөх эмчилгээ	65 000

Даатгуулагчид эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний зардлыг даатгалын сангаас жилдээ олгох дээд хязгаарыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын зөвлөлөөс жил бүр тогтоодог. Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн 2010 оны 04 тоот тогтоолоор эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын дээд хязгаарыг 1112 000 төгрөгөөр тогтоосон. Тэгэхээр өнөөдөр даатгуулагч 8040 төгрөгийн шимтгэлийг төлснөөр эрүүл мэндийн даатгалын сангаас 1112000 төгрөг хүртэлх тусламж, үйлчилгээний зардлыг төлүүлэх боломжтой. Төрөөс эрүүл мэндийн даатгал төлдөг иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээ авсан байдлыг графикаас харна уу.

График 1



Эх сурвалж. Эрүүл мэндийн даатгалаас гадуур үлдсэн хүмүүс. Судалгааны тайлан. УБ., 2011. 21тал

4.2.3. Монгол Улсын иргэнд үнэ төлбөргүй үзүүлдэг тусламж , үйлчилгээ

Монгол Улсын иргэнд түүний даатгуулсан эсэхээс нь үл хамааран дараах тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг. Эрүүл мэндийн тухай хуулиар Монгол улсын иргэн түүний эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эсэхээс үл хамааран дараах тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцдаг. Үүнд:

- Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ;
- Сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн болон удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах зарим эмгэгийн эмчилгээ,
- Халдвар судлалын үйлчилгээ, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх тарилга, халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйжүүлэлт;
- Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээ /зөвхөн төрөлт, жирэмслэлттэй холбоотой шалтгаанаар/;
- Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, осол болон нийтийг хамарсан аюул бүхий халдварт өвчний дэгдэлтийн үед гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ;
- Аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврахаар, эсхүл их хэмжээний хохирлоос сэргийлж яваад гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ.

5. Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ

5.1. Даатгалын тухай үндсэн ойлголтууд

Аливаа даатгал бол эрсдэлийг зөөлрүүлэх, бууруулах, хохирлыг нөхөх агуулгыг илэрхийлж байдаг. Хүний амьдралд жам ёсоороо болон санамсаргүй тохиолдлоор, мөн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр олон янзын эрсдэлүүд гарч болно.

Тэдгээрээс улс үндэстэн бүр өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болох, өвчлөх, тэжээгч нь нас барахад түүний асрамжинд байгаа гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд орлогогүй болох, үйлдвэрлэлийн осолд өртөх зэрэг урьдчилан таах боломжгүй нийгмийн шинжтэй амьдралын зарим эрсдэлийг нийгмийн даатгалд хамруулдаг. Үүнээс гадна эдийн засгийн, байгалийн, улс төрийн хүчин зүйлийн нөлөөллөөс болж иргэдийн орлого олох чадвар буурах сөрөг үр дагавар тохиолддог.

Монгол орны хувьд хүн амын амьдралын чадварт нөлөөлөх нийгмийн шинжтэй эрсдэлээс иргэдийн нийгмийн баталгааг хамгаалах асуудлыг нийгмийн даатгалын системээр дамжуулан шийдвэрлэж байна.

Даатгуулагч гэдэг бол нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ. Харин нийгмийн даатгалын шимтгэл гэдэг бол нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч болон ажил олгогчоос хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын санд төлөх урьдчилсан төлбөрийг хэлдэг.

Тэтгэвэр гэдэг нь даатгуулагчийг өндөр наслахад нь насан туршид нь, тахир дутуу болоход нь хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд /хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл/-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгө мөн. Тэтгэмж бол Даатгуулагчид хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд

нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Төлбөр гэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 буюу түүнээс дээш хувиар алдсан даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нөхөн олгох хиймэл эрхтний үнэ, рашаан сувиллын газрын үйлчилгээний хувьсах зардлыг хэлдэг. Хуримтлалын сан гэдэг нь нийгмийн даатгалын сангийн хөрөнгө болон тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нөөцөлсөн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

5.2. Нийгмийн даатгалын шимтгэл ба нийгмийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж

Ажил олгогч болон даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг дор дурдсан хувь хэмжээгээр төлнө. Энэ хувь хэмжээг хуулиар нарийвчлан тогтоож өгсөн байдаг. Харин зарим аж нэгж, байгууллага, ялангуяа хувийн хэвшилд ажил олгогчийн хувьд төлөх даатгалынхаа хувь хэмжээг бага байлгахын тулд цалингийн хэмжээг бодит олгож буй хэмжээнээсээ багаар тооцож шимтгэл төлөх, бүр төлөхгүй байх тохиолдол ч гардаг байна. Энэ бол чухамдаа Монгол Улсын хуулийг зөрчиж буй хэрэг. Иймээс иргэд энэ байдлыг анхаарч шимтгэлээ зохих хуулийн дагуу төлдөг байхаа л анхаарах шаардлагатай. \Хүснэгт 5\

Хүснэгт 5

Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хэмжээ /хувиар/
Тэтгэврийн даатгал	7.0	7.0
Тэтгэмжийн даатгал	0.5	0.5
ҮОМҮӨ-ний даатгал	1.0, 2.0, 3.0	-
Ажилгүйдлийн даатгал	0.5	0.5
Эрүүл мэндийн даатгал	2.0	2.0
Бүгд	11.0, 12.0, 13.0	10.0

Даатгалын шимтгэл төлсөн иргэд нийгмийн даатгалын сангаас хуульд заасны дагуу хэд хэдэн төрлийн төрлийн тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй байдаг. Гэхдээ тэтгэвэр тэтгэмж бүрийг нийгмийн даатгалын сүлжээнд багддаг тухай тухайн төрөлжсөн сангуудаар дамжуулан олгодог байна. Тухайлбал, Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэрийг олгодог бол Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, оршуулгын тэтгэмж зэргийг олгодог.

Харин Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын даатгуулагчийг сувилахад ногдох тусламж, үйлчилгээний хувьсах

зардал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал зэргийг олгодог бол Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчид үзүүлэх амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зардлыг тус тус олгох журамтай.

5.3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хувь хэмжээ

Нийгмийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэвэр, тэтгэмжийн хувь хэмжээг төлсөн шимтгэлтэй нь уялдуулан мөн хуулиар тогтоож, даатгалын байгууллагаар дамжуулан олгодог. Даатгалын шимтгэл төлөх, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж олгох үндсэн үйл ажиллагааг даатгалын байгууллага хариуцдаг боловч, төрийн байгууллага, ажил оогчийн үүрэг оролцоо нэлээд бий. Эдгээр байгууллагын үйлчилгээ, ажил хариуцсан ажилтнууд, түүний дотор хүний нөөц, архив бичиг хэргийн ажилтнуудын ажлын хариуцлагаас хамаардаг. Энд янз бүрийн чирэгдэл, хүзнд суртал, ажлын хариуцлагагүй байдал гарваас даатгуулагч иргэд хохирох тохиолдол цөөнгүй гардаг байна. Иймээс даатгалын үйлчилгээд оролцогч талуудын нягт уялдсан хамтын ажиллагаа чухал. Сүүлийн жилүүдэд иргэний бүртгэл, мэдээллийн тогтолцоо боловсронгуй болж, үйлчилгээнд мэдээллийн технологи өргөн нэвтэрч байгаа нь даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжэд эерэг сайн нөлөө үзүүлж байна.

Даатгуулагчийн өндөр насны тэтгэврийг дараах хувь хэмжээгээр бодож тогтоох бөгөөд насан туршдаа авах эрхтэй. \Хүснэгт 6\

Хүснэгт 6

Үзүүлэлт	Хөдөлмөрийн нөхцөл			
	хэвийн	хүнд	хортой, халуун	газар доорх
	тэтгэвэр бодох хувь хэмжээ			
Сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлого	45			
Тэтгэвэрийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлсний 1.5% бодож нэмэгдэл олгоно.				
Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэвэрийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1.0 хувиар бодож нэмэгдүүлнэ.				

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмж нь: хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж жирэмсний болон амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж гэсэн үндсэн төрлүүдтэй байна.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ердийн өвчнөөр өвчилж, эсвэл ахуйн осолд орж хөдөлмөрийн чадвараа түр алдахаас өмнө 3 сар буюу түүнээс дээш хугацаагаар тэтгэмжийн даатгалын шимтгэлээ төлсөн иргэн, хүүхдээ жирэмсний 7 сар хүртэл хугацаанд тээж дутуу төрүүлсэн, эсвэл үр хөндүүлсэн иргэд дараах хувь хэмжээгээр \Хүснэгт 7\ авах боломжтой.

Хүснэгт 7

Шимтгэл төлж ажилласан жил	Тэтгэмж бодох хувь
5 хүртэлх жил	50
5 — 14 жил	55
15 а түүнээс дээш жил	75

Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг байгууллагын нягтлан бодогч нь даатгуулагч эхийн жирэмсний чөлөө авахаас өмнөх шимтгэл төлсөн 12 сарын цалин хөлс, орлогыг тодорхойлж, уг цалин хөлс, орлогын нийлбэрээс дундаж цалингийн хэмжээтэй гаргана. Жишээлбэл, жирэмсэн 2011оны 8-р сарын 1-ний өдөр жирэмсний чөлөө авсан бол оны тухайн байгууллагад тасралтгүй ажилласан 2011.08.01-ний өдрөөс 2012.07.31-ний өдөр хүртэлх хугацааны цалин, орлогын нийлбэрээс тооцож бодсон сарын цалин орлогын дундаж хэмжээтэй тэнцэх тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас олгоно. Тухайн амаржих эхийн сард 450 000 төгрөгийн цалин орлоготой байсан гэж тооцоод түүнд нийгмийн даатгалаас олгох тэтгэмжийн хэмжээ ямар байж болохыг жишээ болгон хүснэгт 8-д харууллаа.

Хүснэгт 8

Сарын ажлын өдрийн дундаж хоног	Сарын дундаж хөлс, орлого	Нэг өдөрт ногдох хөдөлмөрийн хөлс, орлого	Тэтгэмж бодох хувь	Нэг өдөрт ногдох тэтгэмж /7*8/	Тэтгэмж олгох хоног /ажлын өдөр/	Олговол зохих тэтгэмж /9*10/
6	5	7	8	9	10	11
21.2*	450 000	21 226	100**	21 226	45***	955 188

Тайлбар: * Жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох сарын ажлын өдрийн дундаж 21.2 хоног.

/21.2-ыг зөвхөн жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодоход хэрэглэнэ./

**Заавал даатгуулагч эхийн тэтгэмжийг 100 хувиар бодно.

***Тэтгэмж олгох ажлын хоногийг жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсан дээрх хуанлийн хоногоос тооцон гаргана.

Харин сайн дурын даатгуулагч эх нь эмнэлгийн хуудас, нийгмийн даатгалын дэвтрээ оршин суугаа аймаг, сум, дүүргийнхээ нийгмийн даатгалын хэлтсийн байцаагчид авчирч өгч шимтгэл төлсөн хугацааг тодорхойлон бичүүлж, тэтгэмжээ бодуулна.

Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан сүүлийн 3 сарын орлогын дунджаас дараах хувиар бодож олгохоор журамласан байдаг. Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг оршин суугаа газрынхаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс /ХХУХ/ эсвэл нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн ажлын 76 өдөр дуустал хугацаанд олгоно. Энэ хугацаанд ажилд орвол ажилд орсон өдрөөс тэтгэмж олгохгүй. Хувь хэмжээг хүснэгт 9-д зааснаар тогтооно.

Хүснэгт 9

Шимтгэл төлж ажилласан хугацаа /жилээр/	Тэтгэмж бодох хувь
5 хүртэл жил	45
5-10хүртэл жил	50
10-15 хүртэл жил	60
15 ба түүнээс дээш жил	70

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж нь тусгайлсан зохицуулалтаар хийгддэг өвөрмөц төрлийн үйлчилгээ байдаг. Энэ нь тэтгэвэр, тэтгэмж, төлбөр гэсэн үйлчилгээний төрлүүдтэй байна.

Тахир дутуугийн тэтгэврийн хэмжээг яаж тооцдог вэ? Тахир дутуугийн тэтгэврийг даатгуулагчийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогоос үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 10 хүртэл хувиар алдсан бол 10 хувиар, 10-аас дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тогтооно. Жишээлбэл, даатгуулагч "Д" үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 55 хувиар алдаж тахир дутуу болсон. Түүний сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлого 375000 төгрөг. Тэгэхээр даатгуулагч "Д" тахир дутуугийн тэтгэвэрт сард 206250 төгрөг ($375000 \times 55\%$) авна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар түр алдахад даатгуулагчид ямар хэмжээний тэтгэмж олгодог вэ? Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг шимтгэл төлж ажилласан хугацааг үл харгалзан даатгуулагчийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогын 100 хувиар тооцож олгоно. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцож олгох ёстой.

Даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас өөр ямар төрлийн төлбөр олгох вэ? Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ хийлгэсний эхний удаагийн үнийн 100 хувь, 2 дахь удаагийн үнийн 50 хувийг олгоно. Мөн зайлшгүй шаардлагаар мэргэжлийн (гэмтлийн) эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дагуу засал эмчилгээ (протез, ортопед)-г гадаад оронд хийлгэхэд түүний нэг удаагийн үнийг олгоно.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч рашаан сувилалд сувилуулахад гарсан зардлыг төлөх үү? Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 ба түүнээс дээш хувиар алдсан даатгуулагч улсын хэмжээний үйлчилгээтэй Хужирт, Өвөржанчивлан, Аржанчивлан, Аварга тосон, Гурван нуур, Оргил, Шаргалжуут, Отгонтэнгэр, Халзан-Уулын сувиллууд, түүнчлэн мэргэжлээс шалтгаалсан өвчний сувилалд сувилуулсан бол сувиллын зардал, ирэх, очих унааны зардлыг олгоно. Уг сангаас олгох сувиллын болон унааны зардлын хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

6. Монгол Улсын нийгмийн бодлогын зарим чухал асуудал

6.1. Ажилгүйдлийг багасгах нь

Иргэн хүн ажил орлоготой байх нь түүний нийгмийн хамгийн гол баталгаа болдог. Ийм учраас ажилгүйдлийг багасгах зорилт аль ч улсын хувьд нийгмийн бодлогын гол цөм асуудал болдог байна. Ажилгүйдэл хэмээх үзэгдэл нь хөдөлмөрийн зах зээл дээрх мөчлөгт үйл явц бөгөөд ажиллах хүчний эрэлтээс нийлүүлэлт давснаар ажилгүйдэл бий болдог.

Ажилгүйчүүд гэдэг нь хөдөлмөрийн чадвартай, ажил хөдөлмөр идэвхтэй хайж байгаа, хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн албанд бүртгэгдсэн ажилгүйчүүдийн тоо нь жинхэнэ ажилгүй байгаа бүх хүний тоог бодит байдлаар илэрхийлж чаддаггүй байна. Гэтэл ажилгүйдлийг багасгахад төрийн бодлогын гол эх сурвалж нь үнэн бодитой мэдээлэл мөн учраас мэдээллийн чанар төрийн бодлогод их чухал юм.

Төрийн нийгмийн бодлогын үндэс болдог гол үзүүлэлтийн нэг бол ажилгүйдлийн төвшин мөн. Энэ хөдөлмөрийн зах зээл дэх өөрчлөлтийг харуулдаг. Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдийг Үндэсний статистикийн хорооноос гаргадаг хүн амын ажил эрхлэлтийн судалгааны үр дүнгээр тооцон гаргадаг байна. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 01\68\94 тоот тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу өнөөгийн статистик мэдээллийг тооцон гаргаж байгаа болно.

Ажилгүйдлийн түвшин гэдэг бол ажиллах хүчний хэдэн хувь нь ажилгүйчүүд эзэлж байгааг харуулдаг үзүүлэлт бөгөөд ийм үзүүлэлтийг олон улсын нийгмийн болон хөдөлмөрийн статистикт өргөн хэрэглэдэг байна. Хамгийн сүүлийн буюу 2013 оны 1-р улирлын мэдээгээр Монгол Улсын ажилгүйдлийн түвшин улсын дундаж нь 9.3 хувь байна. Энэ үзүүлэлт 2013 оны эхэнд 7.9 хувь байжээ. \ Хүснэгт 10\

Хүснэгт 10

Ажилгүйдлийн түвшин: Улсын дундаж 9.3 хувь, 2013 оны I улирал			
Аймаг	Хүйс	2013	2013 1/4
Улсын дүн	Бүгд	7.9	9.3
	Эрэгтэй	8.5	9
Үүнээс:	Эмэгтэй	7.3	9.7
Баруун бүс	Бүгд	11.9	15.1
Баян-Өлгий	Бүгд	19.7	27.7
Говь-Алтай	Бүгд	14.7	15.4
Завхан	Бүгд	4.5	6.9
Увс	Бүгд	11	12.4
Ховд	Бүгд	8.2	8.4
Хангайн бүс	Бүгд	8	9.9
Архангай	Бүгд	6.5	7.4

Баянхонгор	Бүгд	4.5	6.2
Булган	Бүгд	5.1	0.5
Өвөрхангай	Бүгд	1.5	7.3
Хөвсгөл	Бүгд	16	15.4
Орхон	Бүгд	11.4	18.2
Төвийн бүс	Бүгд	8.4	10.1
Дорноговь	Бүгд	3.1	6.8
Дундговь	Бүгд	6.9	11.3
Өмнөговь	Бүгд	5.2	4.4
Сэлэнгэ	Бүгд	6.2	14.2
Төв	Бүгд	8.6	9.9
Дархан-Уул	Бүгд	16.9	10.5
Говьсүмбэр	Бүгд	4.2	9.4
Зүүн бүс	Бүгд	8.3	12.7
Дорнод	Бүгд	5.2	8.2
Сүхбаатар	Бүгд	9.1	10.3
Хэнтий	Бүгд	9.9	18.6
Улаанбаатар	Бүгд	5.9	5.3
Хан-Уул	Бүгд	6.9	4.7
Багануур Багахангай	Бүгд	13.6	6.2
Баянзүрх	Бүгд	4.5	2.8
Налайх	Бүгд	3.5	1.6
Баянгол	Бүгд	6.6	5.1
Сүхбаатар	Бүгд	4.4	1.7
Чингэлтэй	Бүгд	11.2	9.8
Сонгинохайрхан	Бүгд	2.8	8.1

Эх сурвалж. www.mol.gov.mn, статистик мэдээлэл

Монгол улсын хөдөлмөрийн насны нийт хүн 1.8 сая байгаа бөгөөд бүртгэлтэй ажилгүй иргэн 37.2 мянган хүн байна. Тэгвэл 2013 оны 8-р сарын байдлаар ажлын шинэ байранд орж ажилласан иргэн 35.3 мянгад хүрчээ. Эндээс Монгол улсад ажилгүйдлийг бууруулах боломж байгаа гэдэг нь харагдаж байна.

Ажилгүйдлийг багасгах гол бодлого бол шинээр ажлын байрыг бий болгох, үндэсний үйлдвэрлэл, жижиг дунд бизнесийн дэмжихэд чиглэдэг. Энэ бодлого нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хамаардаг учраас “Эдийн засгийн бодлого” гэсэн энэ номын 2-р бүлэгт тоймлон тайлбарласан учраас энд дэлгэрэнгүй авч үзсэнгүй. Зөвхөн нийгмийн бодлогын нэг суурь асуудал гэдгийг онцлов.

6.2. Ядуурал, түүнийг бууруулах нь

Ядуурал бол хувь хүнээс эхлээд айл өрх, нийгэм, үндэстний хэмжээг хамардаг үзэгдэл юм. Тийм учраас ядуурлын шалтгаан, бодит хэмжээ, бууруулах арга замын тухай сэдэв аливаа улсын төрийн бодлого, тэр тусмаа нийгмийн бодлогын суурь асуудал байдаг. Ядуурал нь хамгийн ерөнхий агуулгаараа хүний амьдрал, үйл ажиллагааны хэвийн нөхцөл хангагдахгүй, тогтоосон стандартыг эдийн засгийн

нөөцөөр хангаж чадахгүй байгаа төлөв байдлыг харуулна.

Нийгмийн бодлогод ядуурлын шалтгаан, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг нарийвчлан судалж, ядуурлыг бууруулах арга замыг тодорхойлдог байна. Өнөөдөр Монгол улсад ядуурлын нөхцөл байдал ямар байгааг судлаачид дор дурьдсан байдлаар тодорхойлж байгаа бөгөөд Засгийн газар ядуурлыг бууруулах талаар энд дурдсан арга замуудыг ашиглан тодорхой бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа гэж үзэж болно. |Хүснэгт11\

Хүснэгт 11

Ядуурал гарахад нөлөөлж буй хүчин зүйлс	Ядуурлын шалтгаан	Ядуурлыг бууруулах арга зам
1.Эдийн засгийн уналтаас шалтгаалан үнийн өсөлт, инфляцийн түвшин өндөр байгаагаас орлого, цалин хөлс багасах 2.Ажилгүйдэл нэмэгдэх 3.Бичиг үсэггүй байдал, хангалтгүй боловсрол 4.Хөдөлмөрч бус байдал, бэлэнчлэх сэтгэлгээ 5.Өвчин эмгэг, эрүүл мэндийн дорой байдал 6.Бусад (цаг агаар, байгаль орчны байдал, зах зээлээс алслагдсан нөхцөл, үнийн зөрүү, орон байр, хөрөнгө нөөцгүй гэх мэт)	1.Хүн амын шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотойгоор хот суурин газарт хүн амын нягтрал ихэссэн. 2.Байгалийн гамшигт малчид, тариаланчид олноор өртөх болсон 3.Ажлын байр хомсдсон 4.Гэмт хэрэг ихэссэн 5.Архидалт ихэссэн	1. Хүн амын орлогын эх үүсвэрийг бий болгох, нэмэгдүүлэх 2. Ажлын байр бий болгох 3. Боловсрол, мэргэжилтэй болоход туслах 4. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зээл олгох 5. Нийгмийн хамгаалал, хангамжийн тогтолцоог боловсронгуй болгох

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)болон Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогыг үндэслэн тооцсон ядуурлын үзүүлэлтүүдийг бүсээр тооцон гаргасан мэдээллийг Хүснэгт 12-т харуулжээ. Энэ мэдээллээс үзэхэд жил бүр явуулдаг ӨНЭЗС болон 10 жил тутам зохион байгуулдаг \сүүлийнх нь 2010 онд болсон\ Хүн ам, орон сууцны тооллогын нэгдсэн дүнгээр гарсан ядуурлын мэдээлэлд бага зэргийн зөрөө байгаа боловч ерөнхий дүр зураг адилхан гарсан байна. Харин хөдөөд хотоос ядуурал их, бүс нутгуудын хувьд зүүн болон хангайн бүсүүдэд бусад бүс нутгаас илүү байгаа юм. Ийм учраас төрийн ядуурлыг бууруулах бодлого юуны өмнө хөдөөд голлон чиглэж, түүний дотор зүүн болон хангайн бүсүүдэд илүү их анхаарах шаардлагатай байгаа гэж үзэж болно. |Хүснэгт 12\

Хүснэгт 12

	Ядуурлын хамралтын хүрээ		Ядуурлын гүнзгийрэлт		Ядуурлын мэдрэмж	
	ӨНЭЗС	Тооллого	ӨНЭЗС	Тооллого	ӨНЭЗС	Тооллого
Улаанбаатар	23.5	23.4	5.9	6.7	2.1	2.8
Зүүн	34.3	34.0	9.3	10.1	3.5	4.3
Төв	27.2	26.3	7.1	7.8	2.6	3.3
Хангай	38.9	38.5	9.9	10.9	3.5	4.4
Баруун	30.2	30.2	7.9	7.9	2.9	3.0

Эх сурвалж. Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлын зураглал-2011 Ядуурлыг үнэмлэхүй ба харьцангуй гэж 2 ангилдаг. Үнэмлэхүй ядуурал гэдэг

нь амьдралын наад захын хэрэгцээгээ хангах чадваргүй болсон байдлыг хэлнэ. Үүнийг энгийн үгээр нэн ядуу, туйлын ядуу гэх мэтээр илэрхийлдэг. Харьцангуй ядуурал гэдэг нь амьдралын боломжийн жишиг гэж тухайн улсын хэмжээнд тогтоосон үзүүлэлтүүдийг хангах эдийн засгийн чадваргүй байдал юм. Өөрөөр хэлбэл, амьдралынхаа анхдагч наад захын зайлшгүй хэрэгцээгээ хангаж байгаа боловч тогтоосон амьжиргааны доод түвшинд хүрэхгүй байхыг хэлнэ.

Улс орны хэмжээнд ядуурлыг бууруулах бодлого явуулахдаа гол төлөв өрхийн төвшний ядуурлын үзүүлэлтүүдийг ашигладаг. Тухайн өрхийг үнэмлэхүй эсвэл харьцангуй ядуу гэдгийг тодорхойлохдоо дор дурьдсан үзүүлэлт бүхий аргачлалыг хэрэглэнэ. Үүнд:

1. Тухайн өрхийн нэг хүнд ногдох сард мөнгөний хэмжээг тогтооно
2. Тухайн өрх аль бүсэд харьяалагдаж байна вэ? гэдгийг тодорхойлно.
3. Бүсийн АДТ / амьжиргааны доод түвшин/-гөөс сарын нэг хүний орлого нь их эсвэл бага байна уу гэдгийг тогтооно.
4. Нэг хүнд оногдох мөнгөний хэмжээ нь АДТ-гөөс их байвал ядуу өрхөд тооцогдохгүй. Тиймээс ядуурал тодорхойлох шаардлагагүй. Харин бага байвал ядуу бөгөөд ямар ядуу гэдгийг тодорхойлох шаардлагатай болно.
5. Бүсийн АДТ-г 100% гэж үзээд нэг хүнд оногдсон мөнгөө "Х" % гэж тооцоод бодолт хийнэ. АДТ-гийн 40%-иас доош орлого сард нэг хүнд ноогдож байвал үнэмлэхүй ядуу, харин 40%-иас дээш ноогдож байвал харьцангуй ядуу юм.

Ядуурлыг бууруулах хамгийн үр өгөөжтэй арга зам бол ажил эрхлэлтийг дэмжих явдал мөн. Иймээс төрийн нийгмийн бодлого юуны өмнө ажлын байрыг олноор бий болгож, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэдэг. Төр өөрөө том ажил олгогчийн хувьд хамгийн их ажлын байрыг буй болгох үүрэг хүлээнэ. Харин хувийн секторт хөдөлмөрийн бүтээмж өндөртэй ажлын байр бий болгоход төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх бодлого хэрэгжүүлдэг. Үүнд олон арга хэлбэр байж болох боловч гол нь ажлын байр шинээр буй болгосон хувийн байгууллагыг тодорхой хугацаанд татвараас чөлөөлөх, тэдэнд шууд болон шууд бус татаас олгох, шаардлагатай мэргэжлийн ажиллах хүчин бэлтгэхэд нь төрөөс дэмжлэг үзүүлэх хэлбэрүүд чухал байдаг.

НҮБ-ын Хөгжлийн Тусламжийн Хүрээнд 2012-2016 онд Монгол Улсад хэрэгжиж буй Монгол улсын Засгийн Газар иргэний нийгэм, хөгжлийн бусад түншүүдтэй стратегийн дөрвөн үндсэн чиглэлээр хамтран ажиллах хөтөлбөрт "Нийгмийн суурь үйлчилгээг чанартай тэгш хүртээх, нийгмийн хамгааллын тогтвортой систем бий болгох" зорилтыг дэвшүүлсэн байна. Энэхүү зорилтын хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх зорилгоор хийсэн хүн ам, эдийн засаг, ядуурал, эрүүл мэнд, боловсрол, амьдралын хэв маяг, хүний хөгжил, дэд бүтцийн талаархи судалгааны тайланд

- Ядуу болон эмзэг бүлгийн хүн амын амьжиргааны нөхцөл сайжирсан
- Ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлого, стратегийг боловсруулсан
- Эмзэг бүлгийн хүн амд чиглэсэн боловсролын чанар хүртээмж сайжирсан
- Хотын гэр хороолол болон хөдөө орон нутгийн хүн амын найдвартай ус хангамж, ариун цэврийн үйлчилгээний тэгш хүртээмжийг хангасан
- Эмзэг бүлгийн хүн амд чиглэсэн эрүүл мэндийн чанартай үйлчилгээний хүртээмж болон ашиглалт нэмэгдсэн
- Эмзэг бүлгийнхэнд онцгой анхааран нийгмийн хамгаалал бэхжиж өргөжсөн

\НҮБ-ын Хөгжлийн Тусламжийн Хүрээ. 2012-2016.УБ.,2011.V-VI тал Нийгмийн санаа бодол. 5 дахь засаглал/

тэмдэглэснээс үзэхэд уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ядуурлыг буруулахад нааштай үр дүн гарч байгаа гэж олон нийтийн төлөөлөл үзсэн байна.

Ядуурлыг буруулах бодлого нь хот ба хөдөөгийн өвөрмөц байдлыг нарийн харгалзан үзэхгүйгээр бодит үр дүнд хүрч чадахгүй. Монгол улсад хотын болон хөдөө орон нутагт ядуурлыг буруулахад онцлон анхаарах асуудал нь адил биш байдаг юм.

Хотын ядуурлын дийлэнх хэсэг нь хотын гэр хороололд төвлөрдөг, гэр хорооллын иргэдийн нэлээд хэсэг нь хөдөөнөөс шилжин ирэгсэд байгаа. Тиймээс хотын ядуурлыг бууруулахад гэр хороололд ядуурал, ажилгүйдэл, өндөр байгааг үндэслэн гэр хорооллын ядуучуудыг зорилтот бүлэг болгон сонгон авч цогц арга хэмжээг бодлогод /ажил эрхлэлтийн бодлого/ тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний тулд гэр хорооллын иргэдийн нутаг дэвсгэрийн харьяалал, бүртгэлийг сайжруулах, энэ үндсэн дээрээ тэдэнд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай болгох нь ач холбогдолтой. Энэ нь тэднийг нийгмийн үйлчилгээнээс хүртэх боломжийг бүрдүүлэх, үр хүүхдээ сургуульд хамруулах, эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах улмаар хотын албан секторт ажил олох боломжид эерэг нөлөөтэй билээ. Цаашилбал, албан ёсны бүртгэлтэй болох, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөө бүртгэж баталгаажуулах нь тэднийг банкнаас зээл авах, зээлийн эх үүсвэрээр бизнес эрхэлж, орлогоо нэмэгдүүлж ядуурлаас гарахад тус дэмтэй.

Хөдөөд ядуурлыг бууруулах бодлого нь хөдөөгийн иргэд, ялангуяа, малчдын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэх ёстой. Хөдөөд малчид малгүй болох, бизнес болон ажил эрхлэх боломж муудах зэргээс шалтгаалан орлого нь буурснаас хот руу шилжих болдог. Ингэснээр хөдөөд ажиллах хүчин дутагдах, үйлдвэрлэл үйлчилгээний хүрээ багасах, зах зээлийн хэрэглэгч цөөрөх зэрэг сөрөг үзэгдэл газар авч улмаар ядуурал нэмэгддэг байна. Иймээс хөдөөд ажил эрхлэлт болон орлогыг нэмэгдүүлэх нь ядуурлыг бууруулахад чухал нөлөөтэй. Үүний зэрэгцээ ХАА-н бүтээгдэхүүний үнэ өсөх, малын болон газар тариалангийн үр шим нэмэгдэх нь хөдөөгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх талтай.

Дурдсан хоёр хүчин зүйлийг харгалзан ХАА-н салбарт хүний амьдрах орчин, нөхцөлийг сайжруулж орон сууц, сургууль, цэцэрлэг барьж байгуулах, хөдөөгийн иргэдийн боломжид тохирсон өрхийн болон хоршооллын жижиг бизнесийг дэмжих, хөдөөгийн хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хүнд хүчир хөдөлмөрийг хөнгөвчилсөн орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, энэ бүхэнтэй уялдуулж хөдөөгийн хөдөлмөрчдийн чадвар, чадавхийг сайжруулахад нийгмийн бодлого чиглэж байна. Мөн хөдөөд санхүүгийн секторыг хөгжүүлж, зээлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлснээр хөдөөгийн иргэд эрсдэл багатай, найдвартай санхүүгийн үйлчилгээ хүртэх боломжтой болж, ядуурал, эмзэг байдлыг бууруулахад чухал нөлөө үзүүлнэ. Эндээс л эдийн засгийн болон нийгмийн бодлогыг уялдаатай хөгжүүлэх зайлшгүй шаардлага гардаг.

6.3. Макро эдийн засаг ба хөдөлмөрийн зах зээл, цалин хөлс

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд бол нэг талаас нийгмийн бодлогын чиглэлээр хэрэгжүүлэх зорилт, хөтөлбөрүүдийн суурь үндэс болдог, нөгөө талаас нийгмийн бодлогын үр дүнг илэрхийлж байдаг. Макро эдийн засаг бол эдийн засгийн харилцааны аль нэг эд эсийг бус бүхэлд нь авч судалдаг. Тухайлбал, эдийн засгийн өсөлт, үндэсний нийт бүтээгдэхүүн\ҮНБ\, инфляц, ажилгүйдэл, улсын

төсөв, зарлагын хэмжээ, гадаад худалдааны тэнцэл зэргийг хамарсан улс орны эдийн засгийн чадавхийн зураглал юм.

Макро эдийн засгийн үзүүлэлт сайжирвал нийгмийн салбарт өргөн хүрээтэй, тогтвортой, томоохон хэмжээний төсөл хөтөлбөрүүдийг дэвшүүлэн хэрэгжүүлэх боломж байна гэсэн үг. Харин энэ үзүүлэлтүүд буурч, хүндэрч эхэлбэл нийгмийн салбарт үр дүнтэй бодлого хэрэгжүүлэх бололцоо хязгаарлагдмал болно. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн талаар энэ номын "Эдийн засгийн бодлого" гэсэн хоёрдугаар бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн учраас энэ бүлэгт нийгмийн бодлогод илүү чухалд тооцогддог хөдөлмөрийн зах зээл, цалин хөлсний холбогдол бүхий зарим асуудлыг товч тайлбарлав.

Эхлээд хөдөлмөрийн зах зээлийн тухай авч үзье. Хөдөлмөрийн зах зээл /ХЗЗ/ гэдэг нь хөдөлмөрийн нийлүүлэлт /ажиллах хүч, ажилд авагч/, хөдөлмөрийн эрэлт /үйлдвэрийн эзэн, төр, ажил олгогч/ хоёр зах зээлийн эерэг талын төсөөлөл, боломжийн талаар харилцан мэдээлж, хөдөлмөрийн гэрээ байгуулж болох боломжтой эдийн засгийн харилцааны орон зай юм. Зах зээлийн нийгэмд гагцхүү хөдөлмөрийн зах зээл дээр л хүн ажил, орлоготой болж, ахуй амьдралаа дээшлүүлэх хамгийн өргөн боломжтой байдаг.

Монгол орны хувьд өнөөгийн байдлаар хөдөлмөрийн харилцаатай холбогдох асуудлыг эрхлэх төрийн захиргааны төв байгууллага нь Хөдөлмөрийн яам юм. Хөдөлмөрийн яамны бүтэц, зохион байгуулалт, эрхлэх асуудлын хүрээ, бодлого, үйл ажиллагааны тухай мэдээллийг www.mol.gov.mn цахим хуудаснаас танилцаж болно.

Орчин үеийн нийгмийн хөдөлмөрийн зах зээлд хөдөлмөрийн бирж маш чухал үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улсын Хөдөлмөрийн төв бирж энэ үүргийг гүйцэтгэдэг. Биржийн эрхэм зорилго нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд эрхэлж Монгол Улсын ажиллах хүчний хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой түвшинг хангахад чиглэдэг. Хөдөлмөрийн биржийн гол ажил нь зах зээл дээр ажилд зуучлах үйл ажиллагаа. Энэ нь тодорхой үе шатыг дамжин хэрэгждэг үйлчилгээ юм. Ажилд зуучлах үйлчилгээ нь дараах үе шаттай. Үүнд:

- Ажил хайгч, их дээд сургууль, МСҮТ төгсөгчдийн дэлгэрэнгүй бүртгэл хийх
- Ажил олгогчдоос ирүүлсэн сул, чөлөөтэй ажлын байрны бүртгэл гаргах
- Ажил олгогчийн захиалгад нийцэх ажил хайгчийг сонгох
- Ажил олгогчдын ирүүлсэн ажлын байранд тохирох ажил хайгчийг санал болгох
- Сонгогдсон ажил хайгч ажил олгогч байгууллагад очиж анкет бөглөх
- Ажил олгогч нь ажил хайгчийн анкетад сонгон шалгаруулалт хийх
- Ажил олгогчийн ярилцлагад урих.
- Ажилд авах шийдвэр гаргах

Мэдээллийн цахим технологи эрчимтэй хөгжсөн өнөө үед хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаанд E_Бирж\E-Birj\-ийн хэлбэр өргөн хэрэглэгдэж, биржийн үйл ажиллагаа ч бүхэлдээ цахимжих хандлагатай болжээ.

E_Бирж нь орчин үеийн дэвшилтэд технологиор ажлын байрны талаарх мэдээллийг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилготой төхөөрөмж бөгөөд уг

төхөөрөмжийг 6 сарын хугацаатай Хөдөлмөрийн төв бирж дээр туршиж ажиллуулсны үндсэн дээр Монгол улсын 21 аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн алба болон Улаанбаатар хотын 6 дүүргийн 134 хороонд байршуулахаар шийдвэрлээд байна. Энэхүү электрон самбараас ажлын байрны бүхий л мэдээллийг түргэн шуурхай хэлбэрээр авах боломжтой ба мэдээллийн сан нь Хөдөлмөрийн төв биржийн нэгдсэн сан болон <http://www.labornet.mn> портал цахим хуудастай интернетийн орчинд шууд холбоотой байдаг нь шинэ мэдээг цаг алдалгүй хүргэх давуу талтай.

Өнөө үед хөдөлмөрийн харилцаанд жендэрийн асуудал чухлаар тавигдаж байна. Жендэр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурьд үндэслэсэн тэдний хооронд тогтоосон харилцаа юм. Жендэрийн асуудал бол хүний хөгжлийн үндсэн асуудлын нэг бөгөөд хүйсийн эрх тэгш бус байдлыг арилгахгүй бол хөгжил дэвшилд сөрөг нөлөөтэй. Монголын эмэгтэйчүүд хүний хөгжлийн олон үзүүлэлтээр эрэгтэйчүүдээсээ давж гарсан буюу ойролцоо түвшинд байгаа боловч эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн амьдралд оролцох оролцооны тал дээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд ялгаа оршсоор байна. Өнөө үед хүмүүс бүтээмжээ дээшлүүлэх, орлогоо нэмэгдүүлэх, цалин хөлстэй ажил эрхлэх бүрэн боломжоор хангагдсан байх боломжууд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд тэгш бүрдэж чадсан эсэх нь хүний эрхийн чухал шалгуур, нийгмийн бодлогын суурь асуудал болоод байгаа юм.

Эмэгтэйчүүдийг ажилд авахаас цааргалах, орон тоогоор цомхтгох явдал олон салбарт түгээмэл байдаг нь тэд нийгмийн хамгааллын илүү тааламжтай нөхцөл шаарддагтай холбоотой. Монголд эмэгтэйчүүд хамгийн олноороо албан бус салбарт ажилладагийг судалгааны мэдээлэл харуулдаг. Харин албан бус салбарт ажилладаг хүмүүсийн нийгмийн хамгааллын асуудал үндсэндээ орхигдсон гэж хэлж болно. Тэднийг баталгаатай бус орон тоон дээр, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тааламжгүй нөхцөлд ажиллуулдаг байна. Ийм хүмүүсийн эрх ашгийг ахмагаалах асуудал өнөөдөр нийгмийн бодлогын анхаарах нэг гол асуудал мөн.

Ихэнхи ажил олгогч, ялангуяа хувийн хэвшилд эмэгтэйчүүдийг ажилд авахдаа нас, царай зүс, өндөр нам зэрэг шалгуур тавьж ялгаварлах хандлага түгээмэл байдаг. Энэ бол чухамдаа хүний эрхийн олон улсын гэрээ конвенц, Монгол Улсын хуулийг ноцтой зөрчсөн үйлдэл юм.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, дундаж цалингийн үзүүлэлт бол өнөөгийн Монголын хөдөлмөрийн зах зээлийн зохистой хөгжих гол хэрэгсэл болж байна. Ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээгүүр, улсын дундаж хэмжээнд цалин хөлстэй ажлын байр олноор буй болговол хөдөлмөрийн зах зээл дэх ажил хайгчдын тоо багасах, ажилгүйдэл ядуурал буурах боломж бүрдэнэ.

Хөдөлмөр хөлсний доод хэмжээг Засгийн газар тогтоодог. Чингэхдээ Хөдөлмөр хөлсний доод хэмжээний тухай Монгол Улсын хуульд заасан "Хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлт, Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн зохистой харьцаа, Нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, Эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн түвшин" \ Хөдөлмөр хөлсний доод хэмжээний тухай хууль, 4-р зүйл \ гэсэн 4 багц үзүүлэлтийг иш үндэс болгодог байна.

Тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардагдах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж

байгаа ажилтны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2013 оны 9-р сарын 1-ний өдрөөс эхлэн 1142 төгрөг 85 мөнгө байхаар шинэчлэн тогтоосон. Энэ тухай номын 2-р бүлгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Харин дундаж цалин бол хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох, улмаар хөдөлмөрийн зэх зээл дээр ажилд зуучлахад хэрэглэдэг хамгийн гол үзүүлэлт байдаг. Гэхдээ дундаж цалин гэдэг бол их ерөнхий ойлголт. Дундаж цалинг хувь хүний орлогын хэмжээнд, тодорхой байгууллагад ажилладаг хүмүүсийн авдаг цалингийн хэмжээнд, тодорхой орон нутаг, засаг захиргааны нэгжийн хэмжээнд, мөн бүхэл бүтэн улс орны хэмжээнд гэх мэтээр тооцон гаргадаг байна. Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалинг Үндэсний статистикийн хорооноос улирал тутам тооцон гаргаж, бодлого боловсруулагчид, үйлдвэрчний байгууллага, нийт иргэдэд зориулан мэдээлдэг билээ. Сүүлийн нэг жилийн хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин хэрхэн өөрчлөгдөж ирснийг хүснэгт 13-д үзүүлэв.

Сарын дундаж цалин 2012 1\4- 2013 1\4

Хүснэгт 13

Статистик хүснэгтийн нэр : Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин						
Үр дүн гаргах хугацаа : [Улирал] 2012 1/4 ~ 2013 1/4						
Эх сурвалж : Үндэсний статистикийн хороо						
Нэгж :		мян.төг				
Аймаг	Хүйс	2012 1/4	2012 2/4	2012 3/4	2012 4/4	2013 1/4
Улсын дүн	Бүгд	495.1	571.1	565.5	598.5	692.3
Үүнээс:	Эрэгтэй	452.9	544.8	526.9	572.6	747.8
	Эмэгтэй	540.8	598.8	605.7	627	639.1
Архангай	Бүгд	410.5	523.8	506.1	573.2	575.2
Баян-Өлгий	Бүгд	337.2	434.9	469.3	428.3	504.6
Баянхонгор	Бүгд	420.3	527.9	530	544.8	577.6
Булган	Бүгд	434.4	540.1	558.1	581.7	633.6
Говь-Алтай	Бүгд	373.2	518.5	466.2	575.9	552.2
Дорноговь	Бүгд	395.2	553.9	452.7	552.4	625.5
Дорнод	Бүгд	560.8	537.6	577.1	561.7	587.7
Дундговь	Бүгд	408.1	509.5	492.4	550.9	593.3
Завхан	Бүгд	418.8	511.2	521.2	544.9	602.3
Өвөрхангай	Бүгд	411.8	520.8	501.8	547.5	606.3
Өмнөговь	Бүгд	487.3	648.9	565.7	623.2	953.3
Сүхбаатар	Бүгд	388.7	425.2	464.1	475.5	581.2
Сэлэнгэ	Бүгд	479.6	479.6	479.6	595.1	618.6
Төв	Бүгд	389.6	497.6	488.4	492.2	515.2
Увс	Бүгд	390.2	436.8	450.2	521.9	523.9
Ховд	Бүгд	395.5	497.1	469.2	495.1	566.5
Хөвсгөл	Бүгд	371.8	427.1	456.2	448.3	564.3
Хэнтий	Бүгд	344.8	384	397.8	419.9	593.3
Дархан-Уул	Бүгд	558.7	626.2	613.5	652.9	632.7
Улаанбаатар	Бүгд	556.8	618.1	615.8	652.2	731.6
Орхон	Бүгд	554.2	688.5	683.6	656	607.7
Говьсүмбэр	Бүгд	703.7	721.4	707.5	815.1	749.7

6.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих төрийн бодлого

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бол Монгол Улсын төрийн нийгмийн бодлогын онцгой статус бүхий зорилтот бүлэг юм. 2010 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 108.1 мянган хүн байгаа нь суурин хүн амын 4.1 хувь юм. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 59.7 мянга нь буюу 55.2 хувь нь эрэгтэй, 48.4 мянга буюу 44.7 хувь нь эмэгтэй байна. \ Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого. Нэгдсэн дүн. УБ., 2011. , 118 дахь тал\ Нийгэмд идэвхитэй байр суурь эзэлдэг 20-49 насны гэр бүлийн хосууд хоёул хөгжлийн бэрхшээлтэй гэр бүл 2289 байна.

20-49 насны гэрлэсэн хөгжлийн бэрхшээлтэй хосууд, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хүйсээр дүнд эзлэх хувиар 2010

Хүснэгт 14

Гэрэлсэн хосуудын хөгжлийн бэрхшээлийн төрлөөр эхнэрийн насны бүлгээр	Нийт		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Харааны	13.9	11.1	10.8	13.0	15.2	11.4
Ярианы	7.1	7.3	8.7	9.5	4.6	4.0
Сонсголын	15.5	15.0	16.7	16.8	13.7	12.3
Хөдөлгөөний	23.9	20.6	23.9	19.0	23.9	23.1
Сэтгэцийн	15.0	16.9	12.9	14.6	18.3	20.2
Бусад	24.6	29.1	24.7	29.3	24.4	29.0
Бүгд хувь	100	100	100	100	100	100
Бүгд тоо	2289		1374		915	

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2010 оны Улсын тооллого. Өрх, гэр бүлийн байдал. Сэдэвчилсэн судалгаа 4. УБ., 2011., 84 дэх тал

Төр засгийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн бодлого, эрх зүйн баримт батлан энэ хүрээнд тодорхой ажил, үйлчилгээ хэрэгжүүлж байгаа болно. Засгийн газраас 2001 оныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих жил болгон зарласан. УИХ 2008 оны 12-р сард Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенцыг нэмэлт протоколын хамт соёрхон баталсан. \www.legalinfo.mn\ " Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай" хуулийн 8 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, түүний зохицуулалтыг тодорхой хийж өгсөн байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө болон тэдний асран хамгаалагчдын олонх нь бусдын адил сурч боловсрох, өөрийн авьяас чадварыг нээж илрүүлэх боломж харьцангуй их бий гэж үздэг. Ийм учраас төрийн нийгмийн бодлого нь тэрхүү боломжийг бодит ажил үйлс болгон хэрэгжүүлэхэд чиглэгдэх учиртай. Монголд өнөөдөр хэрэгцээндээ нийцсэн боловсролын үйлчилгээ авч чадахгүй байгаа хамгийн том бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд юм. Тийм учраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрох эрхийг хангах, бодлогын шийдэл гаргах зорилт чухалчлагдаж байна.

Нээлттэй нийгэм хүрээлэн(ННФ)-ын Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн боловсролын үйлчилгээгээр аль болох бага наснаас нь тууштай хангаж

өгөх, ингэхдээ эмнэлэг, нөхөн сэргээх болон нийгмийн халамжийн үйлчилгээтэй уялдуулан цогцоор нь хүргэх тогтолцооны загвар боловсруулах судалгааны ажлыг гүйцэтгэжээ. Судалгаа хийх явцдаа бодлого боловсруулагчдыг мэдээллээр хангах, санал зөвлөмжөө шууд хүргэх замаар нөлөөллийн ажил идэвхитэй хийж ирсний үр дүнд 2013 оны эхээр боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн хуульд оруулсан зарим өөрчлөлтийн суурь болсон юм.

Тус хүрээлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбоотой хамтран Улаанбаатар хотод байгаа тусгай сургуулиудын сургалтын орчинд мониторинг хийх, төрийн бус байгууллага, олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх орон нутагт түшиглэсэн загваруудыг нэгтгэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг дэмжих санаачилгуудын эх сурвалж” ном гаргахаар шийдвэрлэжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлд үйлчилгээ үзүүлэх, эцэг эхчүүдэд мэдээлэл хүргэх чиглэлээр голлон ажилладаг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдийн холбоотой ННФ хамтран бодлогын нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг байна. \ ННФ-2012оны жилийн тайлан\

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дараах дүрслэлд харуулжээ. \Сургагч багшийн гарын авлага, нийгмийн халамжийн хууль, эрх зүй. УБ.,2013\

Орон сууцны хөтөлбөр	Тулгамдаж буй асуудал
Ахмадын орон сууцны хөтөлбөр батлагдсан. Үүний: - Ахмад настан 75% - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 20% - Байгалийн давагдашгүй хүчин зүйлд нэрвэгдсэн иргэд 5%-ийг тодорхой хугацаагаар түрээслэнэ.	- сэтгэцийн өвчтэй, оюуны хомсдолтой иргэдэд зориулсан тусгай асрамжийн газар байхгүй - дэд бүтэц бүрдээгүй - хөгжлийн үйлчилгээ дутмаг - хөдөлмөр эрхлэх тогтолцоо хангалтгүй - гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих чиглэлээр төрөөс цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна.

- Нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх
- Боловсролд тэгш хамруулах
- Эрүүл мэндийн суурь үйлчилгээнд хамруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх халамжийн хэмжээг нэмэгдүүлж, амьжиргааны наад захын хэрэгцээг хангахуйц болгон нэмэгдүүлэх

Энэ гол зорилтуудыг бодитой хэрэгжүүлэхийн тулд Засгийн газраас ойрын үед тухайлсан хөтөлбөр боловсруулан хөрөнгө санхүүг нь шийдвэрлэж дор дурдсан асуудлуудыг дэс дараатай шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ бий болоод байна. Үүнд:

- Оролцоог дэмжих
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тусгай сан байгуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусгай зориулалтын орон сууц барих
- Нийгмийн үйлчилгээний газруудад тэдэнд зориулсан дэд бүтцийг байгуулах
- Зориулалтын автобус, нийтийн тээврийн үйлчилгээг бий болгох
- ХБИ-ийг ажлын байртай болгох эрх зүйн орчныг баталгаажуулах

6.5. Нийгмийн соёлын өөрчлөлт ба иргэдийн улс төр, эрх зүйн боловсрол


Монголчууд эртний түүхт нүүдлийн соёл иргэншлийн уламжлалтай ард түмэн. Нүүдлийн соёл иргэншил нь суурин соёл иргэншилтэй харьцуулахад нийгмийн өвөрмөц соёлыг бий болгосон бөгөөд тэр нь эдүгээ ч тодорхой хэмжээнд уламжлагдан хөгжиж буй гэж судлаачид үздэг. Мөн хорьдугаар зууны 70-аад жилийн туршид хуучин социалист системд багтаж, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, захиргаа хүнд суртлын социалист тогтолцоотой байсан учраас энэ үеийн нийгмийн соёлын нөлөө ч хүн амын дунд байсаар байгааг үгүйсгэж болохгүй.

Харин 1990-ээд оноос ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр нийгмийн соёлд томоохон өөрчлөлт гарч эхэлсэн болно. Гэхдээ нийгмийн соёл бол харьцангуй удаан хугацаанд аажмаар өөрчлөгддөг үзэгдэл. Хэдий тийм ч гэсэн сүүлийн жилүүдэд хүн амын төвлөрөл, хотжих үйл явц хурдтай өрнөсөн, өрнөдийн хөгжилтэй орнуудын соёлын нөлөө маш эрчимтэй орж ирсэн зэрэг өөрчлөлтийг дагалдаж хүн амын соёл, нийгмийн оюуны амьдралд ардчилсан үнэт зүйлс давамгайлах хандлагатай боллоо.

Хууль дээдэлдэг эрх зүйт төр, ардчилал, шударга ёс, эрх чөлөө, хувийн өмч, зах зээлийн харилцааны жам ёс хуулийг ойлгож, тэдгээрийг хэрэгжүүлэн ажиллаж амьдрах амьдралын цоо шинэ хэв маягт хүмүүс түргэн дасан зохицох хэрэгтэй болж байна.

Амьдралын энэхүү шинэ хэв маягтай холбоотойгоор иргэдэд улс төр, эрх зүйн боловсролоо дээшлүүлэх шинэ шинэ хэрэгцээ, шаардлагууд бий болсоор байна. Учир нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд оролцох, өмч хөрөнгөтэй болох, түүнийгээ захиран зарцуулах, хамгаалах, ажил хөдөлмөр эрхлэх, хотжих үйл явцад дасан зохицох гэх мэт олон асуудал бидний өмнө тулгарч байна. Иргэд өөрийн өмч, нас, эрүүл мэнд, аюулгүй байх, язгуур эрхээ хамгаалах чадвартай байх нэг чухал арга зам нь улс төр, эрх зүйн мэдлэг, боловсролтой, түүнийгээ өөрийн өдөр тутмын ажил, амьдралдаа ашиглах чадвартай болох явдал юм.

Нийгмийн ардчиллын онол, практикт нийгмийн үнэт зүйлсийг ихээхэн чухалчилан үздэг. Өнөөдөр Монголын нийгэмд нийгмийн үнэт зүйлсийг эрхэмлэн хэрэгжүүлэх бодит хэрэгцээ их байна. Нийгмийн үнэт зүйлсийн тогтолцоог дараах дүрслэлд тоймлон үзүүлэв.



Нийгмийн эдгээр үнэт зүйлсийг эхлээд зөв ойлгох, улмаар түүнийгээ ажил алба, ахуй амьдралдаа зөв хэвшүүлэн хэрэглэж сурахын тулд иргэн бүр улс төрийн болоод эрх зүйн орчин үеийн сайн боловсролтой байх шаардлагатай болж байна.

Иргэн хүн өмчтэй болох, түүнийг захиран зарцуулах, ажил хөдөлмөр эрхлэх, хоол хүнс авах, дэлгүүрт ороод хувцас худалдаж авах, гэртээ интернет ашиглах, бусдын бүтээл ашиглах зэрэг тохиолдол бүрд улс төрийн болон хувийн эрх зүйн харилцаанд ямар нэг хэмжээгээр оролцдог. Ийм нөхцөлд орчин үеийн улс төр, эрх зүйн боловсролын зорилго нь энэ бүх зүйлтэй холбоо бүхий асуудлаар улс төр, эрх зүйн мэдлэг олгож, түүнийг практикт хэрэглэх чадвар төлөвшүүлэхэд чиглэх ёстой.

Өнөө үед иргэний улс төр, эрх зүйн боловсрол, нийгмийн соёлын төлөвшилтөд түүх, нийгэм, ёс суртахуун, зан заншил, уламжлал, урлаг, утга зохиол зэрэг мэдлэг оюуны олон салбар нөлөөлнө. Улс төр, эрх зүйн боловсрол, нийгмийн соёлын төлөвшил нь тодорхой мэдлэг, мэдээлэл олж авахаас эхлээд түүнийг ойлгох, биелүүлэх, эзэмших, улмаар амьдралдаа хэрэглэх итгэл үнэмшил, дадал зуршилтай болох хүртэл олон үе шат бүхий үйл явцыг дамждаг.

Ашигласан материал

1. Харолд Коуломб. А.Гэрэлтуяа. Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлын зураглал-2011. УБ.,2012
2. НҮБ-ын хөгжлийн тусламжийн хүрээ. 2012-2016. УБ.,2012
3. С. Даваасүрэн, Б.Отгонтөгс, Б. Сувд. Хөдөлмөрийн зах зээл ба нийгмийн эмзэг бүлэг. ННФ.УБ, 2009
4. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн гарын авлага. УБ.,2013
5. Сургагч багшийн гарын авлага. (Нийгмийн халамжийн хууль, эрх зүй) УБ.,2013
6. Хүний хөгжлийн илтгэл. УБ., 2011
7. Төрийн үйлчилгээний мониторинг. Төрийн бус байгууллагуудын мониторингийн тйалангийн эмхэтгэл. ННФ. УБ.2008
8. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр.
9. Монгол Улсын Засгийн Газрын тайлан. 2012.
10. Social Protection concepts and approaches: implications for policy and practice in international development. Center for Aid and Public Expenditure. Working Paper 143. London. 2001
11. B. Cichon, C. Behrendt. V. Wodsak. The UN Social Protection Floor Initiative. International Policy Analysis. (Turning the Tide at the ILO Conference 2011)

Зохиогч



Доржготовын Наранцэцэг

Доктор (Ph.D), проф.

МУБИС, Дэлхийн түүхийн тэнхимийн эрхлэгч

1984 онд Орос 3-р дунд сургууль төгссөн.

1984-1989 онд ЗХУ-ын Ленинградын их сургуулийг түүхийн багш, түүхч мэргэжлээр,

1992-1996 онд ОХУ-ын Томскийн Их Сургуульд Түүхийн ухааны дэд доктор,

1995-1997 онд МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийн англи хэлний багшийн ангийг тус тус төгссөн.

1996 онд ОХУ-ын Томскийн Их Сургуульд "Монгол улс НҮБ-д элссэн нь"(1946-1961он) сэдвээр түүхийн ухааны дэд докторын (PhD) зэрэг хамгаалсан.

1989 оноос өдгөө хүртэл УБДС-д багш, Дэлхийн түүхийн тэнхимийн эрхлэгч, ТНУС-ийн захирал, МУБИС-ийн ТДСА-ны даргаар ажиллаж байна.

Нэг сэдэвт зохиол, гарын авлага:

1. История принятия Монголии в Организацию Объединённых Наций./1946-1961 гг./ Томск. 1996
2. Францын хөрөнгөтний хувьсгал. /1789-1799/ УБ., 1998
3. Европ Америк тив дахь хувьсгалууд. УБ., 2003. Боть 1.
4. Түүхийн судалгааны тайлбар толь. УБ., 1998.
5. Европын түүх. XVI-XIX зуун. УБ., 2000. /Хамтын бүтээлд 2 бүлэг/
6. XX зууны дэлхийн түүх. УБ., 2000 /Хамтын бүтээлд 1 бүлэг /
7. Английн Стюартууд ба парламентийн хөгжил. УБ., 1999
8. Шинэ эртний төрт улсууд. УБ., 1999

Судалгааныхаа чиглэлийн хүрээнд олон тооны ном, судалгааны ажил, өгүүлэл бичиж хэвлүүлсэн. Бүтээлийн дэлгэрэнгүй жагсаалтыг ФЭС-тай холбогдон авч болно.

Цогтсайханы Уянга

Дөрөвдүгээр бүлэг.

МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХӨДӨЛГӨӨН БА МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБОО (МҮЭХ)

1. Монголын үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний түүхэн хөгжил
 - 1.1. 1990 оноос өмнөх үе- МҮЭ
 - 1.2. 1990 оноос хойшхи үе- МҮЭХ
 2. Өнөөгийн МҮЭХ-ны зохион байгуулалт
 - 2.1. Зорилго, зорилт, бүтэц
 - 2.2. Гишүүнчлэл
 - 2.3. Санхүүжилт
 3. Хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн МҮЭХ-ны үйл ажиллагаа
 - 3.1. Хөдөлмөрчдийн дуу хоолой: Хөдөлмөрчдийг төлөөлж, тэдний эрх ашгийг хамгаалах
 - 3.1.1. Эвлэлдэн нэгдэх эрх
 - 3.1.2. Хөдөлмөрлөх эрх
 - 3.1.3. Зохистой Хөдөлмөр
 - 3.2. Нийгмийн чухал хөдөлгөгч хүч: Нийгмийн хөгжилд оруулах хувь нэмэр
- Ашигласан материал
Зохиогчийн тухай

Дөрөвдүгээр бүлэг.

МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХӨДӨЛГӨӨН БА МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБОО (МҮЭХ)

Монгол улсад үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн XX зууны эхэн үеэс үүсчээ. Өнөөдөр энэ хөдөлгөөн Монгол улсын хамгийн ууган, хамгийн олон гишүүнтэй, үндэсний хэмжээний бүтэц, зохион байгуулалттай, бие даасан хуулиар үйл ажиллагааг нь зохицуулдаг хөдөлмөрийн хүний эрх ашгийг хамгаалсан томоохон олон нийтийн байгууллага болон хөгжиж байна. Номын энэ бүлэг 3 дэд хэсэгтэй бөгөөд эхний дэд хэсэгт Монголын үйлдвэрчдийн эвлэлийн хөдөлгөөний түүхийг анх үүссэн цагаас буюу ардын хувьсгалын дараагаас 1990 оныг хүртэл болон ардчилсан хувьсгал ялж улс төрийн шинэ дэглэм руу шилжсэн 1990 оноос өдгөө хүртэл хэмээн 2 том үед хуваан тоймлон гаргав. Дараагийн хэсэгт өнөөгийн үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний бүтэц, зохион байгуулалт, зорилго зорилт, санхүүжилт зэрэг асуудлыг авч үзэв. Гурав дахь хэсэгт хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн МҮЭХ-ний үндсэн үйл ажиллагааг чиглэл бүрээр тодорхойлж, орчин үеийн мэдээлэлд тайлбарлахыг хичээлээ.

1. Монголын үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний түүхэн хөгжил

1.1. 1990 оноос өмнөх үе-МҮЭ

Монголд үйлдвэрчний хөдөлгөөний үүслийн талаар ойлголттой болохын тулд тэр үеийн улс төр, нийгэм, соёлын талаар тодорхой төсөөлөлтэй байх хэрэгтэй. Үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн Монголд хаант засгийг халж бүгд найрамдах засг тогтох түүхэн зурвас үе буюу Х1Х зууны сүүлч, XX зууны эхэн үед үүсэн хөгжсөн билээ. Энэ үед Монгол улс хоёрзуу гаруй жилийн Манж чин улсын дарлалаас чөлөөлөгдөж, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн бие даасан улс болон хөгжих түүхэн зорилтыг шийдвэрлэсэн юм. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал, 1921 оны Ардын ардчилсан хувьсгал дараалан ялалтанд хүрч Монгол Улс тусгаар тогтносон бүгд найрамдах улс боллоо. Хаант ёс, хамжлагын харилцаа үеэ өнгөрөөж, шинэ нийгэмд шилжих үйл явц эхэлснээр орчин үеийн үйлдвэр худалдааны ажилчид бий болж эхлэв. Үүнийг дагалдан Монгол Улсад үйлдвэрчний хөдөлгөөн үүсэн хөгжсөн байна.

Үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний үүслийг монгол улсад анхны ажилчин анги бий болсонтой салшгүй холбоотой гэж судлаачид үздэг. Тэдгээрийн зарим нь үйлдвэрчний эвлэлийн тулгын чулууг бүр 1917 онд албан хаагч нарын эвлэл байгуулснаар тавьсан гэж үздэг бол ихэнх судлаачид энэ үйл явдлыг монголын үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний эхлэл гэж үздэггүй. Учир нь уг эвлэлийн 100 гаруй гишүүдийн дотор монгол харъяат хүн бараг үгүй байжээ. Энэ байгууллагын гол үүрэг нь Монголд түр суурьшиж буй орос цагаачдын эрх ашгийг хамгаалахад чиглэж байлаа. Чухамдаа энэхүү эвлэл бол 1905 оны Оросын хувьсгалын дараа Орос оронд бүрэлдэж эхэлсэн үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн Монголд ажиллаж байсан орос ажилчдын дунд дэлгэрсэн хэрэг бөгөөд энэ нь улмаар Монголд ажилчны эрх ашгийг хамгаалах хөдөлгөөн өрнөхөд шууд нөлөө үзүүлсэн гэж үзэх нь оновчтой санагдана. Яагаад гэвэл уг эвлэл нь монголд ажиллаж

амьдарч байсан орос иргэд зонхилсон, хятад, монгол ажилчдын зарим хэсгийг дотроо багтаасан олон үндэстний зохион байгуулалтын хэлбэртэй үүсч "Олон ястны эвлэл" хэмээн уг байгууллагаа нэрлэж байв. Улмаар монгол ажилчдын хэсэг нь бие даан салж, монголын үйлдвэрчдийн эвлэлийн хөдөлгөөний үндэс суурь болж хөгжсөн байна.

1921 оны Ардын ардчилсан хувьсгал ялснаас 3 жилийн дараа 1924 онд Улсын Анхдугаар Их Хурал болов. Энэ хурлаар монгол улсын хөгжлийн ирээдүйд чухал ач холбогдолтой салбар бол ардын аж ахуйн зэрэгцээ аж үйлдвэрийн салбар хэмээн онцолж, бас газар нутгийн баялгийг ашиглах ба үйлдвэрлэн боловсруулах бодлогыг дэвшүүлсэн нь монголд анхны ажилчин анги бүрэлдэх нөхцөл, шаардлагыг бий болгожээ. 1924 онд Зөвлөлтийн байгууллагуудын ажилчидын "Олон ястны эвлэл" -ээс монгол ажилчид өрх тусгаарлан гарчээ. 1925 онд "Худалдаа, үйлдвэрийн ажилчдын үйлдвэрчний эвлэл" хэмээх монголын үйлдвэрчний хөдөлгөөний анхан шатны байгууллагын удирдах төв байгуулагдав. Энэ эвлэлээс санаачлан тухайн цаг үед байгуулагдаад байсан үйлдвэрчний эвлэлийн таван үүрийг дугаар тэмдэгтэй болгох асуудлыг МАХН-ын Төв Хороонд санал оруулан шийдвэрлүүлжээ. Үүний дараахан 1926 онд МАХН-ын Төв хорооны дэргэд Үйлдвэрчний эвлэлийн асуудлыг хариуцсан байнгын комисс байгуулагдав. Энэ комисс худалдаа аж үйлдвэрийн эвлэлийн ажил, үүргийг өөртөө шилжүүлэн авч ҮЭ-ийн байгууллагуудыг чиглүүлэн удирдах төвийг зохион байгуулах ажлыг эхлүүлсэн байна. 1926 оны 4-р сарын 20-ны МАХН-ын Төв хорооны Тэргүүлэгчдийн тогтоол гарч үйлдвэрчний эвлэлийг яс үндэс харгалзахгүйгээр, гагцхүү үйлдвэрлэлийн төрлийг баримтлан байгуулах, үйлдвэрчн ий эвлэлийн байгууллагууд зохион байгуулалтын нэгдэлтэй байхыг онцлон тэмдэглэжээ. Мөн энэ тогтоолоор байнгын комиссоос 6 үйлдвэрчний эвлэлийг байгуулахаар санал оруулсны 4-ийг нь /Худалдаа-үйлдвэрийн албан хаагчдын эвлэл, Улсын албан хаагчдын эвлэл, Эмнэлэг ариун цэвэр, хөдөлмөрийн эвлэл, тээх нэвтрүүлэхийн товчоо, эвлэл/ албан ёсоор байгуулсан байна. Энэ ондоо багтаан Орос, Монгол, Хятад хүмүүсийн бүрэлдэхүүнтэй МҮЭ-ийн Төв товчоог байгуулснаар дээр дурьдсан байнгын комиссын үйл ажиллагаа дуусгавар болж үйлдвэрчний бүх ажлыг шинээр байгуулагдсан энэхүү товчоонд хариуцуулжээ.

Дээр дурьдсан үйл ажиллагаа нь Монгол улсад үндэсний хэмжээний үйлдвэрчний байгууллага үүсч байгуулагдах бэлтгэлийг хангасан бөгөөд Монголын үйлдвэрчний эвлэлийн анхдугаар их хурал 1927 оны 8-р сарын 15-21 хооронд Улаанбаатарт боллоо. Уг хурлаас МҮЭ-ийн дүрмийг баталж, Төв зөвлөлийг сонгон, ҮЭ-ийн шинж төлөв, түүний зохион байгуулалтын бүтэц, нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцаанд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг зэргийг хууль ёсоор тодорхойлсон түүхэн чухал шийдвэрүүдийг гаргасан байна. Хурлын үеэр мөн МАХН МҮЭ-ийн талаар баримталж буй байр сууриа илэрхийлэхдээ МҮЭ-ийн үйл ажиллагааны чиглэл нь ард түмнээс сонгогдсон засгийн газарыг шүүмжлэн эсэргүйцэгч бус ардын засгаа бататгагч, улс орны аливаа хэргийг туслан гүйцэтгэгч байж, аж үйлдвэрийг хаях зэрэг үйлдэл гаргаж нийтэд хохирол учруулахаас болгоомжлохыг анхааруулсан байна. Үүний дагуу ҮЭ-ийн өөрийн зорилгоо тодорхойлж ажилтан албан хаагчдын эрх ашгийг төлөөлж, шалтгаангүй ажлаас халах, цалин хэрэглэлийг хасах зэрэг аргаар хүчин үнэлэгчдийг хохироохоос хамгаална гэж зааж ҮЭ-ийг засаг төрийг бэхжүүлэх, эдийн засгийг хөгжүүлэх, үйлдвэрчин ардыг гэгээрүүлэн боловсруулах үйл явцад гүйцэтгэх үүрэгтэйгээр оролцно гэж тусгажээ. Мөн уг тогтоолд хөрөнгөтөн улсын адилаар хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор эдийн засгийн

тэмцлийн хэлбэрээр жагсаал цуглаан хийхийг хориглож, ҮЭ-ийг төрийг жолоодох хэрэгт энгийн ард, үйлдвэрчин нарыг ойртуулж, намын үзэл суртал боловсруулах сургууль хэмээн түүний үйл ажиллагааны гол арга нь “ухуулах, гэгээрүүлэх” явдал гэж тодорхойлжээ.

Олон улсын хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах хөдөлгөөн үүссэнийг төв европоос буюу Англи улсад XVIII зууны дунд үеэс аж үйлдвэрлэлийн хувьсгалтай шууд холбон тайлбарладаг. Хэдийгээр аж үйлдвэрийн хувьсгал эхлэхээс өмнө ажилгүйдэл, ядуурал газар авсан байсан ч гэсэн хүмүүс энэ байдалтайгаа бурхны зураг төөрөг хэмээн эвлэрсэн байв. Харин гар ажиллагаатай юм бүхнийг механикжүүлэх ажил өрнөж ялангуяа уурын машин /1765/, ноос ээрдэг машин /1796/, механик хөдөлгүүртэй сүлжмэлийн машин /1786/, галт тэрэг гэх мэт цоо шинэ нээлт хийж үйлдвэрлэлд нэвтрүүлснээр ажлын бүтээмж сайжирч эдийн засагт томоохон түлхэц болсны хажуугаар нийгмийн олон сөрөг үр дагаварыг авчирсан байна. Жишээ нь: гар үйлдвэрлэлийн салбар уналтад орж, ажлын байрны цомхтгол явагдаж, хот суурин газар руу шилжих хөдөлгөөн ихсэх гэх мэт хүчин зүйлс ажилгүйдэл, ядуурлыг улам гааруулж улмаар ажлын байрны хомсдлоос үүдэн ажилчдын дунд өрсөлдөөн ихээр бий болж үүнийг үйлдвэрийн эзэд овжиноор ашиглаж хоногт доод тал нь 13 цаг ажиллуулж, тарчиг хөлс өгч хүний хөдөлмөрийг мөлжиж байв. Яг л энэ дүр зураг Герман болон бусад европын орнуудад XIX зууны дунд үеэс давтагдаж олз ашигийг түрүүнд тавьсан хатуу капитализмын хууль үйлчилж хүчтэй нь хүчгүйгээ “идэж” эхэлжээ. Нэг талаас үйлдвэрийн хэрэгслэлийн эзэн нөгөө талаас түүнд хараатаар ажилладаг ажилчин хоёрын хоорондын харилцаа өнөөгийн түвшин шиг бие биедээ харилцан шаардлага тавих хэмжээнд хүрээгүй байв. Ажилчдын эрх ашгийг хамгаалах, шударга хөлс авах, ажлын илүү таатай нөхцлийг шаардах хөдөлгөөн Германд 1840-өөд оноос эхэлж, ажилчид мэр сэр холбоо байгуулан эздэд шаардах бичиг хүргүүлэх, ажил хаях гэх мэт аргыг хэрэглэж эхлэв. Сонирхолтой нь үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн энгийн, ядуу тарчиг амьдралтай ажилчдын дундаас үүссэн бус харин гар урлалын мастерийн цехүүдэд ажилладаг байсан мастер болон туслах мастеруудын санаачлага байжээ. Учир нь тэд өмнө нь энгийн ажилчдыг бодвол амьжиргаанд хүрэлцээтэй хөлс авч ирээдүйд өөрийн мастерийн цех байгуулах зорилготой, боловсролын хувьд арай илүү, зохион байгуулах чадвараар сайтай, санхүүгийн хувьд илүү бололцоотой байв. Техникийн хувьсгал гарсантай холбогдоод нийгмийн байдал муудаж тэдний амьдрал орвонгоороо эргэсэн нь ажилчдын эрх ашгийг хамгаалах шаардлага хэрэгцээ тулгарч буйг олж харан хүчээ нэгтгэн, зохион байгуулалттайгаар үүний эсрэг тэмцэхийг тэд хамгийн түрүүнд уриалжээ.

1917 оны дунд үеэс анхны үүрүүд үүссэнээс эхлээд үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн 1927 онд зохион байгуулалтад орж албан ёсоор үндэсний хэмжээний байгууллага болон бэхжих хүртлээ 10 жил болсон байна. Монгол дахь үйлдвэрчний эвлэл ажилчдын эрх ашгийг хамгаалахын төлөө ядуус, борчуул, хөлсний ажилчдын эв санааны нэгдэл дээр суурилж үүссэнээс гадна анхнаасаа үйлдвэрлэх хүчнийг бий болгох хэрэгт идэвхтэй тусалж, ард түмнийг социалист үзэл суртлаар хүмүүжүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлж байв. МАХН монголын үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөнийг зохион байгуулалтад оруулахад нь удирдах үүрэг гүйцэтгэсэн байна. Үүний нэг тод жишээ нь ҮЭ-ийг зохион байгуулах, удирдан чиглүүлэх зорилгоор МАХН-аас түр комисс томилогдож анхны хүнд ажлуудыг “нугалж” байв. Энд тухайн түүхэн цаг үеийн нөхцөл байдлаас хамаарсан олон шалтгаан бий. Юуны өмнө тухайн цаг үеэд үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний талаарх ойлголттой жирийн иргэн бараг байхгүй, бичиг үсэгтэй хүн цөөхөн, бусад капиталист бус орны түүхэн туршлага төдийлөн түгээмэл байгаагүйгээс мөн уг байгууллагыг чиглүүлэх боловсон хүчин хомс, материаллаг

бааз дутмаг байсантай холбоотой гэж үздэг ажээ. МАХН-ын удирдлагын хүчинд МҮЭ байгууллага хэдхэн жилийн дотор бодлого, чиглэлээ тодорхойлж, олныг хамарсан том байгууллага болон төлөвшиж, улмаар улс орны нийгэм эдийн засгийн амьдралд маш идэвхтэй оролцож, улс төрийн үйл хэрэгт ч тодорхой үүрэг гүйцэтгэх болсон байна.

1929 оноос ЗХУ болон Коминтерн /олон улсын коммунист намуудын нэгдсэн байгууллага/ -ийн нөлөөн дөр социалист нийгэм байгуулах ажил өрнөж, бүх нийтийг үзэл суртлаар хүмүүжүүлэх аян эхэлж, ноёд, тайж язгууртны хөрөнгийг хураан малчин ардыг үйлдвэрчний эвлэлд нэгтгэх кампанит ажлыг МҮЭ зохион байгуулав. Энэ ажлын явцад сум, орон нутагт үйлдвэрчний эвлэлийн үүрүүд ихээр үүсэж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг зохиох, соёл хүмүүжлийн ажил явуулах, хөдөлмөрийн нормчлол батлах, цалин хөлсний асуудлаар ажил олгогчидтой хэлэлцэх зэрэг олон талт ажил өрнөсөн байна. БНМАУ-ын улс ардын аж ахуйн бараг бүх салбарт аж үйлдвэрлэлийн эхийг тавьж шинэ залуу ажилчин анги үүсэж эхэлснээр ард олны хөдөлмөрийн идэвхи үлэмж сэргэв. хөдөлмөрт хандах хандлагыг улам сайжруулах, хөдөлмөрийн үнэлгээг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн идэвхийг өрнүүлэх зорилгоор олон төрлийн социалист уралдааныг зохиож байв. ҮЭ-ийн нэр хүнд, нийгэмд эзлэх байр суурь нэмэгдэхийн хэрээр ҮЭ-ийн гишүүнчлэл нэмэгдэж хүн болгон идэвхитэй гишүүн байхыг эрмэлзэх болжээ. 1930 оны эцсээр дэлхий дахинд цэрэг, улс төрийн хурцадмал байдал бий болов. Монгол улсын хувьд ч өмнөд хил тайван бус болж байв. Энэ байдал улам даамжирч 1939 онд Халх голын байлдаан болж, улмаар фашист Герман 1941 онд ЗХУ руу гэнэт дайрснаар зөвлөлтийн ард түмний эх орны аугаа их дайн дэгдэв. Үүнтэй холбоотойгоор Монгол улсад Халхын голын байлдаанд оролцогчид болон эх орны аугаа их дайнд тулалдаж буй зөвлөлтийн ахан дүүсдээ бололцоотой бүхнээрээ туслах аян эхэлж МҮЭ үүнд мөн л тэргүүлэх үүрэгтэйгээр оролцжээ. 1937 оны МҮЭ-ийн Төв зөвлөлийн Тэргүүлэгчдийн тогтоолоор улс орны батлан хамгаалах үйлсэд ҮЭ-ийн байгууллагуудын оролцоог тодорхойлж, цэргийн ар гэрийнхэнд туслах, ҮЭ-ийн гишүүд, ажилчдыг эх орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах үнэнч сэтгэлтэй болгон хүмүүжүүлэхийг уриалсан шийдвэр гаргасан байна.

Дэлхийн 2-р дайны дараагаар социалист дэглэм үүсэн бүрэлдэж Европын болон Азийн хэд хэдэн улс энэ эгнээнд элсэж, колончлол задран унахад ЗХУ-ын нэр хүнд өсөж дэлхийн хүчний харьцаанд өөрчлөлт гарав. БНМАУ-ын улсын тусгаар тогтнолыг улс орнууд хүлээн зөвшөөрч улсын хөгжилд гол анхаарлаа хандуулахад маш таатай цаг үе ирээд байлаа. XX зууны 2-р хагасаас БНМАУ ЗХУ-ын бүрэн дэмжлэгэйгээр 5 жилийн төлөвлөгөө гарган улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэх болов. Энэхүү их ажилд ҮЭ-ийн байгууллага идэвхтэй оролцохын зэрэгцээ өөрийн уугуул үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөсгөж, арга барилаа ч шинэчлэж эхэллээ. ҮЭ илүү мэргэжлийн түвшинд хуулийн хүрээнд аливаа асуудалд захиргааны зүгээс бус ажилчдын эрх ашгийг хамгаалдаг байгууллагын зүгээс ханддаг болж өөрийн сонгодог хэв шинж буюу олон нийтийн байгууллагын мөн чанарт нийцсэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. ҮЭ-ийн зүгээс үйлдвэрлэлийг удирдахад ажилчдыг татан оруулах, ажилчдад тулгараад байгаа асуудлууд дээр анхаарч шаардлагатай бол хууль дүрмийг өөрчлөх, гишүүдийнхээ ахуй хангамжийг сайжруулахад үзүүлэх нөлөө улам өсөв.

1950-иад оны сүүлч 60-аад оны эхээр манай улс ЗХУ-аас зээл, тусламж их хэмжээгээр авч мөн Эдийн засгийн харилцан туслалцах нийгэмлэгийн гишүүн

орон болсноор бусад социалист орнуудтай харилцаа тогтоон улсынхаа эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л салбарт хөрөнгө оруулснаар бүтээн байгуулалтын эрин үе эхэлсэн билээ. Нүүрсний уурхай, цахилгаан станцууд, гурилын үйлдвэр, арьс ширний, ноос ноолуурын үйлдвэр, гутлын фабрик, хэвлэлийн газрууд, хүнсний үйлдвэр гэх мэтчилэн олон арван үйлдвэрийн газруудыг оросуудын тусламжтайгаар барьж ашиглалтад оруулжээ. Ингэснээр ажлын байр үлэмж нэмэгдэж, хөдөөнөөс хотод шилжин суурьшигчдын тоо олширч, хотын ачаалал бага багаар нэмэгдэж байв. Гэвч юуны түрүүнд машин техниктэй харьцах мэдлэг туршлага дульмаг залуучуудыг мэргэжил олгох сургууль дамжаанд элсүүлж улмаар нарийн мэргэжил эзэмшүүлэхээр ЗХУ руу хэдэн зуугаар нь сургах бодлого төрөөс баримталсан байна. Хөдөлмөрийн бүтээмжийг улам их өсгөх зорилгоор төлөвлөгөө гаргах, хүн бүрийг ажилтай болгож, хөдөлмөрлөхийн үр шим ямар амттай болохыг үлгэрлүүлэх, ухуулан таниулах зорилгоор ҮЭ олон талт уралдаан тэмцээн, урамшууллын ажлууд удирдан явуулж, хянан тайлагнах гол үүрэгтэйгээр ажиллаж байв. Хөдөлмөрчдийн нийгмийн хангамжийг сайжруулснаар хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ гэж үзсэний дүнд цэцэрлэг, сургууль, ажилчдын орон сууц, соёлын төв, клубууд барьж, амралт сувилал, пионерийн зусланг хөнгөлөлттэй үнээр ажиллуулж, тойрон аялал зохиох, гадаадад амрагч нарыг илгээх гэх мэт маш олон талын арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байжээ. 1970 оны дунд хүртэл МАХН Төв Хороо ҮЭ-ийн байгууллагуудын төсөв, орон тоо зэргийг хянаж шийдвэрлэдэг байсан нь ихээхэн чирэгдэл дагуулдаг, олон шат дамжлагатай төвөгтэй үйл явц байсныг өөрчилж энэ эрхийг МҮЭ Төв Зөвлөлд олгожээ. Хүний нөөцийн бодлогын хувьд МҮЭ тухайн цаг үеийнхээ боломж бололцоонд тааруулан ажилчдынхаа боловсролд өндрөөр анхаарч ирсэн нь бусад социалист орнуудтай тухайлбал Ардчилсан Герман улстай боловсролын салбарт нягт хамтран ажиллаж олон зуун боловсон хүчнээ хэлний болон нарийн мэргэжлийн чиглэлээр сургаж авсан ба дотооддоо сургалт хүмүүжлийн ажлыг тогтмол хийж байснаас харахад илэрхий байна.

1.2. 1990 оноос хойшхи үе - МҮЭХ

1989 оны сүүлээр социалист улс орнуудад дотоодын хямрал улам даамжирч, эдийн засгийн байдал хүндэрч, ард иргэд ч улсынхаа удирдан чиглүүлэгч намдаа итгэл үзүүлэхээ байж социализм системийн хувьд задрах шатандаа очсон байлаа. Нэг намыг шүтсэн, хүнд сурталд автсан, өрөнд баригдсан, хүн болоод нийгэм, эдийн засгийн хөгжлийг тушсан тухайн үеийн нөхцөл байдалд цэг тавьж, улс төрийн дэглэмийг өөрчлөх шаардлагатайг тэр үеийн сэхээтнүүд олж харан эрх баригчдын бодлогыг эсэргүүцсэн ухуулах хуудас тараан шударга ёс, ардчиллыг тогтоохыг уриалав. Удаа дараа шаардлага тавьж өлсгөлөн зарласны эцэст 1990 оны 3-р сард МАХН-ын Улс төрийн Товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч нийгэм улс төрийн тогтолцоонд шинэ салхи орлоо. Өөрчлөлт шинэчлэлийн шаардлага нийгмийг тэр чигт нь хамарч ҮЭ-ийг ч мөн тойрон гарсангүй. МҮЭ-ийн Төв Хороо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч, шинэ нийгмийн нөхцөлд хуучин бүрэлдэхүүнээр, хуучин арга барилаар ажиллаж болохгүй гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрлөө. Ардчилсан хувьсгал ялсны дараах он жилүүд тодорхой баримжаагүй, хөгжлийн төлөвлөгөөгүй, нэгдсэн бодлогогүй “уяанаасаа алдуурсан” мэт өнгөрч 1996 онд үнийг чөлөөлж, зах зээлийн эдийн засаг руу шилжихэд юмны үнэ хурдтай өсч, өргөн хэрэглээний барааны нийлүүлэлт алдагдаж, ажилгүйдэл гаарч, хөдөлмөр үнэгүйдэж, хөдөлмөрийн харилцааг бүдүүлгээр зөрчих явдал өдөр тутам гарах болов. Энэ үед хөдөлмөрчин ард түмэн олон жил түшиж ирсэн МҮЭ-ээс

дорвитой арга хэмжээ авахыг хүлээсэн боловч энэ хүлээлтийг нь МҮЭ хангалттай гүйцэлдүүлж чадаагүйд гишүүдийн итгэл алдарсан нь гишүүдийн тоо эрс буурсан, үйлдвэрчний эвлэлгүй байгууллага олширсон байдлаас илэрхий харагдаж байлаа. Нийгэм хямралтай, улс төр эдийн засгийн шилжилт хийгдэж байсан цаг үед үндэсний хэмжээний бүтэц, зхион байгуулалттай МҮЭ хэмээх энэхүү нүсэр байгууллагыг хөдөлгөхөд их хүч, хугацаа зарцуулах нь тодорхой байв. Хүний нөөцийн хувьд ч тухайн үед МҮЭ-ийн удирдах ажилтанууд бүгд социалист системд боловсрол, хүмүүжил олсон байснаас үзэл баримтлал, арга барил, үйл ажиллагааны хувьд эрс өөрчлөлт хийх боломж төдийлөн хангалттай байсангүй. Хэдий тийм ч МҮЭ-д өөрчлөлт, шинэчлэл эрчимтэй өрнөсөн юм.

1990 оны 6-р сарын 6-нд болсон МҮЭ-ийн ээлжит бус XIV чуулганаар МҮЭ-ийг бие даасан үйлдвэрчний эвлэлүүдийн чөлөөт холбоо болгон, анхан шатны байгууллагад “нэг үйлдвэр нэг үйлдвэрчин” гэсэн зарчмаар зохион байгуулагдахаар болов. Энэ нь аливаа байгууллага дээр нэг холбоонд харъяалагдах нэг л үйлдвэрчний эвлэлийн нэгж байна гэсэн үг юм. Энэ бол олон ургальч үзлийг дарангуйлах гэсэн бус харин зорилго, үйл ажиллагаагаа нэгдмэл байдлаар хэрэгжүүлнэ гэсэн зарчим юм.

Олон ургальч үзлийн нөлөөгөөр 1990 оноос хойш хэд хэдэн үйлдвэрчний эвлэлийн нэгдлүүд үүсэн байгуулагдсан боловч олон шалтгаанаас удаан оршин тогтнож чадаагүй байна. 1992 оны ХҮ Их хурлаар МҮЭ 13 салбар холбоотой болж, шинэ удирдлагуудыг сонгож, олон жил эрхэлж ирсэн аж ахуйн шинж чанартай ажлуудаа больж, улсын нийгмийн даатгал, амралт сувилал, хөдөлмөр хамгааллын техникийн хяналт, соёлын ордон, клуб зэргийг төр засгийн мэдэлд шилжүүлж гол гол гэсэн зорилтууд дээрээ анхаарч ажиллахаар шийдвэр гаргажээ. Энэ үеэс МҮЭХ орчин үеийн үйлдвэрчний байгууллагын жишигээр хөгжиж байгаа гэж үзэж болно.

2.Өнөөгийн МҮЭХ-ны зохион байгуулалт

2.1. Зорилго, зорилт, бүтэц зохион байгуулалт


МҮЭХ өнөөгийн байдлаар 236,000 гаруй гишүүдийг өөртөө нэгтгэсэн Монгол улс дахь хамгийн том олон нийтийн байгууллага болон хөгжжээ. МҮЭХ аливаа улс төрийн нам, бүлэглэлээс ангид, хараат бусаар, гагцхүү хөдөлмөрчдийн хууль ёсны эрх, ашиг, сонирхолд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг. Хэдийгээр улс төрийн аль нэг намыг дэмжиж ажилладаггүй ч улс төрийн байр суурийн хувьд хөдөлмөрчин хүний эрх ашгийг хамгаалсан, хөдөлмөрийн харилцааны орчин үеийн хөгжлийн хандлагыг дэмжсэн бодлого хөтөлбөрийг дэвшүүлэн хэрэгжүүлж буй улс төрийн байр суурийг дэмжих Засгийн газар, ажил олгогчидтой гурван талт гэрээ байгуулан ажилладаг.

МҮЭХ 2011 онд ээлжит XX хурлаа хийж дүрмээ шинэчлэн үйл ажиллагаагааныхаа эрхэм зорилго болон зорилтоо дараах байдлаар тодорхойлжээ. /Үзүүлэн №1-оос дэлгэрэнгүйг харна уу./


Орчин үеийн ҮЭ сонгуульт байгууллагын бүтцийн хувьд холбооны дүрэмд зааснаар ардчилсан буюу “доороос дээшээ” чиглэсэн зарчмаар ажилладаг байна. /Үзүүлэн №2, 3-оос дэлгэрэнгүйг харна уу./ Өөрөөр хэлбэл, МҮЭХ-ны

эрх барих дээд байгууллага нь нийт гишүүдийн төлөөллөөс бүрдэх Их хурал бөгөөд төлөөлөгчдийн 50%-иас доошгүй хувь нь эмэгтэйчүүд болон залуучуудын төлөөлөл байна гэж заажээ. Дүрмээс үзэхэд эрх барих, удирдах дээд байгууллага ба албан тушаалтнууд байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагаатай болон цаг үеийн байдал, нийгэм, эдийн засгийн чухал асуудалтай холбоотой шийдвэрүүдийг дүрэмт заасны дагуу тус тус хурлыг товлон хуралдуулж, гишүүн байгууллагын төлөөллөөр хэлэлцүүлж, тэднээс санал авч, хамтын шийдвэрийн үр дүнд гаргадаг байна.

Үзүүлэн №1: МҮЭХ-ны эрхэм зорилго ба 5 зорилт



Үзүүлэн № 2: МҮЭХ-ны сонгуульт удирдах байгууллагын зохион байгуулалт




2.2. Гишүүнчлэл

Хүний үндсэн эрхийн нэг бол эвлэлдэн нэгдэх эрх. Монголын үйлдвэрчний эвлэлүүд бол эвлэлдэн нэгдэх эрх, хөдөлмөрлөх эрх түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилготой сайн дурын үндсэн дээр үүссэн хөдөлмөрчдийн ардчилсан, чөлөөт нэгдэл юм. МҮЭХ-нд гишүүнээр элсэж гишүүн байхын олон давуу эрхийг эдлэхийн тулд өөрийн ажил эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгж дээр байгуулагдсан үйлдвэрчний эвлэлийн хороонд гишүүнээр элсэж, гишүүнийхээ татварыг төлөх шаардлагатай /ойролцоогоор цалингийн 1%/ гэж хууль, дүрмэндээ заажээ. Хэрвээ өөрийн ажилладаг байгууллага дээр үйлдвэрчний эвлэлийн нэгж байхгүй аваас үүсгэн байгуулах санаачлагыг гартаа авч ажлыг эхлүүлэхэд олон шалгуур байхгүй бөгөөд үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтнуудыг ажил үүргээ саадгүй хийх нөхцлийг Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль хангаж өгдөг.

Тэгэхээр Үйлдвэрчний Эвлэл бол ажилчдын өөрсдийн байгуулсан, өөрсдөө авч явдаг, ажилчны төлөө байгууллага юм. Үйлдвэрчний эвлэлүүд нь мэргэжил үйлдэрлэлийн ба нутаг дэвсгэрийн шинжээр байгуулагдсан үйлдвэрчний эвлэлийн холбоодод нэгдэж зохион байгуулагддаг. Эдүгээ ажил мэргэжлийн салбарын 14 ба нутаг дэвсгэрийн шинжтэй 22 Үйлдвэрчний эвлэлийн холбоо МҮЭХ-д гишүүнчлэлтэй байна. /Үзүүлэн №3-аас дэлгэрэнгүйг харна уу./ Гишүүн байгууллага бүр өөрийн холбооны дүрэмтэй ба үйл ажиллагаагаа бие даан явуулах эрх зүйн статусаар хангагдсан байдаг. МҮЭХ-ны дүрэмд тэдний эрх, үүргийг тодорхой заасан бөгөөд хэрвээ холбоодын дүрэм, МҮЭХ-ын дүрэм хооронд зөрчилдөөн гарваас МҮЭХ-ын дүрмийг барьж ажиллах зарчимтай юм. Олон улсын тавцан дээр үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд мөн мэргэжил, үйлдвэрлэл болон бүс нутгийн шинж чанараар, гишүүнээр элсүүлэх замаар хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хүчээ нэгтгэн ажилладаг. МҮЭХ дэлхийн олон орны үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудтай түншийн харилцаа тогтоон ажилласнаар харилцан туршлага судалж, чадавхиа нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байгаа юм.

Үзүүлэн №3: Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын бүтцийн тойм /2013/



ҮЭ-д нэгдэж, гишүүнээр элсэх 6 шалтгаан

1. Хөдөлмөрлөх эрх ашгаа хамгаалуулах хүчтэй байгууллагатай болно.
2. ҮЭ-ээрээ дамжуулан захиргаа эзэдтэй хамтын гэрээ, хэлэлцээр байгуулж өөрийн ашиг сонирхлыг тусгуулна.
3. Ажил олгогчийн аливаа хууль бус дарамт, шахалтаас хамгаалагдана.
4. Аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан баталгаатай ажлын байранд, хийсэн ажилдаа тохирсон цалин, хөлс ажиллана.
5. Хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө авч хөнгөлөлттэй үнээр өмгөөлүүлнэ.
6. МҮЭ-ийн харьяа байгууллагуудын үйлчилгээг хөнгөлөлттэй үнээр авна.

2.3. Санхүүжилт

МҮЭХ-ны дүрмийн 35-р зүйлд зааснаар санхүүгийн эх үүсвэр дараах байдлаар бүрдэнэ:

- Гишүүдийн татвар /сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 1% ба түүнээс дээш/
- Гишүүн байгууллагын татвар
- Хандив, тусламж
- Орлого /Жишээ нь: ажлын байрны түрээсийн болон төсвийн татаас/
- Бусад шимтгэл

МҮЭХ-ны үйл ажиллагааны санхүүжилт нь дээр дурьдсан эх үүсвэрээс бүрдэх бөгөөд эдгээрийн эхний 2 эх үүсвэр буюу хувь гишүүний болон гишүүн байгууллагын татвар нь хамгийн найдвартай, тогтвортой санхүүжилт болдог. Хандив, тусламж болон орлогын бусад эх үүсвэр нь холбооны болон салбар байгууллагуудын санхүүгийн менежмент, жил бүрийн тодорхой төлөвлөлтөөс хамаарч янз бүр байдаг. Харин төсвийн зарцуулалт, тайлагнал ямар байдлаар зохион байгуулагдахыг дүрмээр нарийн зохицуулсан бөгөөд үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь маш тодорхой байдаг учраас төсвийн зарцуулалт, тайлагнал нь ил тод, ойлгомжтой байдгаараа онцлог. Дүрэмд зааснаар гишүүдийн татварын 70% нь дүрмийн дагуу үндсэн нэгж дээрээ төвлөрч, гишүүд рүүгээ хандсан үйл ажиллагаа явуулахад зарцуулагддаг. Харин үлдсэн 30% нь тухайн үйлвэрчний эвлэлийн хорооны эвлэлдэн нэгдсэн мэргэжил, үйлдвэрлэлийн болон аймаг, нийслэлийн үйлдвэрчний эвлэлийн холбоондоо сар тутам төлнө. Үүний 5-аас доошгүй хувийг МҮЭХ-нд жилд нэг удаа шилжүүлнэ.

3.Хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн МҮЭХ-ны үйл ажиллагаа

3.1. Хөдөлмөрчдийн дуу хоолой: Хөдөлмөрчдийг төлөөлж, тэдний эрх ашгийг хамгаалах

МҮЭХ-ны үндсэн үйл ажиллагаагаа хүний Эвлэлдэн нэгдэх эрх ба Хөдөлмөрлөх эрх дээр суурилан, түүнийг бүрэн хангахад учирч буй саад бэрхшээлийг бие даан буюу нийгмийн түншлэлийн хэлбэрээр даван туулахад чиглэгдэнэ. Тодруулбал, өнөөгийн цаг үеэд хөдөлмөрчин хүмүүст буюу хөдөлмөрийн харилцаанд тулгараад

байгаа асуудлыг шийдэх болон ирээдүйд гарч болзошгүй эрсдлүүдээс хамгаалах нь үйлдвэрчний эвлэлийнхний гол чиг шугам гэж ойлгож болно. Жишээ нь: манай улсад хөдөлмөрийн харилцаанд ямар асуудлууд давамгайлж байна: ажилгүйдэл, цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, жендэрийн тэгш бус байдал гэх мэт олон зүйлийг нягтлаж үзэн, түүн дээр дүн шинжилгээ хийн, тодорхой төсөл хөтөлбөрүүдээ үндэсний хэмжээнд чиглүүлэн явуулна.

Түүнчлэн дэлхийн болон бүсийн түвшинд яригдаж буй нийгэм, эдийн засаг, ялангуяа хөдөлмөрийн харилцааны асуудлууд нь өнөөгийн бидний глобальчлагдсан, худалдаа харилцааны хязгаар бараг үгүй болж буй энэ эрин зуунд ихэнх үндэстний хувьд нийтлэг асуудлууд болоод байна. Ийм учраас тухайн асуудлуудыг дорвитойгоор шийдэхэд улс үндэстнүүд олон улсын байгууллагын шүхэр дор дуу хоолойгоо нэгтгэн, хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн ажиллах зайлшгүй шаардлага тулгараад байгаа.

Жишээ нь: Нэгдсэн Үндэстний Байгууллагын /НҮБ/ дэргэдэх Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага /ОУХБ/ 1919 онд үүссэн, 185 орны гишүүнчлэлтэй, гишүүн улс бүрээс төр, ажил олгогч, ажилтны төлөөлөл адил тэгш эрхтэйгээр оролцдог ороо НҮБ-ын бусад байгууллагаас онцлогтой юм. Олон улсын нийгэм болоод хөдөлмөрийн харилцаанд дахь чухал хэм хэмжээг баталж мөрдүүлэх, даяаршлалын процессыг илүү шударга, нийгмийн баримжаатай чиглүүлж, хүмүүнлэг хөдөлмөрийн нөхцлийг бүрдүүлэх замаар ядуурлыг бууруулахад уг байгууллагын гол зорилго оршино. Манай улс ОУХБ-д 1968 онд гишүүнээр элсэн орсноос хойшхи хугацаанд тус байгууллагын 16 конвенцэд нэгдэн орсон юм. Үүний найм нь суурь конвенци байдаг ба үүнийг хөдөлмөрийн харилцаандаа суурь зарчмаа болгон ажиллахаар бараг ихэнх гишүүн улсууд нэгдэн орсон байдаг.

Суурь найман Конвенци:

- Албадан хөдөлмөрийн тухай 29-р Конвенци
- Албадан хөдөлмөрийг устгах тухай 105-р Конвенци
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба эвлэлдэн нэгдэх эрхийг хамгаалах тухай 87-р Конвенци
- Байгууллага байгуулах ба хамтын гэрээ хийхэд эрхийн зарчмуудыг баримтлах тухай 98-р Конвенци
- Тэгш шан хөлс олгох тухай 100-р Конвенци
- Ажилд авах насны доод хязгаарын тухай 138-р Конвенци
- Ялгаварлан гадуурхахгүй байх (ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) 111-р Конвенци
- "Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай" 182-р Конвенци

Монгол улсын нэгдэн орсон ОУХБ-ын конвенциудын хэрэгжилтийн байдал, цаашид нэгдэн орох шаардлагатай конвенциудын талаарх тандалт судалгааг 2013 оны 10 дугаар сарын 1-ээс 11 дүгээр сарын 20-ны хугацаанд Монгол улсын Хөдөлмөрийн яам, МҮЭ-ийн Холбоо болон түүний харьяа байгууллагууд хамтран хийлээ. Судалгааны дүнг харахад ОУХБ суурь найман конвенцийн хэрэгжилт хангалттай гэдэг дээр 290 санал, дунд зэрэг гэдэг дээр 411 санал, хангалтгүй гэдэг дээр 132 санал, мэдэхгүй гэдэг дээр 93 санал гарсан байна. Энэ байдлаас дүгнэлт хийж үзвэл суурь найман конвенцийн хэрэгжилт дунд зэрэг \411 санал\ явагдаж байгаа ба тэдгээрийг болон түүний хэрэгжилтийг мэдэхгүй ҮЭ-ийн идэвхтэн сонгуультай олон байгаа юм байна.

3.1.1. Эвлэлдэн нэгдэх эрх

Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Энэ эрх нь дараах эх сурвалжтай бөгөөд Монгол Улсын иргэн бүр хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалахын тулд аливаа зөвшөөрөл авалгүй өөрийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхээр хангагдах ёстой.

Эвлэлдэн нэгдэх эрхийн эх сурвалж:

- Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 20-р зүйл ба 23-р зүйл,
- МУ-ын Үндсэн хууль 10-р зүйлийн 10,
- Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (ИУТЭОУП)-ын 22-р зүйлд хүн бүрийн үйлдвэрчний эвлэл(ҮЭ)-д эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний талаарх заалт
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭОУП)-ын 8-р зүйлд,
- ОУХБ-ын дараах гэрээ конвенциуд:87-р конвенц,98-р конвенц, 135-р конвенц, 151-р конвенц, 163-р конвенцид тус тусгагдсан зохицуулалтууд
- ҮЭ-үүдийн эрхийн тухай хуулинд /3-р зүйл/ үйлдвэрчний эвлэлийн гишүүн мөн эсэхтэй холбогдуулан иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах буюу тэднийг ялгаварлан гадуурхахыг хориглох тухай заалтууд нь эвлэлдэн нэгдэх эрхийн хууль зүйн эх сурвалжууд юм.

Монгол улсад, ялангуяа хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээний салбарт ажиллагсад эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах замаар хөдөлмөрлөх эрх ашгаа хамгаалах боломж дутмаг байдаг. Олон улсын ҮЭХ-ны / ITUC/ 2013 онд хөгжингүй ба хөгжиж буй 13 орныг хамруулан хийсэн судалгаанд дунджаар 68% нь ҮЭ-тэй байгууллагын ажилчид ҮЭ-гүй байгууллагын ажилчдаас илүү цалин хөлс авдаг, илүү сайн ажлын нөхцлөөр нь хангагдсан гэсэн мэдээлэл гарчээ. Тэгэхээр иргэдэд ҮЭ-ийн ач холбогдлыг танин мэдэхэд туслах, тэднийг зохион байгуулалтад орохыг олон талаас нь дэмжих, үүнд хэрэглэж буй арга барилаа сайжруулах гэх мэт сорилтууд үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудад тулгарч байгаа бөгөөд үүнийг төрийн дэмжлэгтэйгээр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны суурин дээр хийх нь илүү үр дүнтэй байх болно. Иргэдийнхээ нийгмийн болон эдийн засгийн эрхийг хангах тал дээр үлгэр жишээ ажилладаг улс орнуудад эвлэлдэн нэгдэх эрх маш сайн хангагдан хэрэгждэг ба хөдөлмөрчдийн төлөөллийг бүх шатанд шийдвэр гаргах үйл явцад өргөн оролцуулах хууль, эрх зүйн тогтолцоог бүрэлдүүлсэн байна. Энэ талаар төрийн үүрэг ч тодорхой, иргэдийн идэвхи санаачлага, нийгмийн шахалт ч өндөр байдаг.

Жишээлбэл: ХБНГУ-д хөдөлмөрийн харилцаатай холбоотой гарч буй асуудлыг шийдвэрлэх үйл явцад ажилчдын төлөөллийн оролцоог Үйлдвэрлэлийн үндсэн хууль ба Хамтран шийдвэр гаргах тухай хуулиар баталгаажуулж өгсөн байна. Эхний хуулиар 5-аас дээш ажилчинтай аж ахуйн нэгж дээр заавал үйлдвэрлэлийн зөвлөл буюу манайхаар ҮЭ-ийн төлөөлөл байх ёстой / ажилчдын тооноос хамаарч 1 хүн эсвэл тэрнээс дээш төлөөлөл байхыг хуулиар заасан/. Харин төрийн болон олон нийтийн байгууллага дээр өөр дүрэм, журам үйлчилнэ. Хоёр дахь хуулиар нь хувьцаат компанийн хяналтын зөвлөлд ажилчдын төлөөллийг шийдвэр гаргах, санал хураалтад ижил тэгш эрхтэйгээр оролцох боломжоор хангаж өгсөн байдаг.

3.1.2. Хөдөлмөрлөх эрх

Монгол улс ардчилсан тогтолцоотой, зах зээлийн эдийн засагтай орны хувьд иргэний хөдөлмөрлөх эрх нь улс төр, хууль эрх зүйн болоод эдийн засаг нийгмийн баталгаажин хамгаалагдсан байдаг билээ. Хүний хөдөлмөрлөх эрх дараах хууль эрх зүйн эх сурвалжаар баталгаажигдсан байна. Үүнд:

- НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 23-р зүйл
- Монгол Улсын нэгдэн орсон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7-р зүйл
- МУ-ын Үндсэн Хууль 16-р зүйл 4
- МУ-ын Хөдөлмөрийн тухай хууль

Хөдөлмөр эрхэлж буй хүн бүр баталгаатай, аюулгүй ажлын байранд ажиллах, шударга цалин хөлс авах, нийгмийн даатгалд хамрагдах, эвлэлдэн нэгдэх болон хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрхээ бүрэн эдлэх ёстой. Энэ суурь эрх бодиттой хэрэгжих эрх зүйн байталгаа нь дээр дурьдсан хууль, олон улсын гэрээ конвенциор байталгаажсан гэж үзэж болно. Ялангуяа, Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль нь Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний хөдөлмөрлөх эрхийг хөдөлмөрийн харилцаанд бататган хамгаалах гол эрх зүйн сурвалж мөн.

НҮБ-ын дэргэдэх Олон улсын Хөдөлмөрийн байгууллага дэлхийн хөдөлмөрийн харилцаанд дахь сөрөг үзэгдлүүд дээр дүн шинжилгээ хийн ялангуяа глобалчлалын үр нөлөөгөөр хөгжиж буй улс орнуудад тулгараад буй нийтлэг асуудлуудыг хамтдаа шийдэх төсөл хөтөлбөр гарган, гишүүн улсууд үүнийг өөрийн онцлогтой тааруулан хэрэгжүүлдэг. Жишээлбэл: НҮБ-аас баталж гаргасан “Мянганы Хөгжлийн Зорилтууд” хангах хөтөлбөрийг 2000 онд дэлхийн ядуурлыг бууруулах, баялгийг шударга хувиарлах, илүү сайн сайхан амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой НҮБ-ын гишүүн улсууд олон сар хоног хэлэлцсэний эцэст батлан гаргасан билээ. МХЗ-уудын хэрэгжилтийн байдлын талаар улс орон бүр жил болгон Үндэсний илтгэлийг гаргадаг. Түүнд дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийг маш тодорхой тусгасан байгаа. Энэ хтөлбөр 2015 онд дуусгавар болно.

Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хэрэгжүүлэхэд Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан “Зохист Хөдөлмөр” үзэл баримтлал нь маш чухал нөлөөтэй бөгөөд, нэг нь нэггүйгээрээ хэрэгжих боломжгүй юм.

3.1.3. Зохистой хөдөлмөр

НҮБ-ын гишүүн улс бүр Зохист хөдөлмөрийн төлөө Үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж байгаа билээ. МҮЭ-ийн Холбооны 20 дугаар Их хурлаас баталсан “МҮЭ-ийн Хөгжлийн зорилтууд”-ын нэг болох “Нийгмийн үйлчилгээг өргөтгөн сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлж, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг хүн амын бодит хэрэгцээг хангахуйц түвшинд хүртэл өсгөх, худалдан авах чадварыг ямагт дээшлүүлж байхын төлөө тууштай тэмцэж гишүүд, хөдөлмөрчдийн нийгэм эдийн засгийн хөгжлийг хангах” зорилтыг хангах хүрээнд зохистой хөдөлмөрийн үзэл санааг бүх чиглэлээр дэмжин ажиллах асуудлыг тусгасан байна.

Зохистой хөдөлмөр хэмээх үзэл баримтлал нь:

- өндөр бүтээмжтэй ажлын байртай,
- тохирсон цалинтай,
- эрүүл аюулгүй орчинтой,
- ажилтан өөрөө болон түүний гэр бүл нийгмийн хамгааллын тогтолцоонд хамрагдсан,
- шийдвэр гаргах үйл явцад ажилтан өөрийн санаа бодлыг илэрхийлэх бололцоотой, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй, хүйсийн тэгш боломж олгосон тогтолцоог бүрдүүлэх гэсэн цогц ойлголт юм.


Өндөртэй бүтээмжтэй ажил гэдэг нь аливаа зүйлийг хийхэд зарцуулсан хэсэг /орц/ нь ажлын үр дүнд гарч байгаа хэсгээс /гарц/ бага байх тохиолдлыг хэлнэ. Өөрөөр хэлбэл орц буюу нөөцийг боломжтой хэмжээгээр нь багасгаж, гарцын хэмжээ буюу шинэ баялгийг дээд зэрэгээр нэмэгдүүлснээр бүтээмж өснө.

$$\text{Бүтээмж} = \frac{\text{Гарц}}{\text{Орц}}$$

Бүтээмж нь эдийн засгийн нэг үзүүлэлт бөгөөд үүгээр аливаа улсын эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадварыг хэмждэг гол хэмжүүрийн нэг юм. Бүтээмж, цалин хөлс, амьжиргааны түвшин буюу улсын хөгжил нь харилцан уялдаатай зүйлүүд юм. Бүтээмжинд суурилсан эдийн засгийг хөгжлүүлэх үзэл баримтлал сүүлийн хэдэн Засгийн Газарын мөрийн хөтөлбөрт ороод явж байгаа. МУ-ын Үндэсний Статистикийн хорооноос гаргадаг Статистик эмхтгэлд бүтээмжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хэмжсэн тоо баримт байдаг боловч ажилчдыг жилийн дундаж ажилласан цаг, ажилласан хүн өдрийн статистик мэдээлэл цаашид гаргах нь хөдөлмөрийн бүтээмжийг цалин хөлстэй хэрхэн уялдаж байгааг харуулах, түүнд дүн шинжилгээ хийхэд ихээхэн ач холбогдолтой байх болно.

Хөдөлмөрийн бүтээмж нь хөдөлмөрийг ямар хэмжээгээр авч байгаагаас шалтгаалан олон төрөлтэй байдаг /нэг ажилчинд ногдох, нэг цагт, нэг өдөрт ногдох, хөдөлмөрийн хөлсний нэгж тутамд ногдох хөдөлмөрийн бүтээмж/ ба энэ нь цалингийн бодлоготой шууд хамааралтай юм. Бүтээмжийг өсгөх гол арга хэрэгслийн нэг бол ажиллах хүчний үр чадвар, боловсрол мэдлэг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гэдэг дээр улс орнууд санал нэгдэн, хямд бөгөөд чадвар муутай ажиллах хүч нь цаашид хөдөлмөрийг зохистой үнэлүүлэхэд саад болохыг онцлоод энэ асуудал дээр гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

ОУХБ-ын хийсэн судалгаанаас харахад 1999-2011 оны хооронд хөгжингүй улс орнуудад хөдөлмөрийн бүтээмж нь цалин хөлстэй харьцуулахад 2 дахин



нэмэгдсэн байна. Үүнээс хийсэн дүгнэлт нь цалин хөлсийг хөдөлмөрийн бүтээмжтэй зохистой байдлаар уялдуулж чадахгүй байгаа ба хөдөлмөрийн шударга хуваарилалт явагдахгүйгээс эдийн засгийн өсөлтийн үр өгөөж ажилтнуудад төдийлөн очихгүй байна. /Үзүүлэн № 4/

Үзүүлэн №4: Бүтээмж ба цалин хөлсний хоорондын харьцаа

Эх сурвалж: Global wage report 2012/2013, ILO

Хөдөлмөрийн харилцаанд орж байгаа ажилтан хийсэн ажлынхаа үр дүнд **тохирсон цалин хөлс** авах эрхтэй байдаг ба адил хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэй, эрэгтэй ажилтанд ижил хэмжээний цалин хөлсийг олгох ёстой. Харин нарийн мэргэжил, мэргэшил мэдлэг шаардагдах болон онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн үнэлгээ илүү байна. Цалин хөлс болон хөдөлмөрийн бүтээмж хоорондоо уялдаа холбоотой бөгөөд цалин хөлсийн өсөлт нь хөдөлмөрийн бүтээмжийн өсөлттэй тэнцүү хурдтай байвал хамгийн зохистой гэх боловч ийм нөхцлийг бүрдүүлэх маш төвөгтэй гэж эдийн засагчид үздэг. Тиймээс хөдөлмөрийн бүтээмжийн хурдцыг цалингийн хурдцаас илүү байлгахад чиглүүлэх нь зохистой аж. Ингэснээр бүтээгдэхүүний өртгийг бууруулж, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлдэг байна.

Тохирсон цалин хөлс гэдэгт өөрийн болон гэр бүлийн хэрэглээнд хангалттай, нийгмийн хамгаалалд хамрагдах болон өөртөө болон гэр бүл, үр хүүхдийнхээ ирээдүйн хөгжилд тодорхой хэмжээнд хөрөнгө оруулалт хийх боломжтой байх хэмжээг ойлгож болно. ОУХБ-аас 2012 онд хийсэн судалгаагаар дэлхийн дундаж цалин 1480 ам.доллар байхад манай улсын дундаж цалин 412 ам. доллартай тэнцэж судалгаанд орсон 76 орны сүүлээсээ 7 дугаарт орсон байна. Харин эдийн засгийн өсөлтөөрөө манай улс 12,3% -тай гарч дэлхийн хамгийн хурдтай өсөлттэй улсуудын нэгд багтсан байна.

МУ-ын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж НҮБ-ийн индрээс өнгөрсөн 9-р сард хэлсэн үгэндээ:

"...Монгол Улсад эдийн засгийн өсөлт сүүлийн үед саарсан ч хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэхээр хурдтай нэмэгдэж байна. Эдийн засаг өсөхөд хүн амын дийлэнх хэсгийн орлого үлэмж хэмжээгээр нэмэгддэг байх нөхцөлийг төр, засгийн бодлогоор бүрдүүлэх шаардлагатай байна" гэжээ.

Ерөнхийлөгчийн хэлсэнчлэн улсын эдийн засгийн өсөлт ард иргэдийн амьжиргааны чадварт нөлөөлж, бага дунд орлоготой иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд чиглэгдвэл ядуурлаас гарах нэг боломж юм. 2012 оны байдлаар амьжиргааны баталгаажих доод түвшин буюу хүний амьд явах баталгааны доод түвшин 2013 онд шинэчлэгдэж бүс нутгаас хамаарч сарын 130,500 -149,900 төгрөгөөр тогтоосон байна. Хэрвээ иргэний орлого үүнээс доогуур байвал тэр иргэн ядуу гэж тооцогдно гэсэн үг. Харин үүнээс өндөр байвал баталгаажих доод түвшинд хэрэглээгээ хангасан байна гэж үзнэ. Ерөнхийдөө энэ үзүүлэлтийг ядуурлын түвшнийг тодорхойлох зорилгоор хэрэглэдэг. Энэ үзүүлэлт нь улс орны хөгжлийн түвшнөөс хамаарч өөр өөр байдаг. Манай улсад жишээлбэл 2012 оны байдлаар нийт хүн амын 900,000 нь ядууралд өртсөн албан ёсны статистик мэдээ гарчээ /ҮСХ-ны Өрхийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд 2012/.

Дэлхийн улс орнууд ядуурлыг бууруулах олон арга замыг эрэлхийлэн ажиллаж байна. ОУХБ-аас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоон, мөрдөх ба эмзэг бүлэгт тооцогдох ажилчдыг нийгмийн хамгааллаар хангах нь ажилтай оролготой хэрнээ ядуурал руу ороод байгаа асуудлыг шийдэхэд өндөр ач холбогдолтой гэжээ. Дээрх дурьдсан ядуу өрхийн тэргүүлэгчдийн 74% нь нийгмийн аль нэг салбарт ажил хөдөлмөр эрхэлж байгаагаас харахад ажил олгогчид хуулиа биелүүлэхгүй байгаатай эсвэл ХХДХ нь амьжиргааны баталгаажих түвшинг хангаж чадахгүй байна гэж дүгнэж болох юм.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

Тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардагдах энгийн ажил гүйцэтгэсэн ажилтанд олговол зохих хөлсний хамгийн бага хэмжээг хэлнэ.

ОУХБ 135-р Зөвлөмжийн дагуу ХХДХ-г дараах хүчин зүйлүүдийг харгалзан тогтооно:

- Ажилчны өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд хүрэх эсэх,
- тухайн орныхоо дундаж цалин орлоготой тэнцэхүйц хэмжээний эсэх,
- амьжиргаанд нь хүрэлцэх эсэх,
- түүнээс нийгмийн даатгалд хамрагдах боломжтой эсэх,
- нийгмийн бусад ижил төстэй бүлгийн амьдралын түвшинтэй харьцуулж болох эсэх,
- Эдийн засгийн хөгжлийн бусад хүчин зүйлсийг харгалзах

Манай улсад ХХДХ-г Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо баталж гаргадаг бөгөөд 2000 онд 18,000 төгрөг байсан нь 2013 оны эцсийн байдлаар 192,000 байна. Үүнээс гадна доорх салбаруудад асуудал хариуцсан яам, эзэд, үйлдвэрчний эвлэлтэй хамтраад салбарынхаа цалингийн доод хэмжээг тогтоосон байна.

Цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон салбарууд
2013 он

№	Салбар	Цалингийн доод хэмжээ /төг/
1	Авто тээвэр	224640
2	Эрчим хүч	307200
3	Геологи, уул уурхай	384000
4	Эрүүл мэнд	249600
5	Барилга	358848
6	Хот байгуулалт, нийтийн аж ахуй	268800

МҮЭХ иргэний амьжиргааны баталгаа хангагдаж байгаа эсэх дээр хяналт, шалгалтыг явуулж нийгмийн түншлэлд шахалт үзүүлэх хэлбэрээр энэ асуудлыг шийдвэрлэхэд голлох байр суурь эзэлдэг. Үүнээс гадна сүүлийн жилүүдэд МҮЭХ “Монгол хүнийн хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэхийн төлөө” цалин хөлсний кампанит ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд үүний хүрээнд цалин хөлсөө дутуу авч байгаа, ХХДХ доогуур цалинжиж байгаа болон цалин хөлстэй холбоотой бусад үйлдвэрчний эвлэлийн гишүүд, хөдөлмөрчдөөс санал гомдлыг нь хүлээн авч өөрийн өмгөөлөгчдийн баг, хууль зүйн зөвлөгөө өгөх төв, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нартай хамтран асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авч байна.

Европын социалдемократ үзэл баримтлалтай орнууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хуулиар тогтоох нь нийгмийн баримжаатай төрийн нэг үүрэг бөгөөд нийгэмд шударга ёс тогтоох гол арга хэрэгслүүдийн нэг гэж үздэг. Өнөөгийн байдлаар европын ихэнх улс орнууд үүнийг дагаж мөрдөж байгаа ба ХБНГУ-ын хамгийн том хоёр улс төрийн хүчний хооронд саяхан хийгдсэн Их Эвслийн Засгийн Газарын мөрийн хөтөлбөрт эвсэгч намын нэг болох Германы Социалдемократ намын улс төрийн гол шаардлага нь улсын хэмжээнд хөдөлмөрийн хөлсний доод

хэмжээг тогтоох явдал байсан нь амжилт олж 2016 оноос эхлэн хэрэгжихээр боллоо. ХБНГУ-д өнөөгийн байдлаар зөвхөн тодорхой хэдэн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тарифын гэрээгээр зохицуулсан байдаг. Германд төдийгүй ҮЭ дотроо хүртэл судлаачид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоон мөрдөхийн эерэг болон сөрөг тал дээр маргалдсаар байдаг. Гэвч хэсэг улсын туршлага дээр хийсэн судалгаанаас хөдөлмөр эрхлэлт болон ХХДХ хоорондын харьцаанаас гарсан эерэг, сөрөг нөлөө нь улс бүр дээр харилцан адилгүй гарсан ба нийт дүнгээр эерэг нөлөө нь давамгайлсан байна. /Ragacs, Christian (2003): Mindestlöhne und Beschäftigung. Ein Überblick über die neuere empirische Literatur. Wirtschaftsuniversität Wien. Working Paper 25; Wien./

Улс төрийн үзэл баримтлалаас шалтгаалан улс төрийн хүчнүүд нийгмийн хамгааллын тогтолцооны бүтэц, зохион байгуулалт болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хуульчлах асуудалд өөр өөр байр сууринаас ханддаг. Жишээ нь: социалдемократ ба нийгмийн ардчиллын үзэл баримтлалыг хэрэгжүүлдэг намууд үүнийг шударга ёсыг тогтоох нэг арга мөн гэж үзэхэд консерватив болон либерал үзэлтэнгүүд үүний дэмждэггүй байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний эерэг болон сөрөг үр дагаварын талаар та дор дурьдсан харьцуулсан үзүүлэлтийг харж өөрийн бодлоор тунгаана уу.

Эерэг тал	Сөрөг тал
- Хөдөлмөрийн хөлсийг унагахаас сэргийлнэ - Амьжиргааны баталгаажих түвшинг хангана - Хэтэрхий бага цалин хөлсөөр ажиллахаас хамгаална - Эмэгтэй ажилчдыг цалин, хөлсний ялгаварлан гадуурхалтаас хамгаална - Орлогын илүү тэгш хуваарилалт явагдсанаар бүтээмж өсч, хүний хөгжилд илүү хөрөнгө оруулалт хийгднэ гэх мэт	- Ажлын байрыг устгаж, үйлдвэрлэлийг өөр улс руу шилжүүлэх хандлага - Чадавхи муутай ажилчдын хөдөлмөрлөх боломжийг хаах - Өндөр цалинтай хэсэгт сөрөгөөр нөлөөлөх - Ядуурлыг бууруулахад нөлөөлж чадахгүй - Үйлдвэрчний эвлэлийг хүчгүйдүүлэх гэх мэт

Зохистой цалин хөлсний тогтолцоог бүх талаар дэмжин бүрэлдүүлэх нь ядуурлыг бууруулахад амин чухал боловч зоосны нөгөө тал болох ажлын байрыг нэмэгдүүлж, иргэд хөдөлмөрлөх боломжийг нь бий болгох нь олон улсын анхаарал хандуулж байгаа гол асуудал мөн билээ. Ялангуяа 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын шалтгаан, нөлөөний талаар хийсэн дүн шинжилгээнд үндэслэн ОУХБ-аас “Дэлхийн ажлын байрны талаарх пакт” /Global Job Pact/ гаргасан байна. Үүнийг өнөө үед олон орон өөр өөрийн хөгжлийн бодлогод тодорхой тусгажээ.

Өнөөдөр дэлхийн хүн амын 75% нь хангалттай бус буюу ямар ч нийгмийн хамгаалалд хамрагдах боломжгүй байна. Тиймээс одоогийн үйлчилж буй нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах ба бүх хүнд хүртээмжтэй нийгмийн суурь хамгааллыг бий болгох зайлшгүй шаардлагатай байна. Үүнд үйлдвэрчний эвлэлийн гүйцэтгэх үүрэг маш их байх ёстой.

Олон улсын үйлдвэрчний эвлэлүүд ОУХБ-тай хамтран судалгаа хийж дараах 4 байдлаар нийгмийн хамгааллыг хүртээмжтэй болгохыг зөвлөсөн байна. Үүнд:

- Суурь орлогыг баталгаажуулах /мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр/ жирэмсэн эхчүүдэд, ажилгүйчүүдэд, ажилтай хэрнээ орлого нь хүрдэггүй тохиолдолд дэмжлэг үзүүлэх,
- өндөр настангуудын тэтгэвэр,
- Хүүхдийн мөнгө
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдах

Бусад нийгмийн хамгааллын тухай конвенцид нэгдэх орохоос гадна дээрх 4 суурь зарчмыг улс бүр өөрийн хөгжлийн бодлого, стратегитаа тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай гэж шинжээчид үзэж байна. Бразил, Чили болон зарим Өмнөд Америкийн улсууд гэх мэт үүнийг амжилттай хэрэгжүүлж чадсан хөгжиж буй орнуудаас цөөнгүй туршлага байна. Азийн зарим улсууд нийгмийн суурь хамгааллыг бэхжүүлэхэд хэдийгээр жилийнхээ ДНБ-ээс ердөө 1-2%, зарим улс 2-6% зарцуулсан ч ядуурлыг их хэмжээгээр бууруулж чадсан гэсэн судалгаа гарчээ.

Манай улсын хувьд эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанар харилцан адилгүй, ядуучууд, эмзэг бүлгийнхний хувьд эдгээр үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх явдал түгээмэл байна. Хүн амыг ундны цэвэр ус, эрүүл хүнс, цахилгаан дулааны найдвартай эх үүсвэр, орон сууцаар хангах тулгамдсан асуудал хэвээр байна. /Монгол улсын нийгмийн хамгааллын тогтолцооны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өмнөх бүлэгт орсон байгааг харна уу./ Гишүүд, хөдөлмөрчдийн нийгмийн хамгааллын болон бусад хөдөлмөрийн харилцаанд үүсээд буй тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хөдөлмөр, нийгмийн зөвшлийг хангах гурван талт хэлэлцээр болон хамтын гэрээ, хэлэлцээрийн үүрэг маш чухал байдаг.

МҮЭХ-ны үйл ажиллагаандаа нийгмийн түншлэлийн зарчмыг эрхэмлэж, түншлэлийн хүрээнд холбогдох асуудлыг Засгийн Газар, ажил олгогч, ажилтны төлөөлөл гэсэн гурван талын тэгш оролцоотойгоор хэлэлцээрт орох замаар шийдвэрлэж ирсэн уламжлалтай. Ядангуяа сүүлийн жилүүдэд гурван талт түншлэлийн гэрээ хэлэлцээрийн үр дүнгээр ажилчдын нийгмийн асуудал, түүний дотор цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх талаар тодорхой туршлага хуримтлуудаад байгаа билээ. Түншлэлийн харилцаанд баримтлах олон улсын нийтлэг зарчим, хэм хэмжээг дэлхийн улс орнууд мөрдөн ажилладаг. /Үзүүлэн №5/


Гэхдээ эдгээр нь улс орны өвөрмөц онцлог, хөдөлмөрийн харилцааны шинж байдлаас хамаарч өөр өөр хувилбараар хэрэгжих боломжтой.

Үзүүлэн №5: МҮЭХ-ны үйл ажиллагааны зарчим



Улс орнууд өөрийн улсын улс төр, нийгмийн тогтолцоо, түүхэн уламжлал гэх мэтээс шалтгаалан нийгмийн түншлэлийн хоёр ба гурван талын бүтцийг байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар манай улсад нийгмийн түншлэгч талуудаас бүрдсэн 14 үндэсний хороо, зөвлөлийн бүрэлдэхүүнд МҮЭХ төлөөллөөрөө идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна./Үзүүлэн №6/

Үзүүлэн № 6: Нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний зөвлөл, хороо



Хамтын /тарифын/¹ хэлэлцээр /гэрээ/² хийгдэх явдал нь нийгмийн түншлэлийн үйл ажиллагааны үр дүнгийн нэгэн чухал хэлбэр юм.

Хамтын хэлэлцээр гэдэг нь иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хамтран хамгаалах зорилгоор улсын хэмжээнд болон тодорхой бүс нутаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, салбар, мэргэжлийн хүрээнд ажил олгогч, ажилтны төлөөлөгчид, төрийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан тохиролцоог хэлнэ.

Манайд одоогоор 6 салбар дээр салбарын тарифын хэлэлцээр /гэрээ/ хийгдсэн байна. Үүгээр хөдөлмөрийн нөхцлийг тодорхойлж, мэргэжлийн онцлогуудыг тусгаж, бусад нийгмийн хангамжийн асуудлыг шийдвэрлэж, цалин хөлсийг итгэлцүүрээр олгох, салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, ажил амралтын цагт өөрчлөлт оруулах гэх мэт хөдөлмөрийн хуулиар зохицуулагдаагүй асуудлуудыг гурван тал хамтран шийдвэрлэсэн байна. Уг салбарын хамтын

¹Тариф- гэдэг үгийг хаалтанд хийсэн учир нь уг салбарын хамтын хэлэлцээрт тарифт цалингийн нарийвчилсан зохицуулалт байхгүй зөвхөн жишиг цалинг л тогтоож оруулсан байгаа

²Уг нь хэлэлцээр нь хэлэлцэх үйл явцыг нэрлэдэг үг. Хэлэлцээрийн үр дүнд гарах бүтээгдэхүүнийг гэрээ, санамж бичиг, зөвлөмж гэх мэтээр нэрлэдэг

хэлэлцээр нь 1-2 жилийн хүчинтэй ба шинэ хамтын хэлэлцээрийг эхлүүлэх хамгийн тохиромжтой цаг хугацаа нь тактикийн үүднээс дараа жилийн улсын төсөв хэлэлцэхийн өмнө байх юм.

Хамтын гэрээ мөн 2 талын буюу үйлдвэрчний эвлэлийн хороо ба ажил олгогчийн төлөөлөлтэй аж ахуйн нэгж, байгууллагууд дээр хийгддэг. Дээрхтэй мөн л адил хөдөлмөрийн хуулинд заагаагүй ажилтанд давуу байдал олгох нөхцлүүдийг тохирч хийж болно.

ХБНГУ-д уг тарифын гэрээг зөвхөн тухайн салбарын Ажил олгогч эздийн холбоо ба ҮЭ байгууллага нь төрийн оролцоогүйгээр хийдэг. Үүнийг тарифын автономт байдал гэж нэрлэдэг. Тарифын гэрээ хийхийг зохицуулсан хууль мөн үйлчилнэ. Хамрах хүрээ, зохицуулах агуулгаасаа шалтгаалан тарифын гэрээг өөр өөрөөр нэрлэдэг. Хамгийн чухал нь үүнд ямар мэргэжил, чадавхиас хамаарч, ямар цалин хөлс авахыг нарийвчлан заасан байдаг ба энэ зохицуулалт нь зөвхөн үйлдвэрчний эвлэлд гишүүнчлэлтэй ажилтанд л үйлчилнэ.

Тарифын хэлэлцээрийн үед болон тарифын гэрээнд өөрчлөлт оруулахыг шаардах үйл явцад ҮЗ-ээс ажил хаялт зарлаж шахалт үзүүлэх тохиолдол Герман улсад их гардаг./ Үзүүлэн №7/ Ажил хаялтын үед мэдээж ажил олгогчоос цалин хөлс авахгүй боловч ойролцоогоор татварын өмнөх цалингийн 2/3 тай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг ажил хаясан өдрөөр тооцож үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас төлдөг.

Үзүүлэн № 7: Хөдөлмөрийн тэмцэл /ХБНГУ/



3.2. Нийгмийг хөдөлгөгч хүч: Нийгмийн хөгжилд оруулах хувь нэмэр

ҮЭ-ийн гол зорилго бол гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалж, тэдний сонирхлыг төлөөлөх юм. Ингэхдээ мэдээж нийт хөдөлмөрчид болон үндэсний эрх ашгийг харгалзаж үзэх ёстой. Энэ зорилгын хүрээнд ҮЭ-ийн байгууллагууд аж ахуйн нэгж байгууллагуудтай болон төрийн байгууллагуудтай хамтын ажиллагаа өрнүүлэх замаар нэг талаас компаниудын чадавхийг нэмэгдүүлэн улсынхаа эдийн засгийг дэмжих, нөгөө талаас хөдөлмөрийн таатай нөхцөл бүрэлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Үүний тулд ҮЭ дараах зүйлүүдэд анхаарах хэрэгтэй хэмээн ОУ-ын ҮЭХ-ноос зөвлөсөн байна. Үүнд:

- Аливаа хөдөлмөрийн маргаан, санал гомдлыг тухайн нэгжийн хүрээнд зөвлөлдөх, санал солилцох, харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх арга механизмыг бий болгох,
- ҮЭ-ийн идэвхтэн гишүүд, сонгуультнуудыг байнгын мэдээллээр хангах,
- Идэвхтэн гишүүд, сонгуульт ажилтнуудаа байнгын мэргэжил, мэдлэг дээшлүүлэх боломжоор хангах,
- Гишүүддээ сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд ажлын албыг чадварлаг мэргэжилтнүүдээс бүрдүүлж энгийн гишүүд, ажлын алба, сонгуультны хоорондын холбоо харилцааны боломжийг үр өгөөжтэй болгох,
- ҮЭ-ийн стратеги бодлого, дүрэм журмыг гишүүдэд нээлттэй, хүртээмжтэй болгох
- Хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг хүртээмжтэй, хангалттай хэмжээнд байлгах,
- Хөдөлмөрийн харилцаанд гарч буй, гарч болзошгүй өөрчлөлтүүдийг ажиглан, урьдчилсан таамаг гаргаж, гишүүдээ үүнд бэлтгэх болон хамгаалах арга хэмжээ авах гэх мэт байж болно.

Энд дурьдсан анхаарах ёстой үндсэн үйл ажиллагаа, гол үүргээс гадна ҮЭ байгууллагууд нийгмийн бусад олон салбарт өөрийн гэсэн байр сууриа илэрхийлж, тухайн салбартаа үйлдвэрчний байгууллагын гүйэтгэх үүрэг роль, үйл ажиллагааныхаа ач холбогдлыг мэдрүүлж, таниулах чиглэлээр үр дүтээлтэй ажилладаг байна. Жишээ нь:

- Улс төрийн талбарт
- Зах зээлд эзлэх байр суурь
- Зохицуулах үүрэг
- Ардчиллыг хөхүүлэн дэмжигч
- Гишүүддээ үйлчлэгч байгууллага
- Нийгмийн халамж

Улс төрийн талбарт. Дэлхийн олон улсын түүхэнд ҮЭ-ийн хөдөлгөөнөөс улс төрийн хүчин үүссэн тухай тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Харин Монголд энэ үзэгдэл шууд утгаараа гараагүй. Үйлдвэрчний хөдөлгөөнөөс төрж гарсан улс төрийн нам ба ҮЭ хоорондын хамтын ажиллагаа анхнаасаа дээд түвшинд явагдаж олон асуудлуудад нэгдсэн байр суурьтайгаар хандаж шийдвэрлүүлдэг онцлогтой.

МҮЭ-ийн байгууллага социалист тогтолцооны үед үеэд МАХН-тай нягт хамтарч ажилладаг байснаар хөдөлмөрчдийн болоод нийт иргэдийн аятай тухтай ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэхэд улсын бодлогод нөлөөлж, чухал үүргийг гүйцэтгэсэн байдаг.

Улс төрийн амьдралд ҮЭ-ийн гишүүдийн оролцоо, санал хэзээ ч хаана ч чухал байсан. Орон бүрт магадгүй дор хаяад нэг ҮЭ-ийн нэртэй зүтгэлтэн томоохон улс төрч болсон жишээ байж болох юм. Манай ҮЭ-ийн түүхэнд л гэхэд үе үеийн МҮЭХ-ны дарга, ерөнхийлөгчөөс хэд хэдэн хүн улс төрчийн гараагаа эхэлж байсан бодит баримт бий. ХБНГУ-ын түүхэнд ч олон нэртэй улс төрчдөөс эхлээд Канцлер нь хүртэл /Герхард Шройдер 1998-2005/ Германы ҮЭ-д олон жил ажилласан, гишүүн хүмүүс байсан. Үйлдвэрчний эвлэлийн зүтгэлтэн байсан хүн улс төрд сонгогдсоныхоо дараа улс төрийн бодлого тодорхойлоход идэвхтэй орж, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах байр сууриа хүчтэй илэрхийлэн улсынхаа болоод намынхаа хөгжлийн бодлогод тусгаад явж байсан жишээ олон байдаг. Ийм маягаар ҮЭ улс төрийн шийдвэр гаргах процесст нөлөөлөх, өөрийн лобби хийх арга замыг нээдэг. Сүүлийн үеэд судлаачдын ажигласнаар ҮЭ-ийн байгууллагууд угшил нэгтэй ч улс төрийн намаас үйл ажиллагаагаа илүү хөндийрүүлэх хандлагатай байгаа юм байна.

Эдийн засагт нөлөөлөх нь. Хамтын хэлэлцээрт орж салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоолгох мөн үндэсний хэмжээний ХХДХ-г шинэчлэн тогтоох зэрэгт гар бие оролцсоноор МҮЭХ эдийн засагт томоохон нөлөө үзүүлдэг. Иргэд, хөдөлмөрчдийн цалин хөлс нэмэгдсэнээр Кенсийн онолын дагуу тэдний худалдан авах чадвар нь сайжирч зах зээл дээрээс бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ авснаар эдийн засгийн эргэлтийг хурдасгана. Ажил олгогч болон төрийн зүгээс энэ онолтой төдийлөн санал нийлдэггүй. Учир нь татварын дараах нэмэгдэл цалин эдийн засгийг идэвхтэй эргэлтэд оруулахад төдийлөн нөлөөлж чадахгүйгээс гадна импортын бараа үйлчилгээнээс хамааралтай улсуудад цалин нэмэх нь инфляци нэмэгдүүлэх, ажилгүйдэл үүсгэх эрсдэл ихтэй хэмээн их болгоомжтой харьцдаг.

Зохицуулах үүрэг. Түүхийн хуудаснаа ҮЭ нь ажлын байран дахь хөдөлмөрийн стандарт нормыг батлан мөрдүүлэх дээр голчлон ажилладаг байв. Хэдийгээр олон улсын байгууллагаас тогтсон норм, стандартыг гаргасан боловч улс үндэснийхээ онцлогоос хамаарсан хөдөлмөрийн нөхцлийг тогтоон батлуулах ажилд мэргэжлийн байгууллагууд ҮЭ-ээс санал аван хамтран ажилладаг байна. Ялангуяа ҮЭ-ийн хороо нь сайн ажилладаг аж ахуйн нэгж, байгууллага дээр хамтын гэрээндээ хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуй, ажлын үнэлгээ, дэг журам, нийгмийн хангамж зэрэг нарийвчилсан зүйлүүдийг тусган, аливаа томоохон асуудал дээр ажилтан, ажил олгогч хоёрын хоорондын зохицуулагчийн үүргийг гүйцэтгэдэг.

Ардчиллыг хөхүүлэн дэмжигч. Өмнөх тогтолцооны үеийн МҮЭ-ийн хөгжлийн түүхэнд түүний үйл ажиллагаа “дээрээс доошоо” буюу эрх мэдэлтэй дарга нар шийдвэрийг гаргаж, гишүүд, хөдөлмөрчид үүнийг зөвхөн даган биелүүлэх үүрэгтэй байсан нь өөрчлөгдөж өнөөдөр бүх шатны дарга нар сонгуулиар өрсөлдөн ардчилсан зарчмаар сонгогдож, гишүүд хөдөлмөрчдийн санал хүсэлт юу юунаас илүү чухал болоод байдаг тогтолцоонд шилжээд байна. Үг хэлэх эрх, эвлэлдэн нэгдэх эрх, жагсаал цуглаан зохион байгуулах эрх, хэлэлцээрт орох, хамтын гэрээ байгуулах гэх мэт оролцооны ардчиллыг дэмжсэн олон хэлбэрүүдийг МҮЭХ-ны үйл ажиллагаандаа зарчмаа болгон ажилладаг болжээ. Зарим улсад компаний ажилчдын төлөөллийг захирлуудын зөвлөл эсвэл удирдах зөвлөлийн хуралд санал өгөх эрхтэйгээр оруулахаар хуульчилсан нь ажлын байран дахь ардчиллын том илрэл юм. Одоогоор Монгол улсад хууль зүйн ийм зохицуулалт байхгүй.

Гишүүддээ үйлчлэгч байгууллага. Гишүүнчлэлийг нэмэгдүүлэх зорилготой, гишүүн болон гишүүн бусчуудын заагийг тодорхойлдог зүйл бол ҮЭ-ээс гишүүддээ

зориулан явуулдаг үйлчилгээнүүд байдаг. Үүний сонгодог нэг хэлбэр бол үнэ төлбөргүй хуулийн зөвлөгөө, өмгөөлөл ба сургалтын үйл ажиллагаа юм. Зарим улсын ҮЭ-ийн байгууллага нь үйлчилгээгээ өргөжүүлэн эрүүл мэндийн даатгалд хамруулах, зарим үйлчилгээний газруудаар хөнгөлттэй үнээр үйлчлүүлэх, машин унаагаар үйлчлэх гэх мэтийн үйлчилгээг үзүүлдэг байна.

Төрийн үйл ажиллагааг хянагч байгууллага. Хөдөлмөрийн харилцаа болон нийгмийн хамгаалалтай холбогдолтой гаргасан төрийн шийдвэр болгон дээр ҮЭ-ийн байгууллага байр сууриа илэрхийлж саналаа оруулах эрхтэй бас тийм үүрэгтэй. Түүнээс гадна МҮЭХ нь улсдаа хамгийн том олон нийтийн байгууллага гэдэг утгаараа улс төр, нийгэм, эдийн засагт чухал гэгдэх шийдвэрүүд болон хуулийн хэрэгжилтэд хяналтаа тавьж ажиллахыг чухалчилдаг. Үүнийг ч иргэд үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас хүлээдэг байна. Тухайлбал: 2008 оны 4-р сарын 18-нд зохион байгуулсан жагсаалын үр дүнд нийгмийн даатгалын санд Засгийн Газар 2,1 их наяд төгрөгний өртэй гэдгээ хүлээн зөвшөөрч 2015 он хүртэл төлж барагдуулахаар болсон нь иргэдийн ийм хүлээлтэд ҮЭ хариулт өгч үүргээ сайн биелүүлсний нотолгоо юм.

Ашигласан материал

Г. Адъяа, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны төлөв, чиг хандлага (2008-2012), 2013

Ж. Батсайхан, Монгол дахь үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний хөгжил ба хэтийн чиг хандлага, 2008

Д. Догсомжав, Монголын Үйлдвэрчин, 2007

Д. Цэндээ, Монголын үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн, түүний хөгжил хандлага, 1995

Д. Цэндээ, МҮЭ: Уламжлал, шинэчлэл, тулгамдсан асуудал, 1997

“Эдийн засаг ба нийгмийн ардчилал”, нийгмийн ардчиллын сурах бичиг 2-р дэвтэр, Фридрих-Эбертийн Сан, 2009

Эмхтгэл

МҮЭ-ийн хөдөлгөөн - түүхэн замнал, цаашдын хөгжил, онол практикийн бага хурлын эмхтгэл, 2012

МҮЭ: “Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх талаарх МҮЭХ-ны байр суурь, үйл ажиллагаа” эмхтгэл, 2012

Werner Sengenberger, Globalization and Social Progress: The role and impact of International Labour Standards

Hans- Otto Hemmer, Kurt Thomas Schmitz, “Geschichte der Gewerkschaften in der Bundesrepublik Deutschland”

Aus Politik und Zeitgeschichte “Gewerkschaften”, 13-14/2010, Bundeszentrale für politische Bildung

Global Wage Report 2012/2013, Wages and equitable growth

Вэб сайт:

<http://www.ilo.org>

<http://www.ituc-csi.org/>

<http://www.cmtu.mn/>

<http://www.nso.mn/>

<http://www.legalinfo.mn>

Зохиогч

Цогтсайханы УЯНГА

Фридрих-Эбертийн Сангийн
хөтөлбөр хариуцсан ажилтан



Боловсрол

1999	Нийслэлийн 1-р 10 жилийн дунд сургууль,
2003	МУИС, Олон улсын харилцааны Герман судлалын анги,
2009	ХБНГУ-ын Льюдвиг-Максимилианы Их Сургууль, Улс төрийн шинжлэх ухаан, Төрийн удирдлагын эрх зүй, Макро эдийн засгийн онол

Ажил


2005-2006	Эрдэм шинжилгээний ажилтан, ХБНГУ-ын Льюдвиг-Максимилианы Их Сургуулийн эрх зүйн тэнхим /Проф. Др. Бернд Шьонэман
2010-аас	Фридрих-Эбертийн Сангийн хөтөлбөр хариуцсан ажилтан, ҮЭ-ийн төслийн зохицуулагч

Хэвлэсэн бүтээл

2012	"Zwischen Boom und Frust", Parlamentswahlen in der Mongolei 2012, Friedrich- Ebert Stiftung, /хамтарсан бүтээл, герман хэл дээр/
------	--

Хавсралт 1

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ



Хавсралт 2

Монгол улсын төрийн байгууллын давуу болон сул тал

УИХ – Засгийн газар	Давуу тал	Засгийн газар байгуулах/ үйл ажиллагаанд байнга хяналт тавьж, хариуцлага хүлээлгэх боломжтой. УИХ-аас Засгийн газарт бүхэлд болон сайд нэг бүрээр хариуцлага хүлээлгэх нөхцөл бүрдсэн.
	Сул тал	Нэг улс төрийн нам, хүчин дийлэнх олонх болсон үед УИХ нь Засгийн газрын үйл ажиллагааг дэмжигч буюу засгийн газраас оруулсан бодлого, хуулийн төслийг батлах (хэлэлцэгч) үүрэгтэй болно.
Улс төрийн нам – Засгийн газар	Давуу тал	Нэг улс төрийн нам, хүчин олонх болсон нөхцөлд засгийн газрын тогтвортой байдал хадгалагддаг.
	Сул тал	Олон намын буюу эвслийн Засгийн газартай байх үед засгийн газар ойр ойрхон огцрох магадлал бий. Нөгөө талаар нэг нам дангаараа засгийн эрх барьж байх үед нам-УИХ-Засгийн газрын харилцаа гүнзгийрч, ардчилсан ёс харилцаа сэвтэх байдал ажиглагддаг.
Ерөнхийлөгч	Давуу тал	Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой. Өөрөөр хэлбэл УИХ-ын баталсан хууль, шийдвэр үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл Үндсэн Хуулийн Цэцэд хандана.
	Сул тал	Засгийн газрын үйл ажиллагаанд шууд оролцох боломжгүй. Ерөнхийлөгчийн хоригийг парламент хүлээж авахгүй байх эрхтэй.
Засгийн газар	Давуу тал	Нэг нам, улс төрийн хүчний байгуулсан засгийн газар тогтвортой байх боломж бий. Энэ нөхцөлд бодлого, үйл ажиллагаагаа УИХ дахь өөрийн намын гишүүдээр дэмжүүлэх нөхцөл бүрддэг.
	Сул тал	УИХ-ын гишүүн нь нэгэн зэрэг Засгийн газрын гишүүн байснаар институтууд өөр хооронд уусах, нийлэх хандлага ажиглагддаг. Үүнтэй уялдан УИХ-аас Засгийн газарт тавих хяналт суларна. Улмаар УИХ хуулийн төслийг хэлэлцэж, ёсчлох төдий үүрэгтэй институт болоход хүргэдэг.

Хавсралт 3 МҮЭХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, БАЙР СУУРИЙН ТҮҮХЧИЛСЭН МАТРИЦ

	МҮЭ-ийн хөдөлгөөний үүсэл 1917-1927	МҮЭХ-ны үүсэл, их ажлын эхлэл 1928-1940	МҮЭХ-ны төлөвшлийн үе 1941-1960	Бүтээн байгуулалтын үе 1961-1989	Шилжилтийн үе 1990-2012
Улс төрийн тогтолцоо		Капиталист бус хөгжил буюу социализмын чиг шугамыг баримтлах, төрийн эрх баригчид дунд “баруунтан”, “зүүнтэн” гэх санал зөрөлдөөн их байсан	МҮЭ хууль санаачлах эрхтэй	МҮЭ хууль санаачлах эрхтэй	Олон намын тогтолцоотой, парламентын засаглалтай ардчилсан улс МҮЭ хууль санаачлах эрхгүй болсон
Нийгэм, эдийн засгийн байдал		Феодалын ёс давамгайлсан, хөрөнгө чинээ бүхий давхарга нь ноёд тайж, лам нар байв. Аж үйлдвэрлэлийн үндсэн суурь тавигдсан.	Зөвлөлтөөс их хэмжээний эдийн засгийн тусламж авч, хөдөөд хоршоолох ажил явуулж, олон арван үйлдвэрийн газрууд шинээр баригдаж,	Аж үйлдвэр ихээр бий болж эдийн засагт эзлэх хувь дээшилсэн,	ДНБ ХХДХ Амьжиргааны түвшин Инфляци Ажилгүйдэл
МҮЭ-ийн үйл ажиллагааны гол зорилго	Хөлсний хөдөлмөр эрхлэгчид, ядуу хүмүүс цалин хөлсөө нэмэгдүүлэх, ажиллах нөхцлөө сайжруулах	Социализм байгуулах үйлсэд идэвхтэй оролцох, ардын хувьсгалын ололт, амжилтыг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажилчин албан хаагчдын боловсролд анхаарах, хөдөлмөрийн идэвхи санаачлагыг өрнүүлэх, феодалын ёсыг халах, зарц нарыг эвлэлдэн нэгтгэх, өдрөөс өдөрт өсөж байгаа ажилчин, албан хаагчдын боловсролыг, хөдөлмөрийн хандлагыг сайжруулах, цалин хөлс сайжруулах	Тэтгэвэр тэтгэмж тогтоох, түүнд хяналт тавих, нийгмийн даатгалын төсөв зохиох, албан хаагчдыг амралт сувиллалд, үр хүүхдийг нь пионерын зусланд явуулах, хөдөлмөр хамгаалал	Улсын ард аж ахуйг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр ахуй соёлын талаар ажилчдын эрх ашгийг хамгаалах, санхүү нөөц хөрөнгийг хувиарлах шийдвэр гаргахад оролцох, хөдөлмөр хамгаалалд анхаарах, ажилчдын нийгмийн хангамж	Хөдөлмөрийн харилцаа, нийгмийн баталгааг сайжруулах, хөдөлмөрчдийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах, бүтэц зохион байгуулалтын оновчтой хэлбэрийг эрэлхийлэх, бүх шатны ҮЭ-ийн байгууллагын чадавхийг сайжруулах, гишүүдээ үйлчлэх
МҮЭ-ийн үйл ажиллагааны гол арга барил	Хөдөлмөр, цалин хөлсний асуудлаар эзэн, цехийн удирдлагатай гэрээ хийх, шаардлага тавьж болно, харин жагсаал цуглаан хийх хориотой -анхны сэтгүүл “Бүх монголын улаан үйлдвэрчний эвлэл”	Феодалын хөрөнгийг хураан авах, гишүүдийг намын ажилд идэвхтэй оролцуулах, хувьсгалт уралдаан зарлах /гавшгайчууд/, курс дугуйлан ажиллуулах, ханын сонин гаргах, Зөвлөлтийн мөргөжилтэнүүдээс түршлага хүримтлуулах, Шаардлага хүргүүлж, жагсаал цуглаан хийх	Хөдөлмөр хамгааллын шинэ норм, дүрэм батлах, хууль дүрэм биелүүлэггүй нэгэнд хатуу хариуцлага тооцох, гишүүнээс хасах -1947 “Хөдөлмөр” сонин	Социалист уралдаан зарлах, хөдөлмөрийн норм тогтоох, шагнаж урамшуулах, хөдөлмөрийн баатар тодруулах, хууль дүрэм зөрчигчдөд хатуу хариуцлага тооцох, ажлыг зоогох хаах, хөдөлмөр хамгаалалд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, сургалт сурталчилгаа өргөнөөр явуулсан	Нийгэм, эдийн засаг, хөдөлмөрийн асуудлаар төр, эзэдтэй гурван талт хэлэлцээрт орох, гишүүдээ үнэ төлбөргүй хуулийн болон өмгөөллийн зөвлөгөө өгөх, сургалт явуулах, кампанит ажил зохиох, хууль боловсруулахад гар бие оролцох, нийгэм эдийн засгийн цаг үеийн томоохон асуудалд байр сууриа илэрхийлэх, зохистой хөдөлмөрийг дэмжих

МҮЭ-ийн гадаад харилцаа	Бүриадын үйлдвэрчний эвлэл СССР үйлдвэрчний эвлэл	Профинтерн болон түүний гишүүн байгууллагуудтай Хамтран ажилласан	1949- Дэлхийн үйлдвэрчний эвлэлийн холбоонд элсэн орсон.	Олон орны ҮЭ-ийн 40 гаруй байгууллагуудтай хамтран ажилласан	1989 оны байдлаар олон улсын 60 гаруй ҮЭ-тэй улс төрийн чиг баримжаа үл харгалзан ажиллах болсон
Батлагдсан хууль, дүрэм	1925-"Аливаа хүчин үнэлэгчдийн тухай дүрэм"/ анхны хөдөлмөрийн хууль/ 1924 Үндсэн хууль "Эвлэлдэн нэгдэх эрх"	1930,1933,1934- Хөдөлмөрийн хууль шинэчлэгдэн батлагдсан -1936 МҮЭ-ийн анхны дүрэм "Аймаг, хотын товчоод ба үндсэн үүр, төлөөлөгчийн дүрэм"	1941, 1960-Шинэчлэгдсэн хөдөлмөрийн хууль -ҮЭ бие даан хуульчилсан дүрэм, журам гаргах эрхтэй болсон	1973- Хөдөлмөрийн хууль / шинэчлэгдсэн 1974- Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай дүрэм	1991-ҮЭ-ийн эрхийн тухай хууль
Гол ололт, амжилтууд	Албан ёсоор 1925 онд: - Өдрийн ажлын 8 цаг - Ням гараг амралтын өдөр - Бямба гариг 6 цагаар ажиллахыг хуульчилж өгсөн.	-Хамтын гэрээ - Үйлдвэрлэлийн зөвлөлгөөн ҮЭ үйлдвэрлэл, нутаг дэвсгэрийн нэгжээр зохион байгуулагдах болсон	-Тэтгэвэр, тэтгэмжийн системийн эхлэл -Ажлын цагийг нарийвчилсан -хөдөлмөрийн сахилгын арга хэмжээнүүд	-1974- Жирэмсний болон төрсний дараах цалинт хугацааг сунгасан, 1 жил ажлын байрыг хадгалж, тэтгэмж олгох -1979- ХАА-н нэгдлийн гишүүдийн тэтгэвэрийг 50%-иар нэмэгдүүлсэн -1400 гаруй мэргэжилийн тарифт цалингийн лавлах анхны хөдөлмөр хамгааллын лаборатори байгуулсан -Цэцэрлэг, сургууль, орон сууц олноор барих, барихаа ажлыг идэвхижүүлсэн	Хамтын гэрээ олноор байгуулсан,цалин хөлс хэд дахин нэмэгдүүлсэн, асуудлыг нийгмийн түншлэлийн хүрээнд шийдэх, хөдөлмөрийн тэмцэл амжилттай өрнүүлсэн,гишүүддээ хууль зүйн болон өмгөөллийн туслалцаа үзүүлэх болсон, гадаад харилцаа эрс нэмэгдсэн гэх мэт
Гишүүний тоо	1927 оны байдлаар 3312	1928 оны байдлаар 5078		1989 оны байдлаар 620000	2012 оны байдлаар 160000

Хавсралт 4.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Монголын ард түмэн бид:

-улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
-хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
-төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
-хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
-эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.
Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ

Нэгдүгээр зүйл.

1. Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.
2. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

Хоёрдугаар зүйл.

1. Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.
2. Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.

Гуравдугаар зүйл.

1. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.

2. Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно.

Дөрөвдүгээр зүйл.

1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна.
2. Монгол Улсын хилийг хуулиар бататгана.
3. Хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно.

Тавдугаар зүйл.

1. Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.
2. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.
3. Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.
4. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.
5. Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна.

Зургадугаар зүйл.

1. Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.
2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.
3. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно.
4. Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.
5. Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.

Долдугаар зүйл.

1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.
2. Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн.

Наймдугаар зүйл.

1. Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө.

Есдүгээр зүйл.

1. Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ.
2. Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй.
3. Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна.

Аравдугаар зүйл.

1. Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг

эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.

3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

4. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй. Арван нэгдүгээр зүйл.

1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.

2. Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.

Арван хоёрдугаар зүйл.

1. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн.

2. Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.

3. Төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй байна. Сүлдний төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдний хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.

4. Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн.

5. Монгол Улсын төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундах хэсэг нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байна. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбо байрлуулна. Далбааны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна.

6. Төрийн тамга дөрвөлжин хэлбэртэй, голдоо төрийн сүлдтэй, сүлдний хоёр талаар Монгол Улс гэсэн бичээстэй, арслангийн дүрс бүхий бариултай байна. Төрийн тамгыг Монгол Улсын Ерөнхийлөгч барина.

7. Төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар бататгана.

Арван гуравдугаар зүйл.

1. Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн.

2. Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Арван дөрөвдүгээр зүйл.

1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

Арван тавдугаар зүйл.

1. Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно.

2. Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно. Арван зургадугаар зүйл.

1. Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

1/ амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;

2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;

3/ хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;

4/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;

5/ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;

6/ эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно;

7/ сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;

8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;

9/ шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;

10/ нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;

11/ улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;

12/ төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;

13/ халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;

14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;

15/ шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;

16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;

18/ улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно. Арван долдугаар зүйл.

1. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:

1/ Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

2/ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

3/ хуулиар ногдуулсан албан татвар төлөх;

4/ эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.

2. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.

Арван наймдугаар зүйл.

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална.

3. Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно.

4. Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно.

5. Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно. Арван есдүгээр зүйл.

1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

2. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.

3. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

НЭГ. Монгол Улсын Их Хурал
Хорьдугаар зүйл.

Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.

Хорин нэгдүгээр зүйл.

1. Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.

2. Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

3. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.

4. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.

Хорин хоёрдугаар зүйл.

1. Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг нь хамарсан гэнэтийн аюул тохиолдсон, дайны ба нийтийн эмх замбараагүй байдал үүссэн зэрэг онцгой нөхцөлийн улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй бол мөнхүү нөхцөл арилж, шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

2. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ эдэлнэ.

Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана.

/Энэ заалтыг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн бөгөөд Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн/

Хорин гуравдугаар зүйл.

1. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.

2. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.

Хорин дөрөвдүгээр зүйл.

1. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.

/Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/

2. Улсын Их Хурлын дарга, дэд даргын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд хуульд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж, огцруулж болно.

Хорин тавдугаар зүйл.

1. Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:

1/ хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

2/ төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох;

3/ Ерөнхийлөгчийн ба Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах;

4/ Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа

шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх;

5/ Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, чөлөөлөх, огцруулах;

6/ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд

хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;

7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;

8/ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах;

9/ улсын хил тогтоох;

10/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоох;

11/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг батлах, өөрчлөх;

12/ нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох;

13/ улсын цол, одон, медаль, цэргийн дээд цол бий болгох, төрийн албаны зарим тусгай салбарын албан тушаалын зэрэг дэвийг тогтоох;

14/ өршөөл үзүүлэх шийдвэр гаргах;

15/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах;

16/ ард нийтийн санал асуулга явуулах. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ;

17/ Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд бусад улсаас аюул занал учруулж,

зэвсэглэн халдвал дайн бүхий байдал зарлах, цуцлах;

18/ энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөлд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, эсхүл энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох.

2. Дараахь онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно:

1/ улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;

2/ Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон.

3. Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно.

4. Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

Хорин зургадугаар зүйл.

1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ.

2. Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна.

3. Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Хорин долдугаар зүйл.

1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

2. Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна. /Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/

3. Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган чуулж болно.

4. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг сонгууль явуулсан өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана.

5. Ерөнхийлөгч онц болон дайны байдал зарлавал түүнээс хойш далан хоёр цагийн дотор Улсын Их Хурал онцгой чуулганаа тусгайлан товлонхгүйгээр чуулна.

6. Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ.

/Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/

Хорин наймдугаар зүйл.

1. Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна.

2. Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно.

Хорин есдүгээр зүйл.

1. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.

/Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/

2. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

3. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.

ХОЁР. Монгол Улсын Ерөнхийлөгч

Гүчдугаар зүйл.

1. Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.

2. Ерөнхийлөгчөөр дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

Гучин нэгдүгээр зүйл

1. Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна.

2. Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ.

3. Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргана.

4. Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр

дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.

5. Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтаар сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.

6. Хэрэв хоёр дахь санал хураалтаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол дахин сонгууль явуулна.

7. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.

8. Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө.

Гучин хоёрдугаар зүйл.

1. Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхэлж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно.

2. Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая" хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө. Гучин гуравдугаар зүйл.

1. Ерөнхийлөгч дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ;

2/ Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах; /Энэ заалтыг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/

3/ өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно;

4/ гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах;

5/ Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах;

6/ Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах;

7/ улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах;

8/ уучлал үзүүлэх;

9/ Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх;

10/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх;

11/ бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах;

12/ Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.

2. Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.

3. Ерөнхийлөгч Улсын Их Хуралд болон ард түмэндээ хандан илгээлт гаргаж, чуулганд өөрийн тааллаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, саналаа оруулж болно.

4. Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно.

Гучин дөрөвдүгээр зүйл.

1. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргана.

2. Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.

Гучин тавдугаар зүйл.

1. Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцна.

2. Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна.

Гучин зургадугаар зүйл.

1. Ерөнхийлөгчийн бие, өргөө, унаа халдашгүй дархан байна.

2. Ерөнхийлөгчийн нэр төр, халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

Гучин долдугаар зүйл.

1. Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ.

2. Ерөнхийлөгч огцорсон, нас нөгчсөн, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн бол Ерөнхийлөгч шинээр сонгогдож

тангараг өргөх хүртэл бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн сарын дотор зарлан явуулна.

3. Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэх журмыг хуулиар тогтооно.

ГУРАВ. Монгол Улсын Засгийн газар

Гучин наймдугаар зүйл.

1. Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.

2. Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах;

2/ шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх;

3/ салбарын ба салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;

4/ хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;

5/ төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай удирдаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

6/ улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах;

7/ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

8/ төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх;

9/ Улсын Их Хуралтай зөвшилцөж дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах.

3. Засгийн газрын тодорхой бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. Гучин есдүгээр зүйл.

1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.

2. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.

/Энэ заалтыг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн/

3. Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилно.

Дөчдүгээр зүйл.

1. Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

2. Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно.

Дөчин нэгдүгээр зүйл.

1. Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.

2. Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

Дөчин хоёрдугаар зүйл.

Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

Дөчин гуравдугаар зүйл.

1. Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

2. Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.

3. Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан болон Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш арван тав хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ.

4. Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулах тухай саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.

Дөчин дөрөвдүгээр зүйл.

Өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч Засгийн газар тогтоолын төсөл оруулбал Улсын Их Хурал уул асуудлыг дөчин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмаар шийдвэрлэнэ.

Дөчин тавдугаар зүйл.

1. Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна.

2. Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.

Дөчин зургадугаар зүйл.

1. Монгол Улсын яам, төрийн бусад албан газрыг хуулийн дагуу байгуулна.

2. Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана.

3. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно.

ДӨРӨВ. Шүүх эрх мэдэл

Дөчин долдугаар зүйл.

1. Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.

2. Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.

3. Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.

Дөчин наймдугаар зүйл.

1. Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

2. Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

3. Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

Дөчин есдүгээр зүйл.

1. Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.

2. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.

3. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана.

4. Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ.

5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

Тавьдугаар зүйл.

1. Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

2/ давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;

3/ хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;

4/ Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;

5/ хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.

2. Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.

3. Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй.

Тавин нэгдүгээр зүйл.

1. Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.

3. Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.

4. Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.

Тавин хоёрдугаар зүйл.

1. Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.

2. Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.

3. Хуульд тусгайлан зүйлчилж заасан зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно.

Тавин гуравдугаар зүйл.

1. Шүүн таслах ажиллагааг монгол хэлээр явуулна.

2. Монгол хэл мэдэхгүй хүнд хэргийн баримт сэлтийг хэлмэрчлүүлэн бүрэн танилцуулах бөгөөд шүүх хуралдаан дээр эх хэлээр нь үг хэлэх эрх олгоно.

Тавин дөрөвдүгээр зүйл.

Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ.

Тавин тавдугаар зүйл.

1. Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй.

2. Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. Тавин зургадугаар зүйл.

1. Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.

2. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.

3. Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ

ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА

Тавин долдугаар зүйл.

1. Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.
2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.
3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

Тавин наймдугаар зүйл.

1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.
2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

Тавин есдүгээр зүйл.

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.
2. Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.
3. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.

Жардугаар зүйл.

1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ.
2. Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно.
3. Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална.

Жаран нэгдүгээр зүйл.

1. Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна.
2. Засаг дарга тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй.
3. Тавьсан хоригийг нь Хурал өөрийн төлөөлөгчдийн олонхийн саналаар няцаасан нөхцөлд Засаг дарга үүл шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно.
4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар мөн. Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно.

Жаран хоёрдугаар зүйл.

1. Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.
2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.
3. Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно.

Жаран гуравдугаар зүйл.

1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга захирамж гаргана.
2. Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.
3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

ТАВДУГААР БҮЛЭГ
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

Жаран дөрөвдүгээр зүйл.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.
2. Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.
3. Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.

Жаран тавдугаар зүйл.

1. Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

2. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно.

3. Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно. Түүнийг нэг удаа улируулан сонгож болно.

4. Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.

5. Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж үл болно.

Жаран зургадугаар зүйл.

1. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.

2. Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:

1/ хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

2/ ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

3/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;

4/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана.

4. Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно.

Жаран долдугаар зүйл.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ,

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Жаран наймдугаар зүйл.

1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

2. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна.

Жаран есдүгээр зүйл.

1. Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батална.

2. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд ийнхүү нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн санал авч эс чадвал уул төслийг ээлжит сонгуулиар сонгогдсон Улсын Их Хурлын шинэ бүрэлдэхүүн ажлаа эхэлтэл дахин авч хэлэлцэхгүй.

3. Улсын Их Хурал ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно.

4. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна.

Далдугаар зүйл.

1. Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.

2. Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө.

Мэдэгтүн, сахигтүн!

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРАЛ

1992 оны нэгдүгээр сарын 13-ны өдрийн 11 цаг 35 минут

Улаанбаатар хот

Хавсралт 5.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1991 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

**ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН
ЭРХИЙН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах зорилгоор сайн дураараа чөлөөтэй эвлэлдэн нэгдэж үйл ажиллагаа явуулах эрхийг баталгаажуулж, энэ хүрээнд үүссэн нийгмийн харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай Монгол Улсын хууль тогтоомж

Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай Монгол Улсын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан Монгол Улсын хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх

1. Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй.

2. Үйлдвэрчний эвлэлд гишүүнээр элсэх буюу гишүүнээс гарахыг тулган шаардаж болохгүй.

3. Үйлдвэрчний эвлэлийн гишүүн мөн эсэхтэй холбогдуулан иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах буюу тэднийг ялгаварлан гадуурхахыг хориглоно.

4 дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлэлүүдийн бие даасан байдлыг хангах

1. Үйлдвэрчний эвлэлүүд нь мэргэжил, үйлдвэрлэлийн шинжээр байгуулагдаж үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд бие даан чөлөөтэй явуулна.

2. Үйлдвэрчний эвлэлүүд тэгш эрхтэй.

3. Үйлдвэрчний эвлэлүүд нь сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж холбоо байгуулах, олон улсын үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдэлд гишүүнээр элсэх эрхтэй.

4. Үйлдвэрчний эвлэлүүд болон тэдгээрийн холбоод хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

41 дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлэлийг бүртгэх

1. Үүсгэн байгуулагч нь үйлдвэрчний эвлэлийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлөө хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

2. Өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

1/ үйлдвэрчний эвлэлийн нэр, байрлаж байгаа газрын нэр, үйлдвэрчний эвлэлийн бүтэц, зохион байгуулалтын мэдээ;

2/ үйлдвэрчний эвлэлийн дүрэм;

3/ үүсгэн байгуулсан гишүүний бүртгэл;

4/ хөрөнгийн эх үүсвэрийн тухай мэдээ.

3. Энэ зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан өргөдөл, баримт бичгийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан үзээд үйлдвэрчний эвлэлийг 14 хоногийн дотор улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоно.

4. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үйлдвэрчний эвлэлийг бүртгэхээс татгалзвал энэ тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.

/Энэ зүйлийг 1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн ба 2003 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон /

42 дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэлийг бүртгэхтэй холбогдсон шийдвэрийн талаар гомдол гаргах

1. Үүсгэн байгуулагч нь үйлдвэрчний эвлэлийг бүртгэх талаар гарсан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.

2. Шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэ нь эцсийн шийдвэр болно.

/Энэ зүйлийг 1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн ба 2003 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон /

43 дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэл тарах, үйл ажиллагаагаа зогсоох

Үйлдвэрчний эвлэл сайн дураараа тарах буюу бусад үйлдвэрчний эвлэлд нэгдэж үйл ажиллагаагаа зогсоож болно. Энэ тухай хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 10 хоногийн дотор мэдэгдэнэ.

/Энэ зүйлийг 1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн/.

44 дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлэлийг бүртгэлээс хасах

Үйлдвэрчний эвлэл Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон өөрийн дүрмийг зөрчсөн нь шүүхээр тогтоогдож, энэ нь түүний үйл ажиллагааг зогсоох үндэслэл болохоор байвал хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түүнийг улсын бүртгэлээс хасна.

/Энэ зүйлийг 1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн/.

5 дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэлүүдийн үндсэн эрх

1. Үйлдвэрчний эвлэлүүд нь хөдөлмөрийн харилцаатай холбогдсон үйл ажиллагаа явуулахдаа дор дурдсан үндсэн эрх эдэлнэ:

1/ захиргаа, эзэдтэй хэлэлцээ хийж хамтын болон бусад гэрээ байгуулах, түүний биелэлтэд хяналт тавих;

2/ хөдөлмөрийн маргаан хянан шийдвэрлэх байгууллагад гишүүдийнхээ эрх ашгийг төлөөлөн хамгаалах;

3/ хөдөлмөрлөх эрхтэй холбогдсон БНМАУ-ын хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, тэдгээрийг сахин биелүүлэхийг захиргаанаас шаардах;

4/ хөдөлмөрлөх эрхийг хохироосон захиргааны шийдвэрийг түдгэлзүүлэн зогсоохыг болон өөрчлөх, хүчингүй болгох, гэрээг цуцлахыг шаардах;

5/ хөдөлмөрлөх эрхийг хамгаалахтай холбогдсон аливаа асуудлаар гишүүд, ажилтны санаа, бодол, эрэлт хэрэгцээг судлан захиргаанд шаардлага тавих, мэдэгдэл гаргах, зохих байгууллагад төлөөлөх;

6/ гишүүд, ажилтныхаа зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоолгохоор шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах;

7/ хөдөлмөрлөх эрхтэй холбогдсон аливаа асуудлыг хөдөлмөрчдөөр хэлэлцүүлэхийг санал болгох буюу гишүүдээрээ бие даан хэлэлцүүлэг зохион байгуулах;

8/ үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай мэдээллийг захиргаанаас гаргуулан авах;

9/ БНМАУ-ын хууль тогтоомжид заасан журмаар жагсаал, цуглаан, ажил хаялт зохион байгуулах;

10/ БНМАУ-ын хууль тогтоомжид заасан бусад эрх.

2. Тухайн байгууллагад хоёр, түүнээс дээш үйлдвэрчний эвлэл байвал тэдгээр нь тохиролцож, хамтарсан төлөөлөгчид томилон захиргаа, эзэдтэй хамтын нэг гэрээ байгуулна.

Бусад тохиолдолд хамтын гэрээг нийт ажилтны төлөөлөгчид захиргаатай байгуулж болно.

3. Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсгийн заалтууд үйлдвэрчний эвлэлийн орон нутгийн болон улсын хэмжээний холбоодод нэг адил хамаарна. /Энэ тохиолдолд "захиргаа" гэдэгт БНМАУ-ын төрийн гүйцэтгэн захирамжлах дээд, төв болон орон нутгийн байгууллагыг хамааруулан ойлгоно/

4. Үйлдвэрчний эвлэлүүдийн улсын хэмжээний нэгдсэн холбоо /хэд хэдэн холбоо байвал тэдгээрийн төлөөлөгчид/ нь БНМАУ-ын Засгийн газар, эздийн улсын хэмжээний байгууллагатай нийгмийн зөвшлийг хангах гурван талт хэлэлцээр байгуулж болно. Энэхүү хэлэлцээр байгуулах журмыг оролцогч талууд тогтооно.

6 дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэлүүдийн үйл ажиллагааны болон түүний сонгуульт ажилтны эрхийн баталгаа

1. Үйлдвэрчний эвлэлүүдийг захиргааны журмаар тараах, үйл ажиллагааг нь зогсоох, мөшгин хавчих зэргээр үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглоно.

2. Үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтныг өөрийн болон сонгосон хамт олных нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, захиргааны санаачлагаар ажлаас халах, түүнд сонгуульт үүрэгтэй нь холбогдуулан сахилгын шийтгэл оногдуулахыг хориглоно.

3. Үндсэн ажлаасаа чөлөөлөгдсөн үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтны сонгуулийн хугацаа дуусгавар болсон, түүнчлэн хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар сонгуульт үүргээсээ чөлөөлөгдсөн тохиолдолд захиргаа түүнийг хуучин ажилд нь эгүүлэн ажиллуулах буюу тухайн ажил байхгүй бол өөрийн нь зөвшөөрснөөр урьд авч байсан дундаж хөлс нь буурахааргүйгээр ажил олгоно.

4. Үйлдвэрчний эвлэл, түүний сонгуульт ажилтныг үйл ажиллагаагаа явуулах нөхцөл, бололцоогоор хангах асуудлыг хамтын гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ. Үндсэн ажлаасаа чөлөөлөгдсөн үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтанд хамтын гэрээ нийт ажилтны нэг адил хамаарна.

5. Үйлдвэрийн газар, байгууллагын захиргааны удирдах албан тушаалтан үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажлыг хавсран гүйцэтгэж болохгүй.

7 дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэлүүдийн санхүү, эд хөрөнгө

1. Үйлдвэрчний эвлэлүүд нь өөрөө санхүүжих зарчмаар ажиллана.

2. Үйлдвэрчний эвлэлүүдийн эд хөрөнгө нь гишүүдийн татвар, хандив, үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах бусад эд юмсаас бүрдэнэ.

8 дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай олон улсын гэрээг сахин биелүүлэх

Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хууль тогтоомжийн заалт БНМАУ-ын олон улсын гэрээний заалттай зөрчилдвөл уг олон улсын гэрээний заалтыг баримтална.

9 дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль тогтоомж зөрчсөний хариуцлага

1. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд БНМАУ-ын хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

2. Үйлдвэрчний эвлэл БНМАУ-ын Үндсэн хууль, бусад хуулийг зөрчвөл тийнхүү хууль зөрчсөн үйл ажиллагааг шүүхийн шийдвэрээр зогсоож болно.

10 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1991 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

БНМАУ-ЫН БАГА ХУРЛЫН ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

Тэмдэглэл



Impressum

“ Politics, economy and society of Mongolia: system and policy”

Published by Friedrich-Ebert Stiftung, Ulaanbaatar, Mongolia 2013

Contact: FES, Ulaanbaatar, Mongolia

Address: Red Cross Building

Sukhbaatar District

UB-210648

Mongolia P.O. Box-831

Tel: +976 11 312892

Fax: + 976 11 312889

Web: www.fes.de

E-mail: info@fesmongol.net

**Энэхүү номын зохиогчийн эрхийг
Фридрих-Эбертийн Сан эзэмших бөгөөд ашиг олох
зорилгоор худалдаалахыг хориглоно.**

